



**МОНГОЛ УЛСЫН
МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУДЫН
ХЭРЭГЖИЛТ**

ҮНДЭСНИЙ ГУРАВ ДАХЬ ИЛТГЭЛ

Улаанбаатар хот
2009 он

DDC
338.542
М - 692

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт
Үндэсний гурав дахь илтгэл

2009 он

Үндэсний гурав дахь илтгэлийг монгол, англи хэлээр хэвлэсэн болно. Энэхүү илтгэлд ашигласан тоо, мэдээллийг тусгайлан дурдсанаас бусад тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын албан ёсны эх үүсвэрээс авсан болно.

Харилцах хаяг:

Монгол Улс
Улаанбаатар 15160
Нэгдсэн Үндэстний гудамж 5/1
Засгийн газрын II байр
Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо

Утас: (976)-51-265912, (976)-51-260973

Факс: (976)-51-260973, (976)-51-263569

Веб: <http://www.ndic.gov.mn/>

<http://mongoliamdg.mn/>

Э-шуудан: info@ndic.gov.mn

НҮБХХ-ийн “Ядуурал, МХЗ-уудын хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог дэмжих туршилтын төсөл”-ийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хэвлэв.

Зургийг “Фотомон”, “Фотолнк” агентлаг болон НҮБХХ, НҮБХАС-ын архиваас оруулав.

ISBN 978-99962-0-099-1

АГУУЛГА

Товчилсон үг	4
Тэмдэглэгээ, шигтгээ	6
Хүснэгт	7
Дүрслэл	8
Өмнөх үг. Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж	9
Илгээлт. НҮБ-ын Монгол дахь зохицуулагч, НҮБХХ-ийн Суурин төлөөлөгч Дебора Комини	11
Талархал. ҮХШХ-ны дарга Ч.Хашчулуун	12
Ерөнхий тойм	13
Ололт, ахиц, дэвшил	14
Хүндрэл, саад, бэрхшээл	15
Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн тойм	15
МХЗ-уудын санхүүжилт	19
Ерөнхий дүгнэлт	19
Үндсэн тайлан	
БҮЛЭГ 1. Монгол Улсын МХЗ-уудын хэрэгжилтийн үнэлгээ	21
Зорилго 1: Ядуурал, өлсгөлөнг бууруулах	23
Зорилго 2: Бүх нийтээр анхан шатны боловсрол эзэмших	37
Зорилго 3: Жендэрийн тэгш байдлыг дэмжин хөгжүүлж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх	41
Зорилго 4: Хүүхдийн эндэгдлийг бууруулах	49
Зорилго 5: Эхчүүдийн эрүүл мэндийг сайжруулах	53
Зорилго 6: Бэлгийн замын халдварт өвчин, ХДХВ, ДОХ, сүрьеэтэй тэмцэх, бусад өвчнийг бууруулах	57
Зорилго 7: Байгаль орчны тогтвортой байдлыг хангах	65
Зорилго 8: Хөгжлийн төлөө дэлхий нийтийн түншлэлийг хөгжүүлэх	81
Зорилго 9: Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх	93
БҮЛЭГ 2. МХЗ-ууд болон хөгжлийн урт болон дунд хугацааны бодлого төлөвлөлт, санхүүжилтийн уялдаа холбоо	105
БҮЛЭГ 3. МХЗ-уудын орон нутаг дахь хэрэгжилтийн байдал, сурталчилгаа, олон нийтийн оролцоо	109
БҮЛЭГ 4. Монгол Улсын ядуурлын зураглал	117
БҮЛЭГ 5. МХЗ-уудын хяналт-шинжилгээ, үнэлгээ	123
ХАВСРАЛТУУД	
Хавсралт 1. Монгол Улсын макро эдийн засгийн гол үзүүлэлтүүд, 2005-2008 он	128
Хавсралт 2. МХЗ-уудын хэрэгжилтийн явцад үнэлгээ хийсэн аргачлалын тухай	129
Хавсралт 3. МХЗ-уудын хэрэгжилтийн хандлагын шинжилгээ, үнэлгээ	132
Хавсралт 4. МХЗ-уудын зарим гол шалгуур үзүүлэлтээр тодорхойлсон үнэлгээ, 2008 он (аймаг, нийслэлийг байр эзлүүлснээр)	137
Хавсралт 5. Хүн амын тооллогын 2000 оны тоо, мэдээлэлд суурилсан үзүүлэлтийн МХЗ-уудын зарим зураглал: Аймаг, сумын түвшний үр дүн	138
Ашигласан эх сурвалжууд	144

Товчилсон үг

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АББ	Албан бус боловсрол
АББЗСҮТ	Албан бус боловсролын зайн сургалтын үндэсний төв
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АТГ	Авлигатай тэмцэх газар
АХБ	Азийн хөгжлийн банк
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдвар
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
ГШХО	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ГХО	Гадаадын хөрөнгө оруулалт
ДБ	Дэлхийн банк
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДОХ	Дархлалын олдмол хомсдол
ДЦС	Дулааны цахилгаан станц
ДХБ	Дэлхийн худалдааны байгууллага
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЕСБХБ	Европын Сэргээн босголт, Хөгжлийн банк
ЕТУХН	Европын болон Тусгаар Улсуудын Хамтын Нийгэмлэг
ЗГ	Засгийн газар
ЗГҮАХ	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЖТБҮХ	Жендэрийн тэгш байдлын Үндэсний хороо
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МХЗ	Мянганы хөгжлийн зорилт
МХХТ	Мэдээлэл, харилцаа холбооны технологи
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
МШХХТГ	Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХАС	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн Амын Сан
НҮБХС	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
НҮЭМ	Нөхөн үржихүйн эрүүл мэнд
НХХЯ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
ОУБ	Олон улсын байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс

ОУХА	Олон улсын хөгжлийн ассоциаци
ОУГК	Олон улсын гэрээ конвенц
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
СДЗШ	Сайн дурын зөвлөгөө шинжилгээ
СТС	Сургалтын төрийн сан
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ШОУХА	Шведийн олон улсын хөгжлийн агентлаг
ШХХАА	Швейцарын хөгжлийн хамтын ажиллагааны агентлаг
ШУА	Шинжлэх ухааны академи
ШУТИС	Шинжлэх, ухаан, технологийн их сургууль
ШЭНЭСТ	Шүд, эрүү нүүр, эмгэг судлалын төв
УИХ	Улсын Их Хурал
УМХГ	Улсын мэргэжлийн хяналтын газар
УЦУОШГ	Ус цаг уурын орчны шинжилгээний газар
ҮНО	Үндэсний нийт орлого
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮХЦБ	Үндэсний хөгжлийн цогц бодлого
ҮХШХ	Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо
УБ	Улаанбаатар хот
УБЦТС	Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ
ХАА	Хөдөө аж ахуй
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ХАЁТ	Хөгжлийн албан ёсны тусламж
ХДХВ	Хүний дархлал хомсдолын вирус
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХӨЦМ	Хүүхдийн өвчний цогц менежмент
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХААХОУС	Хөдөө аж ахуйн хөгжлийн олон улсын сан
ХК	Хувьцаат компани
ХМХ	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл
ХХЗХ	Харилцаа холбооны зохицуулах хороо
ХХИ	Хүний хөгжлийн индекс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХНН	Хувь нийлүүлсэн нийгэмлэг
ХЭҮК	Хүний эрхийн Үндэсний комисс
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭНЭШТ	Эх нялхасын эрдэм шинжилгээний төв
ЮНЕСКО	Нэгдсэн үндэстний байгууллагын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага
ЭБЭ	Эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрэгтэй
ЭБҮ	Эмэгтэй биеэ үнэлэгч
ЭЗНХҮЧ	Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл
ЭМД	Эрүүл мэндийн даатгал

Тэмдэглэгээ

Км	Километр
Гб/с	Гига байт/секунд
Е	Электрон
М	Метр
Мб/с	Мега байт/секунд
тн	Тонн
мкг	Микрограмм
квт	Киловатт
кВ	Киловольт

Шигтгээ

Шигтгээ 1	Оюутны хөдөлмөр эрхлэлт
Шигтгээ 2	Сургалтын шинэ тогтолцоо
Шигтгээ 3	Хамтын ажиллагаа
Шигтгээ 4	ХДХВ, ДОХ-д өртөх эрсдэл өндөртэй бүлэгтэй ажиллах
Шигтгээ 5	Цахим Монгол хөтөлбөр
Шигтгээ 6	Авлигатай тэмцэх арга хэмжээ
Шигтгээ 7	Ажил олгогч, бизнес эрхлэгчдийн оролцоо
Шигтгээ 8	Ядуурлын зураглалыг хэрэглэж байгаа орнуудын жишээ

Хүснэгт

Хүснэгт 1	Ядуурлын түвшин, гүнзгийрэлт, хэрэглээ, нэг хүнд ногдох ДНБ;
Хүснэгт 2	Ядуурлын хамралт, гүнзгийрэлт, тэгш бус байдал, нэг хүнд ногдох хэрэглээ, 2003, 2008;
Хүснэгт 3	Тав хүртэлх насны хүүхдийн тураал, өсөлтийн хоцролт, туранхай хүүхдийн хувь;
Хүснэгт 4	Ажиллах хүчний оролцоо, 15-24 насны залуучуудын ажилгүйдэл, бүсээр, 2004-2008;
Хүснэгт 5	Бага боловсролын хамран сургалт, 1-5 дугаар анги хүртэл суралцагчид, бичиг үсэг тайлагдалт;
Хүснэгт 6	Бага, ерөнхий болон дээд боловсрол эзэмшигчдийн хүйсийн харьцаа;
Хүснэгт 7	ХАА-гаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь, 2003-2008;
Хүснэгт 8	ХАА-гаас бусад салбарт ажиллаж байгаа эрэгтэй, эмэгтэйчүүдийн эзлэх хувь, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, 2008;
Хүснэгт 9	Улсын Их Хуралд сонгогдсон, нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь;
Хүснэгт 10	Нялхсын болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, вакцинжуулалт;
Хүснэгт 11	Эхийн эндэгдэл, эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлт;
Хүснэгт 12	Жирэмсэн эмэгтэйчүүд болон 15-24 насны залуучуудын дундахь ХДХВ-ын халдварын тархалт, хувь;
Хүснэгт 13	Сүрьеэ өвчний тархалт, өвчлөлийн түвшин, нас баралт, оношилгоо, эмчилгээний тохиолдлын хувь;
Хүснэгт 14	Хүүхдийн шүд цоорох өвчний тархалт, хувь;
Хүснэгт 15	Ойт нутаг болон улсын тусгай хамгаалалтад авсан газар нутаг, нэг хүнд ногдох давхар исэл, агаар дахь хүхэрлэг хийн агууламж;
Хүснэгт 16	Цөлжилтийн эрчим, хувиар, 1990, 2004, 2007;
Хүснэгт 17	Дулааны цахилгаан станцуудын жилд хэрэглэсэн нүүрсний хэмжээ, агаарт хаяж байгаа хортой бодисын хэмжээ, тн/жил;
Хүснэгт 18	Хамгаалалтад авсан гол мөрний усны урсац бүрэлдэх ундаргын эхийн эзлэх хувь;
Хүснэгт 19	Монгол орны усны эх, урсац, бүрэлдэх хэсэг, 2008;
Хүснэгт 20	Усны нөөц ашиглаж байгаа үйлдвэрлэлийн чиглэл, тоо, 2008;
Хүснэгт 21	Ус хангамж, сайжруулсан ариун цэврийн байгууламж, ядуурлын хүрээ, хот, хөдөө, улсын дунджаар, 2007-2008;
Хүснэгт 22	Ядуурлын дүр төрх сууцны шинж байдлаар, хот, хөдөөгөөр, 2007-2008;
Хүснэгт 23	ХАЁТ, ДНБ-д эзлэх экспортын хувь болон санхүүгийн гүнзгийрэл;
Хүснэгт 24	Дамжин өнгөрөх тээвэрлэлт, мянган тонн, 2003-2008;
Хүснэгт 25	Засгийн газрын өрийн тогтвортой байдлын үзүүлэлтүүд, хувиар;
Хүснэгт 26	МХЗ 9-ийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээний шалгуур үзүүлэлтүүд;
Хүснэгт 27	Олон улсын гэрээ, конвенци;
Хүснэгт 28	Хэвлэл, мэдээллийн хэрэгслийн хараат бус байдлын талаархи иргэдийн төсөөлөл, хэвлэл, мэдээллийн байгууллагуудад итгэл хүлээлгэж байгаа хүн ам, улсын дунджаар, хувиар;
Хүснэгт 29	Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаархи иргэдийн төсөөлөл, улсын дунджаар;
Хүснэгт 30	Төрийн байгууллагуудад итгэл хүлээлгэж байгаа хүн амын эзлэх хувь;
Хүснэгт 31	Аймаг, сумын түвшнээр тооцсон үзүүлэлтүүдийг үндэсний түвшний дүнтэй зэрэгцүүлснээр, 2000;

Дүрслэл

- Дүрслэл 1 Эдийн засгийн өсөлт, нэг хүнд ногдох ДНБ, мянган төгрөг
- Дүрслэл 2 Төсвийн орлого, зарлага, тэнцэл
- Дүрслэл 3 Мөнгөний нийлүүлэлт, инфляци
- Дүрслэл 4 Гадаад худалдаа, сая ам.доллар
- Дүрслэл 5 Гадаадын шууд хөрөнгө оруулалт, улс орноор, салбараар, 2008
- Дүрслэл 6 Гадаад валютын цэвэр албан нөөц (сая ам.дол), импортын долоо хоног
- Дүрслэл 7 Монгол дахь ядуурлын түвшин, хувь
- Дүрслэл 8 Ажиллах хүчний оролцооны түвшин
- Дүрслэл 9 15-24 насны залуучуудын ажилгүйдлийн түвшин, 1998-2008, 2015
- Дүрслэл 10 Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин
- Дүрслэл 11 Нялхсын эндэгдлийн түвшин
- Дүрслэл 12 Эхийн эндэгдлийн түвшин
- Дүрслэл 13 Сүрьеэгийн өвчлөлийн түвшин
- Дүрслэл 14 Агаар бохирдуулагч бодис хүхэрлэг хий, азотын давхар ислийн агууламж, 2004-2008
- Дүрслэл 15 Тусгай хамгаалалттай нутгийн байршил болон урсацын 70 хувь бүрэлдэх газрууд
- Дүрслэл 16 Гадаад зээлийн ашиглалт, салбараар, 2006-2008
- Дүрслэл 17 Засгийн газрын дотоод зээл, 1996-2008
- Дүрслэл 18 Суурин, үүрэн телефон, интернэт хэрэглэгчдийн тоо, мянган ширхэгээр
- Дүрслэл 19 Шилэн кабелийн сүлжээнд холбогдсон сумд, 2008
- Дүрслэл 20 Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлтийн хувь, 2004-2008
- Дүрслэл 21 Авлигын хүрээ, байгууллага, салбараар, 2008
- Дүрслэл 22 Авлигад нөлөөлөх хүчин зүйлс, 2008



Шинэ мянганд ядуурлыг бууруулах талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагаас дэвшүүлсэн зорилтуудыг дэмжиж, дэлхийн улс орнууд өөрийн улс орны Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн явц байдлын талаар үнэлэлт, дүгнэлт өгсөн тайлан, илтгэлээ НҮБ-ын Ерөнхий Ассемблейд танилцуулдаг уламжлалын дагуу Монгол Улс нь Үндэсний гурав дахь илтгэлээ боловсруулж бэлэн болгоод байна.

Монгол Улс нь хөгжлийн алсын хараагаа тодорхойлж, МХЗ-уудад суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогоо боловсруулан хэрэгжүүлж эхлээд даруй нэг жил болоод байна. Монгол Улс нь урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалтай болсон түүхэн энэ үед Үндэсний гурав дахь илтгэл бэлтгэн гаргаж байгаа нь их ач холбогдолтой юм.

Монгол Улсын Үндэсний гурав дахь илтгэлийг МХЗ-уудын хэрэгжилтийн өнөөгийн төлөв байдалд дүн шинжилгээ хийж, албан ёсны статистик тоо, мэдээлэл, баримтуудыг өргөнөөр ашиглан бэлтгэж боловсруулсан байна. Энэхүү илтгэлд МХЗ-уудын хэрэгжилтэд үнэлгээ, дүгнэлтүүдийг хийж, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлж, эдгээр зорилтуудад хүрэхэд авч хэрэгжүүлэх ойрын болон дунд хугацааны бодлого, стратегийг тодорхойлсон юм.

Цаашид Монгол Улс МХЗ-уудаа ханган биелүүлэхийн тулд тэдгээрийн хэрэгжилтийг хөрөнгийн эх үүсвэртэй нягт уялдуулах, МХЗ-уудын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бэхжүүлэх, МХЗ-уудыг орон нутагт хэрэгжүүлэх ажлын үр нөлөөг нэмэгдүүлэх, олон нийтэд таниулах мэдээлэл, сурталчилгааны ажлыг өргөжүүлэх зэрэг асуудалд төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгэм, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Монгол Улс 2015 он гэхэд Мянганы хөгжлийн зорилтуудаа хангахын тулд иргэн, өрх гэр, хот, суурин газар бүрийг тулгамдсан асуудлаа шийддэг, энэ шийдэлдээ бүтээлч оролцогч нь байж чаддаг тийм боломжийг нэмэгдүүлж, улс орноо бүхэлд нь хөгжил дэвшилд хүргэнэ. Монгол Улсын төр, засгаас монгол хүн бүрийн ажилгүйг нь ажилтай болгож, ажилтайг нь бүтээмжээ улам нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Монгол Улсын эдийн засгийн өсөлт, ард түмний амьжиргааг дээшлүүлэхэд чухал үүрэгтэй томоохон төсөл, бүтээн байгуулалтуудыг хийх болно. Ялангуяа, Монгол орны уул уурхай, дэд бүтцийн хөгжлийн үр шимийг нийт ард иргэддээ шударгаар хүртээж, ард түмнийхээ эрх ашгийг дээдлэн, харилцан ашигтай байх зарчмыг баримтлан идэвх санаачилгатай ажиллана.

Өнөөдөр дэлхийн нийтийн тулгамдсан асуудлууд болоод байгаа байгаль орчны доройтол, нийтийг хамарсан халдварт өвчин, гай гамшиг, алан хядах үйл ажиллагаа, цөмийн зэвсгийн аюул, тив дамжсан гэмт хэрэг, мөнгө угаалт, хүний эрхийн зөрчил, хямрал, дэлхийн дулаарал нь дэлхийн улс орнууд зөвхөн өөр өөрийн ашиг сонирхлоор биш, нийтийн эрх ашгийн үүднээс хамтарч ажиллах шаардлагыг бий болгож байна. Монгол улс ч дэлхийн хамтын нийгэмлэгийн идэвхтэй гишүүн байж, бүс нутгийн болон нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлаар идэвхтэй байр суурь баримтлан ажиллах болно.

Үндэсний гурав дахь илтгэлийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлсэн НҮБХХ-ийн Суурин төлөөлөгчийн газрын удирдлагад чин

сэтгэлийн талархал илэрхийлж, манай улстай үр ашигтай хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэн хөгжүүлэхийг хүсэн ерөөе.

Энэ ялдамд, Монгол орны хөгжил дэвшилд гүн туслалцаа үзүүлсээр ирсэн олон улсын байгууллагууд, хандивлагч улс орнуудад чин сэтгэлийн талархал илэрхийлье. Монгол улс уламжлалт гадаад бодлогоо шинэ утга

агуулгаар баяжуулж, тууштай үргэлжлүүлэх болно.

Мөн энэхүү илтгэлийг бэлтгэхэд идэвхтэй оролцсон төрийн болон төрийн бус байгууллагуудад талархал илэрхийлэхийн ялдамд, улс орныхоо хөгжлийн төлөө улам ихийг бүтээхийг хүсэн ерөөе.



Цахиагийн Элбэгдорж
Монгол Улсын Ерөнхийлөгч



МХЗ-уудын хэрэгжилтийн Үндэсний гурав дахь илтгэлийг боловсруулсанд Монгол Улсын Засгийн газарт баяр хүргэе. МХЗ-ууд нь дэлхийн улс орнууд хөгжлийн наад захын стандартыг хангавал зохих олон улсын нэгдмэл үзэл санаа мөн бөгөөд улс бүр МХЗ-уудыг хангах өөрийн арга хэлбэрийг сонгох нь зүйтэй. Уг илтгэлд 2007 онд хэвлэгдсэн МХЗ-уудын хэрэгжилтийн Үндэсний хоёр дахь илтгэлд тусгагдсан асуудлуудын талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ, МХЗ-уудын биелэлтийн талаар дүн шинжилгээг гүйцэтгэсэн.

Монгол Улсад МХЗ-уудыг хэрэгжүүлэхтэй холбоотой бүх төлөвлөлтийг зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо байгуулагдсан нь хамгийн чухал ололт байлаа. Түүнчлэн орон даяар хэрэгжүүлэх МХЗ-уудын мэдээлэл, сурталчилгааны стратегийг батлуулсан нь бас нэг чухал алхам болсон юм. Зарим аймаг, сумд, нийслэлийн зарим дүүргүүд орон нутгийн МХЗ-ууд, түүнд хүрэх арга хэмжээ, тэргүүлэх чиглэлийг тодорхойлоод байна.

Өмнөх илтгэлийн тайлантай харьцуулж үзэхэд энэ илтгэлийг бэлтгэхэд МХЗ-уудын хангалттай статистик тоон мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээг тодорхой хэмжээнд гүйцэтгэсэн, оролцогч талуудын идэвхтэй

үүрэг оролцоо хангагдсан, дэлхийн эдийн засгийн үүднээс нарийвчилсан дүн шинжилгээг гүйцэтгэсэн зэрэг ач холбогдол бүхий байлаа. Эдгээр үйл явцын зэрэгцээ, Монгол улс зорилтот бүлгүүдэд чиглэсэн, оновчтой арга хэмжээнүүдийг тулгамдаад байгаа зорилтууд болох ядуурлыг бууруулах, байгаль орчны тогтвортой байдлыг хангах, шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдлыг хангах зэрэг асуудлуудад нийцүүлэн тодорхойлох шаардлагатай байна.

Монгол Улс амжилтанд хүрэхийн тулд цаашид илүү их мэрийж ажиллах хэрэгтэй юм. Монгол Улсын Засгийн газар, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд бүгдээрээ ядуурал, тэгш бус байдалгүй нийгмийг бүрдүүлэх нэгдмэл үзэл санааг бүрдүүлэх шаардлагатай байна. Үүний тулд төр, хувийн хэвшлийн тогтвортой түншлэлийг бий болгох нь чухал бөгөөд хүний хөгжилд амжилт олох, эдийн засгийн өсөлтийг хангахад дэмжлэг болохуйц шаардлагатай эх үүсвэрийг бүрдүүлэх нь чухал юм. Монгол Улс дахь НҮБ энэхүү үзэл санааг хэрэгжүүлэхэд цаашид дэмжлэг үзүүлсээр байх болно.

Дебора Комини
НҮБ-ын суурин зохицуулагч,
НҮБХХ-ийн суурин төлөөлөгч

Талархал



Хүн төрөлхтний амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэгдсэн Мянганы хөгжлийн зорилтуудыг улс орон бүр өөрийн онцлогт нийцүүлэн хэрэгжүүлэх талаар ихээхэн хүчин чармайлт гаргаж байна.

Монгол Улс дэлхийн хэмжээнд дэвшүүлсэн Мянганы хөгжлийн зорилтуудыг Үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх ажилд тодорхой хувь нэмэр оруулах, өөрийн орны онцлогийг тусгасан зорилтыг дэвшүүлэн тавьж шийдвэрлэх зарчим баримтлан ажиллаж байгаа билээ. Үүний нэг тод илрэл нь Монгол Улс Мянганы хөгжлийн зорилтуудыг өргөжүүлэн баяжуулж УИХ-ын 2008 оны 13 дугаар тогтоолоор 9 зорилго, 24 зорилт, 67 шалгуур үзүүлэлттэйгээр батлан хэрэгжүүлж байна. Эдгээр шалгуур үзүүлэлтүүд нь Мянганы Тунхаглалаар тодорхойлогдсон зорилго, зорилтууд, шалгуур үзүүлэлтүүдтэй агуулгын хувьд ижил бөгөөд тэдгээрт өөрийн орны онцлогийг тусгасан ялгаатай зүйлс бий. Манай улс МХЗ-уудын хэрэгжилтийг хангахад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх бололцоог бүрдүүлэн ажиллаж байгаа нь ихээхэн үр дүнтэй болж байна. Тухайлбал, манай улсын Мянганы хөгжлийн 9 дэх зорилго нь дэлхийн олон улс оронд томъёологдоогүй бөгөөд ардчилсан засаглалыг хөгжүүлэх талаар өөрийн гэсэн зорилго оруулснаараа онцлогтой болж байгааг тэмдэглүүштэй.

Түүнчлэн Монгол Улс урт хугацааны хөгжлийн бодлого болох “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ыг УИХ-аар батлан хэрэгжүүлж эхэлсэн нь МХЗ-уудын хэрэгжилт, бодлогын уялдааг хангахад дорвитой алхам болсон юм. “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” нь МХЗ-уудын хэрэгжилтийг хянахаар боловсруулсан үзүүлэлтүүдийн тоон мэдээллийн эх сурвалжийг улам боловсронгуй болгоход ч ихээхэн ач холбогдолтой болов.

Монгол Улсын Засгийн газар, НҮБХХ-өөс хамтран “Ядуурал, МХЗ-уудын хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог дэмжих” туршилтын төслийн хүрээнд МХЗ-уудын хэрэгжилтийг хянах, үнэлэх, шалгуур үзүүлэлтүүдийн ойлголт, тодорхойлолтыг жигдрүүлэх, улмаар үзүүлэлтүүдийг тооцох арга, аргачлалыг олон улсын нэгдмэл стандартад нийцүүлэн боловсруулж, МХЗ-уудын хэрэгжилтийн мэдээллийн санг 1990-2008 оноор Devinfo 5.0 програмын орчинд төвлөрүүлэн байгуулсан нь МХЗ-уудын хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг боловсронгуй болгоход их дөхөм боллоо.

Үндэсний гурав дахь илтгэлийг бэлтгэх ажлыг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо удирдан зохион байгуулсан бөгөөд илтгэлийг боловсруулахад мэргэжлийн түвшинд зөвлөгөө өгч, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн газрын “Ядуурал, МХЗ-уудын хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог дэмжих төсөл”-өөр дамжуулан дэмжлэг туслалцаа үзүүлэн хамтран ажилласан НҮБ-ын Монгол дахь суурин зохицуулагч хатагтай Дебора Комини, салбар дундын удирдлагын зөвлөл, ажлын хэсгийн гишүүд, байгууллагууд болон илтгэлийг боловсруулах ажилд үнэтэй санал, зөвлөмж, дүгнэлт өгч ажилласан бүх хүмүүст талархал илэрхийлье.

Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай.

A handwritten signature in black ink, appearing to be the name 'Ch. Hashchuluun'.

Ч.Хашчулуун
Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга

ЕРӨНХИЙ ТОЙМ

Ерөнхий тойм

Монгол Улсын Их Хурал (УИХ)-ын 2005 оны 25 дугаар тогтоол, 2008 оны 13 дугаар тогтоолын дагуу Мянганы хөгжлийн зорилт (МХЗ)-уудын 2007-2008 оны хэрэгжилтийн талаархи Үндэсний гурав дахь илтгэл нь өнөөгийн нийгэм, эдийн засгийн явц байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар бодлого, зөвлөмжийг агуулсан баримт бичиг юм.

Үндэсний гурав дахь илтгэлийг бэлтгэхдээ өмнөх илтгэлд тусгагдсан бодлогын зөвлөмж, санал, дүгнэлтийн хэрэгжилтийг хангах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ бүрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхийг эрмэлзсэн болно. Илтгэлийг Засгийн газрын түвшинд боловсруулж, төрийн бус байгууллага (ТББ), иргэний нийгмийн төлөөлөл, эрдэмтэд, судлаачдаар хэлэлцүүлж тэдний байр суурийг тусгасан болно.

Энэхүү Үндэсний гурав дахь илтгэлд Монгол Улсын МХЗ-уудын хэрэгжилтийг УИХ-ын 2008 оны 13 дугаар тогтоолоор баталсан 67 шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэн дүгнэж, түүнчлэн сонгож авсан 12 шалгуур үзүүлэлтийг 2000 оны Хүн ам, орон сууцны тооллого болон 2002-2003 оны Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний түүвэр (ӨОЗАТТ) судалгаанд үндэслэн Ядуурлын зураглалын аргачлалын дагуу аймаг, сумын түвшинд гаргаснаараа онцлог болсон.

Монгол Улс нь МХЗ-уудыг бүрэн хангахаар зорьсон хугацааныхаа шийдвэрлэх үед орсон бөгөөд үндэсний есөн (9) зорилгын хэрэгжилтийн явцыг танилцуулан, үнэлэлт өгч, амжилт, сорилт, анхаарал хандуулах асуудал болон зөвлөмжийг энэхүү илтгэлээр танилцуулж байна.

Үндэсний гурав дахь илтгэл нь 5 бүлгээс бүрдэж байна. Эхний бүлэгт Мянганы хөгжлийн үндэсний зорилго, зорилт тус бүрийн хэрэгжилтийн төлөв байдал, хандлагыг 2007-2008 оны статистик тоо, мэдээлэл болон бүсийн түвшнээр тодорхойлон гаргаж, 2015 оны зорилтуудыг хангахад чиглэсэн Засгийн газрын бодлого, хөтөлбөр, төслүүдийн талаар танилцуулж, тулгарч байгаа сорилт, цаашид шийдвэрлэх асуудлыг багцлан авч үзлээ.

Хоёрдугаар бүлэгт МХЗ-ууд болон хөгжлийн урт болон дунд хугацааны бодлого төлөвлөлт, санхүүжилтийн уялдаа холбоо, гуравдугаар бүлэгт МХЗ-уудын орон нутгийн түвшний хэрэгжилтийн байдал, сурталчилгаа, олон нийтийн оролцоо, дөрөвдүгээр бүлэгт Монгол Улсын ядуурлын зураглал, тавдугаар бүлэгт МХЗ-уудын хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудлыг тусгасан.

Илтгэлийг Монгол Улсын МХЗ-уудын хэрэгжилтийн явцын 2004 болон 2007 оны Үндэсний тайланд¹ түлхүү үндэслэсэн бөгөөд Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо (ҮХШХ)-ноос зохион байгуулж, Монгол дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ)-ийн газрын санхүүгийн дэмжлэгтэйгээр бэлтгэлээ. ҮХШХ нь Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-той хамтран мэдээллийн эх сурвалжийг Devinfo-5-ыг ашиглан бүх тоо, мэдээллийг шинэчилж гаргалаа.

Ололт, ахиц, дэвшил

Өмнөх 2007 оны хоёр дахь илтгэлд дурдсан Монгол Улсын Мянганы хөгжлийн зарим зорилго, зорилт нь хоорондоо уялдаагүй, заримыг нь хэмжих шалгуур үзүүлэлт байхгүй, бодит байдалд нийцэхгүй шалгуур үзүүлэлтийг сонгосон зэрэг дутагдал байсныг арилгалаа. Иймд УИХ-ын 2005 оны 25 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулж, УИХ-ын 2008 оны 13 дугаар тогтоолоор Монгол Улсын МХЗ-уудын шалгуур үзүүлэлт 24 байсныг 67 болгож шинэчлэн баталлаа.

Ингэснээр бодлогын хэрэгжилтэнд үнэлгээ хийхэд дөхөмтэй болсон төдийгүй, дараагийн шатны арга хэмжээний нэг болох орон нутгийн түвшинд МХЗ-уудыг тодорхойлоход суурь болж өгснөөрөө ихээхэн ач холбогдолтой ажил боллоо.

¹ Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн явц байдлын тухай Үндэсний илтгэл, Улаанбаатар: Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Гадаад хэргийн яам, НҮБ-ын улс орны баг, 2004; Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт, Үндэсний 2 дахь илтгэл, Улаанбаатар: Сангийн яам, 2007.

МХЗ-уудыг орон нутагт хэрэгжүүлэх ажлын хүрээнд Говь-Алтай, Дорнод, Дундговь, Хөвсгөл аймаг, нийслэлийн Сонгинохайрхан, Налайх дүүргүүд орон нутгийнхаа хэмжээнд МХЗ-уудыг тодорхойлж, анхны илтгэлээ гарган энэ дагуу хөрөнгийн хэрэгцээний үнэлгээний ажлыг хийж эхлээд байна.

Түүнчлэн МХЗ-уудыг орон нутгийн хэмжээнд тодорхойлох ажлын цар хүрээ өргөжиж улмаар Баян-Өлгий, Увс, Ховд аймгууд болон Улаанбаатар хот туршилтын төслийн хүрээнд шинээр хамрагдаж, МХЗ-уудаа тодорхойлон анхны илтгэлээ гарган ажиллаж байна. Ийнхүү орон нутгийн хэмжээнд МХЗ-уудыг тодорхойлох болсноор урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийг боловсруулахад үр дүнтэй ажил боллоо.

МХЗ-уудыг урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлж ирлээ. Тухайлбал, МХЗ-уудад суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого (ҮХЦБ)-ыг УИХ-аар батлуулж, Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, Жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, Жилийн төсөв, Салбаруудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө зэргийг дурьдаж болно. Мөн МХЗ-уудын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар бодлогын болоод зохион байгуулалтын дараахь арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд:

- МХЗ-уудыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэрэгцээний үнэлгээг дахин шинэчлэх ажлыг хийж эхлээд байна.
- МХЗ-уудыг олон нийтэд таниулан ойлгуулах “МХЗ-уудын мэдээлэл, сурталчилгааны стратеги”-ийг боловсруулж батлуулав.
- МХЗ-уудын хяналт-шинжилгээ хийх ерөнхий бүтцийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлэв.

Хүндрэл, саад, бэрхшээл

Дэлхий нийтийг хамарсан санхүү, эдийн засгийн хямрал нь Монгол Улсын эдийн засгийн хөгжилд нөлөөлж, 2008 онд эдийн засгийн өсөлт өмнөх оноос 1.3 нэгжээр буурч 8.9 хувь боллоо. Ялангуяа, санхүү, эдийн засгийн хямрал 2008 оны дунд үеэс эхлэн

МХЗ-уудын хэрэгжилтэд сөргөөр нөлөөллөө. Ялангуяа хүнсний зарим бүтээгдэхүүн, газрын тосны үнэ 2007-2008 онд ихээхэн нэмэгдсэн нь орлого багатай иргэдэд хүндээр тусч ядуурлын түвшинг нэмэгдүүлэхэд нөлөөлөв. Инфляцийн түвшин 2007 онд 15.1 хувь, 2008 онд 22.1 хувь болж өссөн байна. Ингэснээр ядуурлын хэмжээ бодитой буураагүй, ажилгүйдэл өсөх хандлагатай болж, эдийн засгийн тэнцвэрт байдалд таагүй нөлөө үзүүлэх болов.

Мөн зарим зорилтын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар ихээхэн хүчин чармайлт гаргаж, ажиллах шаардлагатай болж байна. Тухайлбал, амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой буюу орлого нь хүнсний наад захын хэрэгцээг хангаж чадахгүй байгаа иргэдийн эзлэх хувь 2008 онд 35.2 хувь болж суурь түвшнээс 1.1 нэгжээр буурсан байгаа нь 2015 онд ядуурлын түвшинг 18 хувьд хүргэх зорилтыг хангахад ихээхэн хүндрэлтэй байгааг харуулж байна.


Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн тойм

Эдийн засгийн өсөлт, дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ). Эдийн засгийн бодит өсөлт 2008 оны урьдчилсан гүйцэтгэлээр 8.9 хувь болж 2007 оныхоос 1.3 нэгжээр саарсан хэдий ч, 2006 оныхоос 0.2 нэгжээр өссөн байна. Эдийн засгийн өсөлт саарахад барилгын салбарын 8.7 хувийн бууралт болон дэлхийн нийтийг хамраад байгаа санхүү, эдийн засгийн хямралын эхний үе шатын хүндрэл, бэрхшээл голлон нөлөөлсөн байна.

Хэдийгээр ДНБ-ийн бодит өсөлт 2008 онд өмнөх оноос саарсан боловч зах зээл дахь бараа, түүхий эдийн дэлхийн үнийн өсөлтөөс шалтгаалан (2008 оны эцсийн байдлыг эс тооцвол) ДНБ-ий хэмжээ 2008 оны урьдчилсан гүйцэтгэлээр оны үнээр 6,130.3 тэрбум төгрөг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 3,620.5 тэрбум төгрөг болж, 2007 оныхтой харьцуулахад 8.9 хувь буюу 294.6 тэрбум төгрөгөөр өслөө.

Оны үнээр тооцсон нэг хүнд ногдох ДНБ 2008 онд 2,305.2 мянган төгрөг болж 2007 оныхоос 31.1 хувь буюу 546.3 мянган төгрөг, 2006 оныхоос 60.0 хувь буюу 864.6 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.


Дүрслэл 1. Эдийн засгийн өсөлт, нэг хүнд ногдох ДНБ, мянган төгрөг



Улсын нэгдсэн төсөв. Улсын нэгдсэн төсвийн орлого, тусламжийн дүн 2008 оны эцэст 2,170.4 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 35.4 хувьд хүрлээ. 2007 оныхоос 289.9 тэрбум төгрөг буюу 15.4 хувиар, 2006 оныхоос 810.0 тэрбум төгрөг буюу 99.4 хувиар, 2000 оныхоос 1,805.4 тэрбум төгрөг буюу 6.1 дахин тус тус нэмэгдсэн байна.

Харин улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2008 оны эцэст 2,466.8 тэрбум төгрөгт хүрсэн нь ДНБ-ийн 40.2 хувьтай тэнцэж байна. 2007 оныхоос 719.5 тэрбум төгрөг буюу 41.2 хувиар, 2006 оныхоос 1229.8 тэрбум төгрөг буюу 99.4 хувиар, 2000 оныхоос 2,037.1 тэрбум төгрөг буюу 5.7 дахин тус тус өссөн байна.

Дүрслэл 2. Төсвийн орлого, зарлага, тэнцэл




Дэлхийн зах зээлд манай улсын экспортын гол түүхий эд болох алт, зэс зэрэг эрдэсийн гаралтай түүхий эдийн үнэ 2007-2008 оны 4-р улирал хүртэл өссөн нь төсвийн орлого нэмэгдэхэд голлон нөлөөлсөн байна. Өмнөх 2 жилд төсвийн тэнцэл ашигтай гарч байсан хэдий ч 2008 оны 3-р улирлаас дэлхийн зах

зээл дээр түүхий эдийн үнэ огцом унаж эхэлсэн нь 2008 онд төсвийн тэнцэл алдагдалтай гарахад нөлөөлсөн байна.

Мөнгөний нийлүүлэлт. Монголбанкны статистик мэдээгээр 2008 онд мөнгөний нийлүүлэлт 2,318.9 тэрбум төгрөгт хүрч 2007 оныхоос 82.4 тэрбум төгрөг буюу 3.4 хувиар буурлаа. Харин 2006 оныхоос 782.4 тэрбум төгрөг буюу 50.9 хувиар, 2000 оныхоос 8.0 дахин тус тус өссөн байна. Сүүлийн жилүүдэд банкны салбар эрчимтэй хөгжиж, арилжааны банкны санхүүгийн зах зээлд гүйцэтгэх үүрэг нэмэгдэж, олгосон зээлийн хэмжээ өссөнөөр манай эдийн засагт халалтын шинж тэмдэг илэрч эхэлсэн юм.

Дүрслэл 3. Мөнгөний нийлүүлэлт, инфляци




Үнэ, ханшны өөрчлөлт. 2008 онд гадаад зах зээл дээр улаан буудай, хүнсний зарим нэрийн бүтээгдэхүүний үнэ, газрын тосны үнэ өссөн зэргээс шалтгаалж хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тариф нэмэгдэж жилийн дундаж инфляцийн түвшин 28.0 хувь боллоо. Гэвч 2008 оны 4-р улиралд бараа, үйлчилгээний үнэ бага зэрэг буурч улмаар үнийн ерөнхий түвшин оны эцэст 22.1 хувь болов. 2007 оныхтой харьцуулахад 2008 онд инфляци 4.3 нэгжээр, 2006 оныхоос 15.9 нэгжээр тус тус өслөө.

Гадаад валюттай харьцах төгрөгийн ханш. 2000-2008 онуудын ам.доллартай харьцах төгрөгийн дундаж ханш 1,090-1,150 төгрөгтэй тэнцэж ханш тогтвортой байлаа. 2008 онд төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн өөрчлөлт бага байсан хэдий ч оны сүүлчээр гадаад валютын нөөц 2007 онтой харьцуулахад 360 гаруй тэрбум төгрөгөөр буурсан, иргэд, байгууллагын ам.доллар, бусад орны валютын эрэлт өссөн, төгрөгийн хадгаламж багассан зэргээс шалтгаалан ам.долларын төгрөгтэй

харьцах ханш огцом нэмэгдэж жилийн эцэст 1268 төгрөгт хүрсэн байна.

Гадаад худалдаа. Монгол Улс 2008 онд дэлхийн 110 гаруй оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ 5,779.0 сая ам.долларт хүрч, 2007 оныхоос 1,769.7 сая ам.доллар буюу 44.1 хувиар өсч, гадаад худалдааны тэнцэл 710.0 сая ам.долларын алдагдалтай гарлаа. 2008 онд гадаад худалдааны тэнцэл ийнхүү алдагдалтай гарсан нь импортын хурдацтай өсөлт, экспортын гол нэр төрлийн барааны үнийн огцом бууралттай холбоотой байлаа.

Дүрслэл 4. Гадаад худалдаа, сая ам.доллар





Экспорт. Экспортын хэмжээ 2008 онд 2,534.5 сая ам.долларт хүрч 2007 оныхоос 587.0 сая ам.доллар буюу 30.1 хувиар, 2006 оныхоос 992.5 сая ам доллар буюу 64.4 хувиар, 2000 оныхоос 1,998.7 сая ам доллар буюу 4.7 дахин тус тус өссөн байна. Нийт экспортын барааны 60.3 хувийг эрдэс бүтээгдэхүүний экспорт бүрдүүлж, 33.0 хувийг зэсийн баяжмалын экспорт эзэлж байна.

Импорт. 2008 онд импортын хэмжээ 3,244.5 сая ам.доллар болсон нь 2007 оныхоос 1,182.7 сая ам.доллараар буюу 57.4 хувиар, 2006 оныхоос 1,809.6 сая ам.доллар буюу 2.3 дахин, 2000 оныхоос 2,630.1 сая ам.доллар буюу 5.3 дахин тус тус өссөн байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО). ГШХО-ын хэмжээ 2008 онд цэвэр дүнгээрээ 1.9 дахин нэмэгдэж 682.5 сая ам.долларт хүрчээ.

ГШХО-ын 48 хувийг уул уурхайн салбарт, 13 хувийг барилгын салбарт оруулсан байна. Харин улс орноор нь авч үзвэл нийт ГШХО-ын 26 хувийг БНХАУ-аас оруулжээ.

Дүрслэл 5. Гадаадын шууд хөрөнгө оруулалт, улс орноор, салбараар, 2008



Гадаад валютын цэвэр албан нөөц. Монгол Улсын гадаад валютын цэвэр албан нөөцийн хэмжээ 2007 онд 972.4 сая ам.долларт хүрч импортын 23.9 долоо хоногийн хэрэгцээг хангахуйц хэмжээтэй байсан бол 2008 онд 637.2 сая ам.доллар болж буурчээ.

Энэ нь манай улсын импортын 10.2 долоо хоногийн хэрэгцээг хангахуйц хэмжээнд байна. Гадаад валютын цэвэр албан нөөц буурахад гадаад худалдааны алдагдал нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Дүрслэл 6. Гадаад валютын цэвэр албан нөөц (сая ам.дол), импортын долоо хоног



Нийгмийн байдал

Хүн ам. Засгийн газраас гэр бүлийн хөгжлийг дэмжих, хүүхэд, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнд төрөлт нэмэгдэж, 1990 оноос хойш хүн амын өсөлт 2008 онд хамгийн өндөр түвшинд хүрлээ. Нийт хүн ам 2008 онд 2,683.5 мянгад хүрч, өмнөх оныхоос 1.8 хувиар өссөн бөгөөд 2015 онд дунджаар 3,044.9 мянгад хүрэхээр байна.

Ажил эрхлэлт. Засгийн газраас 2008 онд шинээр 80 мянган ажлын байр бий болгох зорилт тавин ажилласны үр дүнд 2008 онд нийт 73.9 мянган ажлын байр шинээр нэмэгдсэн байна. Уг ажлын байрны 11.9 хувь нь хөдөө аж ахуй (ХАА), ан агнуур, ойн аж ахуйн салбарт, 6.9 хувь нь уул уурхай, олборлох үйлдвэрлэл, 13.6 хувь нь боловсруулах аж үйлдвэр, 1.2 хувь нь цахилгаан дулаан үйлдвэрлэл, ус хангамж, 16.0 хувь нь барилга, 21.7 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, 5.3 хувь нь зочид буудал, зоогийн газарт, 3.5 хувь нь тээвэр холбоо, агуулахын аж ахуй, 2.2 хувь нь төрийн удирдлага, батлан хамгаалах, 4 хувь нь боловсрол, 2.2 хувь нь эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, 11.5 хувь нь нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээний салбарт бий болсон байна. Шинээр нэмэгдсэн нийт ажлын байрны 49.7 хувь буюу 36.8 мянган ажлын байрыг хөдөө, орон нутагт бий болгож, нийт ажиллагсадын 47.5 хувийг эмэгтэйчүүд, 52.5 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна.

Нийгмийн халамж. 2008 онд Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй, асарч халамжлах хүнгүй, амьдралын хүнд нөхцөлд амьдарч байгаа ахмад настнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, олон хүүхэдтэй

өрх толгойлсон эцэг, эх зэрэг нийгмийн эмзэг бүлгийн нийт 51.3 мянган иргэнд 23.1 тэрбум төгрөгийн халамжийн тэтгэвэр олгов.

Нийгмийн халамжийн тухай хуулиар олгож байгаа нөхцөлт мөнгөн тэтгэмжийн хэмжээ амьжиргааны доод түвшин, инфляци, тэтгэвэр, тэтгэмжийн өөрчлөлттэй уялдаж жил бүр нэмэгдэн, 2008 онд 24.0 мянган төгрөгт хүрсэн байна.

2008 онд Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламжинд 19.7 мянган иргэн хамрагдаж, 2.6 тэрбум төгрөг зарцуулсан байна. Хүн амын хөгжлийг дэмжих чиглэлээр 87.8 тэрбум төгрөг 1.3 сая иргэнд олгожээ. Тухайлбал, 952.5 мянган хүүхдэд 32.8 тэрбум төгрөг, шинээр төрсөн 63.4 мянган хүүхдэд 6.3 тэрбум төгрөг, шинээр гэр бүл болсон 34.6 мянган өрхөд 17.3 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

Боловсрол. 2008 онд бүх шатны боловсролын чанар хүртээмжийг дээшлүүлж, ерөнхий боловсролын сургалтыг 12 жилийн тогтолцоонд шилжүүлж, 6 настай хүүхдийг 1 дүгээр ангид элсүүлэн сургах болсон. Бага насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн орчинг бүрдүүлж, сургуулийн өмнөх боловсролын сургалтын талаар баримтлах бодлогыг батлан хэрэгжүүлж байна. Ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-ийн 1-5 дугаар ангийн хүүхдүүдэд “Үдийн цай” олгох хөтөлбөрийг 2006 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2007-2008 оны хичээлийн жилд 239.8 мянган хүүхдэд 16.5 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн уул уурхай болон орчин үеийн аж үйлдвэрлэлийн чиглэлээр мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд анхаарч их, дээд сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (МСҮТ)-д элсэгчдийн тоог тогтоож, сургалтын агуулгад өөрчлөлт оруулав. МСҮТ-д суралцагчдад сар бүр 45.0 мянган төгрөгийн тэтгэлэг урамшууллын хэлбэрээр олгодог болсноор элсэн суралцагчдын тоо эрс нэмэгдэв. Монгол улсын 2006-2015 онд хөгжүүлэх боловсролын ерөнхий төлөвлөгөөнд инженер, технологийн чиглэлээр суралцагчдад эдийн засгийн урамшуулал, хөнгөлөлт үзүүлэх, тэднийг ажлын байраар хангах замаар элсэгчдийн тоог нэмэгдүүлэх, энэ чиглэлээр

суралцах дөрвөн оюутан тутмын гуравт нь, бусад мэргэжлийн чиглэлээр суралцах оюутны нэгд нь Сургалтын Төрийн Сан (СТС)-аас сургалтын төлбөрийн зээл олгох бодлого баримталж байна. Ингэснээр 2007-2008 оны хичээлийн жилд инженер, технологийн чиглэлээр элсэгчид 23.3 мянга болж, өмнөх оноос 0.7 нэгжээр нэмэгдсэн.

Шинжлэх ухааны салбарын лаборатори, туршилтын баазыг сайжруулах зорилгоор тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтыг өмнөх оныхоос ихээхэн нэмэгдүүлсэн нь эрдэм шинжилгээ, сургалтын байгууллагын дундын ашиглалттай төрөлжсөн лабораториуд байгуулах боломж олголоо. Технологийн дэд бүтцийг бүрдүүлэх зорилгоор Шинжлэх ухааны академи (ШУА)-д инкубаторын төв, Хөдөө аж ахуйн их сургууль (ХААИС)-д хөдөө аж ахуйн технопарк, экстейншн төв, биотехнологийн инкубатор, Шинжлэх ухаан, технологийн их сургууль (ШУТИС)-д хүнсний технологийн инкубаторийг байгуулах ажлыг эхлүүлээ.

Эрүүл мэнд. Эрүүл монгол хүн Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, анхан шатны үзлэгийг бүх аймгуудад хийж, улсын хэмжээнд 15-аас дээш насны хүн амын 83.6 хувь нь хамрагдаад байна. Хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнийг эрт илрүүлэн, эмчилж, хяналтад авах гол зорилт дэвшүүлэн ажилласнаас гадна иргэдийн эрүүл аж төрөх, эрсдэлт хүчин зүйлс, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндээ хамгаалах мэдлэгийг сайжруулах зорилгоор улсын хэмжээнд “Эрүүл монгол хүн цахим сан”-г бүрдүүллээ.

НҮБ-ын Хүн амын сантай хамтарсан Нөхөн үржихүйн эрүүл мэнд төслийн хүрээнд эх, нярайн тусламж үйлчилгээнд шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, эм хэрэгслийг аймаг, сумын эрүүл мэндийн байгууллагуудад олгоод байна.

Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн тогтолцоог хөгжүүлэх стратегид тусгагдсаны дагуу эмнэлэг дундын мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Төр, хувийн хэвшлийн түншлэл болон зохистой харьцааг хадгалахад шаардагдах мэдээллийг бий болгох, тусгай зөвшөөрөл, импортын зөвшөөрлийн үйл ажиллагааг түргэн шуурхай, ил тод болгох үүднээс вебд суурилсан мэдээллийн санг ашиглалтад орууллаа.

2007-2008 онд бүх сумдын хүн амд нотолгоонд суурилсан оношлогоо, эмчилгээ хийх зорилгоор сумдын эмнэлгийг цус, шээсний шинжилгээ болон зарим халдварт өвчнийг оношлох шинжилгээний оношлуур багаж хэрэгслээр хангасан байна.

МХЗ-уудын санхүүжилт

Засгийн газар 2006 онд МХЗ-уудыг хангахын тулд зайлшгүй авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээг тодорхойлж, түүнд шаардлагатай хөрөнгийн хэрэгцээг анх удаа тооцсон юм. Санхүүжилтийн стратегийг цаашид улсын хөрөнгө оруулалтын дунд хугацааны хөтөлбөртэй нягт уялдуулан боловсруулснаар МХЗ-уудыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн төсөвт тусгах, түүнчлэн олон улсын байгууллага, хандивлагчдаас үзүүлэх санхүүгийн дэмжлэг, тусламжтай уялдуулахад ихээхэн ач холбогдолтой юм.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн урт хугацааны зорилтуудыг тодорхойлсон МХЗ-уудад суурилсан ҮХЦБ, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (ЗГҮАХ), жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл зэрэг бодлогын үндсэн баримт бичгүүдэд МХЗ-уудыг хангах талаар зорилт, арга хэмжээг тусгаж ирлээ.

Гэвч МХЗ-уудын хэрэгцээний үнэлгээнд тусгагдсан бодлогын арга хэмжээнүүд нь хэт жижиг, нэгтгэгдээгүй, санхүүгийн эх үүсвэр, санхүүжилтийн зарчимтай тэр бүр зохицолдоогүй байсан нь хэрэгжилтийг тооцоход хүндрэлтэй, санхүүжилтийг хянах боломжгүй болгож байв. Иймд салбарын бодлогын баримт бичгүүдэд хэрэгцээний үнэлгээний тооцоо, тодорхойлсон интервенцүүдийг шинэчлэн дахин нягтлан уялдуулан тусгах нь чухал байна.

Ерөнхий дүгнэлт

МХЗ-уудын хэрэгжилтийн байдлыг улсын хэмжээнд 2007-2008 оны байдлаар авч үзвэл ерөнхийдөө хэрэгжилтийн явц өмнөх тайлангийн үеэс ахисан хэдий ч 2015 онд бүх зорилтыг ханган биелүүлэхэд төр, засгийн болон хувийн хэвшлийн үүрэг оролцоо ихээхэн чухал гэж үзэж байна. Орон нутгийн хэмжээнд МХЗ-уудын хэрэгжилт харилцан

адилгүй байгаа нь цаашид хэрэгжилтийг эрчимжүүлэхэд тухайн бүс нутгийн онцлог байгаль цаг уурын өөрчлөлтийг харгалзсан бодлого, төлөвлөлтийг шаардаж байна.

Өмнөх 2007 оны илтгэлд дурдсаны нэгэн адил хэрэгжилтийг эрчимжүүлэхэд бодлогын уялдааг сайжруулах, хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ байнга хийж байх албан ёсны нэгж чухал шаардлагатай байсныг харуулж байна.

Хэдийгээр УИХ-ын 25 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт орсон, УИХ-ын 2008 оны 13-р тогтоолоор зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтүүдийн хоорондын уялдаа сайжирсан боловч статистик мэдээллийн хувьд хараахан нэгдсэн нэг эх үүсвэртэй болж чадаагүй байна.

МХЗ-уудыг 2015 он гэхэд хангахын тулд одооноос анхаарах гол асуудлууд болон нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай дараахь арга хэмжээнүүд байна. Үүнд:

- Бүс нутаг хоорондын хөгжлийн ялгаатай байдалд анхаарлаа хандуулах -Улсын дунджаас дээгүүр ядуурлын түвшинтэй бүс, орон нутгуудад хөрөнгө, санхүүгийн дэмжлэг түлхүү үзүүлэх,
- ХАА-н салбарын бүтээмжийг нэмэгдүүлэх,

- Боловсрол болон эрүүл мэндийн салбарын шинэтгэлийн хэрэгжилтийг эрчимжүүлэх-үр ашигтай удирдлага, санхүүжилтийн оновчтой зохицуулалтаар дэмжин боловсролын салбарт шинэтгэл хийх. Ялангуяа, бага боловсролын харьцангуй доогуур хамран сургалт, хөвгүүдийн сургууль завсардалтад боловсролын салбарынхан нухацтай хандах,
- Санхүүжилтийн зөрүүг багасгах-эдийн засгийг сайжруулж, иргэдийн идэвхийг нэмэгдүүлэх хүрээнд дотоодын эх үүсвэрийг дайчлах, хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, орлого, баялгийн тэгш хуваарилах бодлого баримтлах,
- Төрийн үйлчилгээний ил тод, хариуцлагатай байдлыг баталгаажуулах,
- Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дээшлүүлэх, эрх зүйн орчны зохицуулалтыг боловсронгуй болгох,
- Зорилтот бүлэг, мэдээллийн бааз, хяналт-шинжилгээг сайжруулах чиглэлээр ажиллах шаардлагатай байна.

Бүлэг 1.

МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУДЫН ҮНЭЛГЭЭ:

Өнөөгийн байдал, хандлага, дэмжих
орчин, сорилт, шийдвэрлэх асуудал



ЗОРИЛГО 1

ЯДУУРАЛ, ӨЛСГӨЛӨНГ БУУРУУЛАХ

Зорилт 1: Амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой иргэдийн эзлэх хувь хэмжээг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 2 дахин бууруулах

Өнөөгийн байдал, хандлага

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын эдийн засаг өсч байгаа боловч, ядуурлыг бууруулахад дорвитой нөлөөлж чадахгүй байна. Өрхийн нийгэм, эдийн засгийн 2007-2008 оны судалгааны дүнгээс үзэхэд Монгол Улсад

ядуурлын түвшин 35.2 хувьтай байна. Өөрөөр хэлбэл, 930.0 гаруй мянган хүн ядууралд өртсөн болон 100 хүн тутмын 35 нь зайлшгүй шаардлагатай хүнсний болон хүнсний бус хэрэглээний зүйлийг худалдан авах чадваргүй байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Ядуурлын түвшин, гүнзгийрэлт, хэрэглээ, нэг хүнд ногдох ДНБ


Шалгуур үзүүлэлт	1990	2000	2006	2007	2008	2015
1 Ядуурлын түвшин (хувь)	36.3 ^a (1995)	35.6 ^a (1998)	32.2 ^a	29.3 ^б	35.2 ^б	18.0 ^a
2 Ядуурлын гүнзгийрэлт (хувь)	10.9 ^a (1995)	11.0 ^a (2002)	10.1 ^a	8.8 ^б	10.1 ^б	6.0 ^a
3 Үндэсний нийт хэрэглээнд хамгийн бага хэрэглээтэй хүн амын хэрэглээний эзлэх хувийн жин	-	7.5 ^a (2002)	6.3 ^б	6.4 ^б	7.2 ^б	11.0 ^a
4 Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн (оны үнээр, мян.төг)	5.1 ^a	426.2 ^a	1440.7 ^a	1758.9 ^б	2305.2 ^б	6800.0 ^a

Эх үүсвэр: а. УИХ-ын тогтоол 2008 оны #13, Монгол Улсын МХЗ-уудыг батлах тухай
б. ӨНЭЭС, УСХ, 2009

Ядуурлын хамралтын хүрээ хотод 30.3 хувиас 26.9 хувь болж буурсан бол хөдөөд 43.4 хувиас 46.6 хувь болж өссөн байна (Дүрслэл 7). Ядуурлын хамралтын хүрээг бүс нутгаар авч үзвэл, баруун бүсэд 4 хувь, Төвийн бүсэд 3.7 хувиар тус тус буурч, Хангайн болон Зүүн бүсэд 7.9-12.2 хувиар өссөн байна.

Ядуурлын гүнзгийрэлт нь хэрэглээ ядуурлын шугамаас хэр доогуур байгааг тодорхойлдог бөгөөд энэ үзүүлэлт 2007 онд 2006 оноос 8.8 хувь болж буурсан бол 2008 онд дахин 10.1 хувь болж өссөн байна. Үүнээс үзэхэд ядуурал, тэгш бус байдал дорвитой буурахгүй ядуурлын гүнзгийрэлт бага зэрэг хэлбэлзэлтэй байна.

Дүрслэл 7. Монгол дахь ядуурлын түвшин, хувь



Энэ хандлага цаашид үргэлжилбэл ядуурлыг бууруулах зорилтыг биелүүлэхэд ихээхэн хүндрэлтэй болохоор байна.

Монгол Улсад орлогын тэгш бус байдал арилахгүй байгааг Жини коэффициентийн өөрчлөлт харуулж байна (Хүснэгт 2). Тэгш бус байдал бүх бүсүүдэд өссөн дүр зураг харагдаж байгаа нь эдийн засгийн өсөлтийн үр шимийн дийлэнх хувийг амьдралын боломж сайтай хүмүүс хүртэж байгааг илэрхийлж байна.

Үндэсний нийт хэрэглээнд хамгийн бага хэрэглээтэй (20 хувийн) хүн амын эзлэх хувийн жин 2007-2008 онд 7.2 хувь байна. 2008 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэг хүнд ногдох ДНБ оны үнээр 2,305.2 мян.төгрөгт хүрч 2007 оныхоос 31.1 хувиар нэмэгдлээ. Нэг хүнд ногдох бодит хэрэглээ 2002-2003 болон 2007-2008 оны хооронд 8.7 хувиар өссөн байна. Улаанбаатар хотод хэрэглээ 16.5 хувиар, Төвийн бүсэд 13.6 хувиар, Баруун бүсэд 4.8 хувиар өссөн байхад Хангайн болон Зүүн бүсэд 7.4-8.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 2. Ядуурлын хамралт, гүнзгийрэлт, тэгш бус байдал, нэг хүнд ногдох хэрэглээ, 2003, 2008

	Ядуурлын хамралтын хүрээ %		Ядуурлын гүнзгийрэлт		Жини коэффициент		Нэг хүнд ногдох хэрэглээ, мян/төг-өөр	
	2002-03	2007-08	2002-03	2007-08	2002-03	2007-08	2002-03	2007-08
Улсын дундаж	36.1	35.2	11.0	10.1	0.33	0.36	92.8	100.9
Байршлаар: Хот	30.3	26.9	9.2	7.7	0.33	0.36	101.9	115.5
Хөдөө	43.4	46.6	13.2	13.4	0.31	0.32	81.5	81.0
Улаанбаатар	27.3	21.9	8.1	6.3	0.33	0.36	108.6	126.5
Аймгийн төв	33.9	34.9	10.5	9.9	0.32	0.34	93.9	97.7
Бүсээр: Баруун	51.1	47.1	14.6	12.8	0.31	0.30	75.1	78.7
Хангай	38.7	46.6	12.3	13.6	0.32	0.32	86.9	80.4
Төв*	34.4	30.7	10.1	8.4	0.31	0.35	92.9	105.5
Зүүн	34.5	46.7	12.4	14.9	0.32	0.34	89.1	81.8

* Улаанбаатарыг оруулаагүй.

Эх үүсвэр: ӨОЗАТС 2002-2003, ҮСХ болон ӨНЭЗС 2007-2008, ҮСХ, 2009

Дэмжих орчин

Монгол Улсын МХЗ-д суурилсан ҮХЦБ (2007-2015), Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын үндсэн баримт бичгүүдэд ядуурлыг бууруулах, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх асуудлыг гол зорилгоо болгож, тэргүүлэх ач холбогдолтой арга хэмжээг бүрэн дэмжин ажиллаж байна.

Ядуурлыг бууруулахад чиглэсэн олон улсын байгууллагын дэмжлэгтэй дараахь хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд, Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих Үндэсний хөтөлбөр (МУЗГ, АХБ), Тогтвортой амьжиргаа төсөл (МУЗГ, ОУХА/ДБ), Ядуурлын судалгаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл (НХХЯ, ШОУХА, НҮБХХ), Хөдөөгийн ядуурлыг тогтвортой бууруулах хөтөлбөр (МУЗГ,

ХААХОУС), Албан бус эдийн засаг, ядуурал, хөдөлмөр эрхлэлт төсөл (НХХЯ, ОУХБ) зэргийг онцлон дурьдаж болно.

Нийгмийн халамжийн тухай, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулан мөрдөж байна. Шинээр төрсөн хүүхэд, Анх удаа гэрлэгчид олгох мөнгөн тэтгэмжийн хөтөлбөрийг 2006 оноос, Хүүхдийн мөнгө хөтөлбөрийг 2007 оноос хэрэгжүүлсэний үр дүнд хүн амын мөнгөн орлого нэмэгдэж, шинээр гэрлэгсдийн хамтын амьдралын гараанд чухал ач холбогдолтой хөрөнгө оруулалт болж байна.

Засгийн газраас ядуурлыг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний дүнд ядуурлын

хүрээг хэт өргөжүүлэхгүй байх, нийгмийн дэд бүтцийг хөгжүүлэх замаар түр ажлын байр бий болгох, хүүхдийн сурах орчин, сургуулийн өмнөх болон суурь боловсролыг дэмжих, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, хөдөлмөр эрхэлж, амьжиргаагаа дээшлүүлэх хүсэл сонирхолтой иргэдийг орлого нэмэгдүүлэх үйл ажиллагаанд татан оруулах зэрэг чиглэлд тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтыг хийсэн юм. Энэ нь төр, иргэний нийгмийн хамтын ажиллагаа, оролцоо, дэмжлэгийг өргөжүүлэх, хөтөлбөрт зарцуулах хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх, орон нутгийн хэрэгцээнд тулгуурлах чиглэлээр зохих амжилт олж, туршлага хуримтлуулах таатай нөхцлийг бүрдүүлсэн.

Гэвч ядуурлыг бууруулах чиглэлээр авч байгаа арга хэмжээг хэрэгжүүлэхдээ өрх, иргэдийн онцлог, хэрэгцээ, чадавхийг сайтар харгалзаж үзээгүй, өрхийг нэг бүлэг, нэгж байдлаар авч үзэж үйл ажиллагааг чиглүүлээгүй, өрхийн гишүүдийг салган, тусад нь хамруулж ирсэн нь хөрөнгө, хүч нөөцийг тарамдуулах, хугацаа алдах зэргээр үр дүн багатай болоход хүргэсэн байна. Үүнд өрх, иргэдийн үүрэг, оролцоо, санал санаачилгыг урамшуулан дэмжих, түүнд үндэслэн арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх асуудлыг орхигдуулсан нь нөлөөлсөн байж болох талтай.

Ядуу хүн, түүний хэрэгцээг илүү сайн тодорхойлохын тулд ядуурлын хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх нь чухал байна. Үүнтэй уялдаж 2010 оны хүн ам, орон сууцны тооллогыг хүн амын амьжиргааг тодорхойлох, ялангуяа ядуурлын зураглал гаргахад илүү дөхөмтэй мэдээлэл оруулсан асуулгаар явуулах нь олон талын ач холбогдолтой. Монгол Улсын Хүн ам, орон сууцны 2000 оны тооллого болон Амьжиргааны түвшний 2002-2003 оны судалгааны мэдээлэлд үндэслэн бүс, аймаг, сумын түвшний “Ядуурлын зураглал”-ыг анх удаа 2008-2009 онд гаргасан нь ядуурлыг бууруулах бодлого, арга хэмжээг тодорхойлоход чухал хэрэгсэл болно гэж үзэж байна². Орон нутгийн түвшинд ядуурлыг бууруулах нь нутгийн төрийн захиргааны байгууллагуудын гол үүрэг зорилт болж байна. Гэвч тэдэнд энэ чиглэлээр зарцуулах хөрөнгө, хүний нөөц, чадавхи дутагдалтай байна. Энэ

² Харолд Коуломб, Томас Оттер, Монгол улсын Хүн амын тооллогод суурилсан Ядуурлын зураглал: Бүс, аймаг, сумын түвшний дүн, УСХ, НҮБХХ, 2009

нь тэднийг энэ үүрэг хариуцлагаас хөндийрөх шалтгаан болж байна.

Тулгамдсан асуудал

Монгол Улсад ядуурлын түвшин сүүлийн 14 жилийн хугацаанд дөнгөж 1.1 нэгжээр буурсан бөгөөд үлдэж байгаа хугацаанд амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой иргэдийн тоог 2 дахин бууруулах зорилтод хүрэхэд багагүй бэрхшээл учрахаар байна.

Эдийн засгийн өсөлт нь ядуурлыг дорвитой бууруулахгүй байгаа хэдий ч, ядуу хүмүүст байгаа гол нөөц болох ажиллах хүчээ ашиглах боломжийг олгож байна. Зохистой ажлын байрыг олноор бий болгох нь ядуурлыг бууруулах нэг хүчин зүйл болдогийг олон улсын туршлага харуулж байна. Гэтэл Монгол Улсын эдийн засгийн өсөлт нь ядуурлыг бууруулахгүй байгаа нэг шалтгаан нь хөдөлмөр эрхлэлтийн мэдрэмж багатай өсөлт давамгайлж, ажлын байр мэдэгдэхүйц хэмжээгээр бий болж чадахгүйтэй холбоотой байна.

Иймээс хүн амын нийгмийн баталгааг сайжруулах зорилгоор эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбарын үйлчилгээнд зарцуулж байгаа хөрөнгийг нийгмийн эмзэг хэсэг, зорилтот бүлгүүдэд үр ашигтай механизмаар дамжуулан хүргэх, нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчлэх, шинээр ажлын байр бий болгоход чиглэсэн арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Цаашдын зорилт

Ойрын хугацаанд³:

- “Өрхийн хөгжлийг дэмжих Үндэсний хөтөлбөр”-ийг батлан, өрхийн нөхцөл байдал, нөөц боломж, чадавхийг нь өрхийн гишүүдийн оролцоотой тодорхойлж, хэрэгцээ шаардлагад нийцсэн, бодитой хөгжлийн төлөвлөгөөг хамтран боловсруулах замаар хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Хөрөнгө оруулалтыг эдийн засгийн өсөлтийг дэмжих ялангуяа хөдөлмөрийн шингээлт ихтэй үйлдвэрлэлд түлхүү хандуулах замаар ажлын байрыг нэмэгдүүлэх,

³ Ойрын хугацаа: 1-2 жил

- Ажилгүй, ядуу иргэдэд мэргэжил, ажлын дадлага, туршлага эзэмшүүлэн, ажлын байртай болгох, амьжиргааны эх үүсвэртэй болох, орлогоо нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх,
- Ажлын байр шинээр бий болгосон аж ахуйн нэгж, байгууллагад эдийн засгийн урамшуулал олгодог тогтолцоог бий болгох,
- Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд бизнесийн төрөлжсөн инкубаторыг байгуулан, жижиг зээл, ажлын байран дахь болон шавь сургалтыг өргөтгөх замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх,
- Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн бүртгэл, мэдээлэл, зохион байгуулалтыг сайжруулж, төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодын оролцоотойгоор нийгмийн үйлчилгээнд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх,
- Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн эдийн засаг, бизнесийн дэмжлэгийг өргөжүүлэх,
- Орон нутгийн хөгжилд тулгуурласан хөдөөгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх. Энэ хүрээнд мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах аж үйлдвэрийг орон нутагт хөгжүүлэх,
- Нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчлэх, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт оновчтой хүргэх, мөн түүнчлэн хөдөөгийн болон алслагдсан бүс нутагт хүргэх оновчтой, үр ашигтай бүтцийг бий болгож төлөвшүүлэх,
- Эмэгтэйчүүд, ахмад настан, малчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг хүн амын болон нийгмийн бүлгүүдийн

хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээг тодорхойлж, дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.

Дунд хугацаанд⁴:

- Экспортын баримжаатай үйлдвэрлэлийг дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлэх,
- Мэргэжлийн боловсрол, сургалтын талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлж, хувийн хэвшлийн оролцоог дэмжих замаар боловсон хүчнийг хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх,
- Гадаадад ажиллаж, амьдарч байгаа, өндөр боловсрол, мэргэжил эзэмшсэн монгол иргэдийг эх орондоо ирж ажиллах сонирхлыг төрүүлэхүйц эрх зүй, эдийн засгийн таатай орчныг бүрдүүлж, мэргэшсэн чиглэлээрээ ажлын байр бий болгох санал, санаачилгыг хөхиүлэн дэмжих,
- Хүн амын орлогыг бодитой нэмэгдүүлж, тогтвортой өсгөх, орлогын тэгш бус хуваарилалтыг арилгах бодлого баримтлах,
- Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөх, ажил олгогчийн зүгээс тухайн хүний нийгмийн баталгааг хангах чиглэлээр эрх зүйн шинэчлэл хийх,
- Тэтгэврийн олон давхаргат тогтолцоог бий болгох эрх зүйн орчинг бүрдүүлэх,
- Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн даатгалын хууль боловсруулах,
- Тэтгэврийн даатгалын нэрийн дансны сангийн хөрөнгийг урт хугацааны хөрөнгө оруулалтад ашиглах стратегийг тодорхойлж, сангийн менежментийн эрх зүйн орчныг бүрдүүлэх.

⁴ Дунд хугацаа 3-5 жил

Зорилт 2: Хоол, тэжээлийн дуталтай хүн амын тоог 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 6 дахин бууруулах

Өнөөгийн байдал, хандлага

Монгол Улсын хүн ам ялангуяа, эмзэг бүлэг болох хүүхэд, эмэгтэйчүүдийн дунд бичил тэжээлийн дутлууд (төмөр дутлын цус багадалт, иод дутлын эмгэг, аминдэм А, Д дутал, цайр, селений дутал) түгээмэл тохиолдож байна.

Тав хүртэлх насны хүүхдийн тураал 1992 онд 12.0 хувь байсан бол 2005 онд 6.3 хувь болж, жилд 0.44 хувиар буурчээ (Хүснэгт 3). 2015 оны зорилтыг хангахын тулд улсын дунджаас өндөр хувьтай байгаа Баруун, Хангай болон Зүүн бүсүүдэд түлхүү анхаарах хэрэгтэй байна.

Хүснэгт 3. Тав хүртэлх насны хүүхдийн тураал, өсөлтийн хоцролт, туранхай хүүхдийн хувь

	Шалгуур үзүүлэлт	1990	2000	2006	2007	2008	2015
5	5 хүртэлх насны тураалтай хүүхдийн эзлэх хувь	12.0 ^a (1992)	12.7 ^a	6.3 ^a (2005)	6.3 (2005)	6.3 (2005)	2.0 ^a
6	5 хүртэлх насны өсөлтийн хоцролттой хүүхдийн эзлэх хувь	-	25.0 ^a	21.0 ^a (2005)	21.0 (2005)	21.0 (2005)	13.0 ^a
7	5 хүртэлх насны туранхай хүүхдийн эзлэх хувь	-	5.5 ^a	2.2 ^a (2005)	2.2 (2005)	2.2 (2005)	1.0 ^a

Эх үүсвэр: а. УИХ-ын тогтоол #13, Монгол Улсын МХЗ-уудыг батлах тухай, 2008
Хүн амын хоол, тэжээлийн байдал, үндэсний анхдугаар судалгаа, 1992, ЭМЯ
Монголын хүүхэд, эмэгтэйчүүдийн хоол, тэжээлийн байдал, Үндэсний 3 дахь судалгаа, НЭМХ, ЭМЯ, НҮБХС, 2004

Хоол, тэжээлийн архаг дутлыг илэрхийлэх гол үзүүлэлт хүүхдийн өсөлтийн хоцролт 1992 онд 26.0 хувь байсан бол 2004 онд 19.6 хувь болон буурч, харин Үндэсний статистикийн газар (хуучин нэрээрээ) НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран зохион байгуулсан судалгаагаар 2006 онд 21.0 хувь⁵ болж өсчээ. Өсөлтийн хоцролттой хүүхдийн тоог 2015 он гэхэд 13 хувь хүртэл бууруулах зорилтыг хангахын тулд жилд 0.9 хувиар бууруулах шаардлагатай бөгөөд улсын дунджаас дээгүүр хувьтай байгаа Баруун (28.0 хувь) болон Зүүн (26.9 хувь) бүсүүдэд эрчимтэй арга хэмжээ авах хэрэгтэй байна.

Хоол тэжээлийн хурц дуталтай буюу туранхай хүүхдийн тоо 2000 онд 5.5 хувь байсан бол 2005 онд 2.2 хувь болж буурчээ. Хэрэв энэ хурдаар үргэлжилбэл 2015 онд 1 хувьд хүргэх зорилтыг хангах боломж байна. Улаанбаатар хотод энэ үзүүлэлт улсын дунджаас өндөр буюу 2.5 хувь байна.

Бага насны хүүхдийн цус багадалт 1999 онд 48.5 хувь байсан бол 2008 онд 21.4 хувь, А

аминдэмийн дутал 19.8 хувь байсан бол 12.0 хувь, иодын дутал 29.2 хувь байсан бол 13.8 хувь болж буурч, харин Д аминдэмийн дутал 32.1 хувь байсан бол 41.0 хувь болж өсчээ.

Дэмжих орчин

Хүнсний хангамж, аюулгүй байдал. Засгийн газар хүнсний хангамж, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хүрээнд хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, үйлдвэрлэлийг сэргээж, хүн амын хүнсний хангамж, амьдралын түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн бодлогын хэрэгжилтийг хангах арга хэмжээг дэс дараатай явуулж байна. Тухайлбал, Хүнсний баталгаат байдал Үндэсний хөтөлбөр (2009-2016), Атрын гурав дахь аян - тариалангийн хөгжил хөтөлбөр (2008-2010), Экологийн цэвэр бүтээгдэхүүн хөтөлбөр (2006-2015), Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр (2003-2015), Иод дутлын эмгэгтэй тэмцэх хөтөлбөр (2007-2012), ядуу эх, хүүхдийн хоол тэжээлийн байдлыг сайжруулах төсөл зэрэг хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлж байгаа нь зохих үр дүнгээ өгч байна.

⁵ Хүүхэд хөгжил-2005 судалгаа, УСГ, НҮБХС, 2007

Хоол тэжээл, аминдэм. Хүн амын тодорхой хэсэг рүү чиглэсэн буюу ядуу, эмзэг бүлгийн эхчүүд, хүүхдийн хоол, тэжээлийн байдалд дэмжлэг үзүүлэх хүрээнд 2008 онд Засгийн газраас Нийгмийн эмзэг бүлгийн хүн амд хоол, тэжээлийн дэмжлэг үзүүлэх дэд хөтөлбөрийг боловсруулж, батлуулан АХБ-тай хамтран хэрэгжүүлж эхэллээ. Энэ нь орлого багатай иргэн хүнсний хэрэглээний гол бүтээгдэхүүнийг тогтвортой үнээр худалдан авах механизмийг бүрдүүлэх, орон гэргүй, ажилгүй, оршин суугаа нутаг дэвсгэрийн захиргаанд хаягийн бүртгэлгүй иргэнийг түр зуур хоноглох байранд байлгах, тэдэнд өдөрт нэг удаа халуун хоол өгөх үйлчилгээнд хамруулах зорилготой юм.

Хүүхдийн тэжээлийн бодис, эрдэс, аминдэмээр баялаг нэмэгдэл хоолыг насанд нь тохирсон хэмжээгээр олгох, эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүн, угж, түүнтэй адилтгах зүйлийн чанар, аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчинг бүрдүүлж, Хүүхэд, хөгжил, хамгааллыг сайжруулах Үндэсний хөтөлбөр (2002-2010), Эх, хүүхдийг аминдэм, бичил бодисын дутлаас сэргийлэх стратегийг батлан хэрэгжүүлж байна. Бага насны хүүхдийг А аминдэмээр хангах, эхийн сүүгээр бойжуулахыг дэмжих, хүүхдийн өсөлтийг хянах тогтолцоо бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйг сайжруулах, эмнэлгийн ажилтнуудын чадавхийг сайжруулах сургалт, эцэг, эх, асран хүмүүжүүлэгчдийн мэдлэгийг дээшлүүлэх сурталчилгаа, олон нийтийг мэдээлэл авах боломжоор хангахад түлхүү анхаарч байна.

Засгийн газраас ЕБС-ын “Үдийн цай хөтөлбөр” хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2008 оны байдлаар 1-5 дугаар ангийн бүх хүүхдийг хамруулдаг боллоо. Энэ хүрээнд хүнсний тэжээллэг чанар, аюулгүй байдлыг сайжруулах, хүнсний зүйлийн 60-аас доошгүй хувьд сүү, цагаан идээ хэрэглэх зарчим баримталж, хоол хүнсээр дамжуулан авах кальцийн хэрэглээг нэмэгдүүлэхэд анхаарч байна.

Эх, хүүхдийн хоол, тэжээлийг сайжруулах, амин дэмээр хангахад олон улсын болон дотоодын байгууллагууд, тухайлбал, НҮБХС, НҮБХАС, ДЭМБ, АХБ, Дэлхийн Зөн Монгол ОУБ, Өлсгөлөнгийн эсрэг хөдөлгөөн Францын хүмүүнлэгийн байгууллага, Таван богд ХХК зэрэг олон байгууллагууд идэвхтэй дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Тулгамдсан асуудал

Дэлхийн хүнс, өргөн хэрэглээний барааны үнэ байнга өсч байсан нь хүн амын, түүний дотор эмзэг бүлгийн хүн амын хоол тэжээл, амьжиргаанд сөргөөр нөлөөлж байна.

Өрхийн хүнсний хангамж, хоол тэжээл дэх бичил тэжээлийн бодисуудын хангамжийг сайжруулах, нэг хүний хоол тэжээлээр авч байгаа илчлэгийн дундаж хэмжээг нэмэгдүүлэх, хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулан хангамж, хүртээмжийг сайжруулах шаардлагатай байна.

Хоол тэжээл, хүнсний асуудалд салбаруудын хамтын ажиллагааг өргөжүүлж, эдийн засгийн хувьд үр ашигтай хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааг нэмэгдүүлэхийн зэрэгцээ үйлдвэрлэгчдийг оршин тогтноход нь бэрхшээл учруулсан импортын үнийг гэнэтийн бууралт болон шударга бус өрсөлдөөнөөс хамгаалах нь зүйтэй.

Цаашдын зорилт

Ойрын хугацаанд:

- Хүнсний нэмэгдэл бүтээгдэхүүн, амин дэм зэрэг эх, хүүхэд, ахмад настны эрүүл мэндийг хамгаалахтай холбоотой бүтээгдэхүүнийг зорилтот бүлэгт хүргэж, хоол тэжээлийн дутлаас хамгаалах цогц арга хэмжээ төрөөс зориуд анхаарч холбогдох арга хэмжээг авах,
- Хоол тэжээлийн дуталд өртөмтгий зорилтот бүлэг (ялангуяа ядуу, эмзэг)-т үйлчлэх шинэ тогтолцоог бий болгож хөгжүүлэх,

Дунд хугацаанд:

- Мал аж ахуй, газар тариалангийн гаралтай хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх,
- Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг бүсчлэн хөгжүүлж, дотоод зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн чанар сайтай, аюулгүй түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэх, экспортын нөөцийг нэмэгдүүлэхэд чиглүүлэх,
- Монгол Улсын хүнсний баталгаат байдлыг тодорхойлох нэгдсэн

аргачлалыг бий болгохын зэрэгцээ хүнсний балансыг тодорхойлох, хоол тэжээлийн дуталд орсон ядуу иргэд, өрхөд дэмжлэг үзүүлэх, хүнсний хангамж, аюулгүй байдлын бодлого тодорхойлж хэрэгжүүлэх,

- Хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хянах, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, бие даасан, ашгийн бус, үндэсний лавлагаа лабораторийг байгуулах.


Зорилт 3: *Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшинг дээшлүүлж, хөдөлмөрийн зах зээлд шилжиж байгаа залуучуудын ажилгүйдлийн түвшинг бууруулах*

Өнөөгийн байдал, хандлага


Монгол Улсын нийт хүн ам 2008 онд 2,683.5 мянга болж, хөдөлмөрийн насны хүн ам 1,688.7 мянга, эдийн засгийн идэвхтэй хүн ам 1,071.5 мянга болжээ. Хүн амын ажил эрхлэлтийн 2007-2008 оны тайлангаас үзэхэд нийт хүн амын 21.7 хувь, нийт ажиллагчдын 21.0 хувийг 15-24 насны залуучууд эзэлж байна.

Улсын хэмжээний ажиллах хүчний оролцооны түвшин 2007 онд 64.2 хувь, 15-24 насны залуучуудын ажилгүйдлийн түвшин 3.2 хувь байсан бол 2008 онд ажиллах хүчний оролцооны түвшин 63.5 хувь болж 0.7 нэгж, 15-24 насны залуучуудын ажилгүйдлийн түвшин 3.0 хувь болж 0.2 нэгжээр тус тус буурсан байна (Дүрслэл 8-9). Хэдийгээр залуучуудын ажилгүйдлийн түвшин буурсан боловч улсын дунджаас өндөр байна. Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажилгүйчүүдийн 22.8 хувийг 15-24 насны залуучууд эзэлж байна.

Дүрслэл 8. Ажиллах хүчний оролцооны түвшин



Дүрслэл 9. 15-24 насны залуучуудын ажилгүйдлийн түвшин, 1998-2008, 2015



Ажиллах хүчний оролцооны түвшинг бүс нутгаар авч үзвэл, 2008 онд Улаанбаатар хотод өмнөх оноос 0.6 нэгжээр өсч, бусад бүсэд 0.8-2.1 нэгжээр буурсан байна. Бүс нутгийн ажиллах хүчний оролцооны түвшний зөрүү 2007 оны судалгааны дүнгээр 0.5-16.6 байсан бол 2008 оны судалгаагаар 0.4-14.4 болж буурсан байна (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Ажиллах хүчний оролцоо, 15-24 насны залуучуудын ажилгүйдэл, бүсээр, 2004-2008

	Ажиллах хүчний оролцооны түвшин (хувь)						15-24 насны залуучуудын ажилгүйдлийн түвшин, хувь					
	2000	2004	2005	2006	2007	2008	2000	2004	2005	2006	2007	2008
Улсын дундаж	62.9	64.4	63.5	64.4	64.2	63.5	4.4	3.6	3.3	3.2	3.2	3.0
Баруун бүс	75.2	73.2	72.9	72.7	72.6	71.5	-	4.3	3.7	3.7	2.9	3.1
Хангайн бүс	77.6	73.2	73	72.8	73.1	71.1	-	4.5	4.0	3.7	3.9	3.8
Төвийн бүс	66.5	65.8	65.6	65.8	66.1	65.3	-	2.8	2.5	2.6	2.4	2.3
Зүүн бүс	63.5	61.5	61.3	61.6	60.8	58.7	-	3.9	3.9	4.8	3.5	4.7
Улаанбаатар	46.2	55.9	54.4	56.8	56.5	57.1	-	2.8	2.7	2.2	3.1	2.3

Эх үүсвэр: Хүн амын ажил эрхлэлтийн жилийн тайлан, ҮСХ, 2008

Дэмжих орчин

Засгийн газраас 2007 оныг “Их бүтээн байгуулалт, шинэ ажлын байрыг нэмэгдүүлэх жил” болгон зарлаж, иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, амьдрах орчин нөхцөлийг сайжруулахад бүтээмж өндөртэй ажлын байрыг олноор бий болгох зорилт тавин ажилласнаар 80.0 мянган ажлын байр шинээр бий болж, 2008 онд уг ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлснээр 73.9 мянган ажлын байр шинээр бий боллоо. 2008 оны байдлаар шинээр бий болсон ажлын байрны 23 хувийг 15-24 насны залуучууд эзэлж байна.

Мөн Засгийн газраас Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байна. Энэ хөтөлбөр нь оюутнуудыг сургуулиас хөдөлмөрийн зах зээлд шилжихэд бэлтгэх, сурч байгаа мэргэжлийн чиглэлээр нь аж ахуй эрхлэх, жижиг бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, бизнес инкубацийн орчинг хөгжүүлэхэд чиглэгдэж байна. Их, дээд сургуулиудад төгсөх жилдээ суралцаж байгаа нэг бол зээл авах хүсэлт гаргахаас өмнө нэгээс дээшгүй жилийн өмнө их, дээд сургууль төгссөн оюутнуудад бие даан бизнес эрхэлж, ажлын байр нэмэгдүүлэхэд нь зориулан зээл олгох ажлыг зохион байгуулж байна.

Тулгамдсан асуудал

Хүн амын насны бүтцэд гарч байгаа өөрчлөлт хандлагыг хөдөлмөр эрхлэлтийн бодлогод тусгах, ялангуяа, хүн ам зүйн цонхны үеийг үр өгөөжтэй ашиглах шаардлагатай байна.

Хөдөлмөрийн зах зээлд шинээр орж байгаа

залуучууд бэлэн ажлын байранд шууд ажиллах, эсвэл өөрөө бизнес эрхлэх боловсрол, мэдлэг, ур чадвар дутмаг байна. Зарим нь гадаадад өндөр орлоготой ажил хийхийг сонирхдог боловч сурсан сургууль, мэргэжлийн түвшинд нь тохирсон ажил олдох нь ховор байна. Иймд орчин үеийн бизнес, ААНБ-уудын хэрэгцээг хангахуйц мэргэжил, ур чадвар эзэмшсэн ажилтнуудыг бэлтгэх шаардлагатай байна.

Монгол Улсын “Хүн ам зүйн цонх”-ны үед эдийн засагт ажиллах хүчин шингээх чадвар нэн хомс байгаагаас шалтгаалан ажиллах хүчний илүүдэл бодитой байна. Ийм учраас ойрын үед залуучууд, ялангуяа хөдөлмөрийн зах зээлд шинээр орж байгаа залуучууд ажлын байраар дутагдах хандлага, гадаад улс оронд очиж ажиллах хэрэгцээ хэвээр үргэлжлэх төлөвтэй байна. Иймд залуучуудын ажлын байр олноор бий болгодог боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх, хөдөлмөр зохион байгуулалтын хувьд хоршооллыг эрчимжүүлэх, гадаад улс оронд хөдөлмөрийн гэрээгээр ажиллах боломжийг өргөжүүлэх явдал чухал юм.

Эдийн засгийн өсөлт, хөдөлмөрийн зах зээл дэх нөхцөл байдлаас залуучуудын хөдөлмөр эрхлэлт нэлээд шалтгаалдаг. Зохистой, үр бүтээлтэй хөдөлмөр эрхлэх бололцоог бүрдүүлэхийн тулд түүнд чиглэсэн эдийн засгийн болон салбарын бодлогыг тусгайлан боловсруулах хэрэгтэй болно. Өнөөдрийн залуус-ирээдүйн ажилчин, бизнес эрхлэгч, манлайлагч эцэг эх, идэвхтэй иргэнийг төлөвшүүлэх боломжийг өргөтгөх, чадавхийг дээшлүүлэх, буруу сонголт хийснээс алдсан залууст амьдралаа шинээр эхлэх хоёр дахь боломжийг олгох шаардлага тулгарч байна.

Цаашдын зорилт

Ойрын хугацаанд:

- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн мэргэжил эзэмшүүлэх, хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх,
- Хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа залуучууд, түүнчлэн боловсрол багатай залуу иргэдэд зориулан хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх,
- Бизнесийн сургалт, бичил зээл, залуучуудын сүлжээ, үндэсний кампанит ажил, бизнесийн үйл ажиллагааны талаархи мэдээллийг сайжруулах, бизнес эрхлэх таатай орчныг сайжруулах, албан бус салбарт ажиллагчдад дэмжлэг үзүүлэх зэргээр залуучууд бизнес эрхлэх явдлыг хөхиүлэн дэмжих,
- Боловсруулах үйлдвэр, барилга, эрчим хүч зэрэг өсөлт өндөртэй салбарт залуучууд ажиллахыг дэмжих, тэднийг сургаж дадлагажуулах,
- Удаан хугацаагаар ажил эрхлээгүй залуучууд, түүний дотор хөдөөгийн залуучуудад зориулж, олон нийтийг хамарсан ажлын байр бий болгох, боловсролоо дээшлүүлэх, сургалт, ажил эрхлэлтэд хамрагдах боломж бололцоог нэмэгдүүлэх,
- Ажлын байранд нь дадлагажуулах сургалтын зохистой хэлбэрийг эрэлхийлж байгаа ажил олгогч эздийн болон үйлдвэрчний эвлэлийн байгууллагын хүчин чармайлтыг дэмжихийн зэрэгцээ сургууль завсардсан болон дөнгөж сургууль төгссөн залуучуудад ажил эрхлэх боломж олгож байгаа ажил олгогчдыг эдийн засгийн урамшууллын хэлбэрээр хөхиүлэн дэмжих.

Шигтгээ 1. Оюутны хөдөлмөр эрхлэлт

Жил бүр их, дээд сургууль, коллежид суралцагчдын 16 хувь буюу 20.0 мянган оюутан нийгэм, хүмүүнлэг, байгаль, ХАА, техник, анагаах ухааны чиглэлээр дээд, тусгай дунд боловсрол эзэмшиж, тэдгээрийн 73.2 хувь нь аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст ажил эрхлэх хүсэлтээ илэрхийлж байна.

Гэвч хөдөлмөрийн албадад ирж байгаа ажлын байрны захиалгын 70 орчим хувийг ерөнхий ажил мэргэжил, техник мэргэжлийн боловсролтой ажилчдын захиалга эзэлж байна. Харин хөдөлмөрийн зах зээлийн ерөнхий төлөв байдлаас үзэхэд дээд боловсролтой болон ердийн ажилчдын нийлүүлэлт нь эрэлтээсээ 20 хувиар их байхад, техникийн ажилтнуудын хувьд эсрэгээр эрэлт нь нийлүүлэлтээсээ 30 гаруй хувиар их байгаа дүр зураг ажиглагдаж байна.

Иймд оюутнуудыг хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх, чөлөөт цагаар нь хөдөлмөрийн дадлага эзэмших, орлого олох нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж эхэллээ.

Эхний шатанд Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний анхан шатны бүтцийг сонгосон сургуулиудад бий болгох, эдгээр төвүүдээр дамжуулан оюутнуудыг хөдөлмөрийн гараагаа зохистой эхлэхэд зөвлөх, сургах, мэдээллээр хангах, чөлөөт цагаараа ажил хийх, бизнес эрхлэхийг хүссэн оюутныг бүртгэж, “Оюутны хөдөлмөрийн бирж”-ээр зуучлуулах, зээлийн хөтөлбөрт хамруулах, төгсөгчдийн ажлын байрны хангалтыг судлах, үйлдвэрлэлийн дадлагыг аж ахуйн нэгж, байгууллагад хийхэд зуучлах, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлээд байна. Дээрх төлөвлөгөөний дагуу оюутны аж ахуй, бизнес эрхлэлтийг дэмжих зорилгоор ХАС банктai оюутны зээлийн хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

Эх үүсвэр: НХХЯ

Дунд хугацаанд:

- Залуучуудад зориулсан ажлын байр бий болгох тодорхой зорилтуудыг хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусгаж хэрэгжүүлэх,
- Байгаль орчин, мэдээлэл, харилцаа холбооны технологи, уул уурхай, аялал, жуулчлал зэрэг салбарын компани, байгууллагууд залуучуудыг ажилд авах өнөөгийн болон хэтийн төлөв хандлагаа тодорхойлох, мэдээлэх,

- Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний хөтөлбөр боловсруулж гаргах, ажил олгогч эзэд болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх,
- Гадаадад ажиллаж байгаад эх орондоо ирж байгаа залууст дэмжлэг үзүүлэх,
- Залуу малчдад өөрсдийн бизнестэй, өөрсдөө сургалт явуулдаг, бизнес хөгжүүлэх үйлчилгээ үзүүлдэг болоход нь зориулж бизнес инкубаторыг ажиллуулах.

Зорилт 4: *Хүн амын төвлөрөл, шилжих хөдөлгөөнтэй холбогдон гарч байгаа сөрөг үзэгдлийг багасгах, шилжин суурьшигчдыг нийгмийн суурь үйлчилгээнд хамруулах*

Өнөөгийн байдал, хандлага

Сүүлийн 10 гаруй жилд хүн амын ердийн өсөлт, ялангуяа шилжих хөдөлгөөний нөлөөгөөр бус нутгууд дахь хүн амын байршил, нягтшил эрс өөрчлөгдсөн байна. Шилжих хөдөлгөөнд 15-44 насны хүмүүс буюу хөдөлмөрийн идэвхтэй насныхан орж байгаа бөгөөд 15-24 насны залуучууд уугуул нутгаасаа хамгийн олноор шилжин явж, нийслэл хотод суурьшсан байна. Хэдийгээр Улаанбаатар хотод хөдөлмөрийн насны хүн амын хувийн жин нэмэгдэж байгаа нь хүн ам зүйн талаас эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлөх нөхцөл бүрдэж байгаа боловч, хөдөлмөрийн насны хүн бүр эдийн засгийн хувьд идэвхтэй байж чадахгүй байна. Гэхдээ ажил эрхлэх боломж Улаанбаатар хотод хөдөө орон нутгаас харьцангуй өндөр байна.

Шилжин суурьшигч нутгуудад уугуул нутгуудтай харьцуулахад 1 хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2007 оны байдлаар 2.1-2.2 дахин өндөр, орон нутгийн төсвөөс улсын төсөвт оруулах хувь нэмрийн хувьд шилжин суурьшигч нутгийнх өндөр, авч байгаа татаасын хувьд уугуул нутгууд харьцангуй улсын төсвөөс хараат байна.

ЕБС-ийн үндсэн багшид мэргэжлийн бус багшийн эзлэх хувь болон дутагдалтай байгаа багшийн эзлэх хувь уугуул нутагт улсын дундаж болон шилжин суурьшигч нутгуудаас өндөр байна. Эрүүл мэндийн үйлчилгээний хувьд уугуул нутаг дахь нэг их эмчид ногдох хүний тоо улсын дунджаас 1.7 дахин, шилжин

суурьшигч нутгуудынхаас даруй 1.7-2.9 дахин өндөр байна. Энэ нь хөдөө орон нутагт их эмчийн хүрэлцээ харьцангуй бага байгаатай холбоотой байна. Түүнчлэн томоохон төв, суурин газрын боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж сайн байгаа нь хөдөлгөөний түлхэх хүчин зүйлсийн нэг болж байна.

Улаанбаатар хотод нийтийн аж ахуйн үйлчилгээний хангамж, харилцаа холбооны болон тээврийн хэрэгслийн хүртээмж сайн, барилга, бүтээн байгуулалтын ажил илүү хийгддэг нь хөдөөнөөс хот руу шилжих бас нэг шалтгаан болж байна.

2000 оны Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний макро түвшний судалгаагаар Улаанбаатарт шилжин ирж суурьшигчдад ажил олдохгүй байх явдал хамгийн түгээмэл бэрхшээл байсан бол 2008 оны Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний чиг хандлага, үр дагаварын судалгаагаар бүртгэлийн асуудал, бүртгэлээс үүдсэн бэрхшээл, газрын асуудал, мэргэжил гологдох, санхүүгийн хүндрэл нь хамгийн түгээмэл бэрхшээл болсон байна.

Дээрхээс үзэхэд шилжин суурьших гол шалтгаан нь зах зээлд ойртох биш, харин хөгжлийн үр шимээс хүртэх, хөгжилд ойртох боломж эрэлхийлэх явдал болжээ. Хотод шилжин суурьшсанаар шилжин суурьшигч өрхийн хүүхдүүдийн сургалтад эерэг өөрчлөлт гарсан байна. Мөн шилжих хөдөлгөөнд оролцоноор эрхлэх ажилтай болдог нь хамгийн давуу тал болж байна. Түүнчлэн боловсрол, эрүүл мэндийн

үйлчилгээнд ойртсон байна. Энэ зорилтын хэрэгжилтийг харуулах хот суурингийн нийт хүн амд хаягийн бүртгэлгүй оршин сууж байгаа хүн амын эзлэх хувь гэсэн шалгуур үзүүлэлтийн талаар одоогоор мэдээлэл байхгүй байна.

Дэмжих орчин

Монгол Улс 1992 онд Үндсэн хуулиараа хүн ам оршин суух газар нутгаа өөрөө сонгох эрхийг баталгаажуулсан бөгөөд энэ асуудлыг МХЗ-д суурилсан ҮХЦБ, Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, Монгол Улсад Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт тусгасан юм.

Түүнчлэн шилжих хөдөлгөөнийг бүртгэх, шилжин суурьшигчдын хүний эрхийг хангах асуудлыг Иргэний бүртгэлийн тухай, Монгол Улсын засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай зэрэг хууль, холбогдох эрх зүйн журам, дүрмийн хүрээнд зохицуулж байна.

Цаашид шилжих хөдөлгөөний чиг хандлагыг бүх салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусгах, шилжин суурьшигчдад нийгмийн үйлчилгээг жигд хүргэх, шаардлагатай зардлыг шийдвэрлэх уян хатан зохицуулалтыг бий болгох, шилжих хөдөлгөөнд оролцохын өмнө сонголт хийх боломжийг олгоход чиглэсэн зөвлөн туслах үйлчилгээг хөгжүүлэх зэрэг асуудлыг цогцоор авч үзэх шаардлага гарч байна.

Тулгамдсан асуудал

Судалгааны⁶ дүнгээс үзвэл хүн амын шилжих хөдөлгөөний эдийн засаг, нийгмийн шалтгаан 2000 оноос хойш бараг өөрчлөгдөөгүй байна. Ялангуяа хөдөө дэх ажлын байрны хомсдол, нийгмийн үйлчилгээний чанар муу зэрэг нь хот суурин руу чиглэсэн нүүдлийг үргэлжлүүлсээр байна. Шилжих хөдөлгөөн эрчимжсэнээр хотын хүн ам ихсэх, ачаалал өсөх, ажилгүйдэл, ядуурал тодорхой хэмжээгээр нэмэгдэх, хулгай, дээрэм, гэмт хэрэг ихсэх сөрөг хандлагууд гарах болсон байна. Шилжин суурьшигчид ихэвчлэн хотын захаар, аюултай орчинд

амьдарч байна. Гэр хороолол тэлснээр байр, орон сууц, газрын эрэлт хэрэгцээ өсч, агаарын болон орчны бохирдол нэмэгдэх зэрэг сөрөг үр дагаврууд бий болсон байна.

Шилжин суурьшигчдын хамгийн хүндрэлтэй асуудал нь ажилгүй байх явдал юм. Хөдөө орон нутгаас шилжин ирэгчдийн олонхи нь мэргэжил эзэмшээгүйгээс бага хөлстэй, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаагүй нөхцөлд, туслах чанарын түр зуурын ажил хийхийн зэрэгцээ илүү цагаар ажиллах, хөдөлмөрийн хөлсөө бүрэн гүйцэд авч чадахгүй байх зэрэг эрхийн зөрчил элбэг тохиолдож байна. Мэргэжлээс гадна ажилд ороход нас хүйс харгалздаг, эдийн засгийн чадавхи, боломжоор ялгаварлан гадуурхах явдалд шилжин суурьшигчид илүү өртөж байна. Ажилтай болоход бүртгэлгүй шилжин суурьшигч илүү асуудалтай тулгарч байна. Иймд, шилжих хөдөлгөөнд оролцож байгаа шилжигчдийг бүртгэлтэй болгох, эрхийг хамгаалах тэднийг ажлын байраар хангах замаар орлогын тогтмол эх үүсвэртэй болгох асуудал нэн чухлаар тавигдаж байна.

Цаашдын зорилт

Ойрын хугацаанд:

- Хотын захад оршин суугчдын дэд бүтэц, нийгмийн хамгааллыг сайжруулах,
- Хот төлөвлөлтийн бодлогын хүрээнд оршин суухад аюултай газар, бүсийг тогтоон, шилжин суурьшигчид тэнд амьдрахаас урьдчилан сэргийлэх, Шилжих хөдөлгөөнд оролцож байгаа шилжигчдийг бүртгэлтэй болгох,
- Шилжих хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэлтэй холбоотой журамд шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах,
- Шилжих хөдөлгөөний талаар хийгдсэн судалгааны ажлыг улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусгах,
- Улс орны хөгжлийн бодлого, төлөвлөлт, төсвийн тогтолцоог бүс нутгийн хөгжлийг дэмжихэд түлхүү чиглүүлж, төвлөрлийг сааруулахад түлхэц өгөх,
- Хөдөө орон нутагт иргэдийн хөдөлмөрөөрөө хорших, хоршоо,

⁶ "Хүн амын шилжих хөдөлгөөний өнөөгийн байдал, чиг хандлага", НХХЯ, НҮБ-ын Хүн амын сан, МУИС-ийн Хүн амын сургалт, судалгааны төв, 2008 он.

нөхөрлөл байгуулан ажиллах арга барилд суралцахад төр, төрийн бус байгууллагын оролцоог дэмжих, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааг энэ чиглэлээр өргөжүүлэх,

- Уугуул иргэдийг шилжих хөдөлгөөнд оролцоход бэлтгэх, шилжих хөдөлгөөнтэй холбоотойгоор гарч болох эрсдлээс хамгаалах, мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах.

Дунд хугацаанд:

- Хот, хөдөөгийн харилцан хамаарал, сонирхлыг нэгтгэх, хот хөдөөгийн хөгжлийг түргэтгэхэд гол нөлөө үзүүлэгч худалдааны сүлжээ бий болгох талаар судлан, хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусгах,

- Хөдөө орон нутгийн онцлог, давуу талыг харгалзсан орон нутгийн хөгжлийн стратеги боловсруулах, хэрэгжүүлэх, санхүүгийн эх үүсвэрийг зарцуулах эрх мэдлийг өгөх,
- Шилжин суурьшигч ихтэй суурьшлын бүсэд сургууль, цэцэрлэг, өрхийн эмнэлэг байршуулах боломжийг судалж, хэрэгжүүлэх,
- Хувь хүн өөрийн чадавхийг сайжруулах, мэргэжилтэй болох, нөөц боломжоо ашиглах, хөдөлмөрлөх, идэвх, санаачлагатай, хүн бүр зүтгэл гаргах, өөрөө өөрийгөө хөгжүүлэх боломжийг бүрдүүлэхэд төр засгаас дэмжлэг үзүүлэх, иргэний хариуцлагыг дээшлүүлэх, олон нийтийн оролцоотой хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг өргөжүүлэх, хувийн хэвшлийнхнийг татан оролцуулах.



ЗОРИЛГО 2

**БҮХ НИЙТЭЭР АНХАН ШАТНЫ
БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ**

Зорилт 5: 2015 он гэхэд бүх хүүхдэд бага боловсрол олгох**Өнөөгийн байдал, хандлага**

Монгол Улсын анхан шатны боловсролын хамран сургалтын цэвэр жин сүүлийн жилүүдэд харьцангуй тогтвортой байж, 2006-2007 онд 91.4 хувиас 92.7 хувь болж өссөн хэдий ч 2008 онд 91.5 хувь болж буурчээ (Хүснэгт 5). Энэ үзүүлэлт нь дэлхийн дундаж үзүүлэлттэй ойролцоо бөгөөд хөгжиж байгаа

орнуудын дунджаас 3.5 пунктээр илүү, Зүүн Азийн бүс (Хойд, Өмнөд Солонгос, БНХАУ, ХонгКонг, Макао, Монгол)-ийн орнуудын дунджаас 2.5 пунктээр доогуур байна. 2008-2009 оны хичээлийн жилд хамран сургалтын жин буурсан нь ЕБС-ийг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэх хөтөлбөрийн дагуу 6 настай хүүхдийг 1 дүгээр ангид элсүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 5. Бага боловсролын хамран сургалт, 1-5 дугаар анги хүртэл суралцагчид, бичиг үсэг тайлагдалт

	Шалгуур үзүүлэлт	1990	2000	2006	2007	2008	2015
11	Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин	97.5 ^a (1995)	95.0 ^a	91.4 ^a	92.7 ^b	91.5 ^b	100.0 ^a
12	Нэгдүгээр ангид элсэн ороод 5 дугаар анги хүртэл суралцагчдын хувь	91.0 ^a	83.6 ^a	86.8 ^a	89.9 ^b	92.8 ^b	100.0 ^a
13	15-24 насны залуусын бичиг үсэг тайлагдалтын хувь	99.0 ^b (1989)	97.7 ^b	97.7 ^b (2000)	97.7 (2000)	97.7 (2000)	100.0 ^a

Эх үүсвэр: а. УИХ-ын тогтоол #13, Монгол Улсын МХЗ-уудыг батлах тухай, 2008

б. УСХ, БСШУЯ, 2008

в. Монгол Улсын хүн ам, орон сууцны тооллого, 1989, 2000

Өрхийн амьжиргааны байдал нь хүүхдийн боловсрол эзэмшихэд сөргөөр нөлөөлж байгаагийн зэрэгцээ хөдөө, орон нутгийн хүн амын суурьшлын нягтрал бага, тархай байдал нь бага боловсролын хамран сургалтын цэвэр жинг нэмэгдүүлэхэд бэрхшээл учруулсаар байна. Бага сургуулийн нийт суралцагчдын 44.2 хувь нь ядуу өрхөд амьдарч байна. Үүнээс 22.7 хувь нь эрэгтэй, 21.6 хувь нь эмэгтэй сурагч байна. Хөдөө, орон нутгийн бага ангийн нэг сурагчийн нэг сард ногдох зардал ядуу өрхөд 4,000 орчим төгрөг байгаа нь бусад өрхөөс даруй 2 дахин бага байна⁷. ЕБС-ийн бага ангиас тухайлбал, 1-2 дугаар ангиас сургууль завсардах, анги улирах байдал төдийлөн буурахгүй байна. Сургуулийн гадна 6-15 насны 37.0 мянга шахам хүүхэд байгаа нь 2015 он гэхэд бүх нийтэд бага боловсрол эзэмшүүлэх зорилт хугацаандаа бүрэн хэрэгжих бололцоог хязгаарлагдмал болгож байна. Иймд шаардлагатай арга

хэмжээг шат дараатай цаг алдалгүй хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

1 дүгээр ангиас 5 дугаар анги хүртэл суралцагчид 2006 онд 86.8 хувь байсан бол 2008 онд 92.8 хувь болж өссөн байна. Засгийн газраас цогц арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд сургуулийн өмнөх боловсрол (СӨБ)-д хамрагдалт 14.2 хувь, цэцэрлэгт хамрагдалт 13.2 хувиар тус тус нэмэгдсэн байна. Улсын хэмжээнд 502 дотуур байранд 42.1 мянган хүүхэд амьдарч байна. Дотуур байрны хүчин чадал 37.8 мянган ор байгаатай харьцуулбал сургуулийн дотуур байр нь өөрийн хүчин чадлаасаа 11.2 хувиар давсан хүүхдийг байрлуулж байна.

Албан бус мэдээгээр бичиг үсэг үл мэдэгчдийн тоо 2007 онд 11.7 мянга байсан бол 2008 оны байдлаар 15 болон түүнээс дээш насны 11.1 мянган хүн, үүнээс эрэгтэй 6.3 мянган, эмэгтэй 4.9 мянган хүн байна. Үндэсний түвшинд бичиг үсгийн анхан шатны 3 цуврал, бичиг

⁷ Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа 2007-2008

үсгийн дараахь сургалтын 20 гаруй материал боловсруулан түгээжээ. 2008 онд бичиг үсгийн сургалтад 6,254 хүн хамрагдсан нь нийт бичиг үсэг үл мэдэгчдийн 56 хувь болж байна.

Албан бус боловсрол (АББ)-ын төвүүдэд явагддаг хүн амын боловсролын ерөнхий түвшинг дээшлүүлэх сургалтын нэр, төрөл, хамрагдсан хүний тоог тодорхойлон Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу бүтээгдсэн Монгол Улсын Үндэсний атласт “Бичиг үсэг үл мэдэгч” гэсэн үзүүлэлтийг шинээр тусгажээ.

Хүн амын бичиг үсгийн боловсролын түвшний судалгааны үр дүнг АББЗСҮТ-өөс жил бүр гаргадаг бөгөөд бичиг үл мэдэгчдийн тоо жилд 2.0-3.0 мянгаар буурч байна.

Дэмжих орчин

Сургуульд огт суралцаагүй болон сургууль завсардсан хүүхдийн суралцах сонирхлыг дэмжих, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хэвийн аюулгүй орчны стандартыг бүрдүүлэх, сурах бичгийн хангалтыг сайжруулах чиглэлээр Их Британийн Хүүхдийг Ивээх сан, ОУХБ, АХБ, Нордикийн хөгжлийн сангийн техникийн болон санхүүгийн тусламжаар хөтөлбөр, төслүүд хэрэгжүүлж байна. Эдгээр хөтөлбөр, төслийг хэрэгжүүлснээр сургууль, цэцэрлэгийн суудлын болон дотуур байрны орны тоо нэмэгдэж, хүүхдийн сурч, амьдрах орчин сайжирч, сургалтад шинэ технологи нэвтрэх техник, технологийн орчин бүрдэж, сургууль завсардалт бууруулахад чухал нөлөө үзүүлж байна.

Сургуулийн өмнөх боловсрол (СӨБ)-ын үйлчилгээний хүртээмж, аюулгүй орчны стандартыг бий болгох хүрээнд Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг 2008 онд УИХ-аар батлуулав. ЕБС-ийн “Үдийн цай” Үндэсний хөтөлбөрийг 2006 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2008 оны эцэст 1-5 дугаар ангийн нийт 239.8 мянган хүүхдийг хамруулжээ. “Хүүхэд бүрт компьютер” төслийн хүрээнд 2-5 дугаар ангийн сурагч, багш нарт компьютер түгээх, зөөврийн компьютерийг ашиглах сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, хөдөөд 6,900 ширхэг, нийслэлд 12,800 ширхэг компьютерийг түгээлээ.

ДБ-ны дэмжлэгтэйгээр “Үр дүнд түргэн хүргэх санаачилгын түншлэл” төслийг 2008 онд хэрэгжүүлж, 20 аймгийн 21 суманд тус бүр нь 4,000 ам.долларын өртөгтэй 150 гэр цэцэрлэг барьж, иж бүрэн тавилга, тоног төхөөрөмжөөр хангалаа. Ингэснээр өмнө нь цэцэрлэгт хамрагдаж чадаагүй байсан хөдөө, орон нутгийн 3,750 хүүхэд СӨБ-ын үйлчилгээг авч байна.

Шигтгээ 2. Сургалтын шинэ тогтолцоо

Хүүхэд багачуудыг зургаан настайгаас нь боловсролын зохих үйлчилгээнд хамруулах нь дараа, дараачийн шатны сургалтад амжилт гаргах нөхцөл бололцоог бүрдүүлдэг нь судалгаагаар нотлогдсон байдаг. Тиймээс Монгол Улс 2015 он гэхэд Мянган Хөгжлийн үндэсний зорилгод заасанчлан хүүхдүүдийг бага боловсролд бүрэн хамруулахын тулд хүүхэд багачуудад сургуулийн өмнөх чанартай боловсрол эзэмшүүлэхэд анхаарч ажиллах явдал чухлаар тавигдаж байна.

Улсын Их Хурлын 2006 оны 89 дүгээр тогтоолоор ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлж, 6 настай хүүхдийг сургуульд элсүүлэхээр шийдвэрлэсэн. Ийнхүү манай улс 2008-2009 оны хичээлийн жилээс ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлж, 6 настай 36,659 хүүхдийг сургуульд элсүүлэн сургасан нь түүхэнд нэгэн шинэ хуудсыг нээсэн юм.

Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлснээр ерөнхий боловсролын баримт бичгийг хүлээн зөвшөөрөлтөх, улмаар Монгол Улсад ерөнхий боловсролын сургууль төгсөгчид гадаадын улс орнуудын их, дээд сургуульд суралцахад тохиолдож байсан бэрхшээл арилах болно. Мөн 6 настай хүүхдийг сургуульд элсүүлэн сургадаг олон улсын жишгийн дагуу хөгжил нь эрчимтэй явагддаг бага насанд нь тэдний сурч, хөгжих эрхийг хангахад сургуулийн бүтцийн энэхүү өөрчлөлт чухал ач холбогдолтой.

Эх үүсвэр: БСШУЯ

Боловсролын шинэ стандартын шаардлага хангасан ерөнхий боловсролын 11 жилийн сургуулийн бүх ангид үзэх хичээлийн сурах бичгийг 2005-2008 онд бүрэн шинэчилж дуусаад байна. Түүнчлэн 12 жилийн сургалттай ЕБС-ийн 1 болон 2 дугаар ангийн бүх сурах бичгийг шинэчилсэн бөгөөд бага боловсролын сурах бичгийн хангалтыг бүрэн хийж, дунд боловсролын сурах бичгийн хангалтын 40 хувийг сургуулийн номын сангаар дамжуулан үнэ төлбөргүй хэрэглүүлж байна.

Дотуур байрны хангамжийг сайжруулж сургууль завсардсан, хөдөөгийн алслагдмал сумдын сурагчдын сурах сонирхолыг нэмэгдүүлэх хүрээнд 2008 онд боловсролын салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр 340 ор бүхий 3 дотуур байрыг ашиглалтанд оруулав. АХБ-ны зээлийн хөрөнгө, Их Британийн Хүүхдийг ивээх сан, ДБ-ны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр ЕБС-

ийн 22 хичээлийн байр, 21 дотуур байрны их засварын ажил гүйцэтгэсэн байна.

Боловсролын салбарт “Бичиг үсгийн Үндэсний хөтөлбөр”, “Монгол бичгийн Үндэсний хөтөлбөр-2”, “Зайны сургалтын Үндэсний хөтөлбөр” хэрэгжиж байна. Олон улсын стандартад нийцсэн бичиг үсгийн түвшинг тогтоох шалгуур үзүүлэлт боловсруулах ажил ЮНЕСКО-ийн Бичиг үсэг тайлагдалтын хяналт-шинжилгээ, үнэлгээний хөтөлбөр (LAMP)-ийн хүрээнд зарим аймагт судалгаа хийгдсэн.

Тулгамдсан асуудал

ЕБС-ийн 1 болон 2 дугаар ангиас сургууль завсардах, анги улирах явдал төдийлөн буурахгүй байгаа нь бичиг үсэг үл мэдэгчдийн тоог бууруулахад саад болох төдийгүй бүх нийтэд бага боловсрол эзэмшүүлэх зорилт хугацаандаа бүрэн хэрэгжихгүйд хүргэж болзошгүй байна.

Бичиг үсгийн боловсролгүй хүн амын тоог нарийвчлан гаргах мэдээллийн тогтолцоо үгүйлэгдэж байна. ЕБС-ийн суралцагчдын сургууль завсардалт, шилжилт хөдөлгөөнийг хянах, зохицуулах удирдлагын мэдээллийн систем байхгүй байгаа нь бага, дунд боловсролын хамран сургалтын цэвэр жин дорвитой өсөхгүй байх үндэс болж байна. Сурах бичгийн хүрэлцээ дутмаг хэвээр байгаа нь сургалтын чанарыг сайжруулахад сөргөөр нөлөөлж байна.

Алслагдсан хөдөө орон нутгийн малчин өрхийн бага насны хүүхдүүдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулах нь боловсролын салбарын тулгамдсан асуудлын нэг юм. Хөдөөгийн сургуулийн дотуур байрны хангамж, үйлчилгээ шаардлагын хэмжээнд хүрэхгүй, ачаалал даахгүй хэвээр байна.

Цаашдын зорилт

Ойрын хугацаанд:

- Хот, хөдөөгийн болон хотын төв, захын хорооллын боловсролын үйлчилгээний ялгааг арилгах,
- Боловсролын чанарын үнэлгээний оновчтой, үр ашигтай тогтолцоог бүрдүүлэх,
- Боловсролын мэдээллийн бодит үнэн, найдвартай байдлыг дээшлүүлж, мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах шинэ арга зүй, технологийг нэвтрүүлэх,
- Хүүхдийг зохих насанд нь сургуульд бүрэн элсүүлэх, эмзэг бүлгийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургууль, цэцэрлэгт бүрэн хамруулахад дэмжлэг үзүүлэх,

- Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд 2-5 насны хүүхдийг бүрэн хамруулж, сургуульд элсэх бэлтгэлийг хангах,
- Сурагч бүрийг хичээлийн сурах бичгээр хангах арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх.

Дунд хугацаанд:

- Ерөнхий боловсролын сургуулийн бүтэц, хэв шинж, байршлын зураглалыг гаргаж, сургуулийн хэв шинж, байршлыг оновчтой тогтоох,
- Бага боловсролын агуулгын стандарт, сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, үйлчилгээний болон орчны стандартыг боловсруулан хэрэгжүүлэх,
- Бага боловсролын багш нарын мэргэжил, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх тогтолцоог боловсронгуй болгох, бага боловсролын сургалтын чанар, үр дүнг дээшлүүлэх,
- Төрөөс ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг сурах бичгээр хангах ажлыг үргэлжлүүлж, сурах бичгийн агуулга, чанарыг сайжруулах,
- Аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газрын удирдлага, ажилтнуудын менежментийн болон мэргэжил, арга зүйн чадварыг нэмэгдүүлэх.

Урт хугацаанд:

- Боловсролын байгууллагын чадавхийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээ авах,
- Бага ангиас сургууль завсардах явдлыг зогсоож, бичиг үсэггүй хүүхэд, залуучуудын бий болох нөхцөлийг багасгах,
- Боловсролын мэдээллийн бодит, үнэн, найдвартай байдлыг дээшлүүлэх,
- Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах шинэ арга зүй, технологи нэвтрүүлэх,
- Хот, хөдөөгийн боловсролын үйлчилгээний ялгаа, тэгш бус байдлыг багасгаж, хөдөөгийн сургууль, цэцэрлэгийн сургалтын орчин, дотуур байрны нөхцөл, үйлчилгээний чанарыг сайжруулах,
- Бичиг үсэг үл мэдэгч болон бага мэдэгчдийг бичигтэн болгохын зэрэгцээ тэднийг амьдрах арга ухаанд сургах, амьжиргааны түвшингээ дээшлүүлэхэд нь туслах зорилготой сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх,
- Боловсролын чанарын үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх.



ЗОРИЛГО 3

**ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ
ДЭМЖИН ХӨГЖҮҮЛЖ, ШИЙДВЭР
ГАРГАХ ТҮВШИНД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН
ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ**

Зорилт 6. 2009 он гэхэд бага болон дунд боловсрол эзэмшигчдийн дунд, 2015 он гэхэд бүх шатны боловсролын байгууллагад суралцагчдын хүйсийн зохистой харьцааг хангах

Өнөөгийн байдал, хандлага

Улс орны хөгжил дэвшилд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эрх тэгш оролцоог хангаж, тэднийг нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх таатай орчинг бүрдүүлэх нь хүн амын амьдралын чанарыг сайжруулах, нийгэм дэх сөрөг үзэгдлийг арилгахад ихээхэн ач холбогдолтой юм.

1990-ээд оны эхэн үеийн эдийн засгийн шилжилтийн байдал нь боловсролын салбарт таагүй нөлөө үзүүлсэн хэдий ч сүүлийн үед энэ байдал сайжрах хандлагатай байна.

Анхан шатны боловсрол эзэмшиж байгаа хүүхдүүдийн хүйсийн харьцаа 2000 онд 1.01

байсан бол 2008 оны байдлаар 0.97, дунд боловсрол эзэмшиж байгаа хүүхдүүдийн хүйсийн харьцаа 1.2 байсан бол 1.08 болж хүйсийн харьцаа харьцангуй тэнцвэртэй болох хандлагатай байна. Харин ахлах ангийн сурагчдын хүйсийн ялгаа ихэсч энэ байдал гуравдагч шатны сургуульд элсэгчдийн дунд хэвээр хадгалагдаж байна (Хүснэгт 6).

2007-2008 оны хичээлийн жилд нийт 150.3 мянган оюутан, 2008-2009 оны хичээлийн жилд нийт 161.1 мянган оюутан төрийн болон хувийн өмчийн, их дээд сургууль, коллежид суралцаж байна. Дээд боловсрол эзэмшиж байгаа хөвгүүдийн тоо болон хувийн жин нэмэгдэж байна.

Хүснэгт 6. Бага, ерөнхий болон дээд боловсрол эзэмшигчдийн хүйсийн харьцаа

	Шалгуур үзүүлэлт	1990	2000	2006	2007	2008	2015
14	Бага боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа	1.03 ^a (1995)	1.01 ^a	0.98 ^a	0.97 ^b	0.97 ^b	1.0 ^a
15	Ерөнхий боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа	1.33 ^a (1997)	1.2 ^a	1.03 ^a	1.09 ^b	1.08 ^b	1.0 ^a
16	Дээд боловсрол эзэмшиж байгаа эмэгтэй, эрэгтэйчүүдийн тооны харьцаа	1.56 ^a	1.72 ^a	1.53 ^a	1.57 ^b	1.54 ^b	1.0 ^a

Эх үүсвэр: а. УИХ-ын тогтоол #13, Монгол Улсын МХЗ-уудыг батлах тухай, 2008

б. ҮСХ, БСШУЯ, 2008

Дээд боловсрол эзэмшихээр 2000 онд суралцаж байсан оюутнуудын 36.8 хувь нь эрэгтэйчүүд байсан бол 2005 онд 39.5 хувь, 2008 онд 39.9 хувь болж өслөө. 2008 онд нийт суралцагчдын 60.1 хувь нь эмэгтэй суралцагчид байна. Нийт суралцагчдын 90.1 хувь нь бакалаврын, 5.9 хувь нь магистрын, 1.4 хувь нь докторантурын, 2.6 хувь нь дипломын дээд боловсрол олгох түвшинд суралцаж байна. Сурах хэлбэрийн хувьд

өдрийн ангид суралцагчид нийт суралцагчдын 90.5 хувийг, оройн ангид 3.9 хувийг, эчнээгээр 5.6 хувийг эзэлж байна.

2007-2008 онд их, дээд сургууль, коллеж төгсөгчдийн 65.5 хувь нь эмэгтэйчүүд байна. 2007 онд дээд боловсролын сургалтын байгууллага төгсөгчдийн 35.5 хувь нь ажил эрхэлж байна.

Дэмжих орчин

Засгийн газраас жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэхэд ихээхэн анхаарал хандуулж байна. Монгол Улсын Үндсэн хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоороо иргэн бүр сурч боловсрох тэгш эрхтэйг баталгаажуулж, төрөөс ерөнхий боловсролыг бүх нийтэд төлбөргүй олгож байна. Энэ харилцааг Монгол Улсын боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль болон Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулиар зохицуулж байна.

Засгийн газраас Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих Үндэсний хөтөлбөр (2007-2015) батлан хэрэгжүүлж, өсвөр үе, залуучуудын сонголтыг хүндэтгэн, тэдэнд ялгаварлалгүй, тэгш, цогцоор хандах таатай орчинг бүрдүүлэх зарчим баримталж байна.

Төрийн албан хаагчийн гэр бүлээс их, дээд сургуульд суралцаж байгаа нэг оюутны сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлж, дотоодын болон гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад төрийн буцалтгүй тусламж, зээл олгох асуудлыг зохицуулах эрх зүйн орчинг бүрдүүлж, хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын төсөвт тусган Сургалтын төрийн сангаар дамжуулан хэрэгжүүлж байна.

Тулгамдсан асуудал

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл дээрх ажлын байрны хэрэгцээний 60-70 хувийг мэргэжилтэй ажилтны захиалга эзэлж байна. Гэтэл 2004 оны байдлаар дээд болон мэргэжлийн боловсрол эзэмшсэн залуучуудын 71.4 хувь нь их, дээд сургууль, 28.6 хувь мэргэжлийн сургалт, техникийн боловсролын сургуулийг төгсөж байжээ. Сургууль төгсөгчдийн 59.0 хувь нь эрх зүй, сэтгүүлч, эдийн засаг, санхүү зэрэг нийгэм, хүмүүнлэгийн салбарт, 3.0 хувь нь ХАА-н чиглэлийн мэргэжил эзэмшсэн бол манай улсын эдийн засгийн бүтцийн 23.3 хувийг ХАА, 50.1 хувийг үйлчилгээ, 26.6 хувийг аж үйлдвэрийн салбар бүрдүүлж байна.

Үндэсний мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэж байгаа өнөөгийн байдал нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, эдийн засгийн бүтэц, онцлогтойгоо тэр бүр тохирохгүй байна. Цаашид мэргэжлийн боловсролын

сургуулиудын үйл ажиллагааг үндэсний үйлдвэрлэл, технологийн хөгжлийг дэмжих, үндэсний эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй нийцүүлэхэд төрийн оролцоо, зохицуулалтын үүргийг нэмэгдүүлэх, бодлогоор нөлөөлөх стратегийг хэрэгжүүлэх нь боловсролын төдийгүй эдийн засгийн өсөлтийг хангах үндэсний стратегийн чухал бүрэлдэхүүн хэсэг болж байна.

Өнөөгийн байдлаар дээд боловсролтой төгсөгчдийн ажил эрхлэлтийн түвшин 35.5 хувь байна. Төгсөгчдийн 34.2 хувь мэргэжлээрээ ажиллахгүй гэсэн сонирхолтой байгаагийн зэрэгцээ хүн амын ядуу хэсэгт дээд боловсролтой иргэд 25.5 хувийг бүрдүүлж байгааг анхаарч үзэх асуудал болоод байна.

Цаашдын зорилт

Ойрын хугацаанд:

- Инженер, технологи, байгалийн шинжлэл, багш, ХАА-н чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг сургуулиудын сургалтын орчныг сайжруулахад дотоод, гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламжийг нэмэгдүүлэх,
- Бүх шатны боловсролын хөтөлбөрийн агуулгыг жендэрийн мэдрэмжтэй болгох, хөвгүүдийн боловсролын түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх,
- Төрийн болон төрийн бус өмчийн боловсролын бүх шатны байгууллага, багш, суралцагчдын сургалт, хүмүүжил, хөдөлмөрийн харилцаанд адил, тэгш оролцуулах соёлыг хэвшүүлэх,
- Инженер, технологи, байгалийн шинжлэл, багш, хөдөө аж ахуйн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг сургуулиудын сургалтын орчинг сайжруулахад дотоод, гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжийг нэмэгдүүлэх,
- Техникийн боловсрол, мэргэжлийн сургалт, дээд боловсролын чанар болон хамран сургалтын төлөвлөлт, зохицуулалтыг сайжруулах,
- Өндөр хөгжилтэй орнуудад оюутан суралцуулах нээлттэй боломжийг бүрэн ашиглах, зээлийн эргэн төлөлтийн бодлогыг боловсронгуй болгох,

- Хөдөлмөрийн зах зээлийн бодлогод жендэрийн асуудлыг тусган хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэх,
- Сургалтын төрийн сангийн зээлийн тогтолцооны хууль эрх зүйн орчинг сайжруулах,
- Элсэлтийн ерөнхий шалгалтын агуулга, технологийг шинэчилж, элсэгчдийн сурах чадварыг шалгахад чиглүүлэх
- Оюутанд хөнгөлөлттэй үйлчлэх үйлчилгээний хүрээг өргөжүүлэх.

Зорилт 7. Цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын жендэрийн тэгш байдлыг хангах

Өнөөгийн байдал, хандлага

ХАА-гаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын дотор эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн харьцаа ойролцоо байна. Энэ үзүүлэлт 2008 онд 53.0 хувь байгаа нь 1990 оныхоос 1.9 пунктээр өсч, харин 2007 оныхоос 0.1 пунктээр буурсан байгаа нь хэрэгжилт тогтвортой бус байгааг харуулж байна. Хэдийгээр 2015 оны зорилтыг хангаж байгаа боловч энэ хандлага цаашид үргэлжилбэл хүйсийн тэнцвэрт байдал алдагдах магадлалтай юм (Хүснэгт 7). Харин Баруун

болон Төвийн бүс улсын дунджаас доогуур үзүүлэлттэй байна.

ХАА-гаас бусад салбарт ажиллаж байгаа эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эзлэх хувийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар үзвэл эмэгтэйчүүд боловсрол, эрүүл мэнд, зочид буудал, зоогийн газар, бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн засвар үйлчилгээний зэрэг нийгмийн салбарт, харин эрэгтэйчүүд төрийн удирдлага, батлан хамгаалах, уул уурхайн олборлох аж үйлдвэрлэл зэрэг салбарт түлхүү ажиллаж байна.

Хүснэгт 7. ХАА-гаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь, 2003-2008

	ХАА-гаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь					
	2003	2004	2005	2006	2007	2008
Улсын дундаж	51.1	53.1	53.1	53.9	53.1	53.0
Баруун бүс	50.6	51.5	51.4	53.0	52.5	51.1
Хангайн бүс	52.7	52.4	53.6	52.9	52.8	52.2
Төвийн бүс	50.9	50.8	52.3	51.6	52.3	51.7
Зүүн бүс	52.9	53.6	52.8	54.0	53.5	52.4
Улаанбаатар	50.6	54.1	53.4	54.9	53.3	53.7

Эмэгтэйчүүд зонхилсон салбарт эрэгтэйчүүд өндөр цалин авч байгаа нь албан тушаалын эрэмбээр тухайн салбарт эрэгтэйчүүд удирдах, эмэгтэйчүүд гүйцэтгэх түвшинд ажиллаж байгаагаар холбоотой юм⁸.

2006-2007 оны ажиллах хүчний судалгаагаар эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин улсын дунджаар 67.5 хувь, эмэгтэйчүүдийнх 58.3 хувьтай байна.

⁸ Зохистой хөгжил, жендэр төв, "Монгол улсын МХЗ-уудыг жендэрийн үзэл баримтлалд тулгуурлан шинжлэх нь" судалгааны тайлан, 2008 он

Эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 11.4 хувь, эрэгтэйчүүдийнх 11.2 хувьтай байгаа нь хөдөлмөрийн зах зээлд ажил эрхлэх боломж эрэгтэйчүүдэд арай илүү байгааг харуулж байна.

Эмэгтэй ажиллах хүчинд зориулсан ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийн сургалт хоцрогдож байгаа төдийгүй шинээр бий болж байгаа ажлын байрууд нь эрэгтэйчүүдэд түлхүү чиглэж байна.

Албан бус салбарт ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн тоо, мэдээлэл хангалтгүй

байгаа нь хөдөлмөрийн зах зээл дэх эмэгтэйчүүдийн бодит оролцоог үнэлэхэд хүндрэл учруулж байна (Хүснэгт 8).

Дэмжих орчин

Монгол Улсад хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх асуудлыг Төрөөс албан хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого,

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Үндэсний хөтөлбөр зэрэг бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлж байна. Түүнчлэн Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөр, Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого болон Гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлогод хөдөлмөрийн харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангах асуудлыг тусгасан байна.

Хүснэгт 8. ХАА-гаас бусад салбарт ажиллаж байгаа эрэгтэй, эмэгтэйчүүдийн эзлэх хувь, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, 2008

	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа	0.6	0.6	0.6
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй	1.2	1.3	1.0
Нийгэм, бие хүнд үзүүлэх үйлчилгээ	3.0	3.2	2.8
Эрүүл мэнд, нийгмийн халамж	6.4	4.4	8.1
Боловсрол	10.0	6.9	12.7
Төрийн удирдлага, батлан хамгаалах, нийгмийн даатгал	7.7	9.3	6.2
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнес	1.8	1.9	1.8
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	3.0	2.5	3.4
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	7.0	9.7	4.6
Зочид буудал, зоогийн газар	5.2	3.8	6.4
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн засвар үйлчилгээ	25.5	21.4	29.2
Барилга	10.1	12.2	8.1
Цахилгаан, хийн үйлдвэрлэл, ус хангамж	4.5	5.8	3.4
Боловсруулах аж үйлдвэр	7.0	7.3	7.0
Уул, уурхайн олборлох аж үйлдвэр	7.0	9.6	4.7

Эх үүсвэр: Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан, 2008

Тулгамдсан асуудал

Монгол Улсад эмэгтэйчүүд ХАА, худалдаа, үйлчилгээ, нийгмийн салбарт олноор ажиллаж байгаа нь ажил эрхлэлтийн түвшинг өндөр мэт харагдуулж байгаа хэдий ч орлого нь эрэгтэйчүүдийнхээс бага байна. Цаашид эрүүл мэнд, боловсрол зэрэг эмэгтэйчүүд давамгайлсан салбаруудад жендэрийн зохистой харьцааг бий болгох замаар уул уурхай, аялал жуулчлал, ноос ноолуур, банк, санхүү зэрэг салбаруудад өндөр цалин, таатай орчин, уян хатан цагтай ажил эрхлэх нөхцөлийг эмэгтэйчүүдэд бүрдүүлэх хэрэгтэй байна.

Боловсролын түвшнээс хамаарч эмэгтэйчүүдийн ажил эрхлэх боломж ялгаатай байхын зэрэгцээ өндөр боловсролтой эмэгтэйчүүд мэргэжлийнхээ ажлыг хийгээгүй, эсвэл бага цалинтай салбарт ажиллах нь түгээмэл байна.

Манай улсад гэрийн ажил, үр хүүхдээ асрах, хүмүүжүүлэх нь зөвхөн гэр бүлийн эмэгтэй гишүүний үүрэг гэсэн ойлголт давамгайлсан хэвээр байгаа бөгөөд түүнчлэн ажлын байран дахь эмэгтэйчүүдэд үзүүлэх дарамт далд хэлбэртэй байсаар байна.

Хүйсээр ангилсан тоо мэдээлэл хэт ерөнхий, бодит мэдээлэл хангалтгүй байгаагаас жендэрийн тэгш байдлыг хангах эцсийн үр

дүнг илүү бодитой тооцоход хүндрэлтэй байна.

Цаашдын зорилт

Ойрын хугацаанд:

- Эмэгтэйчүүдэд зориулсан ажлын байрыг нэмэгдүүлэхдээ цагийн ажлын системийг нэвтрүүлэх,
- Бага боловсролтой эмэгтэйчүүдийг хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй салбаруудад ажиллах боломжийг нэмэгдүүлэх, нарийн мэргэжил олгох, орчин үеийн техник технологи бүхий ажлын байруудыг хөгжүүлэх,
- Эмэгтэйчүүдэд техникийн нарийн мэргэжил эзэмших боломжийг дэмжих,

эмэгтэйчүүдэд мэргэжлийн боловсрол олгох боломжийг нэмэгдүүлэхийн тулд багш, дадлагажуулагчдыг чадваржуулах, сургалтын болон дадлагын техник хэрэгслийг зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн түвшинд хүргэх,

- Статистик тоо, мэдээллийг жендэрийн мэдрэмжтэй болгох ажлыг арга зүй, мэргэжлийн хувьд дэмжих.

Дунд болон урт хугацаанд:

- Хүйсийн харьцааны талаархи олон нийтийн хэвшмэл хандлагыг өөрчлөх,
- Хөдөлмөрийн харилцааг зохицуулах жендэрийн мэдрэмжтэй шинэ эрх зүйн орчин, хууль тогтоомж боловсруулж хэрэгжүүлэх.

Зорилт 8. Улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх

Өнөөгийн байдал, хандлага

Монгол Улсын хувьд шилжилтийн жилүүдэд эмэгтэйчүүд эдийн засаг, нийгэм, улс төрийн амьдралд оролцох оролцоо сайжирсан хэдий ч шийдвэр гаргах, удирдах албан тушаалд тэдний эзлэх хувийн жин төдийлөн нэмэгдэхгүй байна.

Монголын эмэгтэйчүүд улс төрийн удирдах түвшинд оролцох оролцоо буурсан гажуудлыг арилгах зорилгоор Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөрт эмэгтэйчүүдийн төлөөллийг улс төрийн удирдах болон шийдвэр гаргах түвшин, түүнчлэн төрийн албан дахь

удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх чиглэлээр тусгасан боловч өнөөдөр улс төрийн шийдвэр гаргах үйл явцын бүх шатанд эмэгтэйчүүдийн оролцоо доогуур байна.

Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү өндөр боловсрол эзэмших болсон боловч удирдах болон шийдвэр гаргах түвшний албан тушаал дээр эмэгтэйчүүдийн төлөөлөл цөөхөн хэвээр байна. УИХ-д нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь 1992 онд 8.0 байсан бол 2004 оны сонгуулиар 13.7, 2008 оны сонгуулиар 18.5 болж өссөн нааштай үзүүлэлт гарлаа (Хүснэгт 9).

Хүснэгт 9. Улсын Их Хуралд сонгогдсон, нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь

		1990	2000	2006	2007	2008	2015
18	Улсын Их Хуралд сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь	24.9 ^a	11.8 ^a	6.6 ^a (2004)	6.6 ^b	3.9 ^b	30.0 ^a
19	Улсын Их Хуралд нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь	7.7 ^a (1992)	10.9 ^a	13.7 ^a (2004)	13.7 ^b (2004)	18.5 ^b	30.0 ^a (2012)

Эх үүсвэр: а. УИХ-ын тогтоол #13, Монгол Улсын МХЗ-уудыг батлах тухай, 2008
б. СЕХ, ҮСХ, 2008

1992 оны сонгуулиар Улсын Их Хуралд сонгогдсон нийт гишүүдийн дотор эмэгтэйчүүд 3.9 хувийг эзэлж байсан бол 1996 оны сонгуулиар 9.2 хувь, 2000 оны сонгуулиар 11.8 хувийн төлөөлөлтэй болж өсөх хандлагатай байсан ч 2004 оны сонгуулиар 6.6 хувь, 2008 оны

сонгуулиар 3.9 хувь болж буурчээ. УИХ-ын 1992-2008 оны сонгуулийн дүнгээс үзэхэд сонгогдсон эмэгтэй гишүүдийг нэр дэвшсэн эмэгтэй гишүүдтэй харьцуулахад эмэгтэй нэр дэвшигчийн эзлэх хувь байнга өсч, харин сонгогдсон эмэгтэйчүүдийн хувь буурсан үзүүлэлт гарчээ.

Дэмжих орчин

УИХ-аас Сонгуулийн тухай хуульд шатны сонгуульд нийт нэр дэвшигчдийн 30 хувь нь эмэгтэй нэр дэвшигчид байна гэсэн нэмэлт, өөрчлөлт оруулсан хэдий ч энэхүү нэмэлт, өөрчлөлтөө цуцалсан нь жендэрийн тэгш байдлыг хангах хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд маш том ухралт болсон.

Түүнчлэн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх таатай орчин бүрдүүлэхэд нилээд хугацаа шаардагдах нь сүүлийн 2 удаагийн УИХ-ийн сонгуулийн дүнгээс харагдаж байна. Энэ нь нийгэмд жендэрийн үүрэг, хариуцлагыг хэвшүүлэх нийгэм, сэтгэл зүйн чиг хандлага төлөвшиж чадахгүй байгаагийн нэг илрэл юм.

Улс төр, эдийн засаг, нийгмийн харилцаанд тэгш байдлыг хангахын тулд жендэрийн тэгш байдлыг хангах асуудлаар бие даасан хуультай болох, холбогдох хууль тогтоомжийг жендэрийн агуулгаар баяжуулан нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарч байна.

Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэй, эрэгтэйчүүдийн ялгаатай байдлыг арилгахын тулд дэлхийн олон улс орнууд сонгуулийн хуулиар эмэгтэйчүүдийн квот тогтоосон байдлыг судалж хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Тулгамдсан асуудал

Олон улсын түвшинд хэрэглэгдэж байгаа жендэрийн тэгш байдлын хэмжээг үнэлдэг индексийг тооцоход шаардлагатай захиргааны зарим статистик үзүүлэлтийг манайд тодорхойлон гаргах хэрэгтэй байна. Тухайлбал, удирдах албан тушаалд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эзлэх хувь, техникийн болон мэргэжлийн ажилтны дунд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эзлэх хувь зэрэг үзүүлэлтүүд юм.

Улс төрийн болон шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилтын хувьд УИХ-д нэр дэвшигч эмэгтэйчүүдийн квотыг цуцалсан нь 2015 оны зорилтыг хангахад хүндрэлтэй байдлыг бий болгож болзошгүй байна. Улс, орон нутгийн түвшинд улс төр, эдийн засгийн салбарын бодлого боловсруулах шатанд эмэгтэйчүүдийн оролцоо хангалтгүй байна. Сонгуульд өрсөлдөх, нэр дэвшүүлэхэд эмэгтэйчүүдээс үл хамаарах тогтолцооны доголдлыг засахад төрийн болон ТББ-ын хамтын ажиллагааг бодлогоор дэмжих нь чухал байна.

Сонгогчдын боловсролыг дээшлүүлэх, эмэгтэй нэр дэвшигчдийг дэмжих соёлыг төлөвшүүлэх шаардлагатай байна.

Цаашдын зорилт

Ойрын болон дунд хугацаанд:

- Удирдах албан тушаал эрхэлдэг эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн судалгаа хийх,
- Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны талаархи нийгмийн сэтгэл зүйд ноёрхож байгаа сөрөг хандлагыг өөрчлөх чиглэлээр иргэний нийгмийн байгууллагаас гаргаж байгаа санаачилгыг дэмжиж, хамтран ажиллах,
- Ажил эрхлэлт, ялангуяа, шийдвэр гаргах түвшинд ажиллагчдын талаархи статистик мэдээллийг сайжруулах,
- Хүний нөөцийн бодлогод жендэрийн тэгш байдлыг хангах үзэл баримтлалыг тусгах, шийдвэр гаргах түвшинд ажиллах боломжтой эмэгтэйчүүдийн талаархи мэдээллийн санг бүрдүүлэх
- Эмэгтэйчүүдийн сонгуулийн явц, улс төрийн үйл ажиллагаанд оролцохыг хөхиүлэн дэмжих арга механизмыг бүрдүүлэх,
- Удирдах албан тушаалд сонгогдсон болон томилогдсон эмэгтэйчүүдийн мэдлэг, ур чадвар, байр суурь, чадавхийг нь бэхжүүлэх арга хэмжээг тогтмолжуулах,
- Манлайлагч эмэгтэйчүүдийн ололт амжилтыг сурталчлах.

Урт хугацаанд:

- Улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн хууль, эрх зүйн орчинг төгөлдөржүүлэх,
- Улс төр, нийгэм, эдийн засгийн бодлогын шийдвэр, үйл явц үйл явц болон тогтолцоонд нөлөөлөх боломжийг эмэгтэйчүүдэд нээж өгөхийн ач холбогдлын талаар ухуулга, сурталчилгааг бүх түвшинд идэвхтэй өрнүүлэх.



ЗОРИЛГО 4

ХҮҮХДИЙН ЭНДЭГДЛИЙГ БУУРУУЛАХ

4 ХҮҮХДИЙН ЭНДЭГДЛИЙГ БУУРУУЛАХ

Зорилт 9. *Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 4 дахин бууруулах*

Өнөөгийн байдал, хандлага

Монгол Улсын нялхсын болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1990 оноос хойш тууштай буурч ирлээ. 1,000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1990 онд 88.8, нялхсын эндэгдэл 64.4 байсан бол 2006 онд энэ үзүүлэлт 23.2 болон 19.1 болж тус тус буурч 2015 онд хүрэхээр тавьсан зорилтоо 2006 онд хангасан юм. Иймд Монгол Улс хүрсэн амжилтаа улам бататгахын тулд 2015 он гэхэд тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 21.0, нялхсын эндэгдлийг 15.0-д хүргэх шинэ зорилт тавин ажиллаж байна (Хүснэгт 10).

Харин сүүлийн 2 жилийн статистик мэдээгээр 1,000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2007 онд 21.7 болж буурснаа 2008 онд 23.2 болж 1.5 пунктээр, 1,000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 17.6 болж буурснаа 2008 онд 19.4 болж 1.8 пунктээр тус тус өссөн байна (Дүрслэл 10-11). Гэвч 1990-2008 оны хугацаанд тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 3.8 дахин, нялхсын эндэгдэл 3.3 дахин буурсан явцаас харахад 2015 оны зорилтыг хангах боломж гэж үзэж байна.

Хүснэгт 10. Нялхсын болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, вакцинжуулалт


	Шалгуур үзүүлэлт	1990	2000	2006	2007	2008	2015
20	Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1,000 амьд төрөлт тутамд)	88.8 ^a	44.5 ^a	23.2 ^a	21.7 ^б	23.2 ^б	21.0 ^a
21	Нялхсын эндэгдлийн түвшин (1,000 амьд төрөлт тутамд)	64.4 ^a	32.8 ^a	19.1 ^a	17.6 ^б	19.4 ^б	15.0 ^a
22	Улаан бурхны эсрэг вакцинжуулалтад хамрагдсан хүүхдийн хувь	82.3 ^a (1991)	92.4 ^a	98.9 ^a	98.4 ^б	96.9 ^б	99.0 ^a

Эх үүсвэр: а. УИХ-ын тогтоол #13, Монгол Улсын МХЗ-уудыг батлах тухай, 2008
б. ҮСХ, ЭМЯ, 2008


Нялхсын болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2008 онд Улаанбаатар болон төвийн бүсээс бусад бүсүүдэд улсын дунджаас өндөр байна. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн дотор хөдөөгийн болон амьдралын түвшин доогуур, гэр хороололд амьдарч байгаа хүүхдийн өвчлөл, эндэгдэл зонхилох байрыг эзэлж байгаа нь анхаарал татсан асуудал болж байна. Эрчим хүчний төвлөрсөн шугамд холбогдоогүй, дэд бүтэц сул хөгжсөн

баруун бүсийн аймгуудад нялхсын эндэгдэл харьцангуй өндөр байгаа нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг цаг хугацаанд нь авч чадахгүй байгаатай холбоотой. Түүнчлэн хөдөө, орон нутагт төрөхийн өмнөх болон дараахи эмнэлгийн яаралтай тусламжийг цаг тухайд нь авч чадахгүй, эмч, сувилагч нарын мэдлэг, ур чадвар харилцан адилгүй түвшинд байгаа нь нөлөөлж байна.

Дүрслэл 10. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин



Дүрслэл 11. Нялхсын эндэгдлийн түвшин



Дэмжих орчин

Хүүхдийн эндэгдлийн шалтгаанд нарийвчилсан судалгаа, дүгнэлт хийж, холбогдох арга хэмжээ авах зорилгоор бүх аймаг, дүүргийн хүүхдийн мэргэжилтний зөвлөгөөнийг 2007-2008 онуудад зохион байгуулж, тав хүртэлх насны хүүхдийн өвчлөл, эндэгдлийн байдлыг нарийвчлан хэлэлцэж, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөөг орон нутаг бүрийн онцлог, нөхцөл байдалд тохируулан боловсруулж хэрэгжүүлж байна.

Эцэг, эхчүүд, асран хамгаалагчдад эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор аймаг, дүүргийн түвшинд мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулж, зарим аймаг, дүүрэгт хүүхдийн зуны чийрэгжүүлэх зуслан ажиллуулж эмзэг бүлгийн хүүхдийг эхийн хамт амруулж, хүүхдийн хооллолт, арчилгааны талаар сургалтад хамруулсан нь үр дүн өгч байна.

Жирэмсний хяналтыг чанаржуулж, нярайн эндэгдлээс сэргийлэх арга хэмжээг сайжруулах зорилгоор “Жирэмсэн эмэгтэйн хяналтын хөтөч”-ийг Үндэсний хэмжээнд хэрэгжүүлж эхлээд байна. Нялхсын хооллолтын үндэсний стратегийг (2008-2015) олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж хэрэгжүүлж эхлээд байна.

Шигтгээ 3. Хамтын ажиллагаа

Эрүүл Монгол хүн хөтөлбөрийг үргэлжлүүлж, сумын эмнэлгийг эрүүл мэндийн нэн шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах ажилд хамтрагч талуудын оролцоог нэмэгдүүлэн ажиллаж байна. Тухайлбал, сумын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандартын дагуу хөдөөгийн 300 сумын эмнэлгийг лабораторийн шинжилгээ хийх 10 төрлийн иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангаж, лаборант нарыг сургалтанд хамруулан сумын түвшинд нотолгоонд тулгуурлан оношлох чадавхийг нэмэгдүүлэв.

ДЭМБ, НҮБХАС-ийн дэмжлэг, Эрүүл мэндийн салбарын хөгжил-2 төсөл, хөтөлбөрийн хүрээнд Дорнод, Хэнтий, Завхан, Баянхонгор, Өвөрхангай аймгийн 78 сумын эмнэлгийг 46 төрлийн лабораторийн шинжилгээ хийх тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангаад байна. 11 сумын эмнэлгийг загвар эмнэлэг болгон, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламжийн багаж хэрэгсэл олгожээ.

Францын Санте-Сюд байгууллагын тусламжаар Сэлэнгэ аймгийн бүх сумд, Германы техник туслалцааны төсөл, Дэлхийн зөн ТББ-ын санхүүжилтээр багийн эмч нарыг зайлшгүй шаардлагатай багаж, хэрэгслээр хангаж хөдөөгийн иргэдэд үзүүлэх оношлогоо, эмчилгээний чадавхийг нэмэгдүүлэв. Төсөл хэрэгжсэн эмнэлгүүдэд бий болсон шинэ үйлчилгээг үзүүлэх, тоног төхөөрөмжийг ашиглах чиглэлээр 414 эмч, сувилагч мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаж ур чадвараа дээшлүүллээ.

Мөн гурав хүртэлх насны хүүхдийг олон найрлагат бичил тэжээлээр хангах арга хэмжээг Дэлхийн зөн ОУБ-ын дэмжлэгтэйгээр Сэлэнгэ, Дархан аймагт зохион байгуулсан нь үр дүнгээ өгсөн тул хүүхдийн эндэгдэл өндөртэй зарим аймгуудад энэ төрлийн арга хэмжээг зохион байгуулж эхэллээ. НҮБХС, Дэлхийн зөн ОУБ-ын дэмжлэгтэйгээр тав хүртэлх насны хүүхдүүд, хөхүүл эхчүүдэд А аминдэм, төмрийн бэлдмэл, олон найрлагат тэжээлээр хангах ажлыг 2007-2008 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хамралтын хувийг нэмэгдүүлжээ.

Эх үүсвэр: ЭМЯ

Сумдад эмийн эргэлтийн сан байгуулах санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлж, 2008 онд 20 аймгийн сумдад эмийн эргэлтийн сан ажиллаж, хүүхдийн өвчний нэн шаардлагатай 13 нэрийн эмээр тогтмол хангаж байгаа нь хот, хөдөөгийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний ялгаатай байдлыг арилгахад дэмжлэг болж байна.

Тулгамдсан асуудал

Бүс, аймгийн түвшинд хүүхдийн эндэгдэл харилцан адилгүй байна. Тухайлбал, Увс, Завхан, Говь-Алтай, Архангай, Өвөрхангай, Өмнөговь, Дорноговь, Сүхбаатар, Хэнтий аймгуудад улсын дунджаас дээгүүр байна. Иймд хөдөө, хот, суурин газарт үзүүлж байгаа эмнэлгийн тусламж, үйлчилгээний ялгаатай байдлыг арилгах ажлыг эрчимжүүлэх, эндэгдлийн зонхилох шалтгаан болж байгаа жирэмсний үеийн эмгэг, амьсгалын тогтолцооны эмгэг, төрөлхийн гажиг хөгжлөөс үүдсэн эндэгдлээс урьдчилан сэргийлэх, эрт үеийн оношилгоо хийх, нэн шаардлагатай эмчилгээ үзүүлэх чиглэлээр бүх шатны эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн болон техник, технологийн чадавхийг нэмэгдүүлэх нь тулгамдсан асуудал болж байна.

Ялангуяа жирэмсний үеийн болон төрөлхийн гажиг хөгжлийн шалтгаант эндэгдэл эрс нэмэгдэж, 1998 оныхтой харьцуулахад 2008 онд жирэмсний эндэгдэл 27, төрөлхийн гажиг хөгжлөөс үүдсэн эндэгдэл 12 хувиар тус тус нэмэгджээ. Энэ нь ураг нярайн оношлогоо, эмчилгээг орчин үеийн түвшинд гаргаж, Перинатологийн төв байгуулах шаардлагатайг харуулж байна.

Цаашдын зорилт

Ойрын хугацаанд:

- Хүүхдийг хөхөөр хооллохыг бодлогоор дэмжих, ХӨЦМ-ийн хэрэгжилтийг

эрчимжүүлэх, аминдэм эрдэс бодис болон баяжуулсан бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх, хүүхдийн хооллолт, зөв хэрэглээ, эрүүл хүнсний тухай ойлголтыг төлөвшүүлэх ажлыг үргэлжлүүлэн, хэрэгжилтийг эрчимжүүлэх,

- Хүүхдийн эндэгдэл өндөртэй аймгуудад орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын хүүхдийн тусламж үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн эм, эмнэлгийн хэрэгслийн болон техник технологийн чадавхийг бэхжүүлэхэд эрүүл мэндийн байгууллага төдийгүй, засаг захиргааны удирдлага, төрийн болон ТББ-ууд, иргэд, олон нийтийн оролцоог идэвхжүүлэх,
- 2010 он гэхэд бүх сумдыг нярайн нэн шаардлагатай эмнэлгийн тусламж үйлчилгээний багаж, тоног төхөөрөмжөөр хангах, ЭНЭШТ-ийн нярай судлалын чадавхийг бүрдүүлж, ураг, нярайн оношлогоо, эмчилгээний чанарыг дээшлүүлэх.

Дунд болон урт хугацаанд:

- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулж, хот хөдөө, бүс нутаг хоорондын эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын ялгааг багасгах,
- “Эрүүл эхээс эрүүл хүүхэд” зарчмыг хэрэгжүүлэхийн тулд нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг сайжруулах, жирэмсний хяналтыг чанаржуулах,
- Перинатологийн төв байгуулж, ураг, нярайн оношлогоо, эмчилгээг олон улсын түвшинд ойртуулж хөгжүүлэх.



ЗОРИЛГО 5

ЭХЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ САЙЖРУУЛАХ

5 ЭХЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ САЙЖРУУЛАХ

Зорилт 10: *Нөхөн үржихүйн эрүүл мэндийн шаардлагатай тусламж үйлчилгээг хүн бүрт хүргэж, эхийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 4 дахин бууруулах*

Өнөөгийн байдал, хандлага

Эхийн эндэгдэл нь нөхөн үржихүйн эрүүл мэнд (НҮЭМ)-ийн асуудалтай нягт уялдаатай бөгөөд эхийн нас, төрөлт хоорондын зай, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой байдаг. 100,000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл 1993 онд 259 байсан нь хамгийн

өндөр үзүүлэлт юм. Харин 1990-1995 онд дунджаар 187, 1996-2001 онд дунджаар 162, 2002-2007 онд дунджаар 96 болж буурсан байна. Эхийн эндэгдлийн түвшин 2008 онд 48.6 болж 1990 оноос 2.5 дахин, 2007 оноос 1.8 дахин тус тус буурчээ (Хүснэгт 11). Сүүлийн 3 жилийн дүнгээс харахад эхийн эндэгдлийг цаашид бууруулах боломж байна (Дүрслэл 12).

Хүснэгт 11. Эхийн эндэгдэл, эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлт

	Шалгуур үзүүлэлт	1990	2000	2006	2007	2008	2015
23	Эхийн эндэгдлийн түвшин (100,000 амьд төрөлтөд)	200.0 ^а (1992) 121.6 ^б	166.3 ^а	67.2 ^а	88.3 ^б	48.6 ^б	50.0 ^а
24	Эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлтийн хувь	100.0 ^а	99.6 ^а	99.7 ^а	99.8 ^б	99.8 ^б	99.8 ^а


Эх үүсвэр: а. УИХ-ын тогтоол #13, Монгол Улсын МХЗ-уудыг батлах тухай, 2008
б. ҮСХ, ЭМЯ, 2008

Эхийн эндэгдлийн түвшинг бүсээр авч үзвэл харилцан адилгүй, зарим аймагт өндөр хэвээр байна. 2007 онд Баруун бүсийн Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд аймгууд, Хангайн бүсийн Баянхонгор, Орхон, Өвөрхангай аймгууд, Төвийн бүсийн Өмнөговь зэрэг аймагт 101.0-439.0 эндэгдэл байгаа нь улсын дунджаас үлэмж дээгүүр байна.

Харин 2008 онд эхийн эндэгдэл Улаанбаатар, Зүүн болон Баруун бүс, ялангуяа Дундговь, Завхан, Хэнтий зэрэг аймагт 89.8-112.0 байгаа нь улс болон бүсийн дунджаас өндөр байна.

ҮСХ, НҮБ ХАС-тай хамтран 2008 онд зохион байгуулсан Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаанаас харахад жирэмсний хяналтанд орсон голч хугацаа 1998 онд 3.7 сар байснаа 2003 онд 3.3 сар, 2008 онд 2.9 сар болж эхчүүд жирэмсний хяналтанд эрт орж байгаа эерэг дүн гарчээ.

Дүрслэл 12. Эхийн эндэгдлийн түвшин



Төрсний дараахь 42 хоног дотор тавих идэвхтэй хяналт 2003 онд 62 хувь байсан бол 2008 онд 65 хувь болж нэмэгдсэн байна. Жирэмсний хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдээс ХДХВ-ийн шинжилгээнд 68 хувь нь хамрагдсан байна.

Судалгаанд хамрагдсан гэр бүлтэй болон нийт эмэгтэйчүүд, мөн нөхрүүд ихэнх нь жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгслийн талаар мэдлэгтэй байгаа нь нэн эерэг үр дүн юм. Одоогийн хэрэглээг 1998 оны судалгаатай харьцуулахад ямар нэг арга болон орчин үеийн аргын хэрэглээ нийт эмэгтэйчүүдийн дунд өссөн боловч 2003 онтой харьцуулахад дээрх аргуудын хэрэглээ буурсан байна.

Эмнэлэгт төрсөн эхчүүд 1998 онд 94.1 хувь байснаа 2003 онд 97.3 хувь, 2008 онд 98.3 хувь болж нэмэгджээ. 2003 оны судалгаагаар 1,000 амьд төрөлтөд 234 үр хөндөлт ногдож байсан бол 2008 онд 169 болж буурсан байна. НҮЭМ-ийн 1998 оны судалгаагаар 15-19 насны охидын 9 хувь нь хүүхэд төрүүлж байсан бол 2003 онд 7.4 хувь болж буурсан болон харин 2008 оны судалгаагаар 0.8 хувиар өсч, 8.2 болжээ.

Дэмжих орчин

Засгийн газраас хүн амын талаар баримтлах бодлогын баримт бичиг болон МХЗ-д суурилсан ҮХЦБ-д хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг тодорхойлсон. Төрөлтийг дэмжих арга хэмжээ авсны дүнд сүүлийн жилүүдэд төрөлт нэмэгдэж, 2007 онд 56.6 мянган хүүхэд, 2008 онд 63.8 мянган хүүхэд төрж, цаашид нэмэгдэх хандлагатай байна.

Нөхөн үржихүйн эрүүл мэнд Үндэсний хөтөлбөр, Эхийн эндэгдлийг бууруулах стратегийг хэрэгжүүлснээр жирэмсэн эхчүүдийн хяналтын чанар, хүртээмж сайжирч эхийн эндэгдэл буурахад нөлөөлж байна.

НҮБХАС-тай хамтран НҮЭМ (2007-2011), НҮБХС, ДЭМБ-тай хамтран Эсэн мэнд амаржихуй (2008-2009) зэрэг төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байгаа нь энэ зорилтыг хангахад тодорхой хувь нэмэр оруулж байна.

Эх, хүүхдийн эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа, судалгааны ажлуудыг НҮЭМ-ийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын сүлжээ зохион байгуулж, хувийн хэвшлийн байгууллагууд ч тодорхой хувь нэмэр оруулж байна.

Төвөөс алслагдсан эх, нялхсын эндэгдэл өндөртэй баруун аймгуудийн эх, хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах чиглэлээр аймгуудын Засаг дарга нартай ЭМЯ, НҮБХАС,

НҮБХС, ДЭМБ, АХБ-ын удирдлагууд хамтын ажиллагааны тунхаг бичиг байгуулан ажиллаж байна.

Алслагдсан 8 аймгийн эх, нярайн өвчнийг алсын зайнаас оношлох “Телемедицина” төслийг Люксембургийн Засгийн газрын тусламж, ЭНЭШТ-ийн материаллаг бааз, үйл ажиллагааг сайжруулах төслийг Итали Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээл, Нийслэлийн клиникийн амаржих газруудад оношилгоо, эмчилгээний багаж төхөөрөмж нийлүүлэх ажлыг НҮБХАС-ын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байна.

Тулгамдсан асуудал

Сүүлийн 2 жил дараалан хүн амын төрөлт 15.0-18.0 хувиар өслөө. Гэтэл улсын хэмжээнд төрөх эмнэлгийн барилга, ор, төсөв, хангамж, эмч, мэргэжилтний орон тоо өмнөх онуудаас нэмэгдсэнгүй. Улаанбаатар хотод төрөлт нэмэгдсэнээр эмнэлэгт нэг эх, нярайд ногдох нягтрал ихэсч халдвар авах эрсдлийг нэмэгдүүлж байна. Төрсөн эх төрөх эмнэлэгт тодорхой хугацаанд сувилуулж хяналтанд байх ёстой атал, зарим үед ор хүрэлцэхгүйн улмаас төрсний дараа хэдхэн цаг болоод гэртээ гарах явдал хэвийн үзэгдэл болжээ.

Сумын төвд зөвхөн хэвийн төрөлтийг авч, эрсдэл өндөртэй тохиолдолд аймгийн нэгдсэн эмнэлгийн төрөх тасагт нарийн мэргэжлийн эмчийн хяналтанд жирэмсэн эхийг төрүүлэх бодлого баримталж байна. Гэвч аймгийн төвийн төрөх эмнэлэгт төрөлт нэмэгдэж, эхчүүдийн амрах байрны ачаалал маш их нэмэгдсэн байна.

Жирэмсэн, төрөх, төрсний дараахь үеийн эхийн хүндрэл, нярайн болон ургийн гаж хөгжлийг оношлох, эмчлэх орчин үеийн багаж, тоног төхөөрөмж дутагдалтай, нарийн мэргэжлийн эмчийн хүрэлцээ орон нутагт дутагдаж байна.

Цаашдын зорилт

Ойрын хугацаанд:

- Нийслэл хотод олон улсын стандартын шаардлагад нийцсэн төрөх эмнэлэг яаралтай шинээр барьж ашиглалтанд оруулах, түүнд ажиллах хүний нөөц, техник, тоног төхөөрөмжийг бэлтгэх


ажлыг цаг алдалгүйгээр оновчтой зохион байгуулах,

- Аймгийн нэгдсэн эмнэлгийн төрөх тасаг, эхчүүдийн амрах байрыг чадавхижуулах, төрөлт ихтэй аймгуудад 50 ортой төрөх газруудыг шинээр барьж ашиглалтанд оруулах,
- Орчин үеийн багаж, тоног төхөөрөмжөөр хот, хөдөөгийн амаржих газар, тасгийг хангах, эх барих эмэгтэйчүүдийн эмч, боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах,

- Сум, өрхийн эмч нарыг НҮЭМ, эсэн мэнд амаржихуйн чиглэлээр богино хугацааны сургалт, семинарт бүрэн хамруулах арга хэмжээ авах.

Дунд хугацаанд:

- Нийт хүн амд ялангуяа, өсвөр насныхны дунд НҮЭМ-ийн сургалт, сурталчилгаа хийх, тэдний зан үйлийг эерэгээр өөрчлөх ажлыг улам өргөжүүлэх.



ЗОРИЛГО 6

**БЭЛГИЙН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧИН,
ХДХВ, ДОХ, СҮРЬЕЭТЭЙ ТЭМЦЭХ,
БУСАД ӨВЧНИЙГ БУУРУУЛАХ**

БЭЛГИЙН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧИН, ХДХВ, ДОХ, СҮРЬЕЭТЭЙ ТЭМЦЭХ, БУСАД ӨВЧНИЙГ БУУРУУЛАХ

Зорилт 11: 2015 он гэхэд Хүний дархлал хомсдолын вирус (ХДХВ), Дархлалын олдмол хомсдол (ДОХ) өвчний халдварыг хязгаарлах, урьдчилан сэргийлэх

Өнөөгийн байдал, хандлага

1992 оноос хойш бүртгэгдсэн ХДХВ, ДОХ-ын 52 тохиолдлын 11 нь 2007 онд, 16 нь 2008 онд илэрлээ. Бүртгэгдсэн бүх тохиолдол бэлгийн замаар халдварласан байна. Эдгээрийн 17 нь ОХУ, БНХАУ, БНСУ-д ажиллаж амьдарч байхдаа, 4 нь Монголд гадаадын иргэдээс халдвар авсан байж болох магадлалтай байна.

Одоогоор ДОХ-ын хам шинж 8 хүнд илэрч ретровирусын эсрэг эмчилгээнд ороод байна. Түүнчлэн 8 хүн ДОХ-ын улмаас нас баржээ. ХДХВ, ДОХ-той хүмүүсийн 40 нь эрэгтэй 12 нь эмэгтэй

байгаа бол ХДХВ-ийн халдвартай эрэгтэйчүүдийн 84.2 хувь нь эрэгтэй хүнтэй бэлгийн харьцаанд ордог эрэгтэйчүүд (ЭБЭ), эмэгтэйчүүдийн 54.2 хувь нь биеэ үнэлэгч байна.

2007 онд 15-29 насны 84.6 мянган залуучууд, 2008 онд 153.9 мянган залуучууд ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдсанаас 2007 онд 3, 2008 онд 3 хүнд ХДХВ-ийн халдвар илэрчээ (Хүснэгт 12). Харин 2007 онд 1, 2008 онд 3 хүн ДОХ-ын улмаас нас баржээ.

Хүснэгт 12. Жирэмсэн эмэгтэйчүүд болон 15-24 насны залуучуудын дундахь ХДХВ-ын халдварын тархалт, хувь

	Шалгуур үзүүлэлт	1990	2000	2006	2007	2008	2015
25	Жирэмсэн эмэгтэйчүүдийн дундахь ХДХВ-ын халдварын тархалт	-	-	0.004 ^a (2005)	0.001 ^b	0.0 ^b	<0.1 ^a
26	15-24 насны залуучуудын дундахь ХДХВ-ын халдварын тархалт	-	-	-	0.0007 ^b	0.0005 ^b	<0.1 ^a

Эх үүсвэр: а. УИХ-ын тогтоол #13, Монгол Улсын МХЗ-уудыг батлах тухай, 2008
б. ҮСХ, ЭМЯ, 2008

2007 онд 42.8 мянган, 2008 онд 69.1 мянган жирэмсэн эмэгтэй ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдсанаас ХДХВ-ийн халдвартай нь тогтоогдсон 3 эмэгтэйн халдвар эхээс хүүхдэд дамжихаас сэргийлэх арга хэмжээ авсны үр дүнд төрсөн хүүхдүүд одоогоор халдваргүй нь нотлогдон эрүүл бойжиж байна.

2008 онд БЗДХ-уудын 30.4 мянган тохиолдол бүртгэгдсэн нь 2007 оныхоос 1.3 дахин нэмэгдэж 10,000 хүн амд зонхилон тохиолдох тэмбүү өвчин 18.7, заг хүйтэн 23.1, трихомониаз 24.6 байна. БЗДХ өвчний тархалт их байгаа нь ХДХВ, ДОХ өвчний халдварыг

нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж болзошгүй юм.

Дэмжих орчин

Засгийн газрын дэргэдэх ХДХВ, ДОХ өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажлыг зохицуулах Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг өргөтгөн шинэчилж, аймаг, яамдад салбар хороод байгуулан ажиллав.

ХДХВ, ДОХ, БЗДХ-тай тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого, чиглэлийг тодорхойлон 2015 он хүртэл хэрэгжүүлэх Үндэсний стратегийн төлөвлөгөөний төслийг

боловсруулаад байна.

ХДХВ, ДОХ-ийн эсрэг тэмцэх хамтын ажиллагааг өрнүүлэх, Засгийн газар, олон улсын болон иргэний нийгмийн байгууллагууд, хувийн хэвшил, иргэдийн бүх талын оролцоог идэвхжүүлэх зорилгоор “Бид манлайлья, түншлэлийг хөгжүүлъя” сэдэвт Үндэсний 4 дүгээр чуулган зохион байгуулав.

ХДХВ, ДОХ, БЗДХ-ын илрүүлэлтийг сайжруулах зорилгоор “Сайн дурын зөвлөгөө шинжилгээ” хөтөлбөрийг Үндэсний хэмжээнд хэрэгжүүлж, СДЗШ-ний төвүүдийг бүх аймаг, нийслэлийн дүүргүүд, Замын-Үүд хилийн боомтод байгуулан ажиллуулжээ.

БЗДХ-ын хам шинжийн оношилгоог бүх сум, өрхийн эмнэлэгт нэвтрүүлж, аймаг, дүүргүүдийн ЭМН, нэгдсэн эмнэлгийн БЗДХ-ын кабинет, лабораториудын оношилгооны чадавхийг дээшлүүлжээ.

ХДХВ, ДОХ, БЗДХ-тай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд Глобаль сангийн дэмжлэгтэй хэрэгжүүлж байгаа ДОХ-ын төсөл чухал үүрэг гүйцэтгэж байна. Энэ төсөл 2002 оноос эхлэн хэрэгжиж 2014 он хүртэл үргэлжлэх бөгөөд ХДХВ, ДОХ болон БЗДХ-ын тусламж үйлчилгээ, БЗДХ-ын хам шинжийн оношилгоо, эмчилгээ, Зуун хувь бэлгэвч хэрэглэх зэрэг дэд хөтөлбөрүүдтэй хэрэгжиж байна.

Бэлгэвчийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэхэд зориулан НҮБ-ын ХАС, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төсөл болон Мари Стопс олон улсын байгууллагын Монгол дахь салбарын дэмжлэгтэйгээр бэлгэвчийн түгээлтийг зохион байгуулж байна.

Тулгамдсан асуудал

Хэдийгээр Монгол Улс ХДХВ-ийн тархалт багатай орон гэгдэж байгаа ч, Хятад, ОХУ зэрэг ХДХВ-ийн тархалт өндөр орнуудтай хил залгаа оршдог эрсдэл ихтэй орнуудын нэг юм. Хилийн дагуух бүс нутагт албан болоод албан бус худалдаа арилжаа, эдийн засгийн харилцаа өсөхийн хэрээр биеэ үнэлэх явдал ч газар авч, цаашид ХДХВ тархах нөхцөлийг бүрдүүлж байна.

Тархалт нь нэмэгдэж байгаа БЗДХ-уудын хяналт, эмнэлгийн тусламж үйлчилгээг чанаржуулах, ялангуяа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэг, хоёрдугаар шатлалын

эмнэлгүүдийн оношилгоог чадавхижуулах, шаардлагатай тоног төхөөрөмж, оношлуураар хангах, боловсон хүчнийг сургаж бэлтгэн аймгуудын ДОХ, БЗДХ-ын кабинетуудыг 2-3 эмчтэй, сум, өрхийн эмнэлэгт ХДХВ, БЗДХ-уудыг энгийн хурдавчилсан аргаар оношлох нөхцөлийг бүрдүүлэх асуудлыг яаралтай шийдвэрлэх шаардлагатай байна.

Шигтгээ 4. ХДХВ, ДОХ-д өртөх эрсдэл өндөртэй бүлэгтэй ажиллах

Биеэ үнэлэгчид (ЭБҮ), эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүд (ЭБЭ), хөдөлгөөнт хүн ам, мансуурах бодис судсаар тарьж хэрэглэгсэд зэрэг эрсдэлтэй бүлгийнхэнд хүрч ажиллах, тэдний нийгмийн оролцоо, манлайллыг нэмэгдүүлэх, тусламж үйлчилгээ, мэдээлэл хүргэх чиглэлээр “Хамтдаа”, “Итгэл шүтээн”, “Итгэл найдвар”, “Боломж” ТББ-ууд үйл ажиллагаа явуулж байна.

Зуун хувь бэлгэвч хэрэглэх хөтөлбөрийг бүх аймаг, Хархорин, Замын-Үүд сум, нийслэлийн 9 дүүрэгт хэрэгжүүлж, энэ хүрээнд бүсчилсэн туршлага судлах сургалт-аялал зохион байгуулж, бэлгэвч түгээх автомат машиныг аймаг, нийслэлийн цэнгээний газруудад байрлуулав. Биеэ үнэлэгчдэд мэдээлэл солилцох, эрүүл мэндийн үйлчилгээ авахад зориулж “Сэтгэлд амар” төвийг нийслэлийн 3 дүүрэг, Хөвсгөл аймагт ажиллуулж байна.

Дархан-уул, Орхон аймагт төрөлхийн тэмбүү бууруулах, мөн 8 аймагт жирэмсэн болон эрсдэлтэй бүлгийн эмэгтэйчүүдэд нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх төсөл хэрэгжиж байна.

Хүн ам, эрсдэлт бүлгийнхэнд зориулсан мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэн “Бид манлайлья” сэдэвт ухуулга сурталчилгааны хяналтын ажлыг 2 үе шаттай зохион байгуулж, хүн амын мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн теле болон радиогийн нэвтрүүлэг бэлтгэн нэвтрүүлж, өдөр тутмын сонинд эмчийн зөвлөгөө нийтлэх, сэрэмжлүүлэг, зурагт хуудас, зорилтот бүлгийнхэнд зориулсан гарын авлага, санамж зөвлөмж, тараах, мэдээллийн сэтгүүл гаргах зэрэг ажлыг тогтмол хийж хэвшжээ. ХДХВ, ДОХ, БЗДХ-аас сэргийлэх, эрсдэлгүй зан үйл төлөвшүүлэх танин мэдэхүйн зориулалттай цахим хуудас, найдвартай утас ажиллуулж байна.

Эх үүсвэр: ЭМЯ

ХДХВ, ДОХ, БЗДХ-ын тархалтанд нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйл ядуурал, ажилгүйдэл, архидалт, биеэ үнэлэх, мансуурах бодис судсаар тарьж хэрэглэх хүн амын шилжилт хөдөлгөөн, гадаадад удаан хугацаагаар ажиллаж, амьдарч байгаа зэргийг төрөөс анхаарч оновчтой арга хэмжээ авах хэрэгтэй байна.

ХДХВ, ДОХ, БЗДХ-тай тэмцэх, урьдчилан сэргийлэх хяналтын үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгийн хэмжээ хүрэлцэхгүй байна.

Цаашдын зорилт

Ойрын хугацаанд:

- БЗДХ-ыг оношлох, эмчлэх тусламж үйлчилгээний зардлыг улсын төсвөөс бүрэн хариуцаж чадахгүй байгаад дүгнэлт хийж, ЭМД-ын сангаас санхүүжүүлэх эрх зүйн орчин бий болгох,
- ХДХВ-ийн халдвар цусаар дамжихаас урьдчилан сэргийлж, цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах арга хэмжээг үндэсний түвшинд хэрэгжүүлэх,
- ХДХВ, ДОХ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгаа,

сургалтын ажлыг өргөжүүлэх, нийтэд энгийн, ойлгомжтой байдлаар мэдээллийг хүргэх,

- ХДХВ, ДОХ, БЗДХ-ын харуулдан тандах тогтолцоог өргөжүүлж, оношийн баталгаажилт, чанарын хяналтын тогтолцоог сайжруулах,
- БЗДХ-тай өвчтнүүдийн хавьтал судлалын өнөөгийн практикийг өөрчилж, оновчтой орчин үеийн арга хэрэгсэл нэвтрүүлж, илэрсэн тохиолдлын хавьтагчдыг тогтоон, эмчилгээнд урьж хамруулах, тэдний нууцлалыг чанд хадгалах.

Дунд болон урт хугацаанд:

- ХДХВ, ДОХ, БЗДХ-тай тэмцэх, урьдчилан сэргийлэх, тандалт, хяналтын үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг, ялангуяа улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хувийг нэмэгдүүлэх,
- ХДХВ, ДОХ, БЗДХ-ын халдварыг хязгаарлах, урьдчилан сэргийлэх, НҮЭМ-ийн тусламж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх,
- БЗДХ-тай хүмүүсийн амбулаторын эмчилгээний зардлыг даатгалд хамруулах.

Зорилт 12: 2015 он гэхэд сүрьеэ өвчний тархалтыг бууруулах

Өнөөгийн байдал, хандлага

Улсын хэмжээнд нийт халдварт өвчний дотор сүрьеэ 9.6 хувийг эзэлж, 2008 онд сүрьеэгийн нийт шинэ тохиолдол 4223, уушигны түрхэц эерэг шинэ сүрьеэ 1838 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт сүрьеэгийн шинэ тохиолдол 138 буюу 3.2 хувиар, уушигны түрхэц эерэг шинэ сүрьеэ 18 тохиолдлоор тус тус буурчээ (Хүснэгт 13).


Бүртгэгдсэн сүрьеэгийн шинэ тохиолдлын 58.7 хувийг уушигны сүрьеэ, 41.3 хувийг уушигны бус эрхтний сүрьеэ эзэлж байна. Сүрьеэгийн шинэ тохиолдлын 54.5 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэний 2.7 хувийг

хөдөө, орон нутгийн түр оршин суугч, 1.2 хувийг гэр оронгүй, хаяггүй хүмүүс эзэлж байна. Сүрьеэгийн өвчлөл Сэлэнгэ, Дорнод, Дархан-Уул, Хэнтий, Сүхбаатар зэрэг аймгуудад улсын дунджаас өндөр байна. Нас, хүйсний бүтцийн хувьд авч үзвэл нийт сүрьеэгээр өвчлөгчдийн дотор 0-15 насны хүүхдийн сүрьеэ 10.1 хувь, 16-44 насны хүмүүс 71.6 хувь, эрэгтэйчүүд 53 хувийг тус тус эзэлж байна.

Сүрьеэ өвчний илрүүлэлт сайжирч, богино хугацааны шууд эмчилгээгээр эдгэрч байна. Монгол Улс 1995 оноос Сүрьеэтэй тэмцэх Үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Оношилгоо эмчилгээний олон улсын стандарт”-ыг

нэвтрүүлж, амжилттай хэрэгжүүлж байна. Энэ стандартыг нэвтрүүлснээр эмчилгээний үр дүн 1994 онд 31.4 хувь байсан бол 2008 онд 85.0 хувь болж өсчээ. Сүрьеэ өвчний улмаас нас барсан хүмүүсийн тоо харьцангуй буурч байна. 1990-1995 онд жилд дунджаар сүрьеэ өвчний улмаас 119 хүн нас барсан бол 1996-2001 онуудад 101, 2002-2007 онуудад 78 болж буурсан байна.

Дүрслэл 13. Сүрьеэгийн өвчлөлийн түвшин



Хүснэгт 13. Сүрьеэ өвчний тархалт, өвчлөлийн түвшин, нас баралт, оношилгоо, эмчилгээний тохиолдлын хувь

Шалгуур үзүүлэлт	1990	2000	2006	2007	2008	2015
27 Сүрьеэ өвчний тархалт (100,000 хүн тутамд)	435.5 ^a	60.0 ^a	84.8 ^a	72.6 ^b	72.0 ^b	82.0 ^a
28 Сүрьеэгийн өвчлөлийн түвшин (100,000 хүн тутамд)	79.0 ^a	124.8 ^a	185.3 ^a	166.8 ^b	158.8 ^b	100.0 ^a
29 Сүрьеэгээс шалтгаалсан нас баралт (100,000 хүн тутамд)	4.8 ^a	3.2 ^a	2.9 ^a	2.4 ^b	2.7 ^b	2.0 ^a
30 Оношилгоо, эмчилгээний олон улсын стандартын хүрээнд сүрьеэг илрүүлж, эмчилсэн тохиолдлын хувь	31.4 ^a (1994)	80.9 ^a	82.1 ^a	83.8 ^b	85.0 ^b	100.0 ^a

Эх үүсвэр: а. УИХ-ын тогтоол #13, Монгол Улсын МХЗ-уудыг батлах тухай, 2008
б. ҮСХ, ЭМЯ, 2008

Дэмжих орчин

Зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд “Шууд хяналттай богино хугацааны эмчилгээ (ДОТС)”-г анх удаа ТББ-тай хамтран хэрэгжүүлсэн нь сүрьеэтэй тэмцэх ажилд шинэ арга зүйг нэвтрүүлж, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлж, эмчилгээний чанарыг сайжруулахад чухал нөлөө үзүүлсэн юм.

Мөн түрхэцийн чанарын хяналтын тогтолцоог аймаг, дүүргийн сүрьеэгийн лабораторийн түвшинд нэвтрүүлсэн нь ихээхэн үр дүнтэй боллоо.

Мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажилд олон нийтэд танигдсан нэр, алдартай хүмүүсийг татан оролцуулж, тэднээр дамжуулан үндсэн мэдээллийг хүргэдэг олон улсын туршлагыг нэвтрүүлж, Олимпийн аварга, Монгол Улсын хөдөлмөрийн баатар Э.Бадар-Ууганыг “Сүрьеэтэй тэмцэгч элч” төлөөлөгчөөр ажиллуулж байна.

Сүүлийн жилүүдэд сүрьеэтэй тэмцэхэд зарцуулж байгаа санхүүжилтийн хэмжээ нэмэгдэж, сүрьеэгийн тусламж, үйлчилгээг хүн амд төлбөргүй үзүүлж байгаагаас гадна орон нутгийн түвшинд хамтрагч байгууллагуудын оролцоо нэмэгдэж байна.

Тулгамдсан асуудал

Цаашид сүрьеэгийн тохиолдлыг эрт илрүүлэн төгс эмчлэх, олон эмийн дасалтай сүрьеэг эмчлэх чадавхийг нэмэгдүүлэх, хувийн салбарын оролцоог нэмэгдүүлэх, төвлөрлийг сааруулсан эрүүл мэндийн үйлчилгээгээр дамжуулан сүрьеэтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Цаашдын зорилт

Ойрын хугацаанд:

- Сүрьеэгийн тохиолдлыг эрт илрүүлэн, төгс эмчлэх, олон эмийн дасалтай

сүрьеэг эмчлэх эмнэлгийн чадавхийг бэхжүүлэх,

- Сүрьеэгийн тусламж, үйлчилгээний зардлыг улсын төсвөөс бүрэн хариуцаж чадахгүй байгаад дүгнэлт хийж, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх эрх зүйн орчинг бий болгох,
- Олон эмийн дасалтай сүрьеэгийн оношилгоонд хурдавчилсан арга зүйг нэвтрүүлэх.

Дунд болон урт хугацаанд:

- 2010-2015 онд сүрьеэ өвчинтэй тэмцэх үндэсний стратегийг шинэчлэн боловсруулах,
- Сүрьеэтэй өвчтөнд нийгэм, хамт олны зүгээс тавих анхаарал халамжийг сайжруулах, сүрьеэтэй өвчтнийг ялгаварлан гадуурхах явдлыг арилгах,
- Сүрьеэтэй тэмцэх үйл ажиллагаанд өрхийн болон хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх.

Зорилт 13: Хүүхдийн шүд цоорох өвчний тархалтыг бууруулах

Өнөөгийн байдал, хандлага

Хүн амын дунд хүнсний бүтээгдэхүүний зөв сонголт, зохистой хэрэглээний талаархи мэдлэг дутмагаас чихэрлэг, өтгөрүүлсэн, хийжүүлсэн ундааны хэрэглээ сүүлийн 10 гаруй жилд 2-3 дахин нэмэгдэж, цагаан идээний хэрэглээ 40 гаруй хувиар буурсан нь шүдний цооролт болон яс сийрэгжих өвчний гаралт нэмэгдэхэд шууд нөлөөлж байна.

Эрүүл мэндийн яамны Хүн амын шүдний өвчлөлтэй тэмцэх хөтөлбөрийн түүвэр судалгааны дүнгээр шүд цоорох өвчний тархалт 2004 оны байдлаар 80.1 хувь байна (Хүснэгт 14). Сүүлийн жилүүдэд энэ талаар судалгаа хийгдээгүй тул өнөөгийн түвшинг тодорхойлох боломжгүй байна.

Амны хөндийн эрүүл мэндээ иргэд өөрсдөө хянаж, шүд цоорох өвчнөөс сэргийлэх мэдлэг, дадалтай болоход дэмжлэг үзүүлэх зорилгоор

бага насны хүүхдийн дунд “анхны араа шүд буюу 6 дугаар шүд” сэдвээр үзлэг хийж, 226 хүүхдийн 670 шүдэнд ломбо, сийлантыг тавьж эмчилжээ.

Шүд, эрүү нүүр, эмгэг судлалын төв (ШЭНЭСТ)-өөс хүүхдийн асран хүмүүжүүлэх төвийн бүтэн болон хагас өнчин бага насны нийт 128 хүүхдийн амны хөндийг бүрэн эрүүлжүүлэх арга хэмжээг авчээ. Мөн хөгжлийн бэрхшээлтэй 4-12 насны нийт 600 орчим хүүхдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийж, зөвлөгөө өгч, тэдний амны хөндийг эрүүлжүүлэх арга хэмжээ авлаа.

ШЭНЭСТ-өөс үзлэг зохион байгуулж Нийслэлийн Баянгол дүүргийн 97 дугаар цэцэрлэгийн 120, Хан-уул дүүргийн 28 дугаар цэцэрлэгийн 80 хүүхдийг хамруулж, Хан-уул дүүргийн 52 дугаар сургуулийн 9-16 насны 90 хүүхдэд амны хөндийн эрүүл мэндийн талаар сургалт, сурталчилгаа явуулжээ.

Хүснэгт 14. Хүүхдийн шүд цоорох өвчний тархалт, хувь

Шалгуур үзүүлэлт		1990	2000	2006	2007	2008	2015
31	5-6 настай хүүхдийн шүд цоорох өвчний тархалт	-	-	80.1 ^a (2004)	80.1 (2004)	80.1 (2004)	75.0 ^a

Эх үүсвэр: а. УИХ-ын тогтоол #13, Монгол Улсын МХЗ-уудыг батлах тухай, 2008
б. ҮСХ, ЭМЯ, 2008

Улсын хэмжээнд 748 сургууль, 765 цэцэрлэг ажиллаж байгаагаас 2008 оны байдлаар ЕБС-д 341, цэцэрлэгт 208 их, бага эмч ажиллаж байна. Сургууль, цэцэрлэгийн эмч нь хүүхдүүдийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндэд нь хяналт тавьж бага болон өсвөр насанд нь

эрүүл аж төрөх зөв хэвшил бий болгоход чухал үүрэгтэй. Иймд сургууль, цэцэрлэгт хүүхдүүдийн эрүүл мэндийг хамгаалахын тулд их эмчийг орон тоогоор ажиллуулах, тэдний ажиллах нөхцөлийг сайтар бүрдүүлэх, тогтвортой ажиллуулах хэрэгцээтэй байна.

Дэмжих орчин

Засгийн газраас шүд цоорох өвчин, түүнд нөлөөлөгч эрсдэлт хүчин зүйлийн хяналт, тандалтыг сайжруулах, шүд, амны хөндийн эрүүл мэндээ иргэд өөрсдөө хянаж, сайжруулах, эрүүл зан үйл төлөвшихөд дэмжлэг үзүүлэх орчин бүрдүүлэх чиглэлээр ажиллаж байна. Амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх замаар хүн амын дунд шүд цоорох өвчний тархалтыг бууруулах зорилго бүхий “Амны хөндийн эрүүл мэнд” Үндэсний хөтөлбөрийг 2006-2015 оны хугацаанд 2 үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Бага болон өсвөр насны хүүхдүүдийн дунд түгээмэл тохиолдож байгаа шүдний эмгэгээс урьдчилан сэргийлэх, эмчлэх, боловсон хүчний чадавхийг сайжруулах зорилгоор бүсийн тулгуур 8 төв, нийслэлийн 6 дүүрэгт БНХАУ-ын буцалтгүй тусламжаар “Хүүхдийн шүдний кабинет” байгуулах төсөл хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.

Телевизийн “Боловсрол” сувагтай хамтран бага насны хүүхдэд зориулсан шүдээ хэрхэн угаах, шүдэнд ээлтэй хоол, хүнсийг сурталчилах хүүхэлдэйн нэвтрүүлэг бүтээж нэвтрүүлэв. Хүн амын амны хөндийн эрүүл ахуйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор төрөл бүрийн гарын авлага, өнгөт үзүүлэн, шүдэнд ээлтэй хоолны жор, ном хэвлэж эрүүл мэндийн газар, эмнэлгүүдээр дамжуулан түгээн сурталчилав.

Тулгамдсан асуудал

Зорилтын шалгуур үзүүлэлтүүд нь судалгаагаар гарах тул жил бүр биелэлтийг тооцож, үнэлэлт дүгнэлт өгөхөд бэрхшээлтэй байна.

Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн эрүүл мэндийг хамгаалах, бэхжүүлэхийн тулд их

эмчийг орон тоогоор, тогтвортой ажиллуулах шаардлагатай байна.

Амны хөндийн эрүүл мэнд хөтөлбөрийн үйл ажиллагаа тогтмолжиж байгаа ч бага насны хүүхдүүд, ялангуяа хөдөө, орон нутгийн хүүхдүүдийн дунд шүдний өвчлөл буурахгүй байгаа тул бүсийн тулгуур төв болон нийслэлийн дүүргүүдэд хүүхдийн шүдний эмчилгээний кабинет байгуулах ажлыг эрчимжүүлэх хэрэгтэй байна.

Шүдний цооролт болон яс сийрэгжих өвчнийг бууруулах талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, ЕБС-ийн цайны газар, түргэн хоолны газруудад бага насны хүүхдэд хийжүүлсэн ундаа зарахыг хориглох, хийжүүлсэн ундааны хэрэглээг багасгах талаар мэдээлэл, сурталчилгааг явуулах шаардлагатай байна.

Цаашдын зорилт

Ойрын хугацаанд:

- Зорилтын шалгуур үзүүлэлтүүдийг жил бүр тооцох талаар боломжтой арга хэмжээг авч хэрэгжүүлэх,
- Хөдөө, орон нутаг, бүсийн тулгуур төвүүд, нийслэлийн дүүрэг бүрт хүүхдийн шүдний эмчилгээний кабинет байгуулах, үйл ажиллагааг эхлүүлэх, эрчимжүүлэх,
- Амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах, зонхилон тохиолдох өвчлөлөөс сэргийлэхэд хүн амын мэдлэг, хандлага, дадлыг сайжруулах, бага болон өсвөр насны хүүхдүүд хийжүүлсэн ундаа хэрэглэхийг багасгах зорилгоор мэдээлэл, сургалт, сурталчилгааг үе шаттайгаар зохион байгуулах.



ЗОРИЛГО 7

БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

7 БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

Зорилт 14: Тогтвортой хөгжлийн зарчмыг улсын хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусган хэрэгжүүлж, хот суурин, ялангуяа Улаанбаатар хотын агаарыг цэвэршүүлэх

Өнөөгийн байдал, хандлага

Ойт нутаг. 2008 онд 9,512.0 га талбайд ойг нөхөн сэргээх ажил гүйцэтгэснээс 7,757.0 га талбайд улсын төсвөөр, 191 га талбайд орон нутгийн төсвөөр, 1,403 га талбайд иргэн, ААНБ-ын хөрөнгөөр, 161.4 га талбайд гадаад орны хандив, тусламжийн хөрөнгөөр тус тус гүйцэтгэв. Мөн “Ногоон хэрэм” Үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2008 онд 15 аймгийн 39 ААНБ-ын 535 га талбайд ногоон зурвас

байгуулснаас 265 га-д улсын төсвийн, 270 га-д хандивын хөрөнгөөр хийж гүйцэтгэв. 2008 оны байдлаар нийт газар нутгийн 7.7 хувийг ойт нутаг эзэлж байна (Хүснэгт 15). Ойжуулалтын ажлыг эрчимжүүлэхийн тулд Булган, Хэнтий, Сэлэнгэ, Төв аймагт нарсны үр бэлтгэх, Баян-Өлгий, Дорноговь, Өмнөговь, Төв аймагт навчит модны мөчир, салаа бэлтгэх, Сэлэнгэ, Төв, Хэнтий аймагт шилмэл үрийн плантаци байгуулах ажлыг эхлүүллээ.

Хүснэгт 15. Ойт нутаг болон улсын тусгай хамгаалалтад авсан газар нутаг, нэг хүнд ногдох давхар исэл, агаар дахь хүхэрлэг хийн агууламж

Шалгуур үзүүлэлт	1990	2000	2006	2007	2008	2015
32 Ойт нутгийн эзлэх хувь	7.8 ^a	8.5 ^a	8.1 ^a	7.7 ^б	7.7 ^б 8.7 ^в	9.0 ^a
33 Улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийн эзлэх хувь	3.6 ^a	13.1 ^a	13.76 ^a	13.4 ^б	13.4 ^б 14.0 ^в	30.0 ^{*a}
34 Нэг хүнд ногдох нүүрсхүчлийн давхар ислийн ялгаралт (тн/хүн)	11.52 ^a	6.57 ^a	5.75 ^a (2002)	-	-	4.0 ^a
35 Улаанбаатар хотын агаар дахь азотын давхар ислийн өвлийн хоногийн дундаж агууламж (мкг/м ³)* ^{**}	30.5 ^в	32.0 ^a	33.0 ^a	38.0 ^б	34.0 ^б 36.5 ^в	30.0 ^a
36 Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн өвлийн дундаж агууламж (мкг/м ³)* ^{**}	9.8 ^в	16.0 ^a	22.0 ^a	20.0 ^б	26.0 ^б 23.5 ^в	20.0 ^a

Тайлбар: * Үүнээс 15.0 хувийг орон нутгийн тусгай хамгаалалтад авна.

** Өвлийн сарын дундаж агууламжийг тооцсон.

Эх сурвалж: а. УИХ-ын тогтоол #13, Монгол Улсын МХЗ-уудыг батлах тухай, 2008

б. ҮСХ, 2008

в. БОАЖЯ, 2008

Цөлжилт. Манай орны хуурай, гандуу бүс нутгийн цөлжилтийг үнэлэх зураглалыг Геоэкологийн хүрээлэнгийн эрдэмтэд, судлаачид шинэчлэн боловсруулав. Энэхүү судалгааны дүнгээс үзэхэд Монгол орны хуурай, гандуу бүс нутгийн цөлжсөн газрын талбай 3.4 хувиар нэмэгджээ (Хүснэгт 16). Цөлжилтийн судалгааг манай орны нийт нутаг

дэвсгэрийг хамруулсан нэгдсэн арга зүйгээр явуулж, 2007 оны байдлаар цөлжилтийн зэрэглэлээр сул, дунд болон хүчтэй нэрвэгдсэн нутаг нийлээд 77.2 хувьд хүрсэн гэсэн дүгнэлтийг судлаачид гаргажээ⁹. Цөлжилт үүсэх гол нөхцөл нь дэлхийн дулаарлаас

⁹ Геоэкологийн хүрээлэн, 2007

шалтгаалан хуурайшилт нэмэгдэж, ган болох нь элбэгшснээс ургамлын бүрхэц бууран халцгай газар ихэссэний зэрэгцээ, газрын хөрсөнд аж ахуйн байгууллага, хүний үзүүлэх

сөрөг үйл ажиллагаа бөгөөд нөгөө талаар агаарын температур нэмэгдэж, биологийн төрөл зүйл, экологийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна.

Хүснэгт 16. Цөлжилтийн эрчим, хувиар, 1990, 2004, 2007

Цөлжилтийн зэрэглэл	Хамрах нутгийн хүрээ, хувиар		
	1990	2004	2007
Сул илэрсэн нутаг	76.0	34.9	16.5
Дунд зэрэг илэрсэн	20.0	38.7	37.2
Хүчтэй илэрсэн	3.0	16.1	34.0
Маш хүчтэй илэрсэн	1.0	1.8	7.0
Хэт хуурай гандуу цөл	-	8.5	3.8
Гандуу нутгийн цөлжсөн талбайн хэмжээ	41.3	44.7	44.7

Эх үүсвэр: Геоэкологийн хүрээлэн, 2007

Улсын тусгай хамгаалалтад авсан газар нутаг. Увс аймгийн Ховд сумын Гоожуурын хүрхрээ орчмын газар нутаг, Сагиль сумын Баянзүрх уул орчмын газар нутаг, Хөвсгөл аймгийн Хорьдол сарьдагийн нурууны Жиглэгийн даваа, Дархадын хотгор орчмын газар нутаг болон Баянхонгор аймгийн Их Богд уул орчмын байгалийн цогцолборт газрын нийт 323.4 мян.га талбайг 2008 онд улсын тусгай хамгаалалтанд нэмж авснаар Монгол Улсын нийт газар нутгийн 14.0 хувь буюу 21.9 сая га талбай бүхий 61 хэсэг газар улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан бөгөөд эдгээр газар нутгийн координатыг оруулж шинэчилсэн газрын зураг гаргалаа.

Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн бүртгэлийг шинэчилж, одоогийн байдлаар 16.31 сая га талбай бүхий 911 газар орон нутгийн тусгай хамгаалалтанд хамрагдаад байгаа нь Монгол Улсын нийт газар нутгийн 10.3 хувийг эзэлж байна.

Агаарын бохирдол. Улаанбаатар хот болон томоохон хотуудын агаарын бохирдол жилээс жилд нэмэгдэн зөвшөөрөгдөх хэмжээнээс давж, хүн амын эрүүл мэнд, ахуй амьдралд сөргөөр нөлөөлөн, хүрээлэн байгаа орчны тэнцвэрт байдал алдагдахад хүрээд байна. Улаанбаатар хотын агаарын бохирдол нь олон эх үүсвэрийн үйлчлэлийн үр дагавар бөгөөд хий буюу утаа, тоосжилт, үнэр, шуугиан, цацрагжилт зэрэг бараг бүх төрлийг хамарсан нийлмэл шинжтэй болоод байна. Улаанбаатар хотын агаарын бохирдлын

гол эх үүсвэр нь нүүрс түлдэг 3 том дулааны цахилгаан станц (ДЦС), 1,178 орчим жижиг болон дунд оврын уурын зуух, айл өрх, бензин болон дизель түлшээр ажилладаг улсын хэмжээний нийт автомашины 67 хувь буюу 119,290 орчим байгаа бөгөөд зарим нь экологи, хөдөлгөөний аюулгүй байдлын стандартын шаардлагыг хангаж чадахгүй болсон автомашинууд байна. Мөн хөрсний элэгдэл, эвдрэлд орсон газар, ил задгай хаясан хог, ногоон байгууламжийн хомсдол зэрэг нь агаарын бохирдол, тоосжилтод их хэмжээгээр нөлөөлж байна.

Нийслэлийн эрчим хүчний үйлдвэрээс гарах бохирдол нь хатуу түлшний шаталтын бүтээгдэхүүн, технологийн хаягдал, бохир ус, дуу шуугиан зэргээр дамжин агаар, хөрс, гадаргын болон гүний усыг бохирдуулж байгаа нь судалгаагаар тогтоогдсон байна. Улаанбаатар хотод нүүрсээр ажилладаг 3 ДЦС ажиллаж 2,509.6 сая квт эрчим хүч үйлдвэрлэхэд 2.52 сая гаруй тн нүүрс зарцуулдаг бөгөөд энэ явцад ДЦС-ын яндангаас цаг тутамд 10-20 тн хөө, тортог агаарт цацагддаг (Хүснэгт 17). Органик түлшний шаталтын үр дүнд үнсний хатуу хэсгүүд, дутуу шатсан түлш, хүхрийн ислүүд, азотын исэл, ванадийн исэл ялгарч байдаг. Иймээс ДЦС-уудад агаарын бохирдлын дотоод хяналт-шинжилгээний тоног төхөөрөмж суурилуулах, тэдгээрт байгаль орчны менежментийн нэгж байгуулах чиглэлээр хотын ДЦС-уудад утааны хийг цэвэрлэх, утааны хийн доторх үнс, тоосонцорт хяналт тавих төхөөрөмжүүдийг суурилуулж байна.

Хүснэгт 17. Дулааны цахилгаан станцуудын жилд хэрэглэсэн нүүрсний хэмжээ, агаарт хаяж байгаа хортой бодисын хэмжээ, тн/жил

	"ДЦС-2"ХК	"ДЦС-3"ХК	"ДЦС-4"ХК	БҮГД
2006 онд хэрэглэсэн нүүрсний хэмжээ тн/жил	181,800.0	888,000.0	2,434,349.0	3,504,149.0
Үнсний хэмжээ, тн	31,815.0	157,562.0	227,649.9	417,026.9
Азотын исэл No_x	1,313.9	6,418.0	9,681.2	17,413.1
Хүхрийн исэл SO_2	1,277.7	6,241.0	10,579.5	18,098.2
Нүүрстөрөгчийн дутуу исэл CO	180.8	880.0	3,215.4	4,276.2

Эх үүсвэр: ЭБЭХЯ, 2007


Сүүлийн жилүүдэд агаарын бохирдлыг бууруулах талаар арга хэмжээ авч байгаа боловч тодорхой үр дүнд хүрэхгүй байна. Улаанбаатар хот болон томоохон хотуудын агаарын чанарт хийж байгаа судалгаа, шинжилгээний дүнгээс харахад хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх агаар бохирдуулагч бодисын агууламж стандарт хэмжээнээс давах тохиолдол нилээд ажиглагдах боллоо. Улаанбаатар хотын агаарын чанарын хяналтын станцууд Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо (УБ-1), Баянгол дүүргийн баруун 4 зам (УБ-2), Сонгинохайрхан дүүргийн 1 дүгээр хороолол (УБ-3), Баянзүрх дүүргийн 13 дугаар хороолол (УБ-4), Сүхбаатар дүүргийн 32-ийн тойрог (УБ-5)-т ажиллаж, агаар бохирдуулагч бодис хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2), нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), тоосонцор (PM_{10})-ын сорьц авч хэмжилт хийн хянаж байна.

Нүүрстөрөгчийн дутуу ислийн агууламжийг 11 дүгээр сараас эхлэн автомат анализатораар УБ-1, УБ-2, УБ-5 харуул дээр хэмжилт хийн тодорхойлж байна. Хэмжилтийн дүнгээр нүүрстөрөгчийн дутуу ислийн сарын дундаж агууламж 1,480-11,968 мкг/м^3 (стандарт хэмжээ 10,000 мкг/м^3) байж, Сүхбаатар дүүргийн 32-ийн тойрогт хамгийн их агууламжтай буюу 68,000 мкг/м^3 гарч, стандарт хэмжээнээс 6.8 дахин их бөгөөд, сарын нийт ажиглалтын 13.8 хувь нь хүлцэх хэмжээнээс давсан байна.

Хүхэрлэг хий, угаарын хийн жилийн дундаж агууламж 19 мкг/м^3 байгаа нь агаарын чанарын стандарт хэмжээнээс (стандарт хэмжээ 10 мкг/м^3) 1.9 дахин их, азотын давхар ислийн жилийн дундаж агууламж (стандарт 30 мкг/м^3) 1.2 дахин их байна. Хүхэрлэг хийн жилийн дундаж агууламжийг 2007 онтой

харьцуулахад 6 мкг/м^3 -ээр нэмэгдсэн, азотын давхар ислийн жилийн дундаж агууламж 2007 оны түвшинд байв (Дүрслэл 14).

Дүрслэл 14. Агаар бохирдуулагч бодис хүхэрлэг хий, азотын давхар ислийн агууламж, 2004-2008



Азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж (стандарт 40 мкг/м^3) 20-39 мкг/м^3 байсан нь стандарт хэмжээнд, хамгийн их агууламж 80 мкг/м^3 -д хүрч стандартаас 2.9 дахин их, сарын нийт ажиглалтын 30.5 хувь нь хүлцэх хэмжээнээс давсан байна.

10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламжийг УБ-1, УБ-5 харуулд хэмжсэн дүнгээр хоногийн дундаж агууламж (стандарт хэмжээ 100 мкг/м^3) 12 дугаар сарын байдлаар 70-1,093 мкг/м^3 , хамгийн их агууламж 2,930 мкг/м^3 буюу стандартаас 29.3 дахин их, сарын нийт ажиглалтын 63.6 хувь нь хүлцэх хэмжээнээс давсан үзүүлэлттэй байна.

Түлш, эрчим хүч. Хотын агаарын бохирдлын дийлэнх хувийг эзэлж байгаа гэр хорооллын бүсээс халаалтын улиралд гарч байгаа утааны бохирдлыг богино хугацаанд шийдвэрлэх бодитой арга зам бол коксон түлш үйлдвэрлэж, хотын гэр хорооллыг хангах

явдал гэж үзэн коксон түлшний үйлдвэрийг өргөжүүлэхийг дэмжиж Нийслэлийн Засаг даргын төсвийн багцын санхүүжилтээр “Төгрөг нуурын энержи” ХХК коксон түлшний үйлдвэр байгуулахаар ажиллаж байна.

Эрчим хүчний ашиглалтыг сайжруулж шөнийн цагаар цахилгаан халаагуур ашиглах явдлыг дэмжих хүрээнд Улаанбаатар хотын цахилгаан хангамжийн дамжуулалт, түгээлтийг найдваржуулах зорилгоор 110/10 кВ-ын Баруун дэд станцын өргөтгөл, нийслэлийн цахилгаан эрчим хүчгүй 10,314 айлыг цахилгаан дамжуулах шугамаар холбох ажлыг УБЦТС ХК-аас нийслэлийн ЗДТГ-тай хамтран хэрэгжүүлж, Хайлаастын гэр хорооллын 110/35/10 кВ-ын дэд өртөөний барилга угсралтын ажил хийгдэж байна.

Агаарын бохирдлыг нэмэгдүүлэхэд авто тээврийн хэрэгслээс гарах хорт бодис нилээд хувийг эзэлдэг бөгөөд бууруулах хамгийн дэвшилтэт арга нь бензин, дизель түлшийг халж, хийн түлшинд шилжүүлэх явдал юм. Монгол Улсад 2005 онд 2,200 тн шингэрүүлсэн шатдаг хий импортлож байсан бол 2007 онд 6,000 тн-д хүрчээ. Шатдаг хий хэрэглэгчийн тоо 2007 онд орон нутагт 18.0 мянга, Улаанбаатар хотод 7.6 мянга гаруй болжээ. Улаанбаатар хотод авто тээврийн хэрэгслийг хийгээр цэнэглэх 3 станц үйл ажиллагаа явуулж, хийн түлшний авто тээврийн хэрэгслийн тоо Улаанбаатар хотод 1,000 орчим болжээ.

Монгол орны хүрэн нүүрсийг дулааны аргаар карбонжуулан боловсруулж, утаагүй болгох туршилт, шинжилгээний ажлыг ОХУ, БНХАУ, Япон зэрэг орнуудад хийлгэсэн. Шинжилгээний дүнгээс харахад боловсруулалтанд орсон нүүрсний утаа тортог нь эрс буурч, илчлэг чанар нь өссөн үзүүлэлт гарчээ. Шаардлагад нийцсэн коксон түлшний стандартыг тогтоох, борлуулалтын сүлжээг бий болгох судалгааны ажлыг ЕСБХБ-аас эхлүүлээд байна. Түүнчлэн коксон түлшийг айл өрхийн ахуйн хэрэглээнд нэвтрүүлэхээс гадна, жилдээ 1 сая гаруй тн нүүрсний хэрэглээтэй халаалтын зууханд цэвэр түлш ашиглах боломжийг судлах, утаа багатай техник, технологийн шийдлийг гаргах, цахилгаан станцуудын утааны бохирдлыг бууруулахаар Японы “ЖАЙКА” байгууллагаас судалгаа хийж байна.

Дэмжих орчин

Ойт нутаг. Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлтийг 2007 онд оруулж ойн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, ой огтлох хууль бус зөрчлийг арилгах хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгов. Байгалийн тодорхой төрлийн нөөц баялгийг нутгийн иргэдийн нөхөрлөл, хамтлагт хариуцуулан хамгаалах, ашиглах, эзэмшүүлэх тухай журам гарган ажилласан нь ойн нөөц, баялгийг иргэдийн оролцоотойгоор хамгаалах чухал ач холбогдолтой болов.

Ойн тухай Үндэсний хөтөлбөр болон Ногоон хэрэм хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд 30 жилийн хугацаанд 250.0 мянган га газрыг ойжуулж, ногооруулах зорилготой юм. Ойг тарьж ургуулах ажлын чанарыг сайжруулж, гурван жил арчилж, хамгаалуулах, иргэдийн ойжуулалтад оролцох сонирхолыг бий болгох зорилгоор “Иргэн, ААНБ-ын өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан таримал ойг улсын ойн санд худалдаж авах түр журам батлан хэрэгжүүлж байна.

Ногоон хэрэм Үндэсний хөтөлбөрийг БНСУ дэмжиж, тус улсын Ойн агентлаг болон Монгол Улсын БОАЖЯ-ны хооронд 2006 онд санамж бичиг байгуулан, 2007 оноос эхлэн жил бүр 1 сая ам.долларын буцалтгүй тусламжийг 10 жилийн хугацаанд үзүүлэхээр харилцан тохиролцож үйл ажиллагааг эхлээд байна.

Цөлжилт. Монгол Улс 1996 онд НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцэд нэгдэн орж, 2003 онд Засгийн газраас Цөлжилттэй тэмцэх Үндэсний хөтөлбөрийг батлан, Цөлжилттэй тэмцэх Үндэсний хороо байгуулан, үйл ажиллагаагаа олон улсын байгууллага, гадаад орнуудын зүгээс баримталж байгаа бодлого, чиглэлтэй уялдуулан зохицуулж байна.

НҮБХХ, Даян дэлхийн байгаль хамгаалах сан, Голландын санхүүжилтээр 2006 оноос хэрэгжүүлж байгаа “Газрын тогтвортой менежмент” төсөл, Швейцарын хөгжлийн хамтын ажиллагааны агентлаг (ШХХАА)-аас санхүүжүүлэн 2007 оноос хэрэгжүүлж байгаа “Цөлжилтийг сааруулах” төсөл, Японы “J-Green” байгууллагаас хэрэгжүүлж байгаа “Шар шороон шуурганы эх үүсвэртэй тэмцэх” төслүүд нь цөлжилттэй тэмцэх ажилд ихээхэн хувь нэмэр оруулж байна. ШХХАА-

аас Баянхонгор, Говь-Алтай аймгуудын нутаг дэвсгэрт цөлжилтийг сааруулах арга хэмжээнд зориулж 2007-2014 онд 13.2 сая швейцарь франкийн санхүүгийн дэмжлэг үзүүлж эхлэв.

Тусгай хамгаалалттай нутаг. Монгол орны байгалийн үзэсгэлэнт газруудыг тусгай хамгаалалтад авч, зохистой ашиглах нь аялал жуулчлалыг хөгжүүлэх, улс орны эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхэд түлхэц болох учраас түүнийг зүй зохистой ашиглах, хамгаалах үзэл баримтлал, бодлого барьж байна.

Агаарын бохирдол. Агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх, бохирдлыг бууруулах талаархи төрийн болон орон нутгийн байгууллага, иргэн, ААНБ-уудын эрх, үүргийг тодорхой болгох, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилгоор Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулаад байна.

Агаарын чанарын MNS4585 стандартыг 2007 онд шинэчлэн боловсруулж мөрдөж эхлээд байна. ДЦС-уудын зуухнуудын ашиглалтын явцад ялгарах утаан дахь зарим хортой бохирдуулагч бодисийн стандартыг шинээр, агаар бохирдуулагч хортой бодисын улсын стандартыг шинэчлэн баталж, агаарт агуулагдах зарим химийн хорт бодисийн стандартыг шинэчлэн батлан мөрдөж эхлээд байна.

Агаарын бохирдлыг 6 үзүүлэлтээр хэмжилт хийх агаарын чанарын хяналтын 4 суурин, 1 явуулын станц, иж бүрэн хяналт-шинжилгээний сүлжээний тоног төхөөрөмжийг суурилуулав. 2007 онд Улаанбаатар хотын агаарыг бохирдуулагч эх үүсвэрийн тооллого явуулж, нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэв.

Агаарын чанарын асуудал эрхэлсэн мэргэжлийн албаны чадавхийг бэхжүүлэх хяналт-шинжилгээ, судалгааны нэгдсэн сүлжээг өргөжүүлэх, лабораторын багаж төхөөрөмжийг шинэчлэхэд зориулж 2008 онд 1.2 тэрбум төгрөг зарцуулав.

Түлш, эрчим хүч. Нүүрсийг дулааны аргаар боловсруулж коксон түлш үйлдвэрлэх төслийн санал, санаачилга гадаад, дотоодын ААНБ-аас гарч байгаа бөгөөд тэдгээрт бодлогын дэмжлэг үзүүлэх зорилгоор “Монгол Улсын тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалт”-д “Коксон түлш үйлдвэрлэх” гэсэн заалт оруулснаар Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 19.2 заалтаар

орлогын албан татварын хөнгөлөлт эдлэх боломжтой болсон.

Эрчим хүчний салбарын компаниудын санхүүгийн чадавхийг сайжруулах, үнэ тарифын шинэтгэл (цагийн ялгавартай тарифын бодлогыг шинэчлэх, амьжиргааны түвшний тарифын аргачлал боловсруулах, үнийн зохицуулалт) хийх, цахилгааны гэрээт зах зээлийг хэрэгжүүлэх үүднээс төвийн бүсийн хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тарифт өөрчлөлт оруулж 2008 оноос мөрдөж эхэлсэн.

Шингэрүүлсэн шатдаг хийн түлшний хэрэглээг дэмжих зорилгоор хийн түлш, хийн тоног төхөөрөмжийн нэмүү өртгийн албан татвар болон гаалийн албан татвараас чөлөөлсөн. Засгийн газраас хямд хийн түлшний эх үүсвэрийг дотоодын ашигт малтмалын нөөцөөс илрүүлэн гарган авах ажлыг эхлүүлээд байна.

Улаанбаатар хотын замын хөдөлгөөнд оролцож байгаа нийтийн тээврийн хэрэгслийн ихэнх нь дизель хөдөлгүүртэй, хуучин машинууд байна. Иймээс хосолмол ажиллагаатай автомашиныг Онцгой албан татвараас чөлөөлөх тухай хууль батлан, импортоор оруулж ирэх автомашинд ногдуулах Онцгой албан татварыг түүнийг ашигласан жил болон цилиндрийн багтаамжаас нь хамааруулан нэмэгдүүлэх тухай хууль 2007 оноос эхлэн хэрэгжиж байна.

Тулгамдсан асуудал

Ойжуулах ажлыг зохион байгуулалттайгаар хэрэгжүүлж байгаа боловч түүний үр дүн нь тааруухан байна. Модны хулгайтай тэмцэх ажил үр дүнгээ өгөхгүй байна.

Цөлжилттэй тэмцэх ажлын хүрээнд хуурайшилт ихтэй бүс нутгийг усжуулах, хур бороо, цасны илүүдэл усыг хуримтлуулан ашиглахтай холбоотой далан, хөв байгуулах асуудал тулгарч байна.

Орон нутгийн хамгаалалт авах тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх, энэ асуудлыг эрх зүйн хувьд цэгцтэй болгох асуудал тулгарч байна.

Улаанбаатар хотын агаарын бохирдол бууруулах асуудал олон жил яригдаж байгаа боловч үр дүн гарахгүй байна. Гэр хорооллыг барилгажуулах ажлыг эрчимжүүлэх, утаа тортог багатай түлшний үйлдвэрийг ашиглалтанд

оруулж, гэр хорооллыг утаагүй, чанарын шаардлага хангасан хямд түлшээр хангах явдал тулгарч байна. Нийслэлийн агаарыг бохирдуулж байгаа эх үүсвэрийг арилгах чиглэлээр системтэй арга хэмжээ авах, хуучин эх үүсвэрийн техникийн нөхцлийг сайжруулах, шинэ эх үүсвэрийг нийслэлээс аль болох гадна байршуулах нь чухал байна.

Гэр хорооллын хэрэглэгчдийг цахилгаан халаагуураар халаахад шугам сүлжээний дамжуулах чадвар хүрэлцэхгүй байна. Иймд инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Цаашдын зорилт

Ойрын хугацаанд:

- Ойжуулалтын ажлыг эрчимжүүлж, мод тарих ажилд олон нийтийн оролцоо, санхүүжилтийн гадаад, дотоод эх үүсвэрийг нэмэгдүүлэх,
- Модны хулгайтай тэмцэж байгаа практикийг өөрчилж, шинэ шатанд гаргах, арга барилаа өөрчлөх,
- Хур бороо, цасны илүүдэл усыг хуримтлуулах далан, хөв барьж байгуулах,
- Бэлчээр, бүс нутаг, газар тариаланг усжуулах ажлыг эрчимжүүлэх,
- Гэр хорооллыг барилгажуулах ажлыг эрчимжүүлэх,
- Тээврийн хэрэгслээс гарах хорт утааны хэмжээг стандартын шаардлагад нийцүүлэх ажлыг зохион байгуулах,

Зорилт 15: Гол, горхины усны эхийг хамгаалж, нөхөн сэргээх замаар ширгэлтийг багасгах

Өнөөгийн байдал, хандлага

Монгол орны гадаргын урсац хур бороо, хайлсан цас, мөстөл, мөсөн голын уснаас бүрдэх боловч физик газар зүйн онцлог, уулын ам хөндийн салхи тоссон чиглэл, нутгийн өндөр зэргээс хамааран гол мөрний усны тэжээгдлийн хувийн жин газар бүрд харилцан адилгүй байна. Тухайлбал, Монгол Алтай нурууны голуудад хайлсан цас, мөстөл,

- Улаанбаатар хотын агаарын бохирдолтын талаархи мэдээллийг цэгцтэй болгож, уг мэдээллийг гаргах талаар УЦУОШГ, Агаарын чанарын албад анхаарлаа хандуулах,
- Коксон түлшний үйлдвэрлэлийг байгуулах ажлыг эрчимжүүлэх, энэ салбар дахь хувийн хэвшлийн оролцоог дэмжсэн таатай нөхцөлийг бүрдүүлэх болон коксон түлшний хэрэглээний онцлог, давуу талыг таниулан мэдүүлэх, сурталчилгаа хийх.

Дунд хугацаанд:

- Цөлжилттэй тэмцэж байгаа дэлхийн бусад орны туршлагыг судалж нэвтрүүлэх,
- Орон нутгийн тусгай хамгаалалтанд авах журам, дүрмийг цэгцтэй болгож орон нутгийн тусгай хамгаалалтанд авах нутаг дэвсгэрийн хэмжээг нэмэгдүүлэх,
- Захын гэр хорооллын эрчим хүчний хангамжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, инженерийн байгууламжийг өргөжүүлж, найдваржуулах,
- Импортоор авдаг шингэрүүлсэн шатдаг хийн үнэ газрын тосны бүтээгдэхүүний үнийг дагалдан өсөж байгаатай холбогдон нийтийн тээвэр, ахуй, халаалтын зууханд хийн түлшийг хэрэглэхэд эдийн засгийн хувьд үр ашиггүй байгаа учраас дотоодын ашигт малтмалын нөөцөнд тулгуурлан хийн түлшний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хууль эрх зүй, хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх, бодлогоор дэмжих.


мөсөн голын ус жилийн урсацын 50-70 хувийг, борооны ус 5-10 хувийг эзэлж байхад Хөвсгөлийн уулс, Хангай, Хэнтий нуруунаас эх авсан гол, мөрний савын хур борооны ус жилийн урсацын 56-75 хувьд хүрч байна.

Гол мөрний урсацын 15-40 хувийг ул хөрсний усны тэжээл эзлэх ба ус цуглуулах талбайн усны хагалбарт ойртох тутам багасаж, голын адгаар нэмэгдэх зүй тогтолтой байна. Монгол

орны усны нөөцийг түүний нөхөн сэргээгдэх хэмжээгээр үр ашигтай ашиглах болон сав газрын экосистемийг хамгаалах үндсэн дээр усны нөөц, түүний бүрэлдэх байгалийн нөхцөлийг хамгаалах шаардлага гарч байна (Дүрслэл 15). Энэ нь Монгол орны усны нөөцийн 70 хувь нь бүрэлдэх

Алтай, Хангай, Хэнтий нуруу, Хөвсгөлийн уулс, Их Хянганы нуруу зэрэг уул нуруудын өндөрлөг хэсгийг Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулан голуудын сав газрын эхийг хамгаалалтад авах байдлаар хэрэгжих үндэстэй юм.

Дүрслэл 15. Тусгай хамгаалалттай нутгийн байршил болон урсацын 70 хувь бүрэлдэх газрууд



Эдгээр голын сав газрын эхэн хэсгийн эзлэх талбай нь Монгол орны нутаг дэвсгэрийн 30 хувийг эзэлж, өнөөгийн байдлаар тусгай хамгаалалтад авсан нутаг дэвсгэрийн байршил усны нөөцийн 70 хувь бүрэлдэх нутаг дэвсгэртэй давхцаж байгаа бөгөөд цаашид нэлээд нутгийг нэмж хамгаалалтад авах шаардлагатай байна (Хүснэгт 18).

температурын ажиглалтыг зөвхөн 15 орчим цооногт хийж байна. Монгол орны гол мөрний нийлбэр урсац элбэг устай жилд 69.5 шоо км, бага устай жилд 23 шоо км хүрч хэлбэлзэнэ.

Монгол орны усны хяналт-шинжилгээний сүлжээний хүрээнд ус судлалын 126 харуултай, үүнээс гол мөрний 110, нуурын 16 харуулд ажиглалт судалгаа хийж, судалгааны дүн гаргаж байна. Газрын доорх усны түвшин,

2007 онд Төв, Булган, Сэлэнгэ, Сүхбаатар, Говьсүмбэр, Орхон аймгуудаас бусад 15 аймаг, Улаанбаатар хотод 33 булгийн эхийг тохижуулах, хашиж хамгаалах ажлын гэрээ байгуулж, нийт 26 булгийн эхийг тохижуулан, хашиж хамгаалах ажлыг хийлгэсэн бол 2008 онд 156 булаг, 2 шанд, 5 рашааныг тохижуулах ажлыг хийжээ (Хүснэгт 19).

Хүснэгт 18. Хамгаалалтад авсан гол мөрний усны урсац бүрэлдэх ундаргын эхийн эзлэх хувь

Шалгуур үзүүлэлт	1990	2000	2006	2007	2008	2015
37 Хамгаалалтад авсан гол мөрний усны урсац бүрэлдэх ундаргын эхийн эзлэх хувь	-	40.0 ^а	50.0 ^а	30.0 ^б	44.0 ^б 53.0 ^в	80.0 ^а
38 Хамгаалалт барьж тохижуулсан усны эх үүсвэр, булаг шандын эхийн тоо	-	-	229 ^а	26.0 ^б	163 ^б	1000 ^а

Эх үүсвэр: а. УИХ-ын тогтоол #13, Монгол Улсын МХЗ-уудыг батлах тухай, 2008
 б. ҮСХ, БОАЖЯ, 2008
 в. БОАЖЯ

Усны тоо бүртгэл, тооллогоор 2007 онд нийт 5128 гол, горхи, үүнээс 852 нь ширгэсэн, 9306 булаг, шанд, үүнээс 2277 нь ширгэсэн, 3747 нуур, тойром, үүнээс 1181 нь ширгэсэн, 429 рашаан, үүнээс 60 ширгэсэн дүн гарсан байв. 2008 онд улсын хэмжээнд нийт 5205 гол горхи тоологдсоноос 4563 гол горхи устай гэж бүртгэгдсэн байна. Үүнээс 642 гол горхи тасарсан, шургасан, ширгэсэн гэсэн мэдээлэлтэй байна. Өмнөх онуудын тоо бүртгэлийн дүнтэй харьцуулахад 2008 онд 77 гол, горхи нэмэгдсэн байна. Энэ нь уур амьсгалын өөрчлөлт, хур тунадасны хэмжээ ихэссэн нь усны нөөц, чанарт нөлөөлөл үзүүлсэнийг харуулж байна.

Монгол орны хэмжээнд 2008 оны байдлаар нийт 9320 булаг шанд бүртгэгдсэнээс 7441 булаг, шанд устай гэж тоологдсон байна. 2003 онд 3638 нуур тоологдсоноос 760 гаруй нь ширгэсэн, 2007 онд 3747 тоологдсоноос 1181 ширгэсэн байсан бол 2008 онд хийсэн тооллогын дүнгээс үзэхэд, Монгол орны хэмжээнд нийт тоологдсон нуур 3781, үүнээс устай нь 2835 байв.

Говь, тал хээрийн бүсийн аймгуудын хувьд бороо, цасны уснаас тогтсон жижиг нуур тойром 2003 онд ихээр тоологдсон бөгөөд тухайн жилд болон түүнээс өмнөх жилүүдэд нь хур бороо элбэгтэй, гадаргын ус тэжээгдэл сайтай үе тохиосон нь өндөр тоо гарахад нөлөөлснөөс гадна аргачлалын хувьд 2003, 2007 онуудад нуур тойромыг тоолохдоо зарим газар бүлэг нуурыг 1 нуур хэмээн тоолсон, хур борооноос тэжээгддэг нуур, тойромыг мөн тоо бүртгэлд оруулж байснаас ихээхэн зөрүүтэй дүн гарчээ. Нуур тойрмын 2008 оны тоо бүртгэлээр газар зүйн байршлыг тогтоох, бага масштабтай зурагт буулгах зорилгоор бүлэг нууруудыг салгаж нэг бүрчлэн хамруулжээ.

Сүүлийн жилүүдэд орох хур, тунадасны хэмжээнээс ихээхэн хамаарч, өөр усны тэжээгдлийн эх үүсвэргүй ихэнх жижиг нуур тойромууд хатаж ширгэсэн нь 2003 оны тооллогын дүнгээс зөрүүтэй байгааг мэргэжлийн байгууллага тогтоожээ.

Хүснэгт 19. Монгол орны усны эх, урсац, бүрэлдэх хэсэг, 2008

	Тоо	Талбайн хэмжээ км ²	Усны нөөцийн хэмжээ км ³	Ширгэж утсан гол мөрөн, нуур цөөрөм, рашааны тоо (2008 оны тооллогийн дүнгээр)	Хамгаалалт барьж тохижуулсан усны эх үүсвэр, булаг шандын эхийн тоо
Гол мөрөн	5121	2.4%; 3840 км ²	34.6 км ³	887	0
Рашаан	422			54	5
Булаг	7441			1879	156
Шанд					2
					Нийт: 163
Нуур, цөөрөм	3732	1%; 1.500 км ²	500 км ³	1166	
Мөсөн гол		0.4%; 600 км ²	62.9 км ³	** Хархираагийн мөстлийн талбай 37.5, Түргэн уулын мөстлийн талбай 21.4 хувиар, харин Цамбагарав уулын мөстлийн талбай 1992 онд 13.4, 2000 онд 28.8, 2002 онд 31.9 хувиар тус тус 1940-өөд оны үеийнхээс багасчээ.	
Нийт		3.8%; 6050 км ²	609.5 км ³	2107	

** Мөсөн голын талбай дээш огшиж багассан
(Байгаль орчны төлөв байдлын 2006-2007 оны тайлан)
Эх үүсвэр: Усны хэрэг эрхлэх газар

Усны тухай хуульд заасны дагуу нийт 16 аймаг, Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагаанд үзлэг шалгалт явуулж, нийт 113 аж ахуйн нэгж, байгууллагын 185 орд газар, объектод усны нөөц ашиглуулах мэргэжлийн дүгнэлт гаргаад байна (Хүснэгт 20).

2008 онд Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хотуудын ус хангамжинд зориулсан газар доорхи усны эрэл хайгуулын ажлын гүйцэтгэв. Мөн онд Өвөрхангай аймгийн Богд, Хужирт суманд хүн амын ус хангамжинд зориулсан усны эрэл хайгуулын ажлыг явуулж гүний худаг гаргалаа.

Хүснэгт 20. Усны нөөц ашиглаж байгаа үйлдвэрлэлийн чиглэл, тоо, 2008

	Ус ашиглалтын чиглэл	Тоо
1	алт олборлолтын	94
2	зэс молибдений	1
3	нүүрс олборлолтын	3
4	төмрийн хүдрийн	1
5	жонш баяжуулалтын	2
6	цагаан тугалга, вольфрамын баяжуулалтын	2
7	баргилт чулууны	1
8	элс, хайрга, шавар олборлолтын	2
9	холимог болон ховор металлын	2
10	цайрын	1
11	газрын тосны хайгуул, олборлолтын	2
12	ус хангамж, ариутгах татуургын	8
13	хүнсний	1
14	чацаргана тариалангийн	1
15	цахилгаан, дулаан хангамжийн	1

Эх үүсвэр: БОАЖЯ, 2008

Бүсийн тулгуур төв Дархан, Ховд, Чойбалсан, Зуунмод хотын ашиглалтын хайгуулын гидрогеологийн судалгааны ажил, Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын “Цагаан нуур”-ын худалдааны чөлөөт бүс, Хангайн бүсийн тулгуур төв Хархорин хотын ус хангамж, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ус хангамжийн зориулалтаар “Сэвхүүлийн тойром” орчмын талбай, Замын-Үүд сумын Чөлөөт бүсийн талбай, Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт хэрэгжиж байгаа “Оюу толгой” төслийн Гүний хоолой, Дундговь аймгийн Жаргалант нуур, Архангай аймгийн Түвшрүүлэх сумын Бэрэнгийн талбай, Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Балгасын улаан нуурын талбайн газар доорхи усны эрэл хайгуулын ажлуудыг хийж, Туул гол дээр усан цогцолбор байгуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах урьдчилсан судалгааны ажлыг дуусган, ашиглалтын нөөц баялгийг

Усны салбарын шинжлэх ухаан, техникийн зөвлөлөөр баталгаажуулсан байна.

Дэмжих орчин

Усны тухай хуульд заасны дагуу усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг батлахаар ажиллаж байна. Энэ нь томоохон гол, мөрний урсац бүрэлдэх эхийг хамгаалалтад авахад онцгой ач холбогдолтой юм.

Усны бодлогын шинэчлэлийг эрчимжүүлж гол, мөрний сав газрыг хамгаалах, хэрэглээг зохистой болгох, гадаргын ус ашиглалтыг нэмэгдүүлэх, гүний хайгуулын ажлыг өргөжүүлэх, томоохон усан сан байгуулах, бороо, цасны усыг ашиглах төслүүдэд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ажлуудыг хийж байна.

Усны тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Усны экологи эдийн засгийн үнэлгээний төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, “Хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангах” хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна. Мөн “Усны аудит хийх журам”-ын төслийг боловсруулан хэлэлцүүлээд байна. Түүнчлэн Усны тухай хуулийн 19.2.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Туул голын сав газрын зөвлөлийг байгуулах төслийг боловсруулан харьяа аймаг, нийслэлийн Иргэдийн Хуралд хүргүүлсэн бөгөөд Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2008 оны 78 болон 261 тоот тогтоолоор Туул болон Сэлбэ голын сав газрын зөвлөлийг байгуулав. Мөн “Гол мөрний сав газрын зөвлөлийн дүрэм”-ийн 2.1 дэх заалтыг үндэслэн хоёр буюу түүнээс дээш аймаг дамжин урсдаг гол, мөрний сав газрын зөвлөл байгуулахаар бэлтгэж байна.

Сэлбэ голыг орон нутгийн тусгай хамгаалалтанд авах арга хэмжээний хүрээнд Чингэлтэй дүүргийн ЗДТГ-тай хамтран Сэлбэ голыг 2008-2010 онд хамгаалах хөтөлбөр гаргахаар бэлтгэж байна.

Тулгамдсан асуудал

Үйлдвэрлэлийн зориулалтаар усны нөөц, эрэл хайгуулын ажил гүйцэтгэж байгаа ААНБ-ууд Монгол Улсын Усны тухай хуулийг хэрэгжүүлэх талаар хангалтгүй ажиллаж байна. Тэдний хайгуулын үйл ажиллагаанд тавих хяналт сул байна.

Байгаль, цаг уурын өөрчлөлт, цөлжилт болон хүний хүчин зүйлээс шалтгаалан Монгол орны гол, мөрөн, булаг шанд хуурайшин хатаж, ширгэж байгаа нь онцгой анхаарал татсан асуудал хэвээр байна. Гол горхи, усны эхийг хамгаалах ажил туйлын хангалтгүй, энэ чиглэлээрхи хууль эрх зүйн орчин сул байна.

Нийслэлийн ус хангамжийн гол эх үүсвэр болсон голууд, түүний ай савыг хайрлан хамгаалах, газрын гүний усны хайгуулын

ажлыг хийж гүйцэтгэх ажил удааширалтай байна.

Гол горхи, усны эхийг хамгаалах талаар иргэдийн дунд хийх ухуулга сурталчилгаа бага, ойлголт сул байна. Орон нутгийн захиргааны байгууллагын хүлээх үүрэг хариуцлага гэж байхгүй байна.

Цаашдын зорилт

Ойрын хугацаанд:

- Усны тухай, Рашааны тухай, Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн тухай болон Ургамлын тухай хуулиудад өөрчлөлт оруулж, эрх зүйн орчинг боловсронгуй болгох,
- Хоёр буюу түүнээс дээш аймаг дамжин урсдаг гол, мөрний сав газрын зөвлөл байгуулан, хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх,
- Гол, горхи, усны ундаргын эх дээр аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг хориглосон тусгай хууль гаргаж мөрдөх,
- Нийт иргэдийн дунд гол, горхи, усны эх үүсвэрийг хамгаалах ач холбогдлын талаар ухуулга, сурталчилгаа хийж ойлгуулах,
- Орон нутаг, засаг захиргааны байгууллагуудад тухайн нутаг дэвсгэрт байгаа гол, горхи, ус, рашаан, нуур, цөөрмийн эх үүсвэр ундрагыг хамгаалах талаар хүлээх хариуцлагыг чангатгасан хуулийн заалтыг холбогдох хуульд нэмж оруулах, жил бүр түүний хэрэгжилтийн усны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хянаж үнэлэлт, дүгнэлт өгч байх,
- Гол, горхи, усны эх үүсвэрийг хамгаалах ажилд идэвхтэй оролцсон иргэдийн санаачилгыг дэмжих, урамшуулах.

Зорилт 16: 2015 он гэхэд баталгаат ундны усны хангамжгүй, сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдаагүй хүн амын эзлэх хувийг бууруулах

Өнөөгийн байдал, хандлага

Монгол орны усны нөөц нь дэлхийн усны нөөцийн 0.00004 хувийг, гол мөрний усны нөөцийн 1.63 хувийг эзэлж, тархацын хувьд ялгаатай байна. Тухайлбал, говийн бүсэд нэг хүнд ногдох усны нөөц дэлхийн дунджаас 10 дахин бага байхад Хэнтий, Хөвсгөл, Булган аймагт 45.0-55.2 мянган шоо метр байгаа нь дэлхийн дунджаас 4-5 дахин их юм.

Манай орны 17 аймгийн 115 сумын төвийн иргэд стандартын шаардлагад тохирохгүй ундны ус хэрэглэж байна. Үүнээс 94 сум магнийн агууламж их, 102 сум ерөнхийдөө хатуулаг их, 64 сум эрдэсжилт их, 22 сум фторын агууламж ихтэй ус хэрэглэж байгаа бөгөөд дээрх сумдын усыг зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх ажил хийгдэж байна.

Улаанбаатар хотод төвлөрсөн ус хангамжид холбогдсон айл, өрхүүдийн нэг хүн хоногт 270-340 литр ус хэрэглэдэг бол хотын захын хороолол, аймгийн төвүүдийн гэр хорооллын айл өрхүүдийн нэг хүн хоногт 8-10 литр ус хэрэглэдэг байна.

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2007-2008 оны үр дүнгээр есөн хүн тутмын дөрөв нь сайжруулсан ус хангамжтай, есөн хүн тутмын тав нь эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай, дөрвөн хүн тутмын гурав нь цахилгаан эрчим хүчний хангамжтай бөгөөд нийт хүн амын гуравны нэг нь дээрх хоёр үйлчилгээг бүгдийг нь хүртэж байна (Хүснэгт 22).

Хотын хүн амын дөрөвний гурав, хөдөөгийн хүн амын гуравны нэг нь эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай байна.

Хүснэгт 21. Ус хангамж, сайжруулсан ариун цэврийн байгууламж, ядуурлын хүрээ, хот, хөдөө, улсын дунджаар, 2007-2008

	Ядуурлын хамралтын хүрээ			Хүн амд эзлэх хувь		
	Хот	Хөдөө	Улсын дундаж	Хот	Хөдөө	Улсын дундаж
Ус хангамж: Төвлөрсөн, халуун хүйтэн ус	5.2	22.6	6.2	28.0	2.4	17.1
Төвлөрсөн, хүйтэн ус	17.3	21.7	18.4	3.6	1.7	2.8
Хамгаалалттай худаг	33.3	42.6	37.9	22.6	29.7	25.6
Хамгаалалтгүй худаг	44.2	43.3	43.4	1.8	17.9	8.6
Зөөврийн ¹	36.9	50.0	38.3	42.6	7.2	27.6
Бусад ²	53.5	52.7	52.7	1.5	41.2	18.3
Сайжруулсан ус хангамж ³ : Тийм	37.7	49.8	44.0	45.8	66.3	54.5
Үгүй	17.7	40.1	24.8	54.2	33.7	45.5
Сайжруулсан ариун цэврийн байгууламж ⁴ : Тийм	44.4	51.2	48.8	26.9	65.1	43.1
Үгүй	20.4	38.0	25.0	73.1	34.9	56.9

Тайлбар: 1/ Зөөврийн усыг нөөцөлдөг газрууд багтана, 2/ Булаг, гол, цас, мөс болон бусад, 3/ төвлөрсөн ус хангамжид холбогддог сууцанд амьдардаг, хамгаалалттай худаг, булгаас ус авдаг хүн амын хувийн жин. 4/ Ариун цэврийн байгууламж гэдэгт бохир гадагшлуулах хувийн болон нийтийн цооног, шугамтай өрхүүдийн хувийн жинг оруулна.

Эх үүсвэр: ӨНЭЗС 2007-2008 оны үр дүн, 94-р тал. ҮСХ, ДБ. 2009

Сайжруулсан ус хангамж, ариун цэврийн байгууламж, цахилгаан зэрэг үйлчилгээг хүртэх боломжгүй хүн амын олонхи нь дээрх үйлчилгээг хүртдэг хүн амаас амьдралын хувьд ядуу байна. Энэ ерөнхий хандлага хот, хөдөөгийн суурьшилд аль алинд нь ажиглагдаж байгаа боловч хөдөөд ялгарал арай бага байна¹⁰.

Дэмжих орчин

Улаанбаатар хотын цэвэр бохир усны мастер төлөвлөгөөний хүрээнд гэр хорооллыг 2020 он хүртэл цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах загварыг тодорхойлов. Гэр хорооллыг барилгажуулах ажлыг үе шаттайгаар хийж байгаа нь цэвэр, бохир усны төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй гэр хорооллын айл өрхийн тоог бууруулах боломжийг бүрдүүлж байна.

Тулгамдсан асуудал

Хүн амын дийлэнх хувь нь оршин суудаг гэр хороолол болон зуслан, суурин газрын эмнэлэг, сургууль, хот суурин газраас алслагдсан амралт, сувиллын газар, жуулчны баазад бохир ус татан зайлуулах систем байхгүйгээс нүхэн жорлон ашиглаж хөрс, ус болон байгаль орчныг ихээхэн бохирдуулж байна.

Улаанбаатар, Багануур, Дархан-Уул, Орхон, Зүүнхараа, Хөтөлийн цэвэрлэх байгууламжаас бусдад нь цэвэрлэгээний түвшинд хяналт тавих лаборатори байхгүй байна.

Арьс, ширний үйлдвэрүүдээс гарч байгаа бохир усанд хийсэн шинжилгээний дүнгээр төвлөрсөн ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хэрэгцээт хүчилтөрөгч, умбуур бодисын хэмжээ нь зөвшөөрөгдөх агууламжаас 5-20 дахин их байгаа бөгөөд сульфат, сульфитын агууламжтай байна. Энэ нь Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн технологийн горимд доголдол үүсэх үндсэн нөхцөл болж байна.

Туул, Хараа, Ерөө зэрэг томоохон голуудын ус татарч, голын ай сав бохирдон, ой мод, хөрс, ургамлын бүрхэвч доройтноос газрын доорхи усны тэжээл багассаар байгаа нь Улаанбаатар хот болон бусад хот, суурины ундны усны

нөөцийг нарийвчлан тогтоох, дахин үнэлэх, хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Байгалийн усны нөөцийн нөхөн сэргээх чадавхийг дээшлүүлж, нөөцийг үр ашигтай ашиглах, төвлөрсөн шугам сүлжээний ашиглалт, үйлчилгээг сайжруулах, шинэчлэн засварлах, зохистой хэрэглээг төлөвшүүлэх, усны алдагдлыг багасгах, ус хангамжийн үйлчилгээг эрхэлж байгаа байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, шинэ техник технологи нэвтрүүлэх, цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг сэргээх, гэр хорооллыг цэвэр, бохир усны сүлжээнд холбох, бага оврын цэвэрлэх байгууламж ашиглах зэрэг асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Цаашдын зорилт

Ойрын хугацаанд:

- Ус хангамжийн салбарын хууль эрх зүйн орчин, норм, нормативыг боловсронгуй болгох,
- Хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан усаар хангах хүрээнд төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэн, нөөцийн үнэлгээг хийх, одоо ашиглаж байгаа газрын доорхи усны нөөцийг дахин үнэлэх,
- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тоног төхөөрөмж, барилга байгууламжийг өргөтгөх, сэргээн засварлах, дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар хэвийн найдвартай ажиллагааг хангах,
- Ус хангамж, ариутгах татуургын ажил, үйлчилгээг эрхэлж байгаа байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, энэ хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх,
- Цэвэр, бохир усны чанарын хяналтын лабораториудыг байгуулах, усны чанарын хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох,
- Ус зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх тоног төхөөрөмжийг шаардлагатай газруудад суурилуулах,

¹⁰ Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2007-2008 оны үр дүн, ҮСХ, ДБ, Улаанбаатар, 2009.

- Амины орон сууц, гэр хороолол, хотын захын эмнэлэг, сургууль, цэцэрлэгийг цэвэр, бохир усны нэгдсэн шугам сүлжээнд холбох,
- Хот суурингийн бохир усыг цэвэрлэж үйлдвэрийн зориулалтаар дахин ашиглах,
- Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй газарт цэвэрлэгээний түвшин өндөр, байгаль орчны сөрөг нөлөөгүй, эрчим хүчний хэмнэлттэй бага оврын цэвэрлэх байгууламж суурилуулах.
- Бохир усны цэвэрлэгээнээс гарсан лагийг боловсруулах, саарал усыг дахин ашиглах технологийг судалж нэвтрүүлэх,
- Арьс, шир, ноос ноолуурын үйлдвэрүүдийг урьдчилан цэвэрлэх байгууламжтай болгох,
- Хүн амын төлбөрийн чадвартай уялдсан үнэ тарифын механизм мөрдөх,
- Ус хангамжийн байгууламжийг ашиглах үйл ажиллагаанд нийтийн аж ахуйн үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, хувийн хэвшил түлхүү оролцох боломжтой болгох,
- Салбарын хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах тогтолцоог боловсронгуй болгох.

Дунд хугацаанд:

- Хот суурин газрын усны эрэл, хайгуулын ажлыг хийх,

Зорилт 17: 2015 он гэхэд хүн амын орон сууцны нөхцөлийг сайжруулах

Өнөөгийн байдал, хандлага

Нийт хүн амын 46 хувь нь гэрт, гуравны нэг нь сууцны тусдаа байшинд, тавны нэг нь нийтийн орон сууцны байшинд (цаашид нийтийн тохилог сууц гэнэ) амьдарч байна. Суурьшлаар нь авч үзвэл хотын бараг таван хүн тутмын хоёр нь сууцны тусдаа байшинд, арван хүн тутмын гурав нь нийтийн тохилог сууцанд, мөн арван хүн ам тутмын гурав нь гэрт амьдарч байна. Харин хөдөөгийн хүн амын гуравны хоёр нь гэрт, дөрөвний нэг нь сууцны тусдаа байшинд, үлдсэн нь нийтийн тохилог сууцанд

амьдарч байна (Хүснэгт 22).

Ядуурлын түвшин гэрт амьдран суугчид, сууцны тусдаа байшинд амьдрагчид, нийтийн тохилог сууцанд амьдрагчдын хувьд ялгаатай байна.

Гэрт суугчдын бараг хагас нь хот, хөдөөд амьдардагаас үл хамааран ядуу байна. Хотод нийтийн тохилог сууцанд амьдрагчдын 7 шахам хувь нь ядуу байхад хөдөөд тохилог сууцанд амьдрагчдын 22 хувь нь ядуу байна. Гэрт амьдрагсад илүү ядуу байх хандлагатай буюу таван хүн тутмын гурваас илүү нь ядуу байна.

Хүснэгт 22. Ядуурлын дүр төрх сууцны шинж байдлаар, хот, хөдөөгөөр, 2007-2008

	Ядуурлын хамралтын хүрээ			Хүн амд эзлэх хувь		
	Хот	Хөдөө	Улсын дундаж	Хот	Хөдөө	Улсын дундаж
Нийт	26.9	46.6	35.2	100.0	100.0	100.0
Гэр	46.7	50.1	48.8	28.8	68.6	45.7
Нийтийн тохилог сууц	6.7	22.0	8.5	30.9	5.3	20.0
Байшин	27.9	42.4	32.6	39.8	25.7	33.8
Бусад*	46.1	41.3	44.3	0.5	0.4	0.5

* Бусад сууцанд оюутны дотуур байр, компаний ажилчдын байр болон айл, өрхөд зориулаагүй бусад байшинг хамруулав.
Эх үүсвэр: ӨНЭЭС 2007-2008 оны үр дүн, 94-р тал. ҮСХ, ДБ, 2009

Улаанбаатар хот болон аймгийн төвийн хүн амын 30 шахам хувь нь ядуу байгаа бөгөөд харин ядуучуудын тэн хагас нь гэрт амьдарч байхад нийтийн тохилог сууцанд амьдардаг хүмүүсийн дөнгөж 6.7 хувийг ядуучууд эзэлж байна. Хөдөөд сууцны төрөл тус бүрд ядуучуудын тархалт нь нийт хүн амын тархалттай ойролцоо буюу дөрвөн хүн тутмын гурав нь гэрт, үлдсэн нь байшинд амьдарч байна.

Дэмжих орчин

Засгийн газар “Дөчин мянган орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээс хойш барилгын салбарын хөгжил эрчимжиж, барилга угсралт, хот байгуулалтын ажил өргөжин, Засгийн газрын бонд, гадаадын хөрөнгө оруулалт, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, иргэдийн хүч, хөрөнгөөр 31,550 айлын орон сууц ашиглалтад орсны дотор 15 мянга гаруй нь инженерийн хангамжтай, нийтийн зориулалттай орон сууц байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хотын инженерийн шугам сүлжээ бүхий төвийн хэсэгт нийтийн зориулалттай орон сууц барих, хотын захын ашиглалтгүй нөөц газарт шинээр орон сууцны дэд бүтэц бүрдүүлэх замаар шинэ хотхон, хороолол барих, гэр хорооллын нутаг дэвсгэрт газар зохион байгуулалт дахин хийж, айл өрхүүдийг цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбон орон сууцны нөхцөлийг сайжруулан орон сууцны хороолол болгон хөгжүүлэх ажлыг эхлээд байна.

Улаанбаатар хотын салхины зонхилох чиглэл дээр байрлах байгууллагуудын эзэмшилд байгаа зарим газруудыг эргүүлэн авч барилгажуулах зорилгоор Засгийн газрын 2008 оны 27 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх хөтөлбөр”-ийг баталж, гэр хорооллын хэсэгчилсэн төлөвлөгөөг боловсруулах, дэд бүтцийг барьж байгуулах, иргэдийн үүсгэл санаачилгын үндсэн дээр тэдний өмчлөлд байгаа газрыг орон сууцаар солих, худалдан авах зэрэг ажлыг хийж байна.

Тулгамдсан асуудал

Засгийн газраас хүн амыг орон сууцаар хангах хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлж байгаа хэдий

ч бага, дунд орлоготой иргэдийг орон сууцаар хангах чиглэлээр тодорхой үр дүнд хүрэхгүй байна.

Шатах, тослох болон барилгын материалын зах зээлийн үнийн өсөлт, орон сууцны эрэлт, хэрэгцээ их байгаа, нийлүүлэлт бага зэргээс шалтгаалан орон сууцны нэг ам дөрвөлжин метр талбайн үнэ дунджаар 850 ам.долларт хүрсэн тул бага, дунд орлоготой иргэд орон сууц шууд худалдан авах, орон сууцны зээлийн сарын төлбөрийг төлөх чадваргүй хэвээр байна.

Эрүүл ахуйн шаардлага хангахуйц нөхцөлд амьдарч байгаа хүн амын эзлэх хувь нь хүн амын орон сууцны тооллогын мэдээгээр гардаг учраас хэрэгжилтийг жил бүр хэмжиж, дүгнэх боломжгүй байна.

Цаашдын зорилт

Ойрын хугацаанд:

- “Зуун мянган орон сууц” төсөл, “Орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх,
- Санхүү, эдийн засгийн хямралын үед илүүтэй өртсөн орон сууцны барилгын ажлыг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Орон сууцны барилгын салбарт үүссэн өр төлбөр, банкны зээлийг шийдвэрлэх,
- Хөдөө орон нутагт иргэдийг хувиараа орон сууц барьж ашиглах асуудлыг төрийн бодлогоор дэмжих, урт хугацааны зээл олгох,
- Иргэдийг орон сууцжуулахтай холбогдуулж гадаад орон, олон улсын байгууллагаас зээл тусламж авах, түүнийг хувийн орон сууц барихад нь олгох,
- Орон сууцны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах,
- Үл хөдлөх хөрөнгө барьцаалах тухай, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулиудыг хэрэгжүүлэх,
- Ашиглалтад орсон орон сууцны талаархи үнэн зөв мэдээллийг олон нийтэд хүргэх.

Дунд хугацаанд:

- Орон сууцны урт хугацаатай зээлийн эх үүсвэрийг бүрдүүлэх,
- Хот байгуулалт, барилгын мэдээллийн нэгдсэн санг бий болгох,

- Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар барьсан түрээсийн орон сууцны тогтолцоог бий болгох,
- Шинэ хотхон, хороолол барьж байгуулахад хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих.



ЗОРИЛГО 8

**ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ДЭЛХИЙ НИЙТИЙН
ТҮНШЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ**

Зорилт 18: *Худалдааны болон санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх замаар Мянганы хөгжлийн зорилтуудыг хангах таатай нөхцөл бүрдүүлэх*

Өнөөгийн байдал, хандлага

Худалдаа. Сүүлийн 10 жилийн байдлаар экспортын ДНБ-д эзлэх хэмжээ 46-49.6 хувьтай байгаа бөгөөд 2007 онд 49.6 хувь, 2008 оны байдлаар 48.3 хувь байна (Хүснэгт 23).

Манай улс дэлхийн 110 гаруй оронтой худалдаа хийж байна. Худалдааг либеральчлах бодлогын үр дүнд гадаад худалдааны бараа эргэлтийн хэмжээ нэмэгдэж, нэр төрөл, бүтцэд эерэг өөрчлөлтүүд гарав. Гадаад худалдааны нийт барааны эргэлт 2008 оны байдлаар 5,779.1 сая ам.доллар, үүнээс экспорт 2,534.5 сая, импорт 3,244.6 сая ам.доллар болж, гадаад худалдааны тэнцэл 710.1 сая ам.долларын алдагдалтай гарлаа.

2008 оны гадаад худалдааны нийт барааны эргэлтийн хэмжээг 1996, 2000, 2004 онуудтай харьцуулбал 3-6 дахин, 2007 оныхоос 44.1 хувиар өссөн байна. Хэдийгээр гадаад худалдааны барааны эргэлтийн хэмжээ нэмэгдэж байгаа боловч нийт тэнцлийн зөрүү

өсч байна. Энэ нь нэг талаар манай экспортын бүтээгдэхүүний нэр төрөл цөөн, түүхий эдийн экспорт голлож байгаа, нөгөө талаар импортын бүтцэд өндөр хувь эзэлдэг газрын тосны бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнийн огцом өсөлт голлон нөлөөлсөн байна. Нийт экспортын хэмжээ 2007 оныхоос 30.1 хувь буюу 587.0 сая ам.доллараар өссөний 50.9 хувь нь үнийн өсөлт, 49.1 хувь нь биет хэмжээний өсөлт байна.

БНХАУ-тай хийж байгаа гадаад худалдааны бараа эргэлт манай улсын гадаад худалдааны 43.6 гаруй хувийг эзэлж байна. БНХАУ, ОХУ чухал байр суурь эзэлж байгаа бөгөөд импортын 30.0 гаруй хувийг эзэлж байна.

Монгол Улс 2005 оноос Европын Холбоо (ЕХ)-ны тарифын тусгай хөнгөлөлт (GSP+)-ийн хөтөлбөрт хамрагдаж эхэлсэн бөгөөд 2008 оны байдлаар ЕХ-ны гишүүн орнуудтай хийсэн худалдаа 727.5 сая ам.доллар болж, нийт гадаад худалдаанд 12.6 хувийг эзэлж байна.

Хүснэгт 23. ХАЁТ, ДНБ-д эзлэх экспортын хувь болон санхүүгийн гүнзгийрэл

		1990	2000	2006	2007	2008	2015
42	Худалдааны хүчин чадлыг бий болгоход туслахаар үзүүлсэн ХАЁТ-ийн эзлэх хувь	-	1.63 ^a (2003)	5.3 ^a 0.021 ^b	0.0138 ^b	0.0063 ^b	10.0 ^a
43	Нийгмийн суурь үйлчилгээнд үзүүлсэн ХАЁТ-ийн эзлэх хувь	-	6.92 ^a (2003)	3.28 ^a 22.0 ^b	28.5 ^b	32.5 ^b	5.0 ^a
44	Дотоодын нийт бүтээгдэхүүнд экспортын эзлэх хувь	34.7 ^a 28.0 ^b	56.6 ^a 49.2 ^b	49.0 ^a	49.6 ^b	48.3 ^b	70.0 ^a
45	Санхүүгийн гүнзгийрэл: Дотоодын нийт бүтээгдэхүүн, нийт мөнгөний харьцаа	18.5 ^a (1995) 46.4 ^b	25.4 ^a 22.1 ^b	41.4 ^a	52.2 ^b	37.8 ^b	65.0 ^a

Эх үүсвэр: а. УИХ-ын тогтоол #13, Монгол Улсын МХЗ-уудыг батлах тухай, 2008

б. Сангийн яам, 2008

в. Монгол банк, 2008

Санхүү. Манай улсын санхүүгийн зах зээлийн хөгжилд дэлхийн санхүүгийн хямрал шууд болон шууд бусаар нөлөөлөв. Манай улсын экспортын гол нэрийн бүтээгдэхүүн зэсийн баяжмал, цайр зэрэг металлын үнэ ханш 2008 оны дунд үеэс эхлэн огцом буурсанаас төсвийн орлого бүрдэлтэнд сөрөг нөлөө үзүүлэв.

2008 онд банкны салбарын харилцах дансны дүн 2007 онтой харьцуулахад 2.7 хувиар, хадгаламжийн дүн 2.9 хувиар өсч, банкны системийн нийт актив оны эцсийн байдлаар 3.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 10.7 хувиар өссөн нь ДНБ-ий 59.2 хувьтай тэнцэж байна. Банкны салбарын актив өсөхийн хирээр хувийн хэвшилд олгох зээл, санхүүжилтийн хэмжээ ч нэмэгдсэн байна. Тухайлбал, 2000 онд банкууд 49.6 тэрбум төгрөгийн зээл олгож байсан бол 2008 онд 2,715.0 тэрбум төгрөгт хүрч, 54.7 дахин нэмэгджээ.

Арилжааны банкуудын зээлийн менежмент сайжирч, ААНБ, иргэдийн санхүүгийн хариуцлага, ур чадвар нэмэгдсэний дүнд чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувийн жин 2000 онд 23.5 байсан бол 2008 оны эцсийн байдлаар 7.1 хувь болж буурсан ч энэ дүн 2007 онтой харьцуулахад 3.9 нэгжээр өссөн нь олон улсын санхүү, эдийн засгийн хямрал сөргөөр нөлөөлснийг харуулж байна.

Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-уудын активын чанар харьцангуй сайн байгаа ч, тэдний санхүүгийн зуучлалд гүйцэтгэж байгаа үүрэг хязгаарлагдмал, банктай харьцуулахад өрсөлдөх чадвар сул хэвээр байна.

Үнэт цаасны арилжаа 2007-2008 онд 40.2 тэрбум төгрөгөөр буурсан нь хямралтай холбогдож иргэдийн санхүүгийн салбарт итгэх итгэл суларсныг харуулж байна. Монгол Улсын хөрөнгийн зах зээлд 2006-2008 онд хувьцааны арилжаа голлон хийгдэж, 2006 онд нийт арилжааны 70 хувийг, 2008 онд 97 хувийг эзэлж байна. Монголын Хөрөнгийн Биржийн ТОП 20 индекс нь 2006 оноос 2007 оны 9 сар хүртэл тасралтгүй өсч, 2007 оны 9 сараас 2008 оны 3 сарын хооронд хүчтэй хэлбэлзэн, улмаар тасралтгүй буурчээ. Уг хэлбэлзэл нь хөрөнгийн зах зээлд санхүү, эдийн засгийн хямрал ажиглагдсаны илэрхийлэл юм.

2008 онд даатгалын салбар 21.5 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрүүлсэн нь 2007 оныхоос 1.27 дахин өсчээ. Энэ нь даатгалын компаниуд зах зээлд идэвхтэй оролцон шинэ бүтээгдэхүүнүүд

нэвтрүүлж байгааг, нөгөө талаар иргэд даатгалын ач холбогдлыг илүүтэйгээр ухамсарлан, учирч болох эрсдлийг тооцон даатгалд олноор хамрагдах болсныг харуулж байна.

Дэмжих орчин

Худалдаа. Монгол Улс 1997 онд Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-д гишүүнээр элссэнээр Монгол Улс тарифын болон тарифын бус хэлбэрээр гадаад худалдааг либеральчлах бодлого явуулж байна. Монгол Улс 2004 онд Азийн хамтын ажиллагааны яриа хэлэлцээ (ACD), 2005 онд АСЕАН-ы Найрамдал, хамтын ажиллагааны Гэрээнд нэгдэн орсон билээ.

Монгол Улс 2000 онд Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны Зөвлөлийн хавсарсан гишүүн болсноос хойш АПЕК-т элсэх чиглэлээр ажиллаж байна. АПЕК-ийн нэг том зорилт нь тус бүс нутгийн хөгжингүй орнуудыг 2010 он гэхэд, хөгжиж байгаа орнуудыг 2020 он гэхэд чөлөөт болон нээлттэй худалдаа, хөрөнгө оруулалтын тогтолцоонд тус тус шилжүүлэх явдал юм.

Сүүлийн жилүүдэд хөрш орнуудтай хийж байгаа хоёр талын худалдааны нөхцөлд тодорхой ахиц гарлаа. “Монгол, Оросын хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг 2006-2010 онд хөгжүүлэх хөтөлбөр”-ийг 2007 онд батлан, “Монгол, Хятадын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийг 2008 онд тус тус батлав. Экспортын барааны нэр, төрлийг олшруулах, ХАА-н гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд БНХАУ-тай зарим барааны хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн шаардлагын тухай Протоколуудыг 2008 онд байгуулан ажиллаж байна.

Худалдааны хөнгөлөлтийн асуудлаар хийж байгаа яриа хэлэлцээ үр дүнгээ өгсөөр байна. Европын Холбоо манай улсын худалдааны 3 дахь түнш болж, тарифын тусгай хөнгөлөлтийг 2009-2011 онд Монгол Улс үргэлжлүүлэн эдлэх шийдвэрийг гаргалаа.

Монгол Улсаас Америкийн Нэгдсэн Улс (АНУ)-тай Чөлөөт худалдааны “Ил тод байдлын тухай” хэлэлцээрийг эхлүүлэв. Гар урлалын болон бусад 14 төрлийн бүтээгдэхүүнийг АНУ-ын зах зээлд татваргүй нийлүүлэх боломжтой болсон.

Санхүү. Санхүүгийн салбарын дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулж байна. ББСБ болон хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зуучлалын хүрээг өргөжүүлэн, хүртээмжийг нэмэгдүүлэх, санхүүгийн шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжих үүднээс тус салбарын хууль, эрх зүйн орчин, дэд бүтэц, хяналт, эрсдлийн удирдлага, үйл ажиллагааны зохицуулалтыг боловсронгуй болгох, улмаар цаашдын тогтвортой хөгжлийн суурийг бэхжүүлэх зорилт тавьж байна.

Хөрөнгийн зах зээлийн хууль, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, оролцогчдын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, үнэт цаас гаргах үйл ажиллагааг идэвхжүүлэх замаар хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд анхаарч байна.

Тулгамдсан асуудал

Барааны эргэлт мэдэгдэхүйц өссөн ч гадаад худалдааны нөхцөл сайжруулах асуудал анхаарал татаж байна. 2007 онд 1 ам.долларын экспортод 1.05 ам.долларын импорт ногдож байсан бол 2008 онд мөн хэмжээний экспортод 1.28 ам.долларын импорт ногдох боллоо. Ийнхүү 1 ам.доллартай тэнцэх экспортоор худалдан авах импортын хэмжээ ихэссэн нь импортын барааны үнийн өсөлттэй холбоотой ч экспортын бараа үйлдвэрлэл, борлуулалтанд дорвитой ахиц гараагүй, импортын барааны үнийг ашигтай байлгах, хямдруулах, экспортын урамшуулах талаар хангалтгүй ажиллаж байна.

Тариф, тоон хязгаарлалт зэрэг хүчин зүйлээс гадна барааг импортлох, экспортлох болон транзит тээврийн төвөгтэй, шат дамжлага ихтэй байдал, захиргааны дүрэм, журам, хүнд суртал, хилийн хяналтын давхардсан, хэт нүсэр үйл явц зэргээс үүдсэн саад бэрхшээл нь гадаад худалдаа эрхлэгчдийн зардлыг ихээхэн нэмэгдүүлж байна.

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн эгзэгтэй үед санхүүгийн салбар тэргүүлэх үүргийг гүйцэтгэх шаардлагатай байна.

Цаашдын зорилт

Худалдааны салбарын хүрээнд:

- Монгол Улсын экспортыг хөгжүүлэх Үндэсний стратеги болон Худалдааны

стратеги, хөтөлбөр боловсруулах, хөтөлбөрийг санхүүжүүлэх асуудлаар олон улсын байгууллагуудад санал тавих,

- Худалдааны багц хуулийг УИХ-аар хэлэлцүүлэн батлуулж, эрх зүйн орчинг боловсронгуй болгох,
- Гадаад худалдаанд оролцогч бүх байгууллагуудын ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах,
- Хилийн боомт дээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагуудын хяналт, шалгалтын тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулах, нэгдсэн байр, нэг цэгт хяналт шалгалт явуулах, мэдээлэл солилцох тогтолцоог бий болгох,
- Худалдаатай холбоотой захиргааны дүрэм журмыг цөөлөх, мэдээллийг бизнес эрхлэгчдэд хүртээмжтэй болгох, ил тод байдлыг хангах,
- Үйлчилгээний худалдааг хөгжүүлэх, ялангуяа банк, санхүү, аялал жуулчлалын салбарыг тэргүүлэх чиглэл болгох.

Санхүүгийн салбарын хүрээнд:

- Хөрөнгийн зах зээлийн хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх,
- Шинээр үнэт цаас гаргах харилцааг үнэт цаасны зах зээлд оролцогч этгээдийн үүрэг, хариуцлагатай уялдуулан зохицуулж, журамлах,
- Хөрөнгө оруулагчдыг шаардлагатай, үнэн зөв мэдээллээр шуурхай хангаж, эрсдэлийн үнэлгээ хийх боломжийг бүрдүүлэх, санхүүгийн зах зээлд оролцогчдын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулахын тулд мэдээллийн нэгдсэн сүлжээг байгуулах,
- Ипотекийн хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх,
- Заавал даатгалын тогтолцоо, даатгалын шинэ бүтээгдэхүүнийг олон улсын жишигт тохируулан нэвтрүүлэх, эрх зүйн зохицуулалтыг бий болгох,

- Хяналт, шалгалтыг сайжруулж, чанаржуулан, нягтлан бодох бүртгэл, тайлагналын тогтолцооны чанарыг дээшлүүлэх,
- Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын зөвлөмж, стандартыг

нэвтрүүлэх замаар эрсдэлийн удирдлагыг боловсронгуй болгох,

- Бичил санхүүгийн байгууллагуудыг олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас олгодог бөөний зээлийн үйлчилгээнд өргөнөөр хамруулах.

Зорилт 19: *Далайд гарцгүй Монгол Улсын онцгой хэрэгцээ, шаардлагыг харгалзан илүү тааламжтай нөхцөлөөр далайд гарцтай болох, гадаадад дамжин өнгөрөх тээврийн үр ашгийг дээшлүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээврийг өргөжүүлэх*

Өнөөгийн байдал, хандлага

Манай улсын төмөр зам нь Варшав хотод төвтэй “Төмөр замын хамтын ажиллагааны байгууллага”-ын хүрээнд үйлчилж байгаа тээврийн нэгдүгээр коридорт багтдаг бөгөөд уг коридороор чингэлэг тээвэрлэлтийн болон дамжин өнгөрөх тээвэрлэлтийг зохион байгуулдаг. Энэ коридорын хүрээнд Брест-Улаанбаатарын чиглэлд “Монгольский вектор” олон улсын чингэлгийн галт тэрэг аялж байгаа бөгөөд 2007 онд 25 галт тэргээр 646 ТЭУ (20 тн чингэлэг) тээвэрлэсэн байна.

2007 онд БНХАУ-аас Чех улс руу Шеньжен-Эрлян - Замын-Үүд - Наушки чиглэлээр “Интернациональ Транс Транзит” чингэлгийн галт тэрэгний аялалыг зохион байгуулав.

Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээврийг өргөжүүлэх хүрээнд ОХУ-

ын “Оросын төмөр зам” нээлттэй хувьцаат нийгэмлэг, мөн БНХАУ-ын Төмөр замын яамтай хамтран хамтын ажиллагааны протоколыг байгуулан ажиллаж байна.

2008 онд Бээжин, Москва, Берлин хотноо Хятад, Монгол, Орос, Белорус, Польш, Герман зэрэг улсын төмөр замын байгууллагуудын удирдлагуудын хамтарсан уулзалтыг зохион байгуулсны дүнд БНХАУ-ын Бээжин хотоос ХБНГУ-ын Гамбург хот хүртэл дээрх 6 улсын нутгаар дамжуулан чингэлгийн хоёр галт тэргээр 184 ТЭУ (20 тн чингэлэг) тээвэрлэсэн байна.

2008 онд ОХУ-аар дамжин тээвэрлэх ачааны хэмжээ эрс буурч, 2006 оноос даруй 49.2 хувиар буурсан нь ОХУ-аас БНХАУ руу тээвэрлэж байсан түүхий нефтийн тээвэрлэлт зогссонтой холбоотой юм (Хүснэгт 24).

Хүснэгт 24. Дамжин өнгөрөх тээвэрлэлт, мянган тонн, 2003-2008

	2003	2004	2005	2006	2007	2008
ОХУ-аас БНХАУ-д	3,453.4	4,648.0	5,028.4	4,003.0	2,944.7	1,970.2
БНХАУ-аас ОХУ-д	191.4	176.0	364.9	463.1	528.6	366.9
Бүгд	3,644.8	4,824.0	5,393.3	4,466.1	3,473.3	2,337.1

Эх үүсвэр: а. ЗТБХБЯ, 2008

Улсын төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сан (МУХС)-ийн хөрөнгө оруулалтаар Мянганы зам төслийн хэвтээ тэнхлэгийн чиглэлд 734 орчим км хатуу хучилттай авто зам, 46.8 км хайрган зам тавих, модон гүүр, төмөр бетон гүүр барих, баруун бүсийн босоо тэнхлэгийн чиглэлд 160 км хатуу хучилттай авто замын барилгын ажил хийгдэж байна.

Олон улсын авто замын сүлжээний АН-3-ын Чойр-Сайншанд-Замын-Үүдийн чиглэлд АХБ, БНСУ-ын “Экзим” банкны хөнгөлөлттэй зээлээр 432 км хатуу хучилттай авто зам барьж байна. Мөн Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Мянганы зам төслийн зүүн гол зам буюу Багануур-Өндөрхааны чиглэлд 58.9 км хатуу хучилттай автозамыг барьж дууслаа.

Дэмжих орчин

Дамжин өнгөрөх тээврийн асуудлыг зохицуулах “Худалдаа, тээврийг хөнгөвчлөх Үндэсний хороо”-г байгуулан ажиллаж байна. Энэ хорооноос санаачлан “Транзит Монгол” Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын Засгийн газар хоорондын “Дамжин өнгөрөх тээврийн тухай” ерөнхий хэлэлцээр байгуулах ажиллаж байгаа бөгөөд мөн Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын “Авто тээврийн тухай” хэлэлцээрт оруулах нэмэлт өөрчлөлтийг бэлэн болгов. Дамжин өнгөрөх тээвэрлэлтийг авто тээврийн хэрэгслээр зохион байгуулах, хяналт тавих, тээвэрлэлтийн үнэ тариф тогтоох, орлого бүрдүүлэх, хуваарилах арга хэрэгсэл, тогтолцоог бий болгохоор ажиллаж байна.

Монгол орны далайд гарах шинэ боломжийг бий болгох зорилгоор Монгол Улсын төмөр замын сүлжээг хөгжүүлэх хөтөлбөрийн төслийг боловсруулж, батлуулах чиглэлээр ажиллаж байна. Сүхбаатар-Замын-Үүд хоорондын гол шугам хойд талаараа ОХУ-ын Транссибирийн төмөр зам, урд талаараа БНХАУ-ын төмөр замтай холбогдох зам нь Европоос Зүүн Ази хүртэл тээвэрлэх ачааг Монгол Улсын нутгаар дайруулан тээвэрлэх, Өвөр Байгаль-Манжуурын чиглэлээс 1135 км, Дундад Ази-Зүүн гарын (Торгоны зам) чиглэлээс 1600 км-ээр дөт юм. Мөн БНХАУ-ын Тяньжин хотын Бинхай дүүрэгт далайн тээврийн хөлөг онгоцны зогсоол, терминал бүхий чөлөөт бүсийн газар авч ашиглах талаар БНХАУ-ын талтай тохиролцож, хамтран ажиллах талаар хоёр талын төлөөлөл оролцсон ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Монгол Улсын далайн тээврийн салбарт баримтлах бодлогын талаар МХЗ-д суурилсан ҮХЦБ болон “Транзит Монгол” Үндэсний хөтөлбөрт тодорхой тусгагдсан. ОХУ-ын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хооронд 1992 онд байгуулсан Монгол Улс, ОХУ-ын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэх тээвэр хийх, далайд гарах хэлэлцээрт ОХУ-ын бүх далайн боомтуудыг ашиглаж болохоор тусгагдсан бөгөөд эхний ээлжинд газар зүйн байдлыг харгалзан Владивосток хотын боомтыг ашиглах талаар ОХУ-ын талд санал тавиад байна.

Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын өмнө тулгарч байгаа нийтлэг хүндрэл бэрхшээлийг

судлах, тэдгээрийг даван туулах арга замыг тодорхойлох, бодлогын чанартай санал зөвлөмж гаргах шаардлага нэн чухлаар тавигдаж байгааг харгалзан Монгол Улс Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын Олон улсын судалгааны төвийг Улаанбаатар хотноо байгуулах санаачилга гаргаж НҮБ болон бусад холбогдох талуудын дэмжлэг авсан билээ. НҮБ-ын ЕНБД Бан Ги Мун 2009 оны 7 дугаар сард Монгол Улсад албан ёсоор айлчлах үеэр тус Төвийн нээлтийн ажиллагаанд оролцож, Төвийн үйл ажиллагааг НҮБ-ын системийн байгууллагын хүрээнд дэмжиж ажиллахыг илэрхийлсэн.

Тулгамдсан асуудал

Монгол Улсаар дамжин өнгөрөх тээвэрлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр ОХУ-ын холбогдох эрх бүхий байгууллагуудтай нягт хамтран ажиллах хоёр хөрш орны хооронд хийгдэх дамжин өнгөрөх тээврийн хэмжээг нэмэгдүүлэхэд Монголын төмөр замын оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Төмөр замын дамжин өнгөрөх тээврийн хүчин чадлыг нэмэгдүүлж, парк шинэчлэлтийг эрчимжүүлэх, авто тээврийн дамжин өнгөрөх тээврийг нэмэгдүүлэх техникийн нөхцөлийг сайжруулах асуудал тулгарч байна.

Зам, тээврийн салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, дамжин өнгөрөх ачааг сэлгэн ачих байгууламжийг сайжруулах нь чухал болж байна.

Цаашдын зорилт

- Дамжин өнгөрөх тээврийн тухай Засгийн газрын 3 талт хэлэлцээрийг ойрын үед эцэслэн шийдвэрлэх,
- Дамжин өнгөрөх тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр хөрш орнуудын тээврийн байгууллага болон ачаа тээвэрлэгч нартай хамтран ажиллах,
- Зам, тээврийн салбарт оруулах хөрөнгө оруулалтыг төр, хувийн хэвшлийн оролцоотой шийдвэрлэх,
- Бүс нутагт Монгол Улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, дамжин өнгөрөх тээвэрлэлтийг нэмэгдүүлэх, экспортын зах зээлийг өргөтгөх зорилгоор тарифын уян хатан бодлогыг баримтлах чиглэлээр хөрш орнуудтай байгуулсан

хамтын ажиллагааны тухай хэлэлцээр болон Санамж бичигт тусгах чиглэлээр ажиллах,

- Дамжин өнгөрөх тээвэрлэлтийг нэмэгдүүлэхэд Европоос Ази руу тээвэрлэх ачаа хомс байгааг харгалзан Европын орнуудтай байгуулж байгаа худалдаа, хамтын ажиллагааны тухай баримт бичигт тээвэрлэлтийг дэмжих тухай асуудлуудыг тусгах,

- Зам, тээврийн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх,
- Гадаадад дамжин өнгөрөх тээврийн үнэ тарифыг хямдруулах, саатлыг багасгах замаар хөрш орнуудтай хамтарч ажиллах,
- Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын Олон улсын судалгааны төвийн санхүүжилт, судалгааны чадавхи, олон улсын нэр хүндийн хувьд дэмжих.

Зорилт 20: *Урт хугацаанд гадаад, дотоод өрийн тогтвортой байдлыг хангах үүднээс өрийн стратегийг бий болгох, үндэсний болон олон улсад хэрэглэж байгаа арга хэрэгслийг судалж, Монгол Улсын төсөв, эдийн засагт хүндрэл учруулахгүйгээр өрийг зохицуулан шийдвэрлэж байх*

Өнөөгийн байдал, хандлага

Монгол Улсын гадаад өрийн хэмжээ 2008 оны эцэст 1.6 тэрбум ам.доллар буюу 2.0 их наяд төгрөг байна. Энэ нь ДНБ-ий 21.5 хувь (өнөөгийн үнэ цэнээр)-тай тэнцэж байна. Засгийн газрын өрийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг Хүснэгт 25-д дэлгэрэнгүй харуулав. Эндээс харахад Монгол Улс дунд хугацаанд өрийн дарамт харьцангуй бага байна.

Засгийн газар хандивлагч орон болон олон улсын санхүүгийн байгууллагаас 2006-2008 онд нийт 248 сая ам.долларын зээл авч ашигласан бөгөөд үүний 52 хувийг дэд бүтцийн салбарт, 14 хувийг нийгмийн халамж, ядуурал, эрүүл мэндийн салбарт, үлдсэн 34 хувийг бусад салбарт авч ашиглажээ (Дүрслэл 16).


Хүснэгт 25. Засгийн газрын өрийн тогтвортой байдлын үзүүлэлтүүд, хувиар

Үзүүлэлт	2008	Сэрэмжлэх түвшин**	Тайлбар
Өр*/ДНБ	21.5	40.0	Тогтвортой
Өр*/Экспорт	44.3	150.0	Тогтвортой
Өр*/ЗГ-ын орлого	52.9	250.0	Тогтвортой
Өрийн үйлчилгээ/Экспорт	2.4	20.0	Тогтвортой
Өрийн үйлчилгээ/ЗГ-ын орлого	2.9	30.0	Тогтвортой

Тайлбар: Өр* - Өрийн үлдэгдэл өнөөгийн үнэ цэнээр (2008 оны урьдчилсан гүйцэтгэл)
Сэрэмжлэх түвшин** - ОУВС, ДБ-аас тогтоосон шалгуур үзүүлэлт

Эх үүсвэр: Сангийн яам, 2009

Дүрслэл 16. Гадаад зээлийн ашиглалт, салбараар, 2006-2008




Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдлийн 62 хувийг олон талт эх үүсвэр болох олон улсын санхүүгийн байгууллагын зээл, үлдсэн 38 хувийг хоёр талт эх үүсвэр болох хандивлагч орноос авсан зээлийн үлдэгдэл эзлэж байна. Мөн гадаад зээлийн үлдэгдлийн валютын багцыг авч үзвэл 61 хувийг Зээлжих тусгай эрх (ЗТЭ), 22 хувийг Японы иен, үлдсэн 17 хувийг бусад валютууд эзлэж байна.

Засгийн газраас Улсын төсвийн алдагдлыг үнэт цаас гаргах хэлбэрээр санхүүжүүлж ирлээ. Засгийн газар 1996-2008 оны хооронд нийт 448.6 тэрбум төгрөгийн үнэт цаас гарган

арилжаалсан байна. Түүний 447.3 тэрбум төгрөгийг мөнгөжүүлсэн болон хүүгийн төлбөрт 15.6 тэрбум төгрөг төлсөн байна (Дүрслэл 17).

Дүрслэл 17. Засгийн газрын дотоод зээл, 1996-2008



Эх үүсвэр: Сангийн яам

Засгийн газрын үнэт цаасыг олон нийтэд санал болгон худалдсан нь эдийн засгийн түгжээ болсон өрийн дарамтыг бууруулах, төсвийн тэнцлийг уян хатан шуурхай зохион байгуулж, санхүүжилтийг хугацаанд нь олгоход гол үүрэг гүйцэтгэсэн.

Дэмжих орчин

Засгийн газрын өрийн дунд хугацааны стратегийн баримт бичгийг 2007 онд батлан гаргав. Энэхүү стратегийн баримт бичиг нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Дунд хугацааны Төсвийн хүрээний мэдэгдэлтэй уялдах бөгөөд Засгийн газрын өрийн ачааллыг тогтвортой байлгах, төсвийн болон мөнгөний бодлогод дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн юм. Энэхүү стратеги нь Засгийн газрын өрийн үйлчилгээний зардлыг бууруулах, нийт өрийн

Зорилт 21: *Мэдээлэл холбооны шинэ технологийг хөгжүүлэх, “Мэдээлэлжсэн нийгэм” байгуулах*

Өнөөгийн байдал, хандлага

2004 оноос хойш үндсэн сүлжээнд 5,997 км өргөтгөл хийгдэж, өндөр хурдын шилэн кабелийн сүлжээ өнөөгийн байдлаар 5 дахин нэмэгдэж 11,073 км-т болж нийт 139 сум, суурин газар өндөр хурдын шилэн кабелийн

багцын эрсдэлийг багасгахыг гол зорилтоо болгосон. Түүнчлэн Засгийн газрын үнэт цаасны арилжаа нь дотоод зах зээлийг дэмжих, үйл ажиллагааг нь идэвхжүүлэхэд чиглэгдэж байна.

Тулгамдсан асуудал

Дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал манай улсын төсөв, санхүү, эдийн засагт сөргөөр нөлөөлж байна. Монгол Улсын хувьд хямралыг давахын тулд гадны хоёр талт болон олон талт эх үүсвэрээс зээл авахаар яригдаж байгаа нь гадаад өрийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдэд муугаар нөлөөлж болох юм. Өрийн удирдлагын нэгжийн боловсон хүчний чадавхийг сайжруулах шаардлагатай байна. Мөн үр ашиггүй гадаад зээл, өрийг багасгах нь чухал байна.

Цаашдын зорилт

Ойрын хугацаанд:

- Өрийн удирдлагыг хэрэгжүүлэх нэгжийн бүтцийг олон улсын жишгийн дагуу өөрчлөн зохион байгуулах,
- Хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж байгаа төслүүдийн бүртгэл, хяналтыг сайжруулах, өрийн судалгаа, шинжилгээг тогтмол хийж хэвшүүлэх.

Дунд хугацаанд:

- Засгийн газрын өрийн удирдлагыг хөгжүүлэхийн тулд гадаад өрийн оновчтой багцыг тодорхойлох, гадаад өрийн үлдэгдлийг Санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг ашиглан Монгол Улсын валютын нөөцтэй уялдуулах шаардлагатай байна.

сүлжээнд холбогдлоо.

Суурин утасны цэгийн тоо 2000 оноос хойш тогтмол өссөөр 2008 онд 178.6 мянгад хүрч 2007 оноос 15.3 хувиар нэмэгдлээ (Дүрслэл 18). Суурин холбооны үйлчилгээнд өрсөлдөөнийг дэмжих, үндсэн сүлжээний

ашиглалт чөлөөтэй, ялгаваргүй байх бодлогын арга хэмжээ хэрэгжүүлж, ялангуяа хөдөө, орон нутагт хэрэглэгчийн тоон шугам (ADSL) нэвтрүүлснээр 2008 онд суурин утасны цэгийн тоо өсөх хандлагатай болов.


Үүрэн телефон хэрэглэгчдийн тоо 2000 оноос тогтмол өсч байна. МШХХТГ, ХХЗХ, үүрэн холбооны оператор компаниуд хамтран “Сумдад үүрэн телефон холбоо хүргэх” төслийг хэрэгжүүлж 2008 онд бүх сумдын төв, суурин газруудыг үүрэн телефон холбооны сүлжээнд холбов. Ингэснээр нийт үүрэн телефон хэрэглэгчид 2007 онд 1,175.1 мянга байсан бол 2008 онд 1,745.9 мянга болж 48.5 хувиар өслөө.

Үүрэн телефон холбооны компаниуд техник, технологийг шинэчлэн сүлжээ, үйлчилгээний

хүрээгээ өргөжүүлснээр хэрэглэгчдийн тоо байнга өсч, үйлчилгээний хэлбэр хүрээ нь өргөжиж, үнэ, тариф нь буурсаар байна.

Интернэтийн байнгын хэрэглэгчдийн тоо 2008 онд 42.0 мянга болж 2004 оноос 2 дахин өсч, цаашид ч нэмэгдэх хандлагатай байна. МШХХТГ-аас Улаанбаатар Төмөр зам ХНН-тэй хамтран олон улсын интернэтийн урсгал авдаг технологийг шинэчилж, DWDM шинэ технологид суурилсан 1,2 Гб/с-ийн нэмэлт урсгалыг 2007 онд ашиглалтад орууллаа. Олон улсын интернэт урсгалын хурд, багтаамж 2004 онтой харьцуулахад 4 дахин нэмэгдэж, интернэтийн 1 Мб/с урсгалын түрээсийн үнэ, эцсийн хэрэглэгчдэд хүрэх үнэ, тариф 4 дахин хямдарсан байна.

Дүрслэл 18. Суурин, үүрэн телефон, интернэтийн байнгын хэрэглэгчдийн тоо, мянган ширхэгээр



Дэмжих орчин

Засгийн газар мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ)-ийг нийгэм, эдийн засгийн бүхий л хүрээнд бүтээлчээр нэвтрүүлэх зорилт тавин үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийнхээ нэг болгон зарлаж тус салбарт зах зээлийн өрсөлдөөнт орчинг нэвтрүүлэх, шинэ дэвшилтэт техник, технологи нутагшуулах, хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, шаардлагатай дэд бүтцийг хөгжүүлэхэд онцгой ач холбогдол өгч ажиллалаа.

Мэдээлэл холбооны сүлжээгээр үйлчлүүлэх иргэдэд сүлжээг нээлттэй, тэгш эрхтэй ашиглах боломж олгох үүднээс 2007 онд цахилгаан

холбооны салбарт бүтцийн өөрчлөлт хийж сүлжээ, үйлчилгээний чиглэлээр зааглалт хийв.

Цахилгаан холбооны салбарын хувьчлал, бүтцийн өөрчлөлтөөр тусгай зөвшөөрөл бүхий ААНБ мэдээлэл, холбооны үндсэн сүлжээг түрээслэх, шинээр салбар сүлжээ байгуулах, давхардсан хөрөнгө оруулалтыг зохицуулах боломж бүрдлээ.

Суурин телефон утас холбооны үйлчилгээнд өрсөлдөөн бий болж, шинэ технологи бүхий интернэт протоколд суурилсан суурин холбооны үйлчилгээг хотын дотор, хот хооронд эрхлэх боломжтой боллоо.

Мэдээлэл, харилцаа холбооны үндсэн сүлжээг өргөтгөх, шинэчлэх ажлын хүрээнд 2007 онд 33 сумыг хамарсан 1,615 км шилэн кабелийн сүлжээ, 1,705 км үндсэн сүлжээний нөөц сүлжээг 2008 онд ашиглалтад оруулав (Дүрслэл 19).


Бүх нийтийн цахим боловсрол. Мэдээллийн технологийн бүх нийтийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн материаллаг бааз, орчинг бүрдүүлэх зорилгоор 2007-2008 онд боловсролын салбарт “Хүүхэд бүрт компьютер”, зайн сургалтын “Цахим танхим” зэрэг төслийг хэрэгжүүлж байна.

ЮНЕСКО байгууллагын Монгол Улс дахь

Үндэсний комисстой хамтран “Бүх нийтийг мэдээлэлжүүлэх хөтөлбөр”-ийн Үндэсний хороог байгуулав.

Кодчиллол, мэдээллийн нэгдсэн сан. МШХХТГ-аас 2007 онд Үндэсний нэгдсэн кодчиллын систем бүрдүүлэх зорилгоор кодчиллыг ач холбогдлоор нь дараалал тогтоов. “Шуудангийн нэгдсэн код (зип код)”-ыг бий болгох ажлыг эхлүүлж, дотоодод болон олон улсад хэрэглэж байгаа шуудангийн индексийг бусад төрлийн индекс кодуудтай харьцуулсан судалгаа хийж, аргачлал боловсруулжээ. Бүсчлэлийн кодыг Монгол Улсад нэвтрүүлэн хэрэглэж эхлэв.

Дүрслэл 19. Шилэн кабелийн сүлжээнд холбогдсон сумд, 2008



Тулгамдсан асуудал

Мэдээлэл, холбооны шинэ технологийг эрчимтэй хөгжүүлэхийн тулд оролцогч байгууллагуудын зүгээс хамтын ажиллагаа, дэмжлэг хэрэгтэй байна.

Цахим засаглал, цахим хэрэглээг хөгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдал, төр, хувийн хэвшлийн түншлэлийг зохицуулах эрх зүйн орчин бүрдээгүй байна.

“Өрх бүрт шуудангийн хайрцаг” хөтөлбөр, Иргэний бүртгэл мэдээллийн төвийн архивын цахим сан байгуулах, “Иргэний ухаалаг үнэмлэх”, “Хаягжилт” зэрэг төслүүдийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, санхүүжилтийн асуудал шийдэгдээгүй байна.

Цаашдын зорилт

Ойрын хугацаанд:

- Цахим засаг, цахим харилцааг зохицуулах Мэдээлэл, харилцаа холбооны багц хууль, Мэдээллийн аюулгүй байдлын тухай хууль боловсруулах,
- Бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоонд шилжихэд шаардлагатай дэд бүтэц, техник, технологи, стандарт, нэгдсэн код, програм хангамж, удирдлагын систем, бүтцийн талаар зөвлөмж боловсруулж, хэрэгжүүлэх,
- Үндэсний өгөгдөл мэдээллийн нэгдсэн төвийг ашиглалтанд оруулж төрийн

захиргааны төв байгууллагууд, агентлагуудыг суурь сүлжээнд холбох,

- Өрх бүрт шуудангийн хайрцаг хөтөлбөр, цахим хэрэглээний “е-дэлгүүр”, “е-эм хэрэгсэл”, “е-мэдлэг”, “е-сургалт” “Иргэний ухаалаг үнэмлэх”, “Хаягжилт” зэрэг төслийг боловсруулж хэрэгжүүлэх,
- Интернетийн хэрэглээний талаар судалгаа хийх, аутсорсингийн мэргэжилтэн бэлтгэх,
- Телевизийн 10 сувгийг улс даяар хүлээн авах, нэвтрүүлэх техникийн шийдэл гарган хэрэгжүүлэх,
- Иргэний бүртгэл мэдээллийн төвийн архивын цахим сан байгуулах,
- 21 аймгийн төвд интернэт протокол (IP/MPLS) технологид суурилсан өндөр хурдын түгээх сүлжээг байгуулах.

Дунд хугацаанд:

- Сумын түвшинд цахилгаан холбоо, шуудан, интернетийн үйлчилгээг нэг цэгт төвлөрүүлэх,
- 310 суманд интернэт протоколд суурилсан өгөгдөл дамжуулах, түгээх сүлжээ байгуулах,
- Малчдыг мэдээлэл, харилцаа холбоогоор шуурхай хангах нөхцөлийг бүрдүүлэх,
- Орон зайн мэдээллийн санд тулгуурлан хаягжуулалт, кодчиллол, бар код, зип код зэргийг бий болгож, төрийн үйлчилгээний үр ашгийг дээшлүүлэх,
- Үүрэн холбооны 4 дэх үеийн технологийг нэвтрүүлэх,
- Хөдөө, орон нутагт шуудан хүргэлтийг нэмэгдүүлэх, мэдээллийн технологид тулгуурласан үйлчилгээг нэвтрүүлэх.

Шигтгээ 5. Цахим Монгол хөтөлбөр

Мэдлэгт суурилсан мэдээлэлжсэн нийгмийг байгуулах эрхэм зорилго бүхий “Цахим Монгол” Үндэсний хөтөлбөрийг 2005-2012 оны хугацаанд хэрэгжүүлж байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд 14 дэд хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс мэдээлэл холбооны дэд бүтцийг хөгжүүлэх, цахим хэрэглээг хөгжүүлэх зорилгууд амжилттай хэрэгжиж байна.

Бүх нийтийн компьютержүүлэлт дэд хөтөлбөрийн хүрээнд 2005-2006 онд 2 үе шаттай компьютерийн худалдааг улс даяар зохион байгуулж, холбогдох хууль, эрх зүйн орчинг бүрдүүлж, хэрэглээний түвшнээс хамаарсан, хямд компьютерийг иргэдэд худалдах, зээл, лизенгээр худалдан авах явдлыг дэмжиж, орон нутагт яармаг худалдаа зохион байгуулав.

“Үндэсний өгөгдөл, мэдээллийн нэгдсэн төв” төслийг Монгол Улсын Засгийн газар болон БНСУ-ын тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байна.

Мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийг сайжруулах төслийг 2006 оноос Дэлхийн банкны 11.2 сая ам.долларын санхүүжилтээр хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд мэдээлэл, харилцаа холбооны эрх зүйн орчинг сайжруулах, харилцаа холбооны зохицуулалтын чанарыг дээшлүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар цахим-засаглалыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үндэсний мэдээллийн аюулгүй байдлын хүрээг бий болгох чиглэлээр ажиллаж байна.

Радио долгионы удирдлага, хяналтын систем шинээр ашиглалтад оруулж, радио долгионы болон дугаарлалтын бодлогын баримт бичгүүдийг боловсруулаад байна.

Төрийн байгууллагуудын вэб, и-мэйл төслийг 2005 оноос хэрэгжүүлж, Засгийн газрын нэгдсэн портал байгуулж байгууллагуудыг домэйн нэр, вэб хуудастай болгох, төрийн ажилтнуудыг цахим шуудангийн хаягтай болгох зорилгоор техник, програм хангамжийн шийдэл, зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлжээ.

Эх үүсвэр: МШХХТГ



ЗОРИЛГО 9

**ХҮНИЙ ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛАХ,
АРДЧИЛСАН ЗАСАГЛАЛЫГ
ХӨГЖҮҮЛЭХ**

Энэ зорилгын хэрэгжилтийн явц, хүрэх үр дүнд үнэлгээ хийх үндэсний 12 шалгуур үзүүлэлтийг УИХ-ын 2008 оны 13 дугаар тогтоолоор баталсан. Өмнөх онуудын мэдээлэл бүрэн бус байгаа тул 2008 оны тоо, мэдээлэлд тулгуурлан энэхүү тайланг бичлээ.

МХЗ-9-ын шалгуур үзүүлэлт бүрийг хариуцан гаргах үүрэг хүлээсэн байгууллагуудын хувьд энэ ажлыг анх удаа хийж байгаа учраас арга зүй, аргачлалын тодорхой дэмжлэг туслалцаа шаардлагатай байв. Монгол Улсад НҮБХХ-ийн дэмжлэгтэй хэрэгжиж байгаа “МХЗ-9 хүний эрх, ардчилсан засаглалыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх” төслөөс санаачилан холбогдох байгууллагуудын оролцоотойгоор

шалгуур үзүүлэлт бүрийн тодорхойлолтыг гаргасны зэрэгцээ судалгаа хийх, мэдээлэл цуглуулах аргачлалыг боловсруулан туршсан нь шалгуур үзүүлэлт бүрээр мэдээлэл гаргахад зохих ёсны дэмжлэг болсон.

МХЗ-9-ын гурван шалгуур үзүүлэлтийн судалгааг ҮСХ-ноос эрхлэн зохион байгуулдаг “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-нд (ӨНЭЗС) хавсралт модул болгон явуулахаар тогтож, судалгааны дэд түүвэрлэлтэд хамрагдсан нийт өрхийн гуравны нэг буюу 3,744 өрх бүрээс насанд хүрсэн нэг гишүүн (3744 иргэн)-ийг хамруулан жил бүр хийхээр боллоо. Ингэснээр уг шалгуур үзүүлэлтүүдийг үндэсний хэмжээнд, байнгын давтамжтай тооцох боломжтой болох юм.

Зорилт 22: *Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хүндэтгэн сахиж, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангаж, олон нийтэд мэдээллийг чөлөөтэй олж авах боломж олгох*

Өнөөгийн байдал, хандлага

Монголын Хүний хөгжлийн индекс (ХХИ) сүүлийн жилүүдэд үндэсний болон бүс нутгийн хэмжээнд жил дараалан тасралтгүй өсч байна. Хүн амын дундаж наслалт 2005-2008 онд 2.0 жилээр, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 919.1 ам.доллараар өссөн нь ХХИ 0.738-д хүрэхэд голлон нөлөөлөв (Хүснэгт 26).

Монгол Улс 1921 оноос өнөөг хүртэл 3,000 орчим хоёр талт олон улсын гэрээ байгуулж, 180-аад олон талт гэрээнд нэгдэн ороод байна¹¹. Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн гэрээ, конвенциудаас хүний халдашгүй эрхтэй шууд холбоотой болон суурь конвенциудыг сонгож үнэлгээ хийлээ¹²

(Хүснэгт 27). Хүснэгтээс харахад ерөнхий үнэлгээ 3.4 байгаа нь манай улсын хууль тогтоомжийн олон улсын хүний эрхийн гэрээтэй нийцэж байгаа байдал “дунд зэрэг”-ийн түвшинд буюу хууль тогтоомжийг шинэчлэн нийцүүлэх шаардлага байгааг илэрхийлж байна. Энэ үнэлгээ нь Монгол Улсын хууль тогтоомж, нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцид (ОУГК)-д нийцэж байгаа талаархи одоогийн байдлын суурь хэмжигдэхүүн болж 2015 гэхэд хүрэх түвшинг тодорхойлох ач холбогдолтой юм.

¹¹ Төрийн мэдээллийн тусгай дугаар, УБ., 2004 он, 1 дэх тал.

¹² Монгол Улсын хууль тогтоомж, Олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцид нийцэж байгаа талаархи шинжээчдийн үнэлгээний асуултууд боловсруулах, эдгээр асуултыг экспертээр үнэлүүлэх, үнэлгээг тооцоолох арга зүйг боловсруулах ажлыг ХЭҮК

хариуцаж, хүний эрхийн мэргэжилтнүүд, бусад судлаачид, иргэний нийгмийн байгууллага, олон нийтийн оролцоотой гүйцэтгэв. Үнэлгээ хийхэд НҮБХХ-ийн “МХЗ 9 хүний эрх, ардчилсан засаглалыг бэхжүүлэх” төсөл дэмжлэг үзүүлжээ.

Хүснэгт 26. МХЗ-9-ын хэрэгжилтийн хяналт-шинжилгээний шалгуур үзүүлэлтүүд

Шалгуур үзүүлэлт	1990	2000	2006	2007	2008	2015
56 Хүний хөгжлийн индекс	0.652	0.669	0.691 (2004) 0.720 ^{6*}	0.731 ^{6*}	0.738 ^{6**}	0.83 ^a
57 Монгол Улсын хууль тогтоомж олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцэд нийцэж байгаа талаархи шинжээчдийн үнэлгээ (хувь)	-	-	-	-	3.4	-
58 Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт (хувь)	-	-	66.2 ⁶	68.2 ⁶	73.4 ⁶	-
59 Төлбөрийн чадваргүй иргэдэд үйлчилгээ үзүүлж байгаа өмгөөлөгчдийн тоо	-	-	476 ⁶	517 ⁶	293 ⁶	-
60 Улс төр, эдийн засаг, санхүүгээс хэвлэл, мэдээллийн хэрэгслийн хараат бус байдлын талаархи иргэдийн төсөөлөл	-	-	-	-	28.5	-
61 Төсөв, түүний зарцуулалтын тайланг вэб хуудсандаа тогтмол байрлуулдаг төрийн байгууллагын тоо	-	-	-	-	55.6 ^{***}	-

Тайлбар: * ДБ-аас хэрэгжүүлсэн олон улсын өртгийн зэрэгцүүлэлтийн хүрээнд 2005 онд улс орнуудын худалдан авах чадварын паритетыг шинэчлэн тооцсон тул 2005-07 оны гүйцэтгэл өөрчлөгдсөн.

** Урьдчилсан гүйцэтгэл

Эх үүсвэр: а. УИХ-ын тогтоол #13, Монгол Улсын МХЗ-уудыг батлах тухай, 2008

б. ҮСХ, ХЗДХЯ, 2008

*** - хувиар

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт 2004-2008 онуудад тогтмол өсч 73.4 хувь болжээ (Дүрслэл 20).

2008 оны эцсийн байдлаар төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх 29 төв (29 өмгөөлөгч)-өөр дамжуулан улсын хэмжээнд нийт 700 гаруй эрүүгийн хэрэгт

холбогдогч төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй өмгөөллийн туслалцаа үзүүлж, 3,000 орчим иргэнд хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгч, 2,600 иргэдийг эрх зүйн албан бус сургалтанд хамрууллаа. 2007-2008 онд хуулийн байгууллагын болон иргэдийн хүсэлтээр томилогдсон өмгөөлөгчдийн тоо буурчээ.

Хүснэгт 27. Олон улсын гэрээ, конвенци

Конвенцийн нэр	Шинжээчдийн үнэлгээний дундаж оноо
Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай пакт	3
Иргэний болон улс төрийн эрхийн тухай пакт	3.7
Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг	3.2
Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц	4
Хүүхдийн эрхийн тухай конвенци	3
Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенци	3.9
Монгол улсын хууль олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцид нийцэж байгаа талаархи шинжээчдийн үнэлгээ (хувь)	3.4

Эх үүсвэр: ХЭҮК, 2008

ҮСХ-ны Өрхийн нийгэм, эдийн засгийн 2007-2008 оны судалгаанаас харахад хэвлэл, мэдээллийн хэрэгсэл (ХМХ)-ийг улс төр, эдийн засаг, санхүүгээс нилээд хараат байдалтай байдаг гэж судалгаанд оролцогсдын 80 хувь нь үзсэн байна. Монголчууд санал бодлоо чөлөөтэй илэрхийлдэг (63.6 оноо) боловч ХМХ улс төр, эдийн засгийн хувьд хараат байна (28.9 болон 28.1 оноо) гэж үзжээ (Хүснэгт 28).


“Улс төр, эдийн засаг, санхүүгээс хэвлэл, мэдээллийн хэрэгслийн хараат бус байдлын талаархи иргэдийн төсөөлөл” 28.5 буюу хараат бус байдлын үзүүлэлт дундаас доогуур түвшинд хангагдсан гэсэн үнэлгээ гарчээ.

Судалгаанаас үзэхэд иргэд, олон нийтийн телевиз, радиод хамгийн их (дундаж 93.7), хувийн радио, телевизид харьцангуй дунд зэрэг (дундаж 80.1), өдөр тутмын болон шар хэвлэлд тун тааруухан (дундаж 47.4) итгэдэг байна. Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг ерөнхийдөө сайн (дундаж 87.0) гэж үнэлжээ.

Төсөв, түүний зарцуулалтын ил тод байдал.

2008 оны эхний хагас жилийн байдлаар улсын үйлдвэр, аж ахуйн газруудыг оролцуулахгүй, зөвхөн төсвөөс санхүүждэг 4,037

Дүрслэл 20. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлтийн хувь, 2004-2008



Эх үүсвэр: ХЗДХЯ, 2008

байгууллага байгаагаас төсвийн ерөнхийлөн захирагч (ТЕЗ) 32, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар (ЗДТГ)-ыг оролцуулаад ТЕЗ 54 байна.

Нийт ТЕЗ 54 байгууллагаас төсвийн тоо, мэдээллээ вэб хуудсанд бүрэн байршуулсан 2, өмнөх оны төсвийн тоо, мэдээлэлтэй 23, вэб хуудастай боловч төсвийн талаархи мэдээлэлгүй 20, вэб хуудасгүй 9 байгууллага байна.

Хүснэгт 28. Хэвлэл, мэдээллийн хэрэгслийн хараат бус байдлын талаархи иргэдийн төсөөлөл, хэвлэл, мэдээллийн байгууллагуудад итгэл хүлээлгэж байгаа хүн ам, улсын дунджаар, хувиар

	Огт нийлдэггүй/итгэдэггүй	Нийлдэггүй/Итгэдэггүй	Дунд зэрэг	Нийлдэг/Итгэдэг	Бүрэн нийлдэг/итгэдэг	Мэдэхгүй	Нийлбэр ¹ /Итгэлийн үзүүлэлт ²	Мэдээллийн түвшин ³
ХМХ улс төрөөс хараат бус	10.5	30.9	21.7	15.8	1.1	20.0	28.9	80.0
ХМХ нь эдийн засаг, санхүүгээс хараат бус байдаг	8.5	29.3	21.8	13.8	1.0	25.6	28.1	74.4
Монголчууд санал бодлоо чөлөөтэй илэрхийлдэг	5.3	18.5	31.0	35.0	6.7	3.6	63.6	96.4
Үндэсний радио	1.5	3.9	19.4	57.7	12.3	5.3	93.0	94.7
FM радио (богино долгионы)	2.3	8.3	29.4	33.6	4.2	22.3	78.3	77.7
Монголын үндэсний олон нийтийн телевиз	1.2	3.5	17.4	58.2	18.7	1.0	94.3	99.0
Хувийн телевиз	1.5	9.4	31.3	43.2	6.1	8.5	81.9	91.5
Орон нутгийн телевиз	2.0	6.4	23.6	33.8	4.5	29.8	82.1	70.2
Өдөр тутмын хэвлэл	3.0	13.3	33.0	33.1	4.1	13.5	69.5	86.5
Шар хэвлэл	10.9	30.3	27.7	12.0	1.9	17.2	25.2	82.8

Тайлбар: 1/ Нийлбэр үзүүлэлт нь эерэг үнэлгээнээс сөрөг үнэлгээг хассан стандартчилсан үзүүлэлт (1-100 балл)

2/ Мэдээллийн түвшин нь асуултад хариулсан хүмүүсийн хувь

3/ Итгэлийн үзүүлэлт нь эерэг үнэлгээнээс сөрөг үнэлгээг хассан стандартчилсан үзүүлэлт (1-100 балл)

Эх үүсвэр: ӨНЭЭС, Хавсралт модул “Ардчилсан засаглал” судалгаа, ҮСХ, 2009

Вэб хуудастай байгууллагаас 25 байгууллага буюу 55.6 хувь нь төсвийн тоо, мэдээллээ ил тод байршуулсан байна¹³. Харин Сангийн яам “Төсвийн ил тод байдал” гэсэн вэб хуудас тусгайлан нээж төсвийн гүйцэтгэл, батлагдсан төлөвлөгөөг ТЕЗ нэг бүрээр байнга байршуулж байна.

Дэмжих орчин

ҮСХ жил бүр ХХИ-ийг үндэсний болон бүс нутгийн түвшинд нарийвчлан тооцож байна. Монгол Улсын МХЗ-д суурилсан ҮХЦБ болон бусад хөтөлбөр, төслүүд, холбогдох хууль тогтоомжуудад хүн амын эрүүл мэнд, боловсрол, орлогын хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн урт болон дунд хугацааны тогтвортой бодлого, эрх зүйн орчин бүрдсэн байна.

Монгол Улсад Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг дээдлэн хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хангах бодлого, эрх зүйн суурь орчин бүрдсэн. УИХ-д Хүний эрхийн дэд хороо, бие даасан хараат бус зарчмаар ажилладаг шүүхийн тогтолцоо, Хүний эрхийн Үндэсний комисс (ХЭҮК) ажиллаж байгаагийн зэрэгцээ хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 150 шахам ТББ ажиллаж байна.

Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх Үндэсний хөтөлбөр хэрэгжиж байна.

Хэвлэл мэдээлийн эрх чөлөөний эрх зүйн орчин бүрдсэн байна. Үндэсний олон нийтийн радио, телевизийн зэрэгцээ хувийн хэвшлийн болон ТББ-ын хэлбэрээр ажилладаг ХМХ олноор байгуулагдан идэвхтэй ажиллаж байна.

Төсвийн ил тод байдлыг хангах эрх зүйн орчин бүрдлээ. Нийслэл болон аймгийн төв, томоохон суурин газар ажилладаг төсвийн байгууллагууд техник, технологийн хувьд вэб хуудастай болох, төсвийн тухай мэдээллээ байршуулан шинэчилж байх боломж бүрдээд байна.

Тулгамдсан асуудал

ХХИ-ийг сургалт, судалгааны ажилд харьцангуй сайн ашиглаж байгаа боловч бодлого боловсруулах, шийдвэр гаргах, тэдгээрийг

хэрэгжүүлэх шатанд нягт харгалзан тооцож хэрэглэдэг механизм тогтоогүй байна. ХХИ нь МХЗ-уудын бусад шалгуур үзүүлэлтүүдтэй нягт уялдаатай бөгөөд аль ч зорилтын хэрэгжих суурь боломжийг илэрхийлэх шинжтэй учраас хэрэгжилтийн байдалд үнэлгээ хийхдээ энэ онцлогийг харгалзах шаардлагатай байна.

Хуулийн төслийн агуулга, нэр томъёог ОУГК-д нийцүүлэх явдал дутмаг, судалгааны байгууллага, мэргэжилтнийг татан оролцуулах, санал дүгнэлтийг нь тусгах явдал хангалтгүй байна. Монгол Улсын Үндсэн хуульд олон улсын гэрээнд заасан агуулга, үзэл санааг тусгасан боловч салбарын зарим хууль, тухайлбал, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, бусад хуульд хангалттай тусгаагүйгээс тухайн конвенцийн заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Засгийн газраас Монгол Улсын ОУГК-ийн хэрэгжилтийг НҮБ-ын хороод, ОУХБ-ын Шинжээчдийн хороонд тайлагнах үүргээ хангалтгүй биелүүлж, НҮБ-ын хороодоос Засгийн газрын илтгэлд ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хойрго хандах, хэрэгжүүлэхгүй байх зэрэг дутагдал үргэлжилсээр байна.

ОУГК-ийн албан ёсны орчуулга, түүнийг хэвлэн нийтлэх үйл ажиллагаа хангалтгүй байгаа нь шүүх, хуулийн байгууллагад ОУГК-ийг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулдаг. Монгол Улсын олон улсын гэрээг олон нийтэд сурталчлан таниулах, иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагаа хангалтгүй, ОУГК-ийн хэрэгжилтийг хариуцах байгууллагуудад энэ талаархи нэгдсэн судалгаа, мэдээллийн сан байхгүй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагаа нь Монгол Улсын бүх нутаг дэвсгэрийг хамарч олон субъекттэй харьцаж ажилладаг ч ажиллах орчин сайн биш, машин техник, мэдээлэл, холбооны технологийн хангалт, үйлчилгээ хүрэлцэхгүй хэвээр байна.

Төлбөрийн чадваргүйг тодорхойлсон иргэний оршин суугаа хорооны Засаг даргын тодорхойлолт нь үнэн, зөв эсэх нь эргэлзээтэй байдаг бөгөөд бодит байдалтай нийцдэггүй, хэргийн материал бүрдэлт хангалтгүй байх тохиолдол олон гардаг. Томилогдсон өмгөөлөгчид хэрэг шийдвэрлэлтийн бүх шатанд оролцдоггүй, өмгөөлөл, хууль зүйн туслалцааны чанар, үр нөлөө сул, өмгөөлөгчид ажиллах цаг хугацаа олгодоггүй

¹³ Энэ шалгуур үзүүлэлтийн тоон мэдээллийг МХЗ 9-д дэмжлэг үзүүлэх төслийн судлаачид Сангийн яамны асуудал хариуцсан мэргэжилтэний туслалцаатайгаар гаргав.

зэрэг зөрчлүүд байна.

Мэдээллийн эрх чөлөөг хангах асуудлыг зохицуулах хууль байхгүй тул эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлага байна.

Төсвийн тоо, мэдээллийг ил тод байлгах талаар төсвийн байгууллагууд санаачилгагүй, мэдээллээ шинэчлэх, ялангуяа дараа оны төсөв боловсруулах үед төсвийн төслөө вэб хуудсанд байршуулж иргэдийн санал бодлыг авах, тусгах талаар муу ажиллаж байна.

Цаашдын зорилт

Ойрын хугацаанд:

- МХЗ-уудын хэрэгжилтийн үнэлгээ хийхдээ шалгуур үзүүлэлтүүдээр гаргасан мэдээлэл, тооцоог ХХИ-тэй уялдуулан холбоо, хамаарлыг нь тооцдог байх арга зүй, аргачлал боловсруулах,
- ОУГК-ийн албан ёсны орчуулгыг тухай бүр хийх, ОУГК-ийн зүйл, заалтуудад шинжлэх ухааны болон хууль зүйн албан ёсны тайлбар хийх зэргээр шүүх, хуулийн байгууллагад хэрэглэхэд хялбар болгох,
- Шийдвэр гүйцэтгэх албадыг шилэн кабельд холбож шийдвэр гүйцэтгэлийн статистик мэдээ, судалгааг шуурхай гаргах,
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагааг түргэтгэх зорилгоор Шүүх, Цагдаа, Иргэний бүртгэл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон банк хоорондын нэгдсэн цогц сүлжээ байгуулах,
- Хохирогчийн хохирлыг барагдуулах үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох,

- Эрх зүйн туслалцаа үзүүлэх төвийн өмгөөлөгчдийг бэлдэх, давтан сургах, үйл ажиллагааг тогтмолжуулах, чадварлаг өмгөөлөгчдөөр хангах, зөвхөн өмгөөллийн эрхтэй хүн ажиллах чиглэлээр бодлого, зохион байгуулалтын арга хэмжээ авах,
- Аймаг, нийслэлийн ЗДТГ, аймгийн болон сумдын төсвийн гүйцэтгэл, батлагдсан төсөв, төсөв боловсруулалтын явцын тоо, мэдээллийг веб хуудсанд байнга байршуулж хэвших.

Дунд хугацаанд:

- ХХИ-ийг үндэсний болон бүс, орон нутгийн түвшинд бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх бүх шатанд гол мэдээлэл, үндсэн хэрэглэгдэхүүн болгон ашигладаг ажил хэргийн тодорхой механизм бүрдүүлэх,
- ОУГК-ийн тайланг хугацаанд нь илгээх, НҮБ-ын хороодоос ирсэн зөвлөмжийн хэрэгжилтийг сайжруулах талаар холбогдох байгууллагууд тодорхой арга хэмжээ авах, оновчтой, байнгын механизм бүрдүүлэх,
- Олон улсын гэрээ, конвенцийн талаарх нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлж, нийтэд сурталчлах,
- Олон нийтийн ХМХ-ийн төсөв, түүний зарцуулалтын тайланг ил тод болгох, санхүүжилтийн эх үүсвэрийг олон нийтэд нээлттэй байлгах боломжийг бүрдүүлэх,
- Олон нийтийн ХМХ-үүд иргэдэд үнэн бодитой мэдээллээр үйлчлэх, мэдээлэл олж авах, хэрэглэх тэгш боломж олгож байгаа эсэхэд хяналт, үнэлгээ хийдэг механизм бүрдүүлэх.

Зорилт 23: Ардчиллын үндсэн зарчим, хэв маягийг амьдралд хэвшүүлэх

Өнөөгийн байдал, хандлага

Төрийн байгууллагын үйл ажиллагааны талаархи иргэдийн төсөөлөл. Судалгаагаар иргэд нийгмийн даатгал, халамжийн байгууллагуудын үйл ажиллагаанд хамгийн их сэтгэл ханамжтай (дундаж 90), харин улс төрийн намууд (дундаж 20) болон УИХ-ын үйл

ажиллагаанд (дундаж 31) сэтгэл дундуур байна гэсэн дүн гарчээ. Аймаг, нийслэлийн ИТХ-ууд, баг, хорооны ИНХ-ууд, газрын албад, ТББ-уудын үйл ажиллагааг иргэд хангалтгүй буюу дундаас доогуур гэж үнэлжээ (Хүснэгт 29).

Төрийн байгууллагуудад итгэл хүлээлгэж байгаа байдлыг УИХ, Засгийн газар, Ерөнхийлөгч

гэсэн гурван институтээр төлөөлүүлэн судалжээ (Хүснэгт 30). Үйл ажиллагааны үнэлгээ болон итгэл хүлээлгэж байгаа байдлын 2 үзүүлэлтэд тулгуурласан дүнгээр 53.3 (0-100 онооны

эрэмбээр) буюу төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаархи иргэдийн үнэлгээ нь төсөөллийн судалгаагаар дундаас ялимгүй дээгүүр байна гэсэн дүн гарчээ.

Хүснэгт 29. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаархи иргэдийн төсөөлөл, улсын дунджаар

	Маш муу	Тааруу	Дунд зэрэг	Сайн	Маш сайн	Мэдэхгүй	Үнэлгээний үзүүлэлт ²	Мэдээллийн түвшин ³
Ерөнхийлөгч	4.0	10.2	34.1	43.4	4.7	3.6	77	96.4
УИХ	10.1	25.9	45.2	15.1	0.8	2.9	31	97.1
Засгийн газар	6.9	18.4	39.7	28.4	1.9	4.7	55	95.3
Улс төрийн намууд	12.3	32.1	37.7	10.6	0.5	6.9	20	93.1
Иргэний нийгмийн байгууллагууд (ТББ)	6.4	19.9	37.2	20.1	1.1	15.3	45	84.7
Нийслэл/аймгийн ИТХ	5.2	15.2	33.5	19.7	0.8	25.6	50	74.4
Дүүрэг/сумын ИТХ	7.1	17.5	35.5	21.9	1.0	17.0	48	83.0
Баг, хорооны ИНХ	10.0	17.9	32.4	22.6	1.7	15.5	47	84.6
Нийслэл/аймгийн Засаг дарга	4.7	13.0	34.9	29.0	2.3	16.2	64	83.9
Сум, дүүргийн Засаг дарга	6.0	15.7	35.4	28.9	2.2	11.8	59	88.2
Баг, хорооны Засаг дарга	7.2	15.6	31.7	35.9	3.5	6.1	63	93.9
Дээд шүүх	4.4	9.0	21.8	12.3	1.7	51.0	51	49.0
Нийслэл/аймгийн шүүх	3.6	9.8	23.4	13.4	1.0	48.9	52	51.1
Дүүрэг/сум дундын шүүх	3.6	10.8	24.5	13.4	1.1	46.7	50	53.3
Шүүхийн шийдвэр биелүүлэх газар	3.2	9.7	22.4	16.0	1.7	46.9	58	53.1
Замын цагдаа	4.5	11.6	29.2	35.4	2.9	16.4	70	83.6
Эрүүгийн цагдаа	4.0	12.4	31.3	27.1	2.4	22.8	64	77.2
Хэв журмын цагдаа	4.7	12.9	31.1	31.8	3.7	15.8	67	84.2
Авилгатай тэмцэх газар	11.1	16.2	23.3	11.1	1.2	37.2	31	62.8
Мэргэжлийн хяналтын газар	6.4	14.3	26.8	25.0	2.0	25.5	57	74.5
Аудитын газар	2.2	7.7	20.3	19.2	2.0	48.6	68	51.4
Гаалийн байгууллагууд	5.4	11.7	23.7	17.2	1.1	40.9	52	59.1
Газрын албад	11.2	16.5	28.1	17.9	1.2	25.2	41	74.8
Татварын байгууллагууд	3.1	8.4	25.6	35.9	3.5	23.5	78	76.5
Нийгмийн даатгалын байгууллагууд	1.2	5.2	24.5	53.2	5.9	10.1	90	89.9
Нийгмийн халамжийн байгууллагууд	1.3	5.7	22.4	53.7	7.5	9.3	90	90.7
Улсын сургууль	1.5	6.1	30.9	47.8	6.7	7.1	88	92.9
Хувийн сургууль	2.5	10.4	26.8	27.4	3.9	29.1	71	70.9
Улсын эмнэлэг	4.4	12.3	30.9	43.6	5.2	3.6	75	96.4
Хувийн эмнэлэг	1.7	4.9	23.9	41.5	6.6	21.5	88	78.5

Тайлбар: 1/ Үнэлгээний үзүүлэлт нь эерэг үнэлгээнээс сөрөг үнэлгээг хассан стандартчилсан үзүүлэлт (1-100 балл)
Эх үүсвэр: ӨНЭЗС 2007-2008, Хавсралт модул "Ардчилсан засаглал" судалгаа, ҮСХ, 2009

Улсын төсвийг боловсруулах, батлах явцад иргэний нийгмийн оролцоо. Сангийн яамнаас улсын төсвийн төслийг боловсруулан Засгийн газарт өргөн мэдүүлснээс хойш УИХ-аар хэлэлцэн батлах хугацаанд (9 дүгээр

сарын 15-наас 12 дугаар сарын 1) Сангийн яам, Засгийн газар, УИХ-д төсвийн төслийн талаархи саналаа ирүүлсэн иргэний нийгмийн тоогоор илэрхийлэгдэнэ.

Хүснэгт 30. Төрийн байгууллагуудад итгэл хүлээлгэж байгаа хүн амын эзлэх хувь

	Огт итгэгч-дэггүй	Итгэдэгч-гүй	Дунд зэрэг	Итгэгч-дэг	Бүрэн итгэдэг	Мэдэхгүй	Итгэлийн үзүүлэлт ²	Мэдээллийн түвшин ³
УИХ	7,1	23,2	41,4	25,3	1,3	1,7	46,8	98,3
Засгийн газар	4,6	15,8	39,3	34,6	2,6	3,0	64,6	97,0
Ерөнхийлөгч	4,0	10,4	31,3	45,3	6,9	2,2	78,5	97,8

Тайлбар: 1/ Итгэлийн үзүүлэлт нь эерэг үнэлгээнээс сөрөг үнэлгээг хассан стандартчилсан үзүүлэлт (1-100 балл)
2/ Мэдээллийн түвшин нь асуултад хариулсан хүмүүсийн хувь

Эх үүсвэр: ӨНЭЗС, Хавсралт модул "Ардчилсан засаглал" судалгаа, ҮСХ, 2009

Баг, хорооны Засаг даргад нэр дэвшүүлэхэд иргэдийн оролцоо. Хуулийн дагуу 4 жилд нэг удаа орон нутгийн сонгуулийн дараа, мөн нөхөн сонгуулийн дараа энэ үзүүлэлтийг гаргаж байх боломжтой¹⁴. Орон нутгийн сонгууль 2009 оны хавар болсон тул энэ шалгуур үзүүлэлтийн мэдээллийг энэ удаагийн тайланд оруулах боломжгүй байлаа.

Дэмжих орчин

Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны эрх зүйн орчин бүрдсэн. Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж төрийн албаны шинэчлэлд тодорхой ахиц гарав.

Төсвийн ил тод, нээлттэй байдлыг хангах талаар төрийн бодлого, хууль эрх зүйн ерөнхий орчин бүрдсэн. Төсвийн төсөлтэй танилцах бололцоо нээлттэй байдаг. Төсвийн асуудлыг иргэд, ИНБ-ууд ихээхэн сонирхдог болов. Улсын төсвийн төсөл боловсруулах, хэлэлцэн батлах үйл явцад иргэд, иргэний нийгмийн оролцоог хангах чиглэлээр хамтран ажиллаж байна.

Бодлого, эрх зүйн орчны хувьд улс төрчид, судлаачдын дунд санал зөрүүтэй байгаа боловч эрх бүхий байгууллагын шийдвэрээр хуучин заалт хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Өрхийн болон хүн амын бүртгэл мэдээлэл харьцангуй сайжирлаа.

¹⁴ Энэ шалгуур үзүүлэлтийг улсын хэмжээнд ЗГХЭГ-ын Орон нутгийн хэлтэс, аймаг, нийслэлд бүх шатны ИТХ-ын Нарийн бичгийн дарга нар нэгтгэн гаргана.

Тулгамдсан асуудал

Төрийн байгууллага, ялангуяа улс төрийн нам, түүний үйл ажиллагааны хамааралтайгаар бүрддэг УИХ болон ИТХ-ын үйл ажиллагаанд иргэдийн сэтгэл дундуур, итгэл сул байгаа байдал өөрчлөгдөхгүй байна.

Улсын төсвийн төсөл боловсруулах, хэлэлцэн батлах үйл явц ерөнхийдөө нээлттэй байдаг боловч иргэдэд төдийлөн хүртээмжтэй, ойлгомжтой бус байдаг. Мөн ИНБ-ууд төсвийн талаархи саналаа албан ёсоор ирүүлэхээсээ илүү танил тал, нөлөө бүхий албан тушаалтанд ойлгуулж лобби хийхийг эрхэмд үзэх хандлага байна.

Баг, хороодын ИНХ-д оролцох иргэдийн идэвх санаачилга сул, оролцоо өндөр бус байдгаас хурлын ирц хуульд заасан хэмжээнд хүрэхгүй, дахин хуралдах бэрхшээл гардаг. Баг, хороодын Засаг даргад нэр дэвшүүлэх хуралд нэр дэвшигчид өөрийгээ дэмжих иргэдийг ялгаж цуглуулах, нэр дэвшигчийг дэмжиж сонгох хэмжээний төлөөлөл бүрдээгүй нөхцөлд хурлыг санаатайгаар үймүүлж, хойшлуулах зэрэг дутагдал багагүй гардаг.

Цаашдын зорилт

Ойрын хугацаанд:

- Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаархи иргэдийн төсөөллийн судалгааг тогтмол гаргаж, төрийн

байгууллагууд үйл ажиллагаандаа тогтмол ашигладаг механизм тогтоох,

- ИНБ-ууд төсөв боловсруулах, батлах үйл явцад оролцох оролцоогоо идэвхжүүлэх, ИНБ-аас гаргаж байгаа санаачилгыг хөхиүлэн дэмжих талаар эрх бүхий байгууллагууд онцгой анхаарах шаардлагатай байна.

Дунд хугацаанд:

- Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулах, төрийн албаны шинэтгэлийг эрчимжүүлж,

төрийн байгууллага, албан тушаалтнуудад итгэх иргэдийн итгэлийг сэргээх арга хэмжээ авах,

- Улсын төсвийн төлөвлөлтийн тогтолцоог боловсронгуй болгож төсөв боловсруулах, хэлэлцэн батлах үйл явцыг илүү нээлттэй болгох, иргэд, иргэний нийгмийн оролцоог хангах тогтолцоонд шилжих,
- Баг, хороодын Засаг даргад нэр дэвшүүлэх, сонгож томилох харилцааг эрх зүйн хувьд зөв чиглэлд оруулах, ИНХ-ын үүрэг хариуцлагыг дээшлүүлэх.


Зорилт 24: Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх

Өнөөгийн байдал болон хандлага

Авлига. ДБ-ны судалгаагаар Авлигыг хянах үнэлгээ¹⁵ нь 2006 онд -0.49 байснаа 2007 онд -0.61 болж (+2.5 болон -2.5 шкалын үнэлгээ) 0.12 нэгжээр буурчээ. Олон улсын Транспарэнс Интэрнешнл байгууллагаас гаргасан Авлигын түвшин тогтоох судалгаагаар¹⁶ 2007, 2008 онд тогтмол 3.0 гэсэн үзүүлэлттэй байна. Олон улсын эдгээр судалгаанаас харахад 2007-2008 онд Монгол дахь авлигын төлөв байдалд төдийлөн өөрчлөлт ороогүй байна.

Харин Азийн сангийн судалгаагаар¹⁷ “Хахууль нэхсэн тохиолдолд хахууль өгөхгүй гэж хариулсан хүмүүсийн тоо тогтмол өсч байгаа бөгөөд 2008 оны 9 сард хийсэн судалгаагаар 2006 оны түвшинтэй ойролцоо 42 хувь гэсэн дүн гарсан байна. Авлигатай тэмцэх газраас авлигын индексийн дүнг 0.64 (0-1 эрэмбээр) байна гэж зарласан.

Дүрслэл 21. Авлигын хүрээ, байгууллага, салбараар, 2008



¹⁵ http://info.worldbank.org/governance/wgi/mc_chart.asp

¹⁶ http://www.transparency.org/policy_research/surveys_indices/cpi

¹⁷ Монголын авлигын түвшин тогтоох судалгаа, Азийн сан, 2008 оны 9 сар, 4-р тал.

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлига. НҮБХХ-ийн дэмжлэгтэй хэрэгжиж байгаа төслийн судалгаагаар улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаархи төсөөллийн үнэлгээ 4.09 гэж гарсан байна¹⁸.


Манай орны авлигын шалтгааныг нийгэм, эдийн засгийн хөгжил сул, авлигыг үл тэвчих нийгмийн сэтгэл зүй төлөвшөөгүй, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдал хангалтгүй, хүнд суртал, чирэгдэл их, улс төрчид асуудлыг явцуу ашиг сонирхлын үүднээс шийддэг, төрийн албаны ёс зүй, хууль

зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага сул, ядуурал зэрэгтэй холбоотой гэж дүгнэжээ.

Дүрслэл 21-д харуулсан авлигад өртөмтгий удирдлагын түвшин, салбар, байгууллагын үнэлгээний дундаж оноо 4.7 байгаа нь энэ хүрээнд авлига их тархсаныг илэрхийлж байна.

Авлигын хүчин зүйлсийн үнэлгээгээр улс төрийн намын томилгоо, намын санхүүжилт болон сонгуулийн санхүүжилтийн механизм, сонгуулийн тогтолцоо нь дунджаар 4.6 оноогоор үнэлэгдэж бусад хүчин зүйлсээс дээгүүр дүнтэй байгаа нь энэ хүрээнд өөрчлөлт шинэчлэлт хийх шаардлагатайг харуулж байна (Дүрслэл 22).

Дүрслэл 22. Авлигад нөлөөлөх хүчин зүйлс, 2008



Ажил, албан тушаалд томилоход улс төрчид нөлөөлөх явдал маш их байна гэж шинжээчид үзэж 4.7 гэсэн оноо өгчээ.

Төрийн захиргаа, үйлчилгээний байгууллагын хүрээн дэх авлига. Өрхийн нийгэм, эдийн засгийн 2007-2008 оны

судалгаагаар¹⁹ эмнэлгийн үйлчилгээ авах болон баг, хорооны Засаг даргын тодорхойлолт авах нь судалгаанд оролцогсдын хувьд хамгийн нийтлэг үйлчилгээнүүд боловч бусад үйлчилгээг бодвол авлигын байдал харьцангуй бага байна. Тендерийн шалгаруулалтад нөлөөлөх (1.28 оноо), гаалийн татвараас хөнгөлөх, чөлөөлөх (1.23 оноо), шүүхээр хэрэг шийдвэрлүүлэх (1.10 оноо) нь авлигад их өртөмтгий гэж судалгаанд дүгнэсэн байна.

¹⁸ Энэ талаарх төсөөллийг гаргах шинжээчдээр үнэлгээ хийлгэх судалгааны арга зүй, аргачлалыг боловсруулан судалгаа хийх анхны оролдлогыг НҮБ-ын Ардчиллын сан, НҮБХХ-ийн дэмжлэгтэй хэрэгжиж байгаа “МХЗ 9 хүний эрх, ардчилсан засаглалыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх” төслийн багтай хамтран хийжээ. Судалгааны асуулгыг 13 асуулт, 87 үзүүлэлтээр боловсруулж шинжээчдээр үнэлгээ хийлгэсэн. Шинжээчдийг сонгохдоо тусгай бэлтгэсэн шалгуурыг баримтлан АТГ-ын зөвлөмжийг харгалзаж бизнес эрхлэгчдийг түлхүү оруулжээ. Үнэлгээг 5 онооны эрэмбээр гаргаж (1 огт үгүй (авлига байхгүй) - 5 маш их дэлгэрсэн) нийт дундаж үзүүлэлтээр тооцсон.

¹⁹ Судалгааг авахдаа төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаанаас авлигад хамгийн их өртөж болох 22 ажил үйлчилгээг сонгон, сүүлийн 12 сард төрийн байгууллагаас ямар нэг үйлчилгээ авахдаа авлигын шинжтэй үзэгдэл ажигласан болон ажиглаагүй гэсэн иргэдийн үнэлгээний харьцаагаар иргэдийн төсөөллийг нэгтгэн гаргажээ. Судалгаанд энэ харьцааг 0-2 гэсэн онооны эрэмбэтэйгээр тооцон гаргах арга зүй ашигласан байна.

Судалгаагаар төрийн захиргаа болон үйлчилгээний хүрээнд авлига харьцангуй бага буюу 30.8 (0-100 онооны эрэмбээр) гэсэн үнэлгээ гарчээ.

Дэмжих орчин

Авлигатай тэмцэх бодлого, эрх зүйн үндсийг тодорхойлж, бие даасан байгууллага байгуулагдаад 2 жил ажиллаж байна.

Авлигын түвшинг тодорхойлох, индекс боловсруулах талаар судалгааны ажлууд хийгдэж байна. Шинээр тодорхойлсон шалгуур үзүүлэлтийг гаргах талаар НҮБ-ын Ардчиллын сан, НҮБХХ-ийн дэмжлэгтэй хэрэгжиж байгаа “МХЗ-9 хүний эрх, ардчилсан засаглалыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх” төсөл, ДБ-ны “Засаглалыг дэмжих” төслүүд авлигын индекс тодорхойлох арга зүй боловсруулахад идэвхтэй ажиллаж байна.

Тулгамдсан асуудал

Авлигын индексийг тодорхойлж, түүний арга зүй, аргачлалыг боловсруулах ажил удаашралтай байна.

Авлигын тухай үндэслэлтэй бодит мэдээлэл дутмаг, авлигын нэгдсэн ойлголт, төсөөлөл хангалтгүй, нийгэмд авлига хавтгайрсан гэсэн сэтгэл зүй хүчтэй байгаа зэрэг нь авлигын асуудлаар судалгаа хийж мэдээлэл цуглуулахад зарим талаар хүндрэл учруулж байна.

АТГ нь судалгааны ажлыг зохион байгуулах дадлага, туршлага дутмаг, энэ чиглэлийн мэргэжлийн боловсон хүчин хангалтгүй байгаа нь судалгааны ажлыг үр дүнтэй зохион байгуулахад хүндрэл учруулж байна.

Төрийн байгууллагуудад томилогдон ажиллаж байгаа албан тушаалтнууд сонирхлын зөрчил ихтэй гэсэн ойлголт олон нийтэд түгээмэл байдаг нь нийгмийн сэтгэл зүйд авлигын талаар элдэв таамаг, хардалт гарах нөхцөлийг бүрдүүлж байна.

Сонирхлын зөрчлийн асуудлыг зохицуулсан эрх зүйн зохицуулалт байхгүйгээс төрийн байгууллагын албан тушаалд иргэдийг сонгон шалгаруулах, томилох, тэдэнтэй хариуцлага тооцох боломж хязгаарлагдмал байна.

Шигтгээ 6. Авлигатай тэмцэх арга хэмжээ

Олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх чиглэлээр улсын хэмжээнд сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран цуврал нэвтрүүлэг бэлтгэн цацаж, “Авлигын эсрэг дуу хоолойгоо нэгтгэцгээе” аян зохион байгуулав.

Орон нутгийн ТББ-уудын үйл ажиллагааг дэмжиж Үндэсний хэмжээнд Авлигын эсрэг ТББ-ын сүлжээг бий болгон үйл ажиллагааг нь жигдрүүлэх, “Шинэ хуудас” мэдээллийн хуудсыг тогтмол гарган нийтэд үнэгүй түгээх, “Шударга ёсны шагнал-2008” санаачлан шалгаруулах, төрийн болон ТББ, ажил олгогч, бизнес эрхлэгчдийг хамруулсан төрөл бүрийн арга хэмжээг тодорхой дэс дараалалтай авч хэрэгжүүлэв.

АТГ нэн тэргүүнд төрийн байгууллагын хүнд суртлыг багасгах, төрийн үйлчилгээг ил тод, хөнгөн шуурхай болгох, улмаар авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээллийг хүртээмжтэй байлгах, үйл ажиллагаагаа нээлттэй болгох, иргэдийн оролцоог хангах чиглэлээр 18 заалт бүхий зөвлөмжийг төрийн байгууллагуудад хүргүүлэн, хэрэгжилтийг байгууллага бүрээр шалгаж холбогдох заавар, зөвлөгөө өгч ажиллажээ.

Авлига, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд “Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр хамтран ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө”-г Ерөнхий сайдын захирамжаар батлуулан, төрийн захиргааны албан хаагчдын ёс зүйн дүрмийг шинэчлэн батлах, иргэдээс авдаг төлбөр, хураамжтай холбогдох эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хяналт шалгалт, тусгай зөвшөөрлийг цөөрүүлэх, хүнд суртал гаргаж, чирэгдэл учруулдаг төрийн байгууллагад ёс зүйн хяналтын тогтолцоог бүрдүүлэх талаар арга хэмжээ авах, яам, агентлагийн түвшинд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх зэрэг ажлыг зохион байгуулсан байна.

Хөрөнгө орлогын мэдүүлэгт хамрагдах төрийн албан хаагчдын хүрээг багасгах, хөрөнгө орлогын мэдүүлгийн агуулгыг сайжруулж, ашиг сонирхлын аливаа зөрчлийг илэрхийлэх, илрүүлэх боломжийг бүрдүүлэх, Хувь хүний нууцын тухай хуулийн зохицуулалттай нийцүүлэн боловсронгуй болгох талаар хуулийн төсөл боловсруулж УИХ-д өргөн мэдүүлээд байна.

Эх үүсвэр: АТГ

Цаашдын зорилт

Ойрын хугацаанд:

- Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд сурталчилах, соён гэгээрүүлэх ажлыг тасралтгүй явуулж, олон нийтийн авлигын талаархи мэдлэгийг дээшлүүлэх, энэ чиглэлд ТББ-ын оролцоог нэмэгдүүлэх, ААНБ-д авлигатай тэмцэх арга барилыг эзэмшүүлэх,
- Авлигын индекс тодорхойлох арга зүйг үндэсний хэмжээнд боловсруулах,
- Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаархи шинжээчдийн төсөөлөл, төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын хүрээн дэх авлигын талаархи олон нийтийн төсөөллийн арга зүй, аргачлалыг тодорхойлж, мэдээллийн эх үүсвэр болгон судалгааг ашиглах,
- Улс төрийн намын санхүүжилтын зарчмыг боловсронгуй болгох, үүнтэй холбогдуулан намын санхүүжилтэд төрөөс үзүүлэх дэмжлэг, түүнийг хэмжих шалгуурыг тодорхой болгож, энэ чиглэлээр Улс төрийн намын тухай хуулийг шинэчлэх,
- Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, тусгай зөвшөөрлийн тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох, ил тод байдлыг сайжруулах арга хэмжээ авах,
- Шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгчдийн ёс зүй, үйл ажиллагааны доголдлыг тооцож хариуцлага хүлээлгэх механизмыг боловсронгуй болгож хэрэгжүүлэх,

- Хууль, хяналтын байгууллагын ажилтны цалин, нийгмийн хангамжийг эрс сайжруулж, ажиллах нөхцлөөр бүрэн хангах арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх.

Дунд хугацаанд:

- Авлигатай тэмцэх, шударга ёсыг тогтоох чиглэлээр хууль, эрх зүйн орчинг төгөлдөржүүлж олон нийтэд сурталчилах замаар нийгмийн сэтгэл зүйд шинэ үнэлэмж бий болгох,
- АТГ-ын мэдээлэл, судалгааны чадавхийг дээшлүүлэх,
- Авлигын индексийг ашиглан авлигатай тэмцэх ажлын чанар, өгөөжийг дээшлүүлэх,
- Авлигын эсрэг Монгол Улсын хуулийн хэрэгжилтийг дүгнэх, авлигын эсрэг үндэсний хууль тогтоомжийг авлигын эсрэг НҮБ-ын конвенцид нийцүүлэх арга хэмжээ авах,
- Улс төр, хууль хяналтын байгууллага, томоохон бизнесийн хүрээнийхний харилцаанд авлига үүсэх нөхцөлийг бүрдүүлж байгаа харилцааг зохицуулсан хууль тогтоомжуудад дүн шинжилгээ хийж, шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах,
- Төрийн албан тушаалд томилох тогтолцоог боловсронгуй болгож ур чадвар, ёс зүй, ажлын мэдлэг, туршлага зэрэг гол үзүүлэлтэд тулгуурладаг зарчимд шилжиж, улс төрөөс хамаарал багатай болгох,
- Захиргааны процессийн тухай хуулийг боловсруулж, түүний ил тод байдлыг хангах, олон нийтийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах зохицуулалтуудыг тусган мөрдүүлэх,
- Сонирхлын зөрчлийн тухай хууль боловсруулан хэрэгжүүлэх.

Бүлэг 2.

**МХЗ-УУД БОЛОН ХӨГЖЛИЙН УРТ
БОЛОН ДУНД ХУГАЦААНЫ БОДЛОГО
ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮЖИЛТИЙН
УЯЛДАА ХОЛБОО**

Өнөөгийн байдал

Монгол Улсын МХЗ-уудын санхүүжилтийн хувьд ойрын жилүүдэд огцом их зардал гаргаж макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг алдагдуулах замаар бус, харин санхүүжилтийг эдийн засгийн өргөжилттэй уялдуулж, эдийн засагт огцом нөлөө үзүүлэлгүйгээр МХЗ-уудын хэрэгжилтийг хангах чиглэл баримталж байна.

МХЗ-уудын санхүүгийн стратегийг цаашид улсын хөрөнгө оруулалтын дунд хугацааны хөтөлбөртэй нягт уялдуулан боловсруулснаар МХЗ-уудыг хангах холбогдох санхүүгийн эх үүсвэрийг жил жилийн төсөвт тусган баталгаажуулах, түүнчлэн олон улсын байгууллага, хандивлагчдын санхүүгийн дэмжлэг, тусламжтай уялдуулах ач холбогдолтой юм.

МХЗ-уудыг хангах чиглэлээр улсын төсвийн хөрөнгө оруулалтын тодорхой хэсэг нь чиглэгдсэн байна. Тухайлбал, 2008 оны улсын төсвийн нийт зардалд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын багц 24.0 хувь, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын төсвийн багц 19.0 хувь, Эрүүл мэндийн сайдын багц 12.0 хувь байгаа нь МХЗ-уудыг хангахад ихээхэн дэмжлэг боллоо. Нийгмийн халамжийн тогтолцоонд өөрчлөлт ороогүй боловч нийгмийн халамжийн зардал өссөн байна. Шинээр төрсөн хүүхэд хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө нь 2008 онд өмнөх оноос 8.6 хувиар өссөн байна. Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын хэмжээ 2008 онд 2007 оноос 8.4 хувь нэмэгдэж, боловсролын салбарын хөрөнгө оруулалт ч мөн нэмэгдлээ.

Бодлогын уялдаа холбоо

Мянганы хөгжлийн “Ядуурал, өлсгөлөнг бууруулах” зорилго нь үндэсний болон салбарын бодлого, стратегийн томоохон баримт бичгүүдэд нилээд сайн туссан байна.

Боловсролын чиглэлийн зорилт нь Монгол Улсын ҮХЦБ-д “Бүх нийтийн боловсролыг

нийгмийн үйл хэрэг болгон хөгжүүлж, үндэсний боловсролын тогтолцоог олон улсын түвшинд ойртуулан төгөлдөржүүлж, оюунжсан, бүтээлч чадамжтай хүний нөөцийг байнга нэмэгдүүлнэ” гэж туссан байна. Уг зорилгын хүрээнд бага боловсрол, сургуулийн өмнөх боловсрол, албан бус боловсролын чиглэлээр 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Эдгээр нь Боловсролын салбарын ерөнхий төлөвлөгөө, ЗГҮАХ, жил бүрийн ЭЗНХҮЧ, Англи хэлний боловсролын Үндэсний хөтөлбөр, Монгол бичгийн Үндэсний 2 дахь хөтөлбөр, Бичиг үсгийн боловсролын Үндэсний хөтөлбөр, Зайны сургалтын Үндэсний хөтөлбөр, Бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх Үндэсний хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт туссан байна.

Жендэрийн тэгш байдлыг хангах тухай зорилт нь Монгол Улсын ҮХЦБ-ын 4.2-т “жендэрийн тэгш байдлыг хангах бие даасан хуультай болох, бүх шатны боловсролын хөтөлбөрийн агуулгыг жендэрийн мэдрэмжтэй болгох, өмчийн болон хөдөлмөрийн харилцаан дахь тэгш оролцоог хангах, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх” гэж тусчээ.

Салбарын бодлого, хөтөлбөр, төлөвлөлтөд жендэрийн хандлагыг тусгах, МХЗ-ууд, Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиглэлээр Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулсан Жендэрийн тэгш байдлын Үндэсний хороо, түүний ажлын алба ажиллаж байна. МХЗ-уудын жендэрийн чиглэлийн зорилтуудыг хангах чиглэлээр Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн төсөл боловсруулав.

Мөн Засгийн газрын 2007 оны 225 дугаар тогтоолоор “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх Үндэсний Хөтөлбөр”-ийг батлан, хэрэгжүүлж байна.²⁰ Хөтөлбөрийн

²⁰ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг 2004 оны 5 сард УИХ-аас батлан гаргасан. 2007 онд шинэчилсэн.

хэрэгжилтийг Үндэсний хэмжээнд удирдан зохион байгуулах, хянах үүргийг Жендэрийн тэгш байдлын Үндэсний хороо, бүх шатны Засаг дарга нар хүлээн ажиллаж байна.

Эрүүл мэндийн чиглэлээр Монгол Улсын МХЗ-уудад суурилсан ҮХЦБ-д дээрх зорилтуудын талаар "...эх, нялхасын эрүүл мэндийг хамгаалах чадамжийг цогц байдлаар хөгжүүлэх...эх нялхасыг хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох..." гэсэн заалт туссан байна. Эрүүл мэндийн салбарын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд Эхийн эндэгдлийг бууруулах стратеги, Тусламж үйлчилгээний нэн шаардлагатай болон нэмэлт багц, Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах Үндэсний хөтөлбөр, Эрүүл монгол хүн Үндэсний хөтөлбөр, Нөхөн үржихүйн эрүүл мэндийн Үндэсний гурав дахь хөтөлбөр, Сумын эмнэлэгийн хөгжлийн хөтөлбөр зэргийг хэрэгжүүлж байна.

Байгаль орчныг хамгаалах, ойн нөөцийг нэмэгдүүлэх бодлого зохицуулалтыг сайжруулах хүрээнд Ойн тухай хуулийг шинэчлэн баталж, Засгийн газрын бүтцэд өөрчлөлт оруулж Ойн хэрэг эрхлэх газрыг байгуулан ажиллаж байна.

Хүний эрх, ардчилалыг хангах бодлогын хүрээнд "Эрх зүй, төрийн байгуулалын хөгжлийн бодлого" чиглэлээр туссан байна.

МХЗ-уудын хэрэгцээний үнэлгээнд тусгагдсан арга хэмжээнүүд нь хэт жижиг, зангидаж нэгтгэгдээгүй, санхүүгийн эх үүсвэр, санхүүжилтийн зарчимтайгаа зохилдоогүй нь хэрэгжилтийг хангахад хүндрэлтэй, төсөв санхүүжилтийг хянах боломжгүй болгож байна.

Тухайлбал, эхчүүдийн эрүүл мэндийг сайжруулах гурван гол зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд 34 арга хэмжээг тодорхойлсон ч арга хэмжээ бүрээр санхүүжилтийг тооцоогүй байна. Тухайлбал, эрүүл мэндийн тусламжийн анхан болон дунд шатны түвшинд эх, хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний санхүүжилтийг ялган тооцоход хүндрэлтэй байгаа тул санхүүгийн төлөвлөлт, төсөвлөлт, бүртгэл, мэдээллийн тогтолцоог сайжруулах шаардлагатай байна.

Эндээс Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль нь улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдийг үндэс болгох, тодорхой түвшний төлөвлөлтүүд бие

биенээ уламжлан хэрэгжих бодит нөхцөлийг бүрдүүлэх тал дээр учир дутагдалтай байгаа нь харагдаж байна. Улсын төсвийг боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах, тайлагнах үйл явц болон цаг хугацаа нь яамдын арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдаатай байгаа учраас МХЗ-уудтай холбогдох яамдын дээрх баримт бичигт хэрэгцээний үнэлгээгээр тодорхойлсон интервенцүүдийг тусгаж өгөх нь илүү ач холбогдолтой харагдаж байна.

Дэмжих орчин

Монгол Улсад олон улсын байгууллагууд, хандивлагч донор орнууд салбарын урт, дунд, богино хугацааны бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ихээхэн хэмжээний дэмжлэг зээл, тусламжийг үзүүлж байна.

Эдгээр төсөл, хөтөлбөр нь МХЗ-уудыг хангах чиглэлээр тусдаа тодорхойлогдоогүй боловч, тус салбарын хөгжлийг дэмжих чиглэлээр тусгагдсан МХЗ-уудын хэрэгжилтийг хангахад цогц байдлаар туссан байна.

МХЗ-уудын эрүүл мэндийн чиглэлийн зарим зорилтуудыг хангах хөрөнгийн эх үүсвэрийг олон улсын байгууллага, хандивлагч орнуудын тусламжаар хэрэгжүүлж ирсэн бөгөөд 2007-2008 онд энэ чиглэлээр улсын төсөвт тодорхой хэмжээний хөрөнгийн эх үүсвэр тусган хэрэгжүүлээ.

Монгол Улсын төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангах тогтолцоо өнөөдөр бүрдээгүй нь МХЗ-уудыг хангахад хувийн хэвшлийн оролцоо хангалтгүй байгаа хэдий ч энэ чиглэлээр анхны арга хэмжээнүүд хийгдэж эхлээд байна. Тухайлбал, "Таван богд" ХХК нь Хоол тэжээлийн дутлыг бууруулах зорилтын хүрээнд хяналт, үнэлгээ мэдээллийн тогтолцоог бий болгоход дэмжлэг үзүүлэх чиглэлээр 50.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлээ.

Тулгамдсан асуудал

МХЗ-уудыг хангахад шаардагдах хөрөнгийн хэрэгцээний үнэлгээ хийх арга зүйг улам боловсронгуй болгож, зорилт тус бүрт шаардагдах санхүүгийн хэрэгцээг нарийн тодорхойлон тусгах хэрэгтэй байна. Хэдийгээр МХЗ-уудыг хангах хөрөнгийн хэмжээний нийт тойм тооцоо 2006 онд гарсан боловч түүнийг хэрэгжүүлэх "Санхүүжилтийн стратеги"-ийг боловсруулаагүй байна. Энэ нь хэрэгжилтийг

бүрэн үнэлэхэд хүндрэл учруулж байна. Улсын төсөв, хөрөнгө оруулалтын бодлогыг цогц байдлаар, МХЗ-уудын хэрэгжилтийг хангахад чиглүүлэх шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, төсвийн зүйл анги бүрээр МХЗ-уудын хэрэгжилтийг хангах эх үүсвэрийг тусад нь тусгаж, түүний хэрэгжилтийг жил бүрийн төсвийн гүйцэтгэлтэй уялдуулан дүгнэж байх тогтолцоог бүрдүүлэх хэрэгтэй байна. МХЗ-уудыг хангахад төр, хувийн хэвшлийн түншлэлийн тогтолцоог нэвтрүүлж, ялангуяа хувийн хэвшлийнхний хөрөнгө оруулалтыг дэмжих, компаниудын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр тэдэнтэй нягт хамтран ажиллах шаардлагатай байна.

Цаашдын зорилт

МХЗ-уудын хэрэгжилтийг хангахад нилээд үүрэгтэй санхүүгийн үйл ажиллагааг дэмжихэд дараахь асуудлуудад анхаарч ажиллах хэрэгтэй байна. Үүнд:

- МХЗ-уудын санхүүжилтийн стратегийг боловсруулж, хөрөнгө оруулалтыг дунд хугацааны хөтөлбөртэй уялдуулах,
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тогтолцоог нэвтрүүлж, хувийн хэвшлийг МХЗ-уудыг хангахад татан оролцуулах чиглэлээр идэвхтэй ажиллах,
- МХЗ-уудыг хангах санхүүгийн хэрэгцээг зорилт, арга хэмжээ тус бүрээр гаргаж, түүнийг санхүүгийн стратегид тусгах,
- Туршилтийн журмаар сонгосон аймаг, нийлэл, дүүргийн хэмжээнд МХЗ-уудыг хангах хөрөнгийн хэмжээний үнэлгээг хийх,
- МХЗ-уудын хөрөнгийн хэрэгцээний дүнг үндэслэн хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг хандивлагч орон, олон улсын байгууллагуудад тавих,
- МХЗ-уудыг 2015 он гэхэд хангахад санхүүгийн хувьд учирч болзошгүй эрсдлийн үнэлгээг хийж, “Санхүүгийн стратеги”-д тусгах зэрэг болно.

Бүлэг 3.

**МХЗ-УУДЫН ОРОН НУТАГ
ДАХЬ ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ,
СУРТАЛЧИЛГАА, ОЛОН НИЙТИЙН
ОРОЛЦОО**

Өнөөгийн байдал

МХЗ-уудыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх ажлыг НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр “Ядуурал, МХЗ-уудын хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог дэмжих” туршилтын төслийн хүрээнд 2007 оноос хэрэгжүүлж байна. Орон нутгийн хүний хөгжлийн түвшин, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал зэргийг харгалзан бүс бүрээс 1 аймаг, тухайлбал, Дорнод, Дундговь, Говь-Алтай, Хөвсгөл аймаг, нийслэлийн Налайх, Сонгинохайрхан дүүргийг сонгон авч, 2007 оны 12 сард Сангийн Яам, эдгээр аймаг, дүүргүүдийн Засаг дарга, НҮБХХ-ийн газар Харилцан Ойлголцлын Санамж Бичигт гарын үсэг зурж туршилтын төслийг албан ёсоор эхлүүлэв.

МХЗ-уудыг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг өргөжүүлэн 2008 онд НҮБХАС-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр Ховд, Увс, Баян-Өлгий аймагт төсөл хэрэгжүүлж, эдгээр аймгийн МХЗ-уудын хэрэгжилтийн өнөөгийн байдлыг тодорхойлсон тайланг боловсруулж байна. Улаанбаатар хотын ЗДТГ-аас МХЗ-уудын анхны тайлангаа бэлтгэх санаачилга гаргасаныг дэмжин НҮБХХ-ийн төслийн хүрээнд техникийн туслалцаа үзүүлэв. Ийнхүү Монгол Улсын хэмжээнд 7 аймаг, Улаанбаатар хот, 2 дүүрэг МХЗ-уудаа тодорхойлох туршилтийн төсөлд хамрагдан үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна.

МХЗ-уудын хэрэгжилт нийслэл, аймаг бүрт харилцан адилгүй байгаа тул цаашид үйл ажиллагаа, төсөв, санхүүгийн хүрээг зорилт бүрээр нарийвчлан тодорхойлж, МХЗ-уудыг хангахад анхаарах шаардлагатай байна.

Орон нутгийн санаачлагууд

Орон нутгийн өөрийн онцлогийг тусгасан МХЗ-уудыг тодорхойлон, тэдгээрийг хангах үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах нь нэн тулгамдсан асуудлуудын нэг бөгөөд уг ажлыг нутгийн удирдлага, холбогдох талууд, иргэд харилцан зөвшилцөж

боловсруулах, хэрэгжилтийг хянах тогтолцоог бүрдүүлэх ажлын хүрээнд Дундговь, Дорнод, Говь-Алтай, Хөвсгөл аймаг, нийслэлийн Сонгинохайрхан, Налайх дүүргийн “МХЗ-уудын хэрэгжилт, тулгамдсан асуудлууд” анхны тайланг боловсруулж, олон нийтэд сурталчилах ажлыг хийлээ.

Аймаг, дүүргийн МХЗ-уудын хэрэгжилт, тулгамдсан асуудлууд²¹ анхны тайлан нь дээр дурдсан аймаг, дүүргийн МХЗ-уудын өнөөгийн төлөв байдлыг дүгнэн хэрэгжилтийг үнэлж, цаашид шийдвэрлэх асуудлуудыг багцлан тодорхойлсон бодлогын баримт бичиг юм. Энэхүү тайланг төсөлд хамрагдсан аймаг, дүүргүүдийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор байгуулагдсан МХЗ-уудыг хэрэгжүүлэх Бодлогын Хороо, сэдэвчилсэн ажлын хэсгүүд болон сум, орон нутгийн холбогдох ажилтнууд, Сангийн яам, НҮБХХ-ийн ажилтнууд, ТББ-ын хамтын оролцоотойгоор хийж гүйцэтгэсэн юм.

Эдгээр аймаг, дүүрэг МХЗ-уудын 2015 онд хүрэх үр дүнг, орон нутгийн онцлогтой нийцүүлэн шалгуур үзүүлэлтүүдийн хамт тодорхойлж, аймаг, дүүргийн ИТХ-аар батлуулан хэрэгжүүлж эхлээд байна. Аймаг, дүүргийн МХЗ-уудын хэрэгжилтийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлуудад тулгуурлан МХЗ-уудад суурилсан орон нутгийн хөгжлийн баримт бичгийг боловсруулж хэрэгжүүлэх, шинэчлэн сайжруулах зэрэг үйл ажиллагааг хийхээр бэлтгэж байна.

МХЗ-уудын талаархи ойлголтыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааг нутгийн иргэд, бодлого боловсруулагчид, салбарын мэргэжилтэн, ажил олгогчид ИНБ-уудад зориулан явуулав.

²¹ “Аймаг, дүүргийн МХЗ-уудын хэрэгжилт, тулгамдсан асуудлууд” тайлангийн бүрэн эхийг www.mongoliam-dg.mn вэб сайтаас үзнэ үү.

Туршилтын аймаг, дүүрэг, Улаанбаатар хотын МХЗ-уудын хэрэгжилт, тулгамдсан асуудлууд

Дорнод аймаг. Аймгийн 2007 оны “Өрхийн хэрэгцээний судалгаа”-гаар хэрэглээ багатай буюу ядуу өрхүүд дунджаар 29.0 хувийг эзэлж байв. Ядуурлын үндсэн шалтгаан нь малчид мал сүргээ ган зуданд ихээр хорогдуулсны зэрэгцээ, идэвх санаачилга сул, залхуурал, архидалт, мөрийтэй тоглоом ихэссэн гэж дүгнэжээ.

Бага насны хүүхдийн хоол, тэжээлийн дутал харьцангуй бага, аймгийн төвд тав хүртэлх насны хүүхдийн жингийн алдагдал хөдөө сумдынхаас их байгаа нь хөдөөнөөс малгүй болсон иргэдийн аймгийн төв рүү чиглэсэн шилжилт, ажилгүйдэл, ядууралтай нэг талаар холбоотой байна.

Тус аймагт 2007 оны эцсийн байдлаар ажилгүйдлийн түвшин 4.5 хувь болж, ажиллах хүчний оролцооны түвшин улсын дунджаас 18.0 нэгжээр доогуур байжээ.

Бага боловсролын хамран сургалт 2007 онд 96.5 хувь болж өссөн нь улсын болон бүсийн дунджаас өндөр байна.

Тав хүртэлх настай хүүхдийн эндэгдэл 2007 онд 1990 оныхоос 4 дахин, 2000 оныхоос бараг 2 дахин буурсан боловч улсын болон бүсийн дунджаас их байна. Эхийн эндэгдлийн түвшин тогтвортой буурч чадахгүй байгаа нь төрөх насны эмэгтэйчүүдийн суурь болон хавсарсан өвчлөл их, жирэмсний эрт хяналт сул, БЗДХ өвчин их, ядуу эмэгтэйчүүдийн дунд жирэмслэлтээс сэргийлэх арга, хэрэглээ харьцангуй доогуур, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж тэр бүр хангалттай байж чадахгүй байгаатай холбоотой байна.

Сүүлийн 5 жилийн дунджаар нийт халдварт өвчний дотор БЗДХ өвчин 42.1 хувийг эзэлж байгаа бөгөөд 15-24 насны залуучуудын дунд илэрсэн БЗДХ өвчнөөр өвчилсөн тохиолдол 2007 онд 2003 оныхоос 31.6 хувь, 2005 оныхоос 23.8 хувиар тус тус буурсан байна. Тус аймагт сүрьеэ өвчний тархалт болон сүрьеэгээс шалтгаалсан нас баралт улсын дундаж түвшнээс өндөр байна.

Дундговь аймаг. Амьжиргааны түвшний судалгаагаар нийт хүн амын 30 хувь нь ядуу, нэн ядуу амьдарч байна. Тус аймагт 2007

оны байдлаар ажилгүйдлийн түвшин 2.5 хувь байгаа нь улсын дунджаас доогуур байна.

Байгаль, цаг уур, дэд бүтцийн нөхцөл байдлын улмаас үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх боломж сул байгаа нь ажлын байрыг нэмэгдүүлэхэд саад болж байна. Тав хүртэлх насны хүүхдийн тураал, туранхай, өсөлтийн хоцролттой хүүхдийн хувь улсын дунджаас доогуур байна.

Бага боловсролын хамран сургалтын цэвэр жингийн үзүүлэлтээр улсын хэмжээнд 19 дүгээрт орж, улсын дундаж түвшнээс 4.4 нэгжээр доогуур байна. 1,000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 12.7, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 13.7-д хүрч улсын болон говийн аймгуудтай харьцуулахад бага түвшинд байна. Эхийн эндэгдлийг бууруулах стратегийг боловсруулан хэрэгжүүлсний үр дүнд 2007 оны байдлаар эхийн эндэгдэл улсын дунджаас 2 дахин, төвийн бүсээс 1.4 дахин доогуур байгаа нь эхийн эрүүл мэндийн үйлчилгээнд гарсан тодорхой ахиц юм.

БЗДХ-ын тархалт 2000 онд нийт халдварт өвчний 33.1 хувийг эзэлж байсан бол 2007 онд 27 хувь болж буурч, цаашид эрсдэлт хүчин зүйлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг эрчимжүүлэх, эрсдэлт бүлгийн талаар нарийн судалгаа хийх шаардлагатай байна.

Говь-Алтай аймаг. Нийт хүн амын 30.4 хувь нь 2006 оны байдлаар амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой байна. Бага орлоготой болон ядуу иргэдэд чиглэсэн дэмжлэг эзнээ олж хүрэхгүй байгаа бөгөөд тэдний боловсрол, ур чадвар хангалтгүй байна. 2007 оны байдлаар ажилгүйдлийн түвшин 3.9 хувь байна.

Тав хүртэлх насны хүүхдийн тураалын эзлэх хувь улсын болон бүсийн дунджаас өндөр байгаагийн шалтгаан нь тус аймагт рахит, цус багадалт өвчин түгээмэл байгаатай холбоотой юм.

Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин 2007 онд 95.7 хувь болж улс, бүсийн дундаж түвшнээс дээгүүр байна.

1,000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 2007 онд 36.2 болж 1990 оныхтой харьцуулахад 2 дахин буурсан ч улсын болон баруун бүсийн дунджаас өндөр байна. Нярайн эрт үеийн эндэгдлийн 84.2 хувийг эхийн жирэмсний хожуу хордлого, эмчилгээний үр дүнгүй

байдал, хугацаанаас өмнөх төрөлт эзэлж байгаа бөгөөд сүүлийн таван жилийн байдлаар авч үзэхэд нийт төрсөн хүүхдийн 73.6 хувийг дутуу жинтэй, амьдрах боломжгүй төрсөн нярай эзэлж байна. Эндсэн нярайн ээжүүдийн 73.9 хувь нь малчин, ажилгүй, үүнээс 60 гаруй хувь нь боловсролгүй байгаа нь жирэмсний хяналтад хамрагдахгүй, жирэмсэн үеийн эх, ургийн хүндрэл, эрсдэл гарахад нөлөөлж байна.

100,000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин 1991 онд 228.7 байснаа 1999 оноос 2006 оны хооронд нэг түвшинд тогтворжин буурах хандлагатай байсан боловч 2007 онд 411.9 болж бараг 2 дахин буюу улсын дунджаас 4.5 дахин ихэсч, хамгийн их эндэгдэлтэй аймаг болж байна. Эхийн эндэгдлийн шалтгааны 18 хувийг төрсний дараахь халдвар, 18 орчим хувийг умайн гадуур жирэмслэлт эзэлж байгаа бөгөөд үлдэж байгаа хувийг ураг орчмын шингэнээр бөглөрөх, зүрхний төрөлхийн хавсарсан гажиг, элэгний хатуурал зэрэг өвчлөл эзэлж байна.

Хэдийгээр сүрьеэгийн өвчлөлийн түвшин улсын болон баруун бүсийн дунджаас доогуур байгаа ч сүүлийн 7 жилд өвчлөл нэмэгдэх хандлагатай байна. 2007 онд сүрьеэгээр өвчилсөн хүмүүсийн 44.4 хувь нь уушигны, 55.6 хувь нь бусад эрхтний сүрьеэ эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 1990-ээд оныг хүртэл нийт мал сүргийн 90 шахам хувийг бог мал эзэлж, 2 хонь, 1 ямаа гэсэн харьцаатай байсан бол, 2007 оны байдлаар 95 орчим хувийг бог мал эзлэх болсны зэрэгцээ 2 ямаа, 1 хонь гэсэн урвуу харьцаатай болсон нь мал аж ахуйн салбарын үндсэн бүтээгдэхүүн махны үйлдвэрлэлд болон байгаль экологийн тэнцвэрт байдалд сөрөг нөлөө үзүүлж байна. Ямааг хяналтгүй өсгөснөөс цөлжих үйл явц хурдсах хандлагатай байдгийг олон улсын туршлага харуулж байна. Иймд байгаль, цаг уурын нөхцөл, бэлчээр, экологид сайтар зохицсон, арвин ашиг шимтэй үүлдэр, омог, хэвшлийн малыг сонгон үржүүлэх зайлшгүй шаардлага гарч байна.

Хөвсгөл аймаг. Ядуурал дорвитой буурахгүй, нийт хүн амын гуравны нэг орчим нь амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой амьдарч байгаа нь тэгш бус байдал нэмэгдэж, түүнчлэн цаатан зэрэг үндэсний цөөнхийн хөгжлийн үзүүлэлтүүд аймгийн ядуурлын үзүүлэлтэд шууд нөлөөлж, нөгөө

талаар ядуу хүнийг тодорхойлох арга аргачлал болон аймгийн хэмжээнд бүтээж байгаа орлогыг үнэн зөв бүртгэх нь бэрхшээлтэй байгаа зэрэгтэй холбоотой байна.

Хоол, тэжээлийн дутлаас үүдэлтэй олон төрлийн өвчинд хүн ам өртөж байна. Аймгийн хэмжээнд ажилгүйдлийн түвшин буурч байгаа ч улсын дунджаас 0.4 нэгжээр илүү, бүсийн дунджаас 0.9 нэгжээр доогуур байна.

Хамран сургалтын түвшин нэмэгдэж байгаа ч 2007 оны байдлаар энэ үзүүлэлтээр улсад 17 дугаар байр эзэлж байна. Цаатан хүүхдүүдийн сургуульд хамрагдалт төдийлөн хангалттай бус, бага боловсрол болон ялангуяа 1,7,8 дугаар ангийнхны дотор сургууль завсардалт бүх сумдын хэмжээнд нилээд их байна.

Хүн ам, хүүхдэд нарийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх бүсийн оношилгооны төв Орхон аймагт байдаг нь хүүхдийн эндэгдэл ихтэй сумдын хувьд нарийн мэргэжлийн үйлчилгээ авахад бэрхшээл учруулдаг байна.

1992 оноос хойш ХДХВ/ДОХ-оор өвчилсөн буюу халдвар авсан хоёр тохиолдол тус аймагт бүртгэгдсэн бөгөөд БЗДХ авсан хүний 40 гаруй хувийг эрхэлсэн ажилгүй, 5 орчим хувийг төлбөрийн чадвар муутай, 10 гаруй хувийг биеэ үнэлдэг хүмүүс эзэлж байна.

Сонгинохайрхан дүүрэг. 2006 онд хүн амын 35.9 хувь нь амьжиргааны түвшнээс доогуур орлоготой байгаа нь 1996 онтой харьцуулахад 14.7 нэгжээр өндөр, ядуурлын гүнзгийрэлт 2006 онд 21.6 хувь байгаа нь ажилгүйдэл, хөдөө, орон нутгаас шилжин ирэгсэд ихээр нэмэгдэж байгаатай холбоотой байна.

Хөдөлмөрийн насны хөдөлмөр эрхлээгүй хүн ам 2004 онд дүүргийн хүн амын 12.9 байсан бол 2005 онд 18.6 хувь, 2007 онд 20.9 хувь болж, жил ирэх тутам хөдөлмөр эрхлээгүй хүний тоо нэмэгдэж байна. Хөдөлмөрийн насны нийт хүн амд хөдөлмөрийн чадваргүй хүний тоо 2004 онд 3.2 хувь, 2007 онд 2.8 хувийг тус тус эзэлж байна.

Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин 2000 онд 95.1 байсан бол 2007 онд 91.3 хувь болж буурсан нь хөдөө, орон нутгаас шилжин ирж байгаа иргэдийн дийлэнх хувь нь суурьшиж, хүн амын тооны механик өсөлт нэмэгдэж, сургууль ачааллаа даахгүй болсон, нөгөө талаар шилжин ирэгсдийн ихэнх нь ядуу, нэн ядуу амьдралын боломж

тааруу иргэд байдаг учраас хүүхдээ сургуульд оруулахгүй завсардуулж байгаатай холбоотой юм. Нэгдүгээр ангид элсэн ороод 5 дугаар анги хүртэл суралцагчдын хувь 2000 онд 85.7 хувь байснаа 2007 онд 89.2 хувь болж өссөн байна.

Хүүхдийн буруу хооллолт, асаргаа, эхийн хоолны чанар, тэжээллэг хүнсний хэрэглээ зэрэг хүчин зүйлээс шалтгаалан тураалтай, туранхай хүүхдийн эзлэх хувь өндөр байна.

Улсын дундажтай харьцуулахад тус дүүрэг сүрьеэ өвчний тархалт ихтэйд тооцогдож байгаа бөгөөд 100,000 хүн тутамд ногдох сүрьеэгийн бүртгэгдсэн тохиолдол 2000 онд 163.9, 2007 онд 243.7 болж өсчээ. Сүрьеэ өвчнөөр өвчлөгчдийн 70 орчим хувийг 16-44 насны хүмүүс эзэлж байгаагийн 60-аас дээш хувь нь ажилгүй, амьдралын түвшин доогуур хүмүүс байна.

Иргэдийн ус хангамжийн хүрэлцээг нэмэгдүүлэх үүднээс ус түгээх байр барих, цэвэр усны шугам сүлжээнд ус түгээх байрыг холбох ажлыг хийж байгаа боловч шинээр шилжин ирж байгаа айл өрх нэмэгдэж байгаатай холбогдон ундны усны хүрэлцээ, хангамж төдийлөн сайжрахгүй байна.

Орон, гэргүй иргэдэд гэр олгох асуудлыг анхаарч ажилласны үр дүнд 2006 онд орон гэргүй иргэд нийт өрхийн 1.2 хувийг эзэлж байсан бол 2007 онд 0.3 хувь болж буурлаа.

Налайх дүүрэг. Нийт хүн амын 63.1 хувь нь 2000 онд амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой байсан бол 2007 онд 22.36 хувь болж буурсан байна. Сүүлийн 2 жилд ядуурлын шугамаас доогуур орлоготой хүн амын тоо буурсан ч ядуурал нэлээд байгаагийн гол шалтгаан нь ажлын байр дутмаг, улирлын чанартай, ажлын байрны аюулгүй ажиллагааны баталгаа муу (нүүрсний уурхай) байгаагаас болж байна. Хэдийгээр ядуурлын түвшин 2007 онд улсын дундажтай харьцуулахад 11.8 нэгжээр доогуур байгаа боловч, энэ нь Улаанбаатар хотын түвшинтэй харьцуулахад 5.4 нэгжээр өндөр үзүүлэлт юм.

Тав хүртэлх насны хүүхдийн тураал 1997 онд 28.3 хувь байсан бол 2007 онд 1 хувьд хүрч, нийт 27.3 нэгжээр буурсан үзүүлэлттэй байгаа хэдий ч хүүхдийг чийрэгжүүлэх, эрүүлжүүлэх, нөхөн сэргээх чиглэлийн үйл ажиллагаа дутмаг, эцэг, эхчүүдийн бага насны хүүхдийг асрах талаархи мэдлэг боловсрол дутмаг, дүүргийн

хэмжээнд өрхийн эмч нарын хүрэлцээ муу, хүүхдийн нарийн мэргэжлийн эмч дутагдалтай зэрэг асуудлууд байсаар байна.

Тус дүүрэгт ажилгүйдлийн түвшин 2006 онд 1.6 хувь байсан бол 2007 онд 2.6 хувь болж өссөн нь ажилгүй иргэд хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлж, ажилд зуучлуулж ажилтай болох гэсэн сонирхол өссөн, ажил олгогч эздийн тавьж байгаа шаардлагад нийцсэн мэргэжилтэй ажилтан ховор, ажлын дадлага туршлага бага, хөдөө орон нутгаас шилжин ирэгсэд нэмэгдсэн, үүнийг дагаад эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо эрс нэмэгдсэн зэрэг шалтгаантай байна.

Налайх дүүргийн хувьд 2001 онд нийт шилжилт хөдөлгөөнд оролцогчдын 18.3 хувь нь шилжин ирж, 81.7 хувь нь шилжин явж байсан бол 2007 оны байдлаар 81.2 хувь нь гаднаас шилжин ирж, 18.7 хувь нь шилжин явсан байна. Шилжилт хөдөлгөөнтэй холбоотойгоор сургууль, цэцэрлэг, эмнэлгийн хүртээмжийг цаашид нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна.

Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин улсын болон Улаанбаатар хотын түвшинтэй харьцуулахад өндөр байна. Сургууль завсардсан хүүхдүүдийн дундахь судалгаагаар 80 хувь нь бага боловсрол эзэмших явцад сургууль завсардсан гэсэн дүн гарсан байна.

Дүүргийн хэмжээнд 2007 онд тав хүртэлх насны эндсэн хүүхдийн 23.8 хувь нь нярайн эмгэгийн, 14.3 хувь нь суулгалт өвчний, 9.5 хувь нь уушигны хатгалгааны, 14.3 хувь нь түлэгдэлтээс, 38 хувь нь бусад шалтгааны улмаас энджээ. Улаанбаатар хотод ойр учраас хотын төвийн эмнэлэгт төрөх боломж байгаа нь эхийн эндэгдэл бага гарахад нөлөөлдөг байна.

Сүрьеэ өвчний өвчлөлийн түвшин жилээс жилд буурч байгаа хэдий ч сүрьеэгээс шалтгаалсан нас баралт улсын дундажтай харьцуулахад өндөр байна.

Уурхайн ашиглалтын явцад үүссэн нүхнүүдийг булаагүйн улмаас нуралт, цөмрөлт үүсэх, уурхайн нүхнүүдэд хог, хаягдлыг ихээр хаядаг зэрэг нь хөрсний бохирдлыг нэмэгдүүлж байна. Уурхайн эргэн тойронд 6-7 тоосгоны үйлдвэр үйл ажиллагаа явуулан хөрсийг ихээр хуулж, мөн жилд 200 шахам иргэд хувиараа ам гарган нүүрс олборлодог нь байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байна.

Дүүргийн нийт газар нутгийн 41.1 хувийг тусгай хамгаалалттай газар нутаг эзэлж байгаа бөгөөд энэ бүс нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аялал жуулчлалын байгууллагуудаас иргэдийг богино хугацаанд ажлын байраар хангаж байна. Түүнчлэн аялал жуулчлалын бааз болгон өөрсдийн хэрэгцээнд гүний худаг гаргаж байгаагаас гадаргын усны хэмжээ багассан нь бороо хурын хэмжээ, цаг агаарт сөрөг нөлөө үзүүлж байна.

Улаанбаатар хот. Улаанбаатар хотын МХЗ-уудын хэрэгжилтийн байдлыг тодорхойлсон анхны илтгэлийг 2009 оны эхээр гаргасан. Энэ үнэлгээний тайланд үндэслэн Монгол Улсын Мянганы хөгжлийн 9 зорилго, 24 зорилтын 40 шалгуур үзүүлэлтийг ашиглаж үнэлгээ хийжээ. Улсын хэмжээнд дэвшүүлсэн зорилтод “эрт хүрсэн” 7 (17.5%), зорилтыг хангах “боломжтой” 19 (47.5%), хэрэгжилт “удаан” 7 (17.5%), өмнө хүрсэн түвшнээс “ухарсан” 7 (17.5%) гэсэн дүн гарсан байна.

Улсын түвшинд 2015 онд хүрэхээр дэвшүүлсэн зорилтын 65 хувийг өнөөгийн түвшингээр Улаанбаатар хот биелүүлэх боломжтой гэсэн дүн гарчээ. Тухайлбал, ядуурлын түвшин 2008 онд 21.9 хувь болж, 1990, 2000 оны түвшнээс буурсан бөгөөд ядуурлын гүнзгийрэлт 6.3 хувь, ядуурлын мэдрэмж 2.6 хувьд хүрсэн нь улсын дунджаас доогуур түвшинд байна.

Улаанбаатар хот МХЗ-уудын дийлэнхийг хангах боломжтой байгаа нь нийгмийн үндсэн суурь үйлчилгээнүүдийн хүртээмж, чанар нь хөдөө, орон нутгаас харьцангуй өндөр байдгаас хүн амын боловсрол, эрүүл мэнд, амьдрах орчин нөхцөл, хоол, хүнсний хангамж, мэдээлэл хүлээн авах, солилцох боломжоор хангагдсан байдагтай холбоотой байна.

Улаанбаатар хотод шилжин суурьшигчдын 37.0 хувь нь ядуу байгаа нь нэлээд анхаарал татах асуудал болоод байна. Шилжин ирэгсдийн 72.7 хувь нь хотын Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргүүдийн захын төлөвлөгдөөгүй суурьшлын бүсэд зөвшөөрөлгүй суурьшдаг байна. Хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн, хүн амын хэт төвлөрлөөс шалтгаалж хүрээлэн байгаа орчин болон хүн амын амьжиргаатай холбоотой нилээд тулгамдсан асуудлууд байна. Улаанбаатар хотын захын болон алслагдсан дүүрэг, хороодод ажилгүйдэл, ядуурлын түвшин харьцангуй өндөр, гэр хороололд оршин суугчдын эдийн засгийн чадавхи орон сууцанд суугчдынхаас доогуур буюу гэр хороололд

амьдрагсдын 45.0 хувь ядуу байхад орон сууцанд суугчдын 15.0 хувь нь ядуу амьдарч байна. Тодруулбал, Сүхбаатар дүүргийн нийт өрхийн 18.9 хувь ядуу байгаа нь ядуурал ихтэй Налайх дүүрэгтэй харьцуулахад 18.1 нэгжээр бага байна.

Нийслэлд ерөнхий боловсролын сургуулиуд 3 ээлжээр хичээллэж, бүлэг дүүргэлтийн дундаж 45-50-д хүрсэн байна. Энэ нь бага ангийн норматив үзүүлэлтээс 15-20 хүүхдээр хэтэрч, сургалтын хэвийн үйл ажиллагаа алдагдахад хүргэж байгаа юм. Түүнчлэн нэг хүүхдэд ногдох талбай эрүүл ахуйн нормыг хангахгүй болж, улмаар анги танхимын агаарын бохирдлын хэмжээ ихэссэнээр сурагчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, элдэв төрлийн өвчинд нэрвэгдэх нэг үндэс болж байна. Түүнчлэн хүүхдийн цэцэрлэгүүд ч ачааллаасаа хэтэрч, халдварт өвчлөлийн тархалтын суурь тавигдаж байгааг үгүйсгэх аргагүй юм. Тав хүртэлх насны хүүхдийн хоол, тэжээлийн дутал өндөр байгаа нь хүүхдийн эрүүл өсч, бойжиход сөргөөр нөлөөлж энэ чиглэлийн бодлогын хэрэгжилт дутагдалтай байгааг харуулж байна.

Тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэхэд нэн тэргүүнд хүн амыг нийгмийн суурь үйлчилгээнүүдэд бүрэн хамруулах, үйлчилгээний чанарыг сайжруулах, амьдрах орчин нөхцөлийг нь дээшлүүлэхэд төрөөс арга хэмжээг авах, хүн амын ядуурлыг бууруулах, нийгмийн зорилтот бүлгүүдэд чиглэсэн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна. Нийслэлийн удирдлагаас хүн амын суурьшилын асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлэж, улмаар тулгамдаж байгаа дээрх асуудлуудыг цогцоор нь шийдэх бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Энэ бодлогын хэрэгжилтэд нийслэлийн иргэд, олон нийтийн оролцоо чухал байр суурь эзлэх бөгөөд улмаар Улаанбаатар хотын эдийн засаг, нийгмийн хөгжлийг түргэтгэхэд тодорхой хувь нэмэр оруулах ач холбогдолтой юм.

Сургалт, сурталчилгаа

МХЗ-ууд, түүний хэрэгжилтийн явц байдлын талаархи мэдээллийг орон нутгийн иргэдэд хүргэх, сурталчлах, хэрэгжилтэд мэргэжлийн болон ТББ, иргэдийн идэвхи оролцоог хангах, санаачлагыг өрнүүлэх зорилгоор туршилтын аймаг, дүүргүүдийн бүх сум, баг, хороог хамарсан сургалт, сурталчилгааны ажлыг 2008

онд зохион байгуулав. Сурталчилгааны ажлын үеэр Монгол Улсын МХЗ-уудын тухай 11 ангит цуврал баримтат киног олон нийтэд үзүүлж, Мянганы тунхаглал, Дэлхийн МХЗ-уудын тухай танилцуулга, Монгол Улсын МХЗ-ууд, тэдгээрийг дүгнэх шалгуур үзүүлэлтийн тухай, Монгол Улсын МХЗ-уудын хэрэгжилтийн Үндэсний хоёр дахь илтгэлийн дүн, сургамж, МХЗ-уудыг орон нутагт хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны тухай хэвлэмэл материал тараав.

Орон нутагт сургалт, сурталчилгааны ажлыг нийгмийн бүлэг бүрийн ялгаатай байдалд тохируулан, аль болох энгийн үг, хэллэгээр хүртээмжтэй, хялбаршуулсан байдлаар боловсруулж, лекц, ярилцлага, уулзалт хэлбэрээр зохион байгуулсан нь үр дүнтэй ажил боллоо. Орон нутагт ялангуяа алслагдсан сумдад зохион байгуулсан сургалт, сурталчилгаа, мэдээллийг иргэд халуун дотноор хүлээн авч өргөнөөр оролцож байв.

Түүнчлэн сургалт, сурталчилгааны хүрээнд Монгол Улсын МХЗ-уудын хэрэгжилтийн Үндэсний хоёр дахь илтгэлийн хураангуй тайлан, статистикийн лавлагаа, МХЗ-д суурилсан Үндэсний Хөгжлийн Цогц Бодлого, МХЗ-уудын талаархи улирал тутмын сонин, зурагт хуудас, хуанли зэргийг олон нийтэд тараав. Сурталчилгааг орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр шууд дамжуулж, МХЗ-уудын хэрэгжилтийн тухай баримтат киног орон нутгийн бүх телевизүүдээр нэвтрүүлж ард иргэдийн МХЗ-уудын талаархи ойлголтыг дээшлүүллээ.

Туршилтын аймаг, дүүргүүдийн МХЗ-уудыг, 2015 онд хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүдийн хамт аймаг, дүүргийн ИТХ-аар батлуулж, аймаг, дүүргийн МХЗ-уудын хэрэгжилтийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд сэдэвт тайланг боловсруулан гаргасантай холбогдуулан албан ёсны нээлтийн үйл ажиллагааг орон нутгийн засаг захиргаа, НҮБХХ-ийн газартай хамтран зохион байгуулав. Орон нутгийн иргэд, мэргэжлийн байгууллага, иргэний нийгмийн төлөөлөл, хэвлэл мэдээллийнхнийг өргөнөөр оролцуулсан албан ёсны нээлтийн үйл ажиллагаанд Аймаг, дүүргийн Засаг дарга нар, Сангийн Яам, НҮБХХ-ийн төлөөлөл биечлэн оролцлоо.

Шигтгээ 7. Ажил олгогч, бизнес эрхлэгчдийн оролцоо

Ядуурал, МХЗ-уудын хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоог дэмжих төслийн баг Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоотой хамтран “Монгол улсын МХЗ-уудыг хэрэгжүүлэхэд ажил олгогч эзэд, бизнес эрхлэгчдийн оролцоо” сурталчилгааны гарын авлагыг боловсруулан олон нийтийн хүртээл болгов. Сурталчилгаанд зориулсан энэхүү гарын авлага нь ажил олгогч эзэд, бизнес эрхлэгчдэд Монгол улсын МХЗ-уудын талаар нэгдсэн ойлголт өгч, МХЗ-уудыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тэднийг татан оролцуулах, нөөц бололцоог бүрэн ашиглаж 2015 оны зорилгодоо хүрэх хамтын ажиллагааг бүрдүүлэхэд чиглэгдэнэ. Түүнчлэн ажил олгогч эзэд, бизнес эрхлэгчид, эздийн төлөөллийн байгууллага, мэргэжлийн холбоодын оролцоо, үүрэг хариуцлага, арга барил, хандлагуудыг санал болгохын зэрэгцээ эдгээр нь МХЗ-уудыг хэрэгжүүлэх, улмаар МХЗ-д суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, түүний хэрэгжилтийг хангах үйл ажиллагаатай уялдуулж хувийн хэвшлийн гүйцэтгэх үүрэг, оролцоог нэмэгдүүлэхэд гол чиглэл болох юм.

Монгол улсын МХЗ-ууд нь ядуурлыг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, амьжиргааны түвшинг дээшлүүлэх, иргэдийг бодит орлогын эх үүсвэртэй болгох зэрэг нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэгдэж байгаа бөгөөд энэ бүх үйл ажиллагаа нь төр, ажил олгогч эзэд, бизнес эрхлэгчид, хувийн хэвшлийн идэвхтэй хамтын ажиллагааны үр дүн гэдгийг сурталчилгааны гарын авлагад дэлгэрэнгүй тусгажээ. Нөгөө талаар нийгмийн хариуцлагатай ажил олгогч эздийг төлөвшүүлэхэд энэхүү гарын авлага багагүй хувь нэмэр оруулна гэж найдаж байна.

Эх үүсвэр: МАОЭНХ

Орон нутгийн засаг захиргаа, МХЗ-уудын анхны илтгэлийн ач холбогдлыг ихээхэн үнэлж, цаашид аймаг, дүүргийн МХЗ-уудад суурилсан орон нутгийн хөгжлийн баримт бичгийг боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж байв. Тухайлбал, Хөвсгөл аймаг “Хөвсгөл аймгийн эдийн засаг, нийгмийг 2008-2015 онд хөгжүүлэх хөтөлбөр”, Говь-Алтай аймаг “Говь-Алтай аймгийг хөгжүүлэх цогц төлөвлөгөө 2008-2021 он” баримт бичгүүдийг боловсруулж гаргасан бөгөөд Дундговь, Дорнод аймгууд хөгжлийн баримт бичгээ шинэчлэн сайжруулах ажлыг хийж байна.

Иргэний нийгэм болон хувийн хэвшлийн оролцоо

МХЗ-уудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад иргэний нийгмийн оролцоог хангах, төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хооронд түншлэлийг бий болгож, тэдгээрийн үр ашигтай хамтын ажиллагааг өрнүүлэх, иргэдийг өргөнөөр татан оролцуулах нь зайлшгүй авах ёстой арга хэмжээний нэг юм. Монгол Улсын МХЗ-уудын хэрэгжилт

ямар түвшинд байгаа, Засгийн газар 2015 оны зорилтдоо хүрч чадах эсэх талаар иргэний нийгмийн байр суурийг тодорхойлох, Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээнүүд иргэдийн амьжиргаанд хэрхэн нөлөөлж байгаа талаар хөндлөнгийн үнэлэлт өгөх зорилгоор ТББ-ын тайлан (сүүдрийн тайлан)-г Мянганы хөгжлийн 1-р зорилт “Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийн эзлэх хувь хэмжээг 1990 онтой харьцуулахад 2015 онд 2 дахин бууруулах”, Мянганы хөгжлийн 14-р зорилт “2015 он гэхэд баталгаат ундны ус хэрэглэх боломжгүй хүн амын эзлэх хувийг 2 дахин бууруулах” болон Мянганы хөгжлийн 16-р зорилт “Худалдааны болон санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх замаар МХЗ-уудад хүрэх таатай нөхцөл бүрдүүлэх” гэсэн сэдвийн хүрээнд боловсруулах нээлттэй сонгон шалгаруулалт зарласан юм.

Энэ ажлыг гүйцэтгэхээр Мониторингийн төв ТББ, МУИС-ийн судалгааны баг болон Монголын байгаль орчны хөгжлийн ассоциаци шалгаран судалгааны ажлаа эхлээд байна.

Бүлэг 4.

МОНГОЛ УЛСЫН ЯДУУРЛЫН ЗУРАГЛАЛ

Товч танилцуулга

Саяхныг хүртэл өрхийн түвшинд явуулсан судалгааны мэдээлэл тулгуурлан ядуурлын үзүүлэлтүүдийг мөнгөн болон мөнгөн бус дүнгээр тодорхойлон гаргаж байлаа. Ийм төрлийн мэдээллийг ашиглан улс орны ядуурлын дүр төрхийг тодорхойлж, улмаар МХЗ-уудын хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтүүдийг үндэсний болон бүсийн түвшинд гаргаж байсан нь тэр бүр бодлого, шийдвэр гаргах, төлөвлөхөд дэлгэрэнгүй нарийн мэдээлэл болж чадахгүй хязгаарлагдмал ашиглагдаж байлаа.

Чухамдаа ядуурлыг бууруулахад чиглэсэн сайн бодлого шийдвэр гаргахад илүү нарийвчлалтай тоо мэдээлэл илүү шаардлагатай байдаг бөгөөд ялангуяа Монгол улсын хувьд аймаг, сумын түвшин дэх ядуурлын үзүүлэлтүүд тун чухал юм. Ийм төрлийн засаг захиргааны түвшнээр нарийвчлалтай мэдээлэл ядуурлыг бууруулахад чиглэсэн зорилтот хөтөлбөрүүдийг оновчтой хэрэгжүүлэх мөн түүнчлэн угаасаа хязгаарлагдмал хөрөнгө нөөцийг үр ашигтай зарцуулахад сайн нөлөөтэй.

Ийнхүү аймаг, сумын түвшний нарийвчлалтайгаар ядуурлын үзүүлэлтүүдийг тодорхойлсон явдал нь Монгол Улсын Засгийн Газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт орсон ядуурлыг тооцох аргачлалыг сайжруулах, ядуурлын зураглал гаргах, нийгмийн хамгааллын мэдээллийн санг байгуулах гэсэн зорилтыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой болсон юм.

Монгол Улс дахь НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр Монгол Улсын Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам, Үндэсний Статистикийн Хороотой хамтран Монгол Улсын түүхэнд анх удаа Ядуурлын талаарх хэд хэдэн үзүүлэлтүүдийг аймаг, сумын түвшинд тооцож гаргалаа. Тухайлбал, ядуурлын хамралтын хүрээ, ядуурлын гүнзгийрэлтийн үзүүлэлтүүдийг Монгол Улсын 2000 оны Хүн ам, орон сууцны тооллого, 2002/2003 оны Амьжиргааны түвшний судалгааны тоо мэдээллийг үндэслэн тооцлоо²².

²² Коуломбе Харолд, Томас Оттер, 2009, *Монгол Улсын Хүн амын тооллогод суурилсан Ядуурлын Зураглал*:

Түүнчлэн 2000 оны Хүн ам, орон сууцны тооллогын мэдээллийг үндэслэн МХЗ-уудын шалгуур үзүүлэлтүүдээс тооллогын мэдээллээс тооцох боломжтой нийт арван нэгэн үзүүлэлтээр МХЗ-уудын шалгуур үзүүлэлтүүдийг тооцсон болно²³. Зарим боломжит үзүүлэлтүүдийг хүйсээр задалж гаргалаа.

Аливаа хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн үр ашгийг хамгийн дээд хэмжээнд хүргэх асуудал нь шийдвэр гаргагчдын нэн чухал анхаарах зүйл билээ. Иймд хөтөлбөр төслийн хэрэгжилтийн үр ашгийг илэрхийлэх гол гол шалгуур үзүүлэлтүүдийг тухайн хөтөлбөр төслийг боловсруулж байх явцад төсөл хөтөлбөрийнхөө зорилттой уялдуулан гаргаж төлөвлөх нь тун чухал байдаг. Ялангуяа, төсөл хөтөлбөрийг зорилтот бүлэг рүү зөв оновчтой онилохын тулд төсөл хөтөлбөрөө хэрэгжүүлэхээс өмнө бодитой, тодорхой мэдээлэлтэй байх, мөн түүнчлэн хэрэгжүүлэлтийн дараа тавьсан зорилт хэрхэн хэрэгжиж байгаа, хэр үр ашигтай, оновчтой байгааг тооцох нарийвчилсан мэдээлэлтэй байх нь чухал. Зорилтот бүлгийг тодорхойлох хамгийн гол шалгуур үзүүлэлт нь тодорхой ямар зорилго тавьж байгаагаас ихээхэн хамааралтай байна. МХЗ-уудын олон нарийвчилсан шалгуур үзүүлэлтүүдээр тодорхойлогдох хэдий ч төр, засгийн газрын хөрөнгөөр санхүүжүүлж байгаа ядуурлыг бууруулахад чиглэсэн бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхдээ хамгийн их тусламж хэрэгцээ шаардлагатай байгаа орлого хомстой хэсэг рүүгээ чиглүүлэх нь илүү үр дүнтэй юм.

Ядуурлын зураглал

Ядуурлын зураглал нь аргачлал, арга зүйн хувьд нилээд нарийн, маш нарийвчлалтай тоо мэдээлэл шаарддаг хэдий ч байгаа тоо мэдээллээ ашиглан 21 аймаг, нийслэл хот,

Бүс, аймаг, сумын түвшний үр дүн, Улаанбаатар, ҮСХ, НҮБ-ын ХХ.

²³ Коуломбе Харолд, 2009, *Мянганы Хөгжлийн Зорилтууд, Газар зүй зорилтот Зураглал, Ulaanbaatar, UNDP*

340 сумын түвшинд ядуурлын үзүүлэлтүүдийг тооцож зураглалыг гаргаж чадсан нь том амжилт юм. Статистикийн арга, техникүүдийг ашиглан шалгаж үзэхэд ядуурлын зураглалын мэдээлэл нь амьжиргааны түвшний судалгааны мэдээллийг ашиглан тооцсон ядуурлын үзүүлэлтүүдтэй бүрэн нийцэж байгаа бөгөөд уг мэдээллийг илүү баяжуулах боломж олголоо. Нэн ялангуяа, ядуурлын зураглалаар гаргасан үзүүлэлтүүд нь статистикийн хувьд бодитой, бүрэн итгэлтэйгээр ашиглах боломжтой мэдээлэл болсон.

Ядуурал нь олон хүчин зүйлээс шалтгаалдаг учир ядуурлын зураглалыг МХЗ-уудын шалгуур үзүүлэлтүүдээр баяжуулан тооцох нь бодлогын чухал хэрэгсэл болно. МХЗ-уудын хэрэгжилтэд 67 шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч байна²⁴. Дийлэнх үзүүлэлтүүдийн хандлагыг улсын түвшинд л тооцож байна. Гэтэл ядуурлыг бууруулах асуудалд хяналт-шинжилгээ хийх, хэтийн тооцоо хийх, шаардлагатай бодлого, шийдвэрийг гаргах зэрэгт аймаг, сумын түвшинд тооцсон ядуурлын үзүүлэлтүүд нэн чухал. МХЗ-уудын үзүүлэлтүүдийг аймаг сумын түвшинд тооцсон нь орон нутагт хэрэгжүүлэх бодлого, шийдвэрийг гаргахад чухал бөгөөд шаардлагатай. Гэхдээ зарим үзүүлэлтүүд тухайлбал, УИХ дахь эмэгтэй гишүүдийн хувь гэх зэрэг үзүүлэлтүүд үндэсний түвшинд тооцогдсон. Ядуурлын зураглалд мөнгөн дүнгээр тооцсон ядуурлын хоёр үзүүлэлтээс гадна МХЗ-уудын 11 шалгуур үзүүлэлтийг аймаг сумын түвшинд Монгол Улсын 2000 оны Хүн ам, орон сууцны тооллогын мэдээллийг үндэслэн тооцлоо.

Ядуурлын зураглалыг баяжуулж байгаа гэж хэлдэгийн гол учир нь дийлэнх МХЗ-уудын шалгуур үзүүлэлтүүд мөнгөн дүнгээр илэрхийлэгдсэн ядуурлын үзүүлэлтүүдтэй статистикийн хувьд хамааралгүй (корреляцигүй) байгаа юм.

Хүснэгт 31-д улсын түвшний 12 үзүүлэлтийг аймаг, сумын түвшинд тооцсон үзүүлэлтүүдтэй харьцуулан үзүүлээ. Ажилгүйдлийн түвшингээс бусад бүх үзүүлэлтүүд төсөөтэй дүнг илэрхийлж байна. Учир нь ажилгүйдлийн түвшинг арай өөр аргаар тооцсон болно. 2000 онд 15-24 насны залуучуудын албан ёсны бүртгэлтэй ажилгүйдлийн түвшин 3.2 хувь байжээ. Харин энэ үзүүлэлтийг ядуурлын зураглалд Олон улсын хөдөлмөрийн байгууллагын стандарт аргачлалын дагуу өөр аргаар тооцсон. Хүснэгт 31-д үзүүлсэн дөрвөн үзүүлэлтийг аймаг,

²⁴ УИХ, 2008, Монголын МХЗ-ууд, Улаанбаатар

Шигтгээ 8. Ядуурлын зураглалыг хэрэглэж байгаа орнуудын жишээ

Ядуурлын зураглал нь үндэсний болоод олон улсын хэмжээний ядуурлыг бууруулахад чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх чухал арга хэрэгсэл болж байгаагийн жишээ бол Никарагуа Улс Ядуурлын зураглалд үндэслэн 1.1 тэрбум ам.долларын хөрөнгийг таван жилийн туршид (2001-2005) ядуурлыг бууруулах стратегийнхээ хүрээнд тодорхой зорилттойгоор хуваарилан үр ашигтай зарцуулсан явдал юм.

Ядуурлын зураглал гаргаснаар улсын төсвийн зарцуулалтыг хамгийн их хэрэгцээ, шаардлагатай хүн ам руу чиглүүлэх боломжтой болдог. Жишээ нь, Гватемал Улс жилд зарцуулдаг байсан олон зуун сая (2002 оны санхүүгийн жилд 576 сая ам. доллар) ам.долларын хөрөнгийг ядуурлын зураглал ашиглан хүн амынхаа суурьшлар тодорхой зорилтот бүлэгт чиглүүлэн зарцуулах Үндэсний Хөрөнгө Оруулалтын тогтолцоондоо бүтцийн өөрчлөлт хийжээ.

Нэн яаралтай тусламжийн үйлчилгээ, хүнсний тусламжийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд илүү дэлгэрэнгүй мэдээлэл агуулсан Ядуурлын зураглалын шинэ аргуудыг ашиглаж байгаагийн жишээ бол 2001 оны эхээр Өмнөд Африкийн КваЗулу Натал мужид гарсан холерийн халдварыг зогсоох зорилгоор хүн амынхаа суурьшилд тулгуурласан стратеги боловсруулахын тулд ядуурлын судалгааны тоо, мэдээллийг эрүүл ахуй, цэвэр усны хангамжийн мэдээлэлтэй нэгтгэн тооцоо хийсэн явдал байна. Энэ стратегийг хэрэгжүүлснээр гуравхан сарын дотор уг халдвараар нас барагсдын тоо урьд өмнө хэзээ ч ажиглагдаж байгаагүйгээр хурдацтай буурч (0.22%) үр дүнгээ өгсөн байна. Камбожид, Дэлхийн Хүнсний Хөтөлбөрийн тусламжийн хүрээнд “хөдөлмөрлөхөд хүнс хэрэгтэй” хөтөлбөрөөр нэн шаардлагатай зорилтот бүлгийн хүн амд хүргэхэд зориулсан 50 сая ам.долларын хөрөнгийг (2001-2003) зарцуулах хамгийн ядуу бүс нутгийг тодорхойлоход ядуурлын зураглалыг ашигласан байна.

Олон орны туршлагаас үзэхэд өндөр нарийвчлалтай тооцоолсон Ядуурлын зураглал нь үндэсний болон орон нутгийн түвшинд шийдвэр гаргахад ихээхэн ашиг тус өгч байна. Бразилийн томоохон муж болох Минас Герайст ядуурлын зураглалыг ашиглаж жил бүрийн улсын татварын орлогынхоо нэг тэрбум гаруй ам.долларын хөрөнгийг илүү анхаарал татсан, ядуу буурай бүс нутгууддаа чиглүүлэн дахин хуваарилснаар хүн амынхаа эрүүл мэнд, боловсрол, эрүүл ахуй болон хүрээлэн буй орчныг хамгаалахад дорвитой нөлөө үзүүлжээ.

Эх үүсвэр: Норберт Хенненгер, Матилд Снил, 2002 Ядуус хаа байна? Хөгжлийн туршлагууд, ядуурлын зураглалыг ашиглах нь, Дэлхийн мэдээллийн институт, Вашингтон хот

сумын түвшинд хүйсээр задалж тооцлоо. Энэ тайлангийн 5 дугаар хавсралтад эдгээр үзүүлэлтүүдийг аймаг, сумын түвшингээр үзүүллээ.

МХЗ-уудын шалгуур үзүүлэлтүүдээр зураглал гаргах нь харьцангуй хялбархан.

Зорилтот бүлгийг газар зүйн байршлаар нь тодорхойлох зураглал

Янз бүрийн аргаар тооцсон тоо мэдээллүүд нь сонирхолтой байдаг хэдий ч ашиглагдаж байж л үнэ цэнгээ үзүүлнэ. Тэгвэл чухам яаж ашиглах вэ гэдэг асуудал тулгарна. Дээрх зураглалуудыг ашиглах олон арга байдаг бөгөөд түүний дотроос нилээд чухал нь зураглалыг төсөв хөрөнгийг засаг захиргааны янз бүийн түвшинд хуваарилахад ашиглах явдал ихээхэн түгээмэл байдаг. Тухайлбал, Засгийн газраас бүсүүд рүү, бүсүүдээс аймаг, сумдад гэх мэт. Дээрх төрлийн зураглалууд төвлөрөлийг сааруулах үйл явцыг хэрэгжүүлж байгаа Монгол Улсын хувьд тун чухал хэрэгсэл болж байна.

Зорилтот бүлгийг тодорхойлох олон арга механизмууд байдаг хэдий ч алийг нь сонгох нь чухамдаа хүн амын ямар бүлэгт чиглэсэн, ямар арга хэмжээ авах шаардлагатай

байгаа, хэрэгжүүлэх ямар боломж нөхцөл байгаа зэргийг илэрхийлсэн шалгууруудаас хамаарна. Ийм нөхцөл байдлыг илэрхийлэх тоо мэдээллийн сан тун чухал. Зорилтот бүлгийг тодорхойлох механизмыг газар зүйн байршлаар, хувь хүмүүсээр, хамт олноор нь гэх мэт гурван бүлэгт хувааж болно.

Зорилтот бүлгийг газар зүйн байршлаар нь тодорхойлох зураглалыг гаргахдаа засаг захиргааны янз бүрийн түвшингийн буюу Монгол Улсын хувьд аймаг, сумын түвшний мэдээлэлд тулгуурлана. Зорилтот бүлгийг газар зүйн байршлаар нь тодорхойлох зураглалыг ашиглан тухайн засаг захиргааны нэгж харгалзах ядуурлын үзүүлэлтүүддээ нийцсэн хөрөнгийг хүлээн авна гэсэн үг. Хүлээн авсан хөрөнгө тухайн газар нутагт оршин байгаа бүх хүмүүст ижил хэмжээгээр хуваарилагдах, аль эсвэл тухайн газар нутгийн хүн амын нийтийн хэрэгцээний дэд бүтцийг хөгжүүлэхэд хэрэглэгдэнэ. Тухайн газар нутгийн мэдээлэлд үндэслэж бүр цааш нь нарийвчлан зорилтот бүлгээ тодорхойлох боломж бас бий. Зорилтот бүлгийг газар зүйн байршлаар нь тодорхойлох зураглалыг ихэвчлэн хүн амын тооллогын мэдээллээс тооцоход хялбар үзүүлэлтүүдийг, тухайлбал, сургуульд хамрагдалт, эрчим хүчний хангамж гэх мэт үзүүлэлтийг ашигладаг. Мөн түүнчлэн мөнгөн хэмжигдэхүүнээр тооцсон

Хүснэгт 31. Аймаг, сумын түвшнээр тооцсон үзүүлэлтүүдийг үндэсний түвшний дүнтэй зэрэгцүүлснээр, 2000

Код	Шалгуур үзүүлэлтүүд	МХЗ-ууд	Хүн ам, орон сууцны 2000 оны тооллого		
		2000	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
1	Ядуурлын хамралтын хүрээ (%)	35.6 ²⁵			
8	Ажиллах хүчний оролцооны түвшин (%)	62.9	64.9	71.3	58.8
9	15-24 насны залуучуудын ажилгүйдлийн түвшин (%)	3.2	24.3	24.8	23.7
11	Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин (%)	95.0	90.4	88.7	92.0
13	15-24 насны залуусын бичиг үсэг тайлагдалт (%)	97.7	97.8	97.1	98.4
14	Бага боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа	1.01	1.06	*	*
15	Ерөнхий боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа	1.20	1.40	*	*
17	ХАА-гаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь	50.4	48.9	*	*
39	Баталгаат ундны усны хангамжгүй хүн амын эзлэх хувь (%)	60.8 ²⁶	64.9	*	*
40	Сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдаагүй хүн амын эзлэх хувь (%)	73.4 ²⁷	76.3	*	*
41	Инженерийн шугам сүлжээтэй орон сууцанд амьдарч байгаа хүн амын эзлэх хувь (цахилгаан, ус, бохир, халаалт) (%)	22.7	22.7	*	*
53	Суурин утасны цэгийн тоо (1000 хүн тутамд)	46.6	38.1	*	*

Тайлбар: * тооцох боломжгүй

²³ УИХ, 2008, Монгол Улсын МХЗ-ууд, Улаанбаатар

²⁴ Коулумб, Оттер, 2009, Монгол Улсын Хүн амын тооллогын тоо мэдээлэлд суурилсан Ядуурлын зураглал: Бүс, аймаг, сумын түвшний үр дүн, Улаанбаатар. ҮСХ, НҮБХХ

²⁵ 1998 оны тоо мэдээлэл

²⁶ 2006 оны тоо мэдээлэл

²⁷ 2006 оны тоо мэдээлэл

ядуурлын зураглалыг²⁵ ашигладаг.

Цаашдын төлөв байдал

Ядуурлын зураглалыг дэлхийн олон орны эдийн засагчид, эрдэмтэд, судлаачид, бодлого боловсруулагчид, түүнчлэн иргэний нийгмийн байгууллагууд, хувийн бизнес эрхлэгчид ашиглаж эхлээд байна.

Хүн амын тооллогын тоо, мэдээллийг үндсэн зорилгоос нь гадна янз бүрийн судалгаа, шинжилгээний ажилд хэрэглэж, бодлогын боломжит хувилбарыг гарган, түүнээс оновчтойг нь сонгох боломжийг ядуурлын зураглал олгож байгаа юм. Ийнхүү бодит мэдээлэлд суурилсан зураглал, тооцоолол, дүн шинжилгээ нь бодлого, хөтөлбөрийн үндэслэлийг сайжруулах, хэрэгжилтийн явцад гарсан болон гарч болох алдаа оноог дүгнэж, үр ашгийг үнэлэхэд чухал хувь нэмэр оруулах болно.

Ядуурлын болон МХЗ-уудын шалгуур үзүүлэлтүүдийн зураглалын тусламжтайгаар аймаг, сумын түвшинд бодитой мэдээллийг гаргах болсноор Монгол улсын дунд болон урт хугацааны стратеги, бодлогын зорилтуудад ядуурлыг бууруулах талаар дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, идэвхи санаачлагыг дэмжих бодит боломж бүрдэж байна.

Ядуурлын зураглал нь ядуурлын түвшин өндөртэй аймаг, сумдад зорилтот хөтөлбөрүүдийг чиглүүлэх, хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ төсөв хөрөнгийг оновчтой хуваарилах, ялангуяа, ядуурлыг бууруулах, хүмүүсийн амьжиргааг дээшлүүлэхэд бодлогын чухал хэрэгсэл болно.

Цаашид ядуурлын зураглалыг бодлогод хэрхэн ашиглах талаар дорвитой алхам хийх нь нэн чухал юм. Үүний зэрэгцээ цаашид ямар хугацаанд зураглалыг хийж байх, тоо мэдээллийн эх үүсвэрээ хэрхэн баяжуулж, чанаржуулах, үндэсний түвшин дэх чадавхи, хүн хүч, хөрөнгө нөөц, зохион байгуулалт бий болгох шаардлагатай зэрэг олон асуудал байна. Тухайлбал, Монгол Улсын хүн амын тооллого удахгүй явагдах гэж байна. Арван жилд нэг удаа ихээхэн зардал, хүчээр хийгддэг энэ ажлын хүрээнд хүн амын амьжиргааны түвшнийг тодорхойлох, нийгмийн үйлчил-

гээний үр ашгийн үзүүлэлтүүдийн мэдээлэл цуглуулах боломжийг бий болгох чиглэлээр холбогдох байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна.

Түүнчлэн цуглуулсан тоо, мэдээллийг ашиглан зураглал, тооцоолол, судалгаа хийх үндэсний чадавхийг бэхжүүлэх, байгууллагуудаас гаргаж байгаа дотоод буюу захиргааны мэдээллийг сайжруулах хэрэгтэй байна.

Үүний үр дүнд газар нутгийн аль хэсэг нь хөгжлийн хувьд сул байгаа болон хөрөнгө оруулалт, төр, засгийн үйлчилгээ түлхүү шаардлагатай хүн амын хэсэг бүлэг оршин сууж байгааг тодорхойлсноор тэр хэсэгт хөрөнгө нөөцөө илүү төвлөрүүлэх боломжтой болж байгаа юм.

